

“Буддын ухаан ба Шинжлэх ухаан: шүтэн барилдлагын шинжилгээ”
суурь судалгааны төсөл (2019 - 2022)

Суурь судалгааны төслийн тайлан

Захиалагч:	Боловсрол, шинжлэх ухааны яам
Санхүүжүүлэгч:	Шинжлэх ухаан технологийн сан
Гүйцэтгэгч байгууллага:	СУИС-ийн Соёлын сургууль
Төслийн удирдагч:	Х.Дондог, Ph.D. Дэд профессор

Улаанбаатар 2022 он

АГУУЛГА

1. Хураангуй.....	3
2. Төслийн үйл ажиллагаа.....	4
2.1. Хийж гүйцэтгэсэн ажлын тойм.....	4
2.2. Буддын ухааны нэр томъёо, хэллэгийн түүвэр хийсэн байдал.....	5
2.3. Хамтарсан эрдэм шинжилгээний хурал.....	5
2.4. Социологийн судалгаа.....	5
2.5. Хамтын ажиллагаа.....	5
2.6. Төслийн багийн гишүүд.....	5
2.7. Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал.....	6
2.8. Мониторинг, явцын тайлан.....	6
2.9. Байгууллагуудтай хамтран ажилласан байдал.....	6
2.10. Зөвөлгөө авсан байдал.....	7
2.11. Чөлөөт судлаачидтай хамтарсан ажил.....	7
2.12. Судалгааны зарим үр дүнг хялбаршуулсан байдал.....	8
3. Төслийн үр дүн.....	8
3.1. Нэгдүгээр үр дүн: Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх.....	8
3.2. Хоёр ба гуравдугаар үр дүн: ЭШ-ний хурал зохион байгуулж, илтгэлийн эмхэтгэлийн эх бэлтгэсэн байх.....	9
3.3. Дөрөвдүгээр үр дүн: Социологийн судалгаа явуулсан байх.....	9
3.4. Тавдугаар үр дүн: Дөрвөн хэлний толь бичгийн эх бэлтгэх.....	9
4. Төслийн судалгаа.....	10
4.1. Буддын ухаан нь гносеологи, эпистемологийн салбар мөн болох нь.....	10
4.2. Өөрийгөө танихад шүтээний гүйцэтгэх үүрэг.....	19
4.3. Их хөлгөний судлагдахууны шинжилгээ.....	26
4.4. Дүйра буюу нотлох арга аргачлалын тухай.....	37
4.5. Буддын шинжлэх ухааны товч агуулга.....	47
4.6. Гадаад, дотоод ертөнцүүдийн танин мэдэхүйг харьцуулсан шинжилгээ.....	63
4.7. Мэдрэлийн шинжлэх ухаан болон Буддын шашин дахь “Би”, “Чөлөөт хүсэл”, “нийгэм” хэмээх ойлголтууд.....	71
4.8. Буддын бясалгалын товч агуулга.....	76

4.9. Монголчуудын билиг ухааны өв уламжлал, монгол дархлаа, эрдэмжих зам мөрийн шинжилгээ.....	83
4.10. Буддын танин мэдэхүйн эрдэм ухааныг дэмжих эрх зүйн асуудал.....	99
4.11. Социологийн судалгаа.....	106
4.12. Дөрвөн хэлний дүйцүүлсэн толь бичиг.....	123
4.13. Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” сэдэвт ЭШ-ний хурлын эмхэтгэл.....	124
5. Тайлангийн ерөнхий үр дүн, зөвлөмж.....	133
6. Хавсралтууд.....	134
6.1. Хавсралт 1.....	135
6.2. Хавсралт 2.....	136
6.3. Хавсралт 3а.....	137
6.4. Хавсралт 3б.....	138
6.5. Хавсралт 3в.....	139
6.6. Хавсралт 3г.....	140
6.7. Хавсралт 4а.....	141
6.8. Хавсралт 4б.....	142
6.9. Хавсралт 5а.....	143
6.10. Хавсралт 5б.....	144
6.11. Хавсралт 5в.....	145
6.12. Хавсралт 5г.....	146
6.13. Хавсралт 5д.....	147
6.14. Хавсралт 6 (Дөрвөн хэлний толь бичгийн эх тусдаа PDF файл хэлбэртэй).....	147

1. Хураангуй

Буддын ухааныг дөрвөн талаас нь харж болохыг бид судалгаанаас олж мэдсэн. Үүнд: 1. Буддын шашин, шашин судлал, 2. Буддын гүн ухаан, тогтсон тааллууд, 3. Буддын шинжлэх ухаан, сэтгэл судлал, 4. Гэгээрэх зам мөр, зөв зам мөрийн технологи тус тус багтана. Энэ дөрвөн талыг шүтэлцүүлвээс Буддын сургаалыг иж бүрэн харж болох юм. Аль нэг талыг нь дагнан авч үзэж болох ч, туйлшралаас зайлсхийхын тулд бусад талуудыг оролцуулан тэнцвэржүүлэн авч үзэх нь онолын судалгааны хийсвэр түвшинг онож барихад тустай. Одоогоос дөчөөд жилийн өмнөөс Буддын сургаалын танин мэдэхүйн талыг шинээр нээн илрүүлэхэд Дээрхийн гэгээнтэн 14-р Далай лам санаачилга гаргаж, Барууны шинжлэх ухааны салбарын зарим эрдэмтэдтэй хэлэлцүүлэг өрнүүлж, хамтарсан судалгааны хүрээлэнгүүдийг байгуулж ажиллуулсан билээ. Энэ ажлын хүрээнд Буддын сургаалаас шинжлэх ухааны танин мэдэхүйн холбогдолтой зүйлсийг Цогт Налэндра хийдийн мэргэдийн оролцоотойгоор тодруулаад, “Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй” сэдэвт цуврал бүтээлүүдийг хэвлүүлсээр байгаа юм. Монгол улс нь буддын салбарын “Номт гурван улс”-ын нэг байсаар ирсэн түүхэн уламжлалтай бөгөөд түүнийг Далай ламын санаачилгатай уялдуулан шинэ өнгө аясаар үргэлжлүүлэх үүднээс энэхүү суурь судалгааны төслийг хэрэгжүүлсэн болно.

Шинжлэх ухааны танин мэдэхүйн үр дүн нь албан боловсролоор дамжин өнөөгийн нийгмийн бүхий л давхарга, байгууллага, гэр бүл, хувь хүний түвшинд амьсгалах агаар лугаа түгэж, технологийн хөгжлийн үр шим нь ахуйд гар утас адил өргөн хэрэглэгдэж буй тул шинжлэх ухааныг танилцуулах нь илүүц билээ. Миний хувьд, бас бусад судлаачдын ч хувьд шинжлэх ухаанаар хэдэн арван жил хичээллэсэн тул бидэнд шинжлэх ухааны мэдлэг, хандлага, арга зүй нэвт шингэсэн байгаа бөгөөд алив зүйлд хандахдаа ч шинжлэх ухаанчаар хандаж буй гэдгийг дурдах нь бас илүүц биз. Харин энэ хандлагаараа Буддын ухааныг шинээр харж, танин мэдэхүйн ололт нь шинжлэх ухаанаас юугаараа ялгаатай, бас юугаараа төстэй, эсвэл ижил байгааг олж тогтоох нь энэ төслийн судалгааны зорилго байсан болно.

Судалгааны явцад шинжлэх ухаан (гадаад ертөнцийн танин мэдэхүй давамгайлсан), Буддын ухаан (хүний дотоод ертөнцийн танин мэдэхүй давамгайлсан) хоёр нь танин мэдэхүйн ерөнхий түвшинд харилцан шүтэлцэж буй нь илт болсон бөгөөд түүнийг нь дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд: 1. Бие сэтгэл хоёроос хүн бүтэх тул гадаад, дотоод ертөнц нь шүтэлцэхгүй байхын аргагүй байна. 2. Бие нь гадаад орчныхоо ургамал тул гадаад, дотоод ертөнц шүтэлцэхгүй байхын аргагүй юм. 3. Таньж мэдсэндээ л түшиглэж сэтгэл үүсдэг учраас хоёр танин мэдэхүй нь үндэс, үр дагавар хоёроороо шүтэлцэхгүй байхын аргагүй байна. 4. Хоёр танин мэдэхүй нийлж байж шийдэх асуудал их байгаа учраас практик түвшинд ч шүтэлцэхгүй явахын аргагүй юм. Иймд гадаад ертөнц, дотоод ертөнц хоёрын танин мэдэхүйг “нэгтгэж”, шинжлэх ухааны танин мэдэхүйг хийсвэр (субъектив) ертөнцийн танин мэдэхүйгээр баяжуулан өргөтгөх нь хүн төрөлхтний хувьд дэвшил болно.

Буддын сургаал нь оршихуйн жам ёсны тухай мэдлэг, түүнийгээ нутагшуулсан зөв оршихуйн технологи юм. Хүн эрх мэдэлтэй, хөрөнгө чинээтэй байх, сайн мэргэжилтэн, сайн эцэг эх байх нь чухал ч зөв оршихуйтай байх нь түүнээс илүү чухал ажээ. Иймээс оршихуйн өргөн хүрээ (“хийсвэрлэлийн өндөр түвшин”)-ний танин мэдэхүйг үе үеийн гүн ухаантнууд сонирхож ирсэний утга учир их юм. “Амьдрал бол өөрийгөө ухамсарлагч үзэгдэл” хэмээн философич М.Хайдэггэр зургаан зүйл хамаг амьтны түвшинд харгалзуулан хэлсэн бол Бурхан Будда “амьтдын дотроос зөвхөн хүн л орчлон ертөнцийн жам ёсыг ухаарч, зөв зам мөрөөр явж

чадах нэгэн” болохыг онцлон дурсан байна. Буддын сургаалын түвшинд “оршихуй нь өөрчлөгдөн урсахуй” бөгөөд түүний механизм нь “шүтэн барилдахуй” юм. Шүтэн барилдлага нь чинад хязгаарын үзэгдэл, билиг ухааны хараа билээ. Барих барьцгүй ч, “чинад хязгаарын түвшин”-д (танин мэдэхүйн энэхүү хийвэрлэл нь математикийн “хязгаар олох”-той нэг талаар төстэй) оршихуйн жам-шүтэн барилдахуйг ухаарах нь “сохор хүн хараа орохтой адил ид шидтэй”, үгээр илэрхийлэхийн аргагүй ч түгээмэл ач тустай зүйл ажээ. Билиг ухааны чинад хязгаарын танихуйг хураангуйлж, “Мяла богдын найман гүн”-ээр илэрхийлж болох нь бидний судалгаанаас тодорсон юм. Үүнд:

Үзэгдэхүүн хоосон бол үзлийн гүн
Хоосон нь амгалан бол явдлын гүн
Сэтгэл огторгуй хоёр адил бол номын гүн
Сэтгэл бурхан хоёр адил бол үрийн гүн
Зүүд өдрийн явдал хоёр адил бол бясалгалын гүн
Нисванис бэлгэ чанар хоёр адил бол онолын гүн
Жаргал зовлон хоёр адил бол увдис утгын гүн
Энэ хойд хоёр нас адил бол ахуй ёсны гүн болой.

Бид судалгааныхаа хүрээнд Буддын ухааны танин мэдэхүйн үр дүнг зөвөөр ойлгон шинжилж, олж барьсан зүйлээ орчин үеийн шинжлэх ухааны боловсролтой хүмүүс хийгээд судлаачдад ойлгомжтой байдлаар олон түвшинд, шинжлэх ухааны өгүүлэл, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, толь бичиг зэрэг арга хэлбэрүүдээр, энгийн үг хэллэгээр дамжуулан хүргэхэд анхаарсан болно.

Судалгааны ажлын бодит үр дүн (Үр дүнгийн даалгаврыг **Хавсралт 1**-ээс харна уу) нь:

1. Эрдэм шинжилгээний арван дөрвөн өгүүлэл хэвлүүлсэн
2. “Буддын ухааны нэр томъёо, ухагдахуун, хэллэгийн монгол, түвд, орос, англи дөрвөн хэлний дүйцүүлсэн толь бичиг”-ийн эх бэлтгэсэн
3. “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” сэдэвт хоёр салбарын судлаачдын хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан
4. Энэхүү хурлын илтгэлүүдийн эмхэтгэлийг хэвлүүлсэн
5. “Хүний дотоод ертөнцийн янз байдал”-ыг тандан судлах социологийн судалгааны иж бүрэн асуумжийг шинээр боловсруулсан
6. Уг асуумжийг хэрэглэн социологийн судалгаа явуулсан
7. Судалгааны зарим үр дүнг хялбаршуулан “Физикийн боловсрол” сэтгүүлд хэвлүүлсэн, зарим их дээд сургуулийн тэнхимийн Их семинарт хэлэлцүүлсэн зэргээр илэрхийлэгдэж байгаа болно.

2. Төслийн үйл ажиллагаа

2.1. Хийж гүйцэтгэсэн ажлын тойм

1. Буддын эрдэм мэдлэгийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, уг салбарын үзэл онол, тогтсон тааллуудын төрөл, харилцан уялдаа зэргийг тоймлон тодруулав.
2. Буддын үзэл онол, тогтсон тааллуудын төрөл, агуулгын хүрээг тодруулан, Буддын танин мэдэхүйн хүрээг схемчлэв.
3. Буддын эрдэм ухааны сэтгэлгээний онцлог, үг хэллэг, нэр томъёо, ухагдахуун, ойлголтуудын системийг судалж тодруулав.
4. Буддын ухааны танин мэдэхүйн хүрээний мэдлэг, шинжлэх ухааны танин мэдэхүйн хүрээний сэдвүүдээр эрдэм шинжилгээний хуралд 15 илтгэл тавж хэлэлцүүлэн, эрдэм шинжилгээний 13 өгүүлэл хэвлүүлэв.

2.2. Буддын ухааны нэр томъёо, хэллэгийн түүвэр хийсэн байдал

1. Буддын ухааны эрдэм мэдлэг, тогтолцоотой нарийвчлан танилцаж, өөрийн олж авсан баттай мэдлэг-хандлагын үндсэн дээр буддын ухааны үндсэн олголтууд болон ухагдахуун, үг хэллэгийн түүвэр жагсаалт гаргав.
2. Буддын ухааны ойлголт, ухагдахуун, нэр томъёо, хэллэгийн түүврийг монгол, түвд, орос, англи хэлээр харгалзуулж, дүйцүүлсэн толь бичгийн эхийг бэлдэв.

2.3. Хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулалт

1. Буддын ухаан, шинжлэх ухааны салбарууд хоорондын мэдээлэл солилцоо, хамтын сургалт, семинар, судалгааг сайжруулах зорилго бүхий “Судлаачдын хамтарсан ЭШ-ний хурал”-ыг
2. “Буддын ухаан ба Шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” сэдвийн дор 2022 оны 5-р сарын 27-нд онлайн хэлбэрээр Зүүм ашиглан зохион байгуулав.
3. Хурлын үр дүнд хоёр салбарын судлаачид харилцан мэдээлэл солилцож, цаашид хамтран ажиллахад таатай боломж бүрдэв. Хурлын явцын зарим зураг-мэдээллийг хавсаргав (Хавсралт 3).
4. Хурлын зар, ЭШ-ний өгүүлэлд тавигдах шаардлагын хамт 2022 оны 4-р сарын 18-нд олон нийтэд түгээсэн бол Хурлын хөтөлбөрийг (Хавсралт 2) 2022 оны 05 сарын 24-нд илтгэгч нарт түгээсэн.
5. Хуралд нийтдээ 24 илтгэл хэлэлцүүлсэн.

2.4. Социологийн судалгаа

- Бэлтгэсэн асуумжийн дагуу “Монгол хүний дотоод ертөнцийн янз байдал”-ыг тандан судлах социологийн судалгааны асуумжийг бэлтгэв (Хавсралт 3).
- 2022 оны 10 сард социологийн судалгааг бүрэн явуулж дуусгасан.
- Буддын суурь ухаан, гүн ухаан болон шинжлэх ухааны сэтгэл судлал, социологийн онолын сууринд тулгуурлан “нийгмийн сэтгэл зүйн байдал”-тай уялдуулан социологийн судалгааны асуумжийг бэлтгэхэд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулсан.
- “Хүний дотоод ертөнцийн янз байдал”-ыг тандан судлах социологийн судалгааны иж бүрэн арга зүйг шинээр боловсруулж, хэрэглэсэн.

2.5. Хамтын ажиллагаа

2.6. Төслийн багийн гишүүд

Нэр	Эрдмийн зэрэг, цол, албан тушаал
1 С.Гантөмөр	Гавж, Дашчоймбол дацангийн шунлайв
2 Д.Даваасүрэн	Доктор, дэд проф. СУИС-ийн ЭШ-инновацийн газрын дарга
3 Х.Түмэнбаяр	Төвдөч, Үндэсний Төв номын сангийн Ховор судар бичгийн фондын эрхлэгч
4 М. Гантуяа	Доктор, процессор, МУИС философийн тэнхим, Буддын гүн ухаан судлаач
5 Д. Ганболд	Доктор, профессор, МУБИС-ийн Бичиг соёлын төвийн эрхлэгч, Хэл-шашины үйл судлаач

- | | | |
|---|----------------|--|
| 6 | Ш.Болд | Доктор, Академич, Ач их сургуулийн ЭШ-эрхэлсэн захирал, уламжлалт анагаах ухааны судлаач |
| 7 | Р. Отгонбаатар | Доктор, Хэл зохиолын хүрээлэн, ЭШ-ний тэргүүлэх ажилтан, төвд судлаач |

2.7. Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал

Төслийн хугацаанд дараах Эрдэм шинжилгээний хурлуудад оролцож илтгэл тавьж хэлэлцүүлж байв. Үүнд:

1. СУИС-ийн “Монголчуудын үнэт зүйлс” Эрдэм шинжилгээний хуралд, 2020
2. Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойн Олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2022.
3. Природные условия, история, культура и язык западной Монголии и сопредельных регионов, Ховд Их Сургууль, 2019.
4. Орхон Их сургуулийн Эрдэм шинжилгээний хуралд 2019, 2020, 2021, 2022, 2023.
5. “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” Эрдэм шинжилгээний хуралд. УБ., 2022.
6. МУИС, “Монгол судлал, шашин судлалын асуудлууд” сэдэвт 2019 оны Олон улсын эрдэм шинжилгээний хуралд, 2020.
2. СУИС-ийн Эрдэмтдийн их чуулганд, 2019.

2.8. Мониторинг, явцын тайлан

1. МУСУИС-ийн эрдмийн зөвлөлд Төслийн танилцуулгаа хийж, судалгааны арга зүйгээ батлуулсан. Мөн түүнчлэн 2019 оны Эрдэмтдийн их чуулганд илтгэл хэлэлцүүлж оролцсон.
2. 2020 оны 6-р сард, мөн 2022 оны 9-р сард БСШУЯ, ШУТСан, МУСУИС-ийн хамтарсан төслийн мониторингийн хуралд өөрийн төслийн явцын талаар танилцуулга хийж, ярилцлагад оролцов.
3. Төслийн явцын тайлангаа Календарчилсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь ШУТСанд өгч ирсэн.

2.9. Байгууллагуудтай хамтран ажилласан байдал

Хамтарсан судалгаа, хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Байгалийн шинжлэх ухаан болон Буддын ухаан хоорондын уялдаа холбоог тодруулах үүднээс ШУТИС-ийн физикийн тэнхимийн багш нарын Их семинарт “Хоосон чанар ба квант физик” сэдвээр илтгэж, хэлэлцүүлэг хийв.
2. МУБИС-ийн түүхийн тэнхимийн Их семинарт “Монголчуудын эрдэмжих арга ухаан” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.
3. Гандантэгчэнлин хийдийн харъяа Шашны дээд сургууль болон Дашчоймпэл дацангийн чойрын ухааны мэргэдтэй хамтран “Шинжлэх ухаан ба Буддын ухаан: гэрлийн мөн чанар” сэдэвт хэлэлцүүлэг нэг удаа хийв.
4. Монголын сүсэгтний холбооны шугамаар Гандантэгчэнлин хийдийн гадаад харилцааны мэргэжилтэн, бясалгалын багш Мөнхбаатартай хамтран “Буддын тогтоон төвлөрөх бясалгал болон ажиглан шинжлэх бясалгалын арга технологийн судалгаа” хийсэн.
5. Оросын холбооны улсын Москвагийн их сургуультай хамтарсан судалгаа хийх ажлыг эхлүүлэхээр томилолтоор ажиллав. Томилолтын хугацаанд Москвагийн Улсын Их сургуулийн Философи, шашин судлалын тэнхимийн профессор Бойцова Ольга Юрьевна тэргүүтэй багш судлаачидтай уулзаж, судалгааны чиглэлийг хэлэлцэж, Буддын танин

мэдэхүйн толь бичгийн орос хэл дээрх ойлголт, ухагдахуун, үг хэллэг дээр цаашид хамтран ажиллахаар тохиролцов.

6. Мөн түүнчлэн Москвагийн Улсын Их сургуулийн сэтгэл судлалын тэнхимийн профессор А.Г. Асмолов тэргүүтэй багш, судлаачидтай уулзалт хийж, шинжлэх ухааны сэтгэл судлал болон Буддын сэтгэл судлал хоорондын харьцуулсан судалгаа хийх сонирхолоо илэрхийлж, дэмжлэг авав.
7. Гандантэгчэнлин хийдийн харьяа Шашны дээд сургуулийн сургалтын арга технологийн судалгааг хийж, түүний уламжлал, соёл, онцлогыг тодруулав.
8. МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Н.Амгалантай 3 удаа уулзаж, Буддын шашны түүх, танин мэдэхүйн асуудлаар ярилцсан.
9. Сэтгэлийн танин мэдэхүйн үндсэн аргын нэг болох бясалгалын механизмын судалгааг гүнзгийрүүлэн хийв. Үүнд Зүүн хүрээ, Дашчойлон хийдийн бясалгалын багш Б.Дарамбазартай хамтран “Бумшийн бясалгал”-ын арга технологийг судалсан. Ингэхдээ “Итгэлийн бясалгал”, “Базарсадын бясалгал”, Мандалын бясалгал”, “Багшийн егүзэрийн бясалгал” гэсэн дөрвөн чиглэлий онцлог, ач холбогдол, үр дүнг тодруулав.
10. Дилов Хутагт сангийн ажилтнуудтай хамтран “Буддын ухаан ба Шинжлэх ухаан” сэдвээр биечлэн уулзаж ярилцлага хийсэн.
11. Монголын сүсэгтний холбооны удирдах зөвлөлтэй уулзсан ярилцлага. УЗ-ийн гишүүн Р.Оюунчимэг “ Буддын ухаан ба хууль эрх зүй” сэдвээр ЭШ-ний хуралд оролцсон.
12. Ховд Их Сургуулийн профессор А.Батсуурьтай хамтран ажиллаж, “Буддын гүн ухаан дахь сав, шим ертөнц – оюун мандалын шүтэлцээний үндэс”, Хутагт Васубандугийн “Төв хийгээд хязгаарын тийн ялгалын тайлбар” бүтээлийн орчуулгыг хийлгэх болсон.

2.10. Зөвөлгөө авсан байдал

1. Анагаах ухааны Ач их сургуулийн профессор, академич Ш.Болдтой хамтран “Монголын уламжлалт анагаах ухааны онол, арга зүй”-н зөвөлгөө авч ажилласан.
2. Судлаач Отгонбаатартай хамтран “Монголын уламжлалт мэдлэг ухаанд дээдийн номын агуулга туссан байдал”-д дүн шинжилгээ хийх арга зүйн асуудлаар зөвөлгөө авч ажилласан.
3. Лхарамба Ц.Бат-Итгэлтэй бясалгалын тухай ярилцаж, “Таван цогцын бясалгалын судалгаа” хийв.
4. Гандантэгчэнлин хийдийн лам Ж.Даваадоржийн “Сэ дүйра”-ийн онлайн хичээлд сууж, мэтгэлцээний арга зүйг судалсан.

2.11. Чөлөөт судлаачидтай хамтарсан ажил

1. Астрофизикч Физикч Я.Авирмэдтэй хамтран орчин үеийн Космологи ба космофизикийн салбарын мэдлэг, түүний онцлогтой шүтэн барилдлагын ухааныг харьцуулах судалгаа хийсэн.
2. Төв номын сангийн “Ховор судар номын танхим”-ын ажилтан Түмэнбаяртай хамтран Буддын сургаалын агуулгын тогтолцоог хэрхэн ойлгох талаар дөрвөн удаа зөвлөлдөж ярилцсаны зэрэгцээ “Дөрвөн хэлний дүйцүүлсэн толь бичиг”-ийн агуулгыг хэрхэн зангидах арга аргачлал дээр зөвөлгөө авч ажилласан.
3. Дашчойнпэл дацангийн шунлайв, гавж С.Гантөмөртэй хамтран “Буддын шашны шинжлэх ухааны агуулгын тойм”-ын талаар гурван удаа ярилцаж, судалгааг хийж, хамтарсан ЭШ-ний өгүүлэл хэвлүүлсэн.
4. Жонан Ханчен Гэгээнтэй 3 удаа уулзаж, дээдийн ном сургаал, дагсал хаялцах урлаг, сэтгэлгээний арга барилтай холбоотой хэлэлцүүлэг хийсэн.
5. Т.Ганбаатар. Монголын уламжлалт эмийн жоронд ордог зарим эмт бодисуудын талаар ярилцлага хийсэн.

6. Чөлөөт орчуулагч Бугат Л.Алтангэрэлтэй хамтран ажиллаж, Сундуй, Жадамба судруудын орчуулга хийгээд агуулгын тухай ярилцлаг өрнүүлж, улмаар “Жадамба судрын орчуулгын тухай” ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

2.12. Судалгааны зарим үр дүнг хялбаршуулсан байдал

Боловсролын сэтгүүл, эмхэтгэлийн өгүүлэл (Сэтгүүлийг **Хавсралт 4а,б**-ээс харна уу)

- Х.Дондог, Танин мэдэхүйн бясалгал, түүний талаарх зарим физик жишээ, “Физикийн боловсрол” сэтгүүл, 2021. №45, 46
- Х.Дондог, Гэрлийн квантын зарим томъёоны гаргалгааг бясалгах жишээ, “Физикийн боловсрол” сэтгүүл, 2022. №49, 50
- Х.Дондог, Өөрөө эрдэмжих зам мөрийн тухай эргэцүүлэл, “Физикийн боловсрол” сэтгүүл, 2022. №51, 52
- МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн сургууль, Түүхийн тэнхимийн Их семинарын илтгэлийн эмхэтгэл, 2022.

3. Төслийн үр дүн

3.1. Нэгдүгээр үр дүн: Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх

Төслийн суурь судалгааны агуулгын хүрээг хамарсан эрдэм шинжилгээний өгүүлэл арван гурвыг хэвлүүлэв (Хаана хэвлүүлснийг **Хавсралт 5а,б,в,г,д**-ээс үзнэ үү). Үүнд:

1. Х.Дондог, Д.Даваасүрэн, М.Гантуяа, Буддын ухаан бол гносеологи, эпистемологийн салбар мөн, Орхон Их сургуулийн ЭШБ, 2021.
2. Х.Дондог, Гадаад, дотоод ертөнцүүдийн танин мэдэхүйн харьцуулалт, “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” ЭШ-ний хурлын эмхэтгэл, УБ, 2022 он.
3. Х.Дондог, Их хөлгөний судлагдахууныг шинжилсэн дүн, Орхон Их сургуулийн ЭШБ, 2020.
4. Х.Дондог, Монгол дархлаа нь бидний үнэт зүйл болох нь, МУСУИС, СУС-ын хүрээлэн, Монголын соёл, урлаг судлал, 2019, Боть-XXXI, Дэвтэр 1-20, х100-110.
5. Х.Дондог, Монгол соёл иргэншлийн язгуур тогтолцоо, түүний онцлог, тогтвортой хөгжлийн асуудалд, Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойн Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2022.
6. Х.Дондог, Ц.Цэрэнгомбо, Шүтээнээ тунгаахуй нь өөрийгөө танихуй мөн, Природные условия, история, культура и язык западной Монголии и сопредельных регионов, 2019 он. х.94-104.
7. С.Гантөмөр, Х.Дондог. Буддын шинжлэх ухааны товч, “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” ЭШ-ний хурлын эмхэтгэл, УБ, 2022 он.
8. Дийтер Яагер, Ц.Бат-Итгэл, Х.Дондог. Мэдрэлийн шинжлэх ухаан болон Буддын шашин дахь “Би”, “Чөлөөт хүсэл”, “нийгэм” хэмээх ойлголтууд, “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” ЭШ-ний хурлын эмхэтгэл, УБ, 2022 он.
9. Х.Дондог, Б.Дарамбазар. Буддын бясалгалын товч, “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” ЭШ-ний хурлын эмхэтгэл, УБ, 2022 он.

10. Х.Дондог, “Хөдөлмөрийн хүн” загвараар нийгмийн сэтгэл зүйг шинжих нь, Орхон Их сургуулийн ЭШБ, 2019, №19, х59-77.
11. Х.Дондог, Билиг ухаанаар нотлох арга аргачлалын тухай, Орхон Их сургуулийн ЭШБ, 2019, №19, х79-96.
12. Х.Дондог, Ю.Цэцгээ, “Абхидхарма бүхнээс түүсэн” номын орчуулгын үгийн сан-утга зүйн зарим онцлог, Орхон Их сургуулийн ЭШБ, 2022.
13. Х.Дондог, Буддын мэдлэг ухааныг дэмжих эрхзүйн асуудалд, МУИС, “Монгол судлаал, шашин судлалын асуудлууд” сэдэвт 2019 оны Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал. МУИС, Философи, шашин судлал. ЭШБ. 2020, №22 (541), х125-134.
14. Х.Дондог, Монгол хүний хандлагын дүр төрх, Орхон Их сургуулийн ЭШБ, 2023.

3.2. Хоёр ба гуравдугаар үр дүн: ЭШ-ний хурал зохион байгуулж, илтгэлийн эмхэтгэлийн эх бэлтгэсэн байх

- Хурлын үр дүн болох “Буддын ухаан ба Шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” сэдэвт ЭШ-ний хурлыг зохион байгуулсан.
- Эмхэтгэлийн эхийг хэвлэлтэнд бэлтгэж, 600 хувь хэвлүүлсэн (**Хавсралт 5г**).

3.3. Дөрөвдүгээр үр дүн: Социологийн судалгаа явуулсан байх

- Бэлтгэсэн асуумжийн дагуу “Монгол хүний дотоод ертөнцийн янз байдал”-ыг тандан судлах “Таны эрхэмсэг оршихуй” нэрт социологийн судалгааг 2022 оны 10 сард бүрэн явуулж дуусгасан.

3.4. Тавдугаар үр дүн: Дөрвөн хэлний толь бичгийн эх бэлтгэх

4. Буддын ухааны танин мэдэхүйн ойлголт, нэр томъёо, хэллэгийн монгол, түвд, орос, англи дөрвөн хэлний дүйцүүлсэн тайлбар толь бичгийн (2600 гаруй мөр үг, хэллэг агуулсан) эхийг бэлтгэсэн (**Хавсралт 6**).

4.Төслийн судалгаа

4.1. Буддын ухаан нь гносеологи, эпистемологийн салбар мөн болох нь

Буддын шашин дахь Бурханы тухай ойлголт Буддын сургаалыг ойлгох эс ойлгохоос нь үл хамааруулан бишрэх, сүслэх зан үйл талаас нь авч үзвэл шашин мөн боловч түүний гүн гүзгий хийгээд өргөн цар хүрээтэй утга агуулгын талаас нь авч үзвэл танин мэдэхүйн ухаан ажээ. Ингэж хандахыг Шагжамуни Будда өөрөө ч тодотгож өгсөн байна¹. Хүний сэтгэлийн үндэс нь шүтээн мөн (Васубандху) тул түүнийг голлон бариваас шашин тал руугаа илүү орно. Харин Буддын сургаалыг мэдлэг талаас нь нарийвчлан үзвээс оршихуйн хийсвэр суурийг судалдаг танин мэдэхүйн салбар болох нь илт харагдана. Бүр тодруулбал, хүний сэтгэлийн дотоод ертөнцийн танин мэдэхүй бөгөөд хүн өөрийн төлөвшил, хөгжил, оршихуйгаа сэтгэлийн

¹ ང་ཡི་ཚོས་ཚུལ་རྣམས་གཞིས་ཏེ་།།བཟླ་བ་དང་ནི་ཤུབ་མཐའ་འོ།།བྱིས་བ་རྣམས་ལ་བཟླ་བ་བཤད།།རྣལ་འབྱོར་བ་ལ་ཤུབ་མཐའ་འོ།།

боловсролоор дамжуулан жолоодох тухай ухаан юм (Х.Дондог, 2019). Бурхан хэмээх ойлголт нь “бүтээгч”, “аврагч” гэсэн хоёр үндсэн чадварыг хамардаг. Тэдгээрээс бүтээгч шинжийг нь тодруулбал “ертөнцийг бүтээгч далд шидтэн”, “өөрийгөө буюу өөрийнхөө ертөнцийг бүтээгч хүн” гэсэн хоёр төрөл байх ажээ (Зураг 1). Буддын сургаалын хувьд “Бурхан бол эхлээд өөрийнхөө мөн чанарыг танин мэдэж, өөрийн ертөнцийг зөв бүтээгээд, дараа нь тэрхүү олсон эрдэм чадлаараа бусдад зөв зам мөрийг заагч, хамаг амьтныг аврагч хүн юм”. Харин бусад шашны хувьд “Бурхан нь амьтан, хүн, сав шим ертөнцийг бүхэлд нь бүтээсэн, бас тэдний алийг нь ч хоцроолгүй аврагч далд шидтэн” байна. Энэхүү өгүүллийн хүрээнд Буддын сургаал нь шинжлэх ухаанч танин мэдэхүйн салбар мөн болохыг долоон үндсэн чиглэлээр батлан харуулахыг зорив. Үүнд нэгдүгээрт төгс хөгжсөн хүний тухай мэдлэг, хоёрдугаарт танин мэдэхүйн арга аргачлалын сан, гуравдугаарт хүнийг төгс хөгжүүлэх технологийн тухай мэдлэгийг сэргээн баяжуулж, өвлүүлэн тайлбарлаж ирсэн мэргэдийн бүтээл туурвил, дөрөвдүгээрт Уламжлат анагаах ухаан ба Зурхайн ухаан, тавдугаарт Буддын бясалгалыг орчин үеийн тархи судлал, сэтгэл судлалын салбарт үнэлж буй байдал, зургадугаарт хүний оршихуйн зөв зам мөрийн тухай мэдлэг, эцэст нь Буддын онолын мэдлэг тус тус багтах болно.

А.Төгс төгөлдөр хөгжсөн хүний тухай мэдлэг. Буддын сургаалд төгс сайн хөгжсөн хүнийг Бурхан хэмээнэ. Хүний сэтгэл нь бие, хэл хийгээд ахуйн бүхий л үйл, үйлсийг чиглүүлэн тодорхойлогч тул Бурхан нь чухамдаа сэтгэлийн боловсролыг ханьцашгүй дээд түвшинд хөгжүүлсэн (билиг билгүүнийг оносон) хүн ажээ (Т.Булган, 2016). Тийм хүний сонгодог жишээ нь Шагжамуни Будда юм. Бурханлаг хүнийг нэг талаас “Номын биеийг үүсгэгч”, “Билиг билгүүнийг төрүүлэн үйлдэгч”, “Мунхагийн нойрноос сэрсэн”, “Түүнчлэн заларсан”, “Ялж төгс нөгчсөн”, “Үнэхээр туулсан”, “Дайснаа дарсан”, “Нэн арилсан”, “Гаслангаас гэтэлсэн”, “Тийн бөгөөд тонилсон”, “Дээр үгүй бодь хутаг” (Очироор огтлогч, Их хөлгөний хураангуй, Алтангэрэл, Миларайвын дуулал, Тарва ченбо) гэх зэргээр илт өгүүлэх нэрүүдээр тодотгоно. Эс бөгөөс арван зүгийн гурван цагийн тоолшгүй олон бурхад, бодисадва нарын оноосон нэрээр товч танилцуулах бөгөөд тэдгээр тодруулагч хэллэг, нэрс тус бүрд харгалзах эрдэм чадлыг их хөлгөний ном сударт дэлгэрүүлэн гаргасан буй. Нөгөө талаас, бурханлаг хүний зам мөрийг бодьсавын арван газар, бодьсавын арван сэтгэл, бодьсавда нарын хорин үйлс, бурханы биеийн төгөлдөр шинж, арван зүйл номоор явагч, зургаан ихэс лугаа хандагч зэргээр илэрхийлжээ. Түүгээр ч зогсохгүй Бурхан, ном, хуврагийн чуулган буюу гурван эрдэнэ, их бага дунд гурван хөлгөн, Бурханы гурван лагшин зэргээр сургаал хийгээд боловсролын түвшинг ялгамжтайгаар багцалсан мэт боловч үнэн хэрэгтээ гурван эрдэнэ нь номонд, гурван хөлгөн нь их хөлгөнд тус тус хураагдаж, гурван лагшин нь номын лагшинд шүтнэ. Ийнхүү төгс хөгжсөн нэг л хүнийг олон төрөл, арга зүйгээр ялгаатай тайлбарлаж буй нь Буддын ухааны эрдэм мэдлэг нь янагуухын түвшинд шууд оноход бэрх ханьцашгүй дээд түвшинд хүрсэнтэй холбоотой ажээ.

Б. Буддын сургаалын танин мэдэхүйн арга аргачлал. Буддын мэдлэгийг олох, нотлох, ойлгуулах, түгээн дэлгэрүүлэх үндсэн арга нь нотлохуй ухаан буюу ном хаялцах ёс юм (Х.Дондог, 2019). Энэ аргаар өнөө үед ч шавь сургалт явдаг бөгөөд үе үеийн мэргэдүүд уг

аргаар эсрэг, буруу, эндүүрсэн, төөрөлдсөн мунхаг үзлүүдийг няцааж, хүн төрөлхтнийг танин мэдэхүйн зөв зам мөрд чиглүүлж ирсэн уламжлалтай. Энэ талаар хэд хэдэн жишээ дурдая. Нагаржуна гэгээн шашны дотоод сан буюу винайн шашин, ёс доройтсоныг дахин сэргээхийн тухайд сургаал цаазыг цалгардуулсан 8000 хуврагийг Наландарын хийдээс гаргаж байсан бол Арьяандэв гэгээн нь Цогт Наландарын хийдийн шилдэг 500 бандидаг номоор дийлж ялагдашгүй байдалд хүрсэн байсан тэрсүүд үзэлтэн Мүдэгдаянтай ном хаялцан ялсан бөгөөд номоор ялагдсан Мүдэгдаян дараа нь Бурханы ном судрыг уншиж гүн утгыг гүнзгий ойлгон авч, бурханы сургаалыг дагаж Ловон Бавуу гэх шинэ нэрээр алдаршин олон сайн бүтээл туурвисан байдаг. Ловон Бхававивэкагийн шавь нар Ловон Лодойдамба тэргүүтний алдаатай сургаал урсгалтай ном хаялцан ялж байсан бол Ловон Чандрагирди бээр Өмнөд Энэтхэгийн Гонгуна хэмээгч оронд олон тэрсүүдийн мэргэдийг зуун нотлолоор няцааж байсан. Шантаракшита гэгээн, Ловон Бадамжунай нар хар зүгийн бүхий л тэнгэр, газрын эзэд лус савдгуудыг номын хүчээр ялан дийлж номхотгон сөхрүүлж, өөрийн номын мөрд оруулж байв. Гамалашила гэгээн нь Хуушаан Махаяна (Хашин хэмээх) нэгэн гэлэнгийн гаргасан буруу үзэл, урсгалыг ном хаялцан няцаасан бол Ловон Егнэн нь 500 орчим тэрсүүдийг багштай нь хамт номоор дарсан тул таван зуун мянга орчим тэрсүүд үзэлтэн их хөлгөний шавь болсон түүх байдаг. Цадамын ухаанд мэргэшсэн Ловон Чоглан тэрсүүдийн олон ловон лам нарыг номоор ялж байв. Ийнхүү нотлохуйн ухаанаар жинхэнэ мэдлэгийг хуурамч мэдлэгээс ялган зааглаж, тэрсүүд талыг ялагдалд хүргэн, улмаар тэдэнд үнэмшил төрүүлэн зөв номлолыг хүлээн зөвшөөрүүлж ирсэн нь танин мэдэхүйн оновчтой арга болон түүгээр олж авсан үнэн мэдлэг хоёрын үнэн хүчийг харуулж буй хэрэг болно. Буддын мэргэдийн ялалт нь зэвсэгт тэмцэл бус, харин эрдэм номын маргаан мэтгэлцээн, үнэнийг хүлээн зөвшөөрүүлсэн мэргэн ухаан байсаар иржээ.

Шинжлэх ухааны танин мэдэхүй нь баримт цуглуулан шинжлэх, таамаглал дэвшүүлэх, математик загварчлал гаргах, туршилтаар нотлох зэрэг үндсэн үе шатуудтай байдаг бол Буддын танин мэдэхүй нь сүсэг, сахил хоёрт суурилан төвлөрөх хийгээд ажиглан шинжлэх бясалгалын механизмаар дамжин билиг билгүүнийг нээдэг байна. Ингэхдээ сонсох, санах, бясалгах гурав нь хоорондоо маш нарийн шүтэн барилдлагатайгаар бие биеэ дэмждэг. Сахил санваар тэргүүтэн шагшабад нь бясалгалыг дэмжих суурь болдог ба бясалгал нь билиг билгүүний эрдмийг олох үндсэн механизм болно. Билгүүн тодрох тусам шагшабад бясалгал хоёр илүү ахицтай хэрэгжинэ. Сонсох ба санах үйлүүд нь дээрх гурван үе шат тус бүрд чухал бэлтгэл нөхцлийн үүрэгтэй оролцоно. Бясалгалыг өөр өгүүлэлд тусад нь нарийвчлан авч үзэх тул энэ удаад үүгээр товчлов.

В. Буддын мэдлэг ухааныг сэргээн хөгжүүлж, тайлбарлаж ирсэн уламжлал Их хөлгөний сав аймгийн номыг анх Майдар, Самандбадра, Очирваань, Манзушри тэргүүтэй бодьсатва нар хураан эмхтгэсэн байдаг. Бурхан багшаас хойш замбуутивд их хөлгөний номын сав бологч үгүй болсонд Бурханд ихэд сүсэгтэй Лус нар (Лус нь хүмүүн төрөлхтний 6 ангиллын нэг, Х.Дондог) уг номыг өөрийн орондоо шүтээн болгон залсан гэдэг. Хожим нь Хутагт Нагаржуна Лусын орноос Билэг барамидын судар тэргүүтэн их хөлгөний сав аймгийн номыг залж, хүмүүний оронд их хөлгөний шашныг дахин дэлгэрүүлсэн. Ийнхүү дээдийн номын уламжлалыг сэргээх, хөгжүүлэх их үйлсэд Нагаржуна тэргүүтэн Цогт Наландра хийдийн арван долоон их бандида нарын оруулсан хувь нэмэр их юм. Буддын мэдлэгийн санг сэргээн хөгжүүлж ирсэн түүх нь танин мэдэхүйн утгаараа шинжлэх ухааны мэдлэгийн сангийн хөгжлийн түүхээс огтхон ч

ялгарах зүйлгүй бөгөөд Буддын ухааны салбар нь хэрхэн сэргэж, уламжлагдаж ирсэнийг тэдгээр арван долоон их бандита нарын бүтээл туурвилаас илт харагдана. Билиг билгүүний дээд нь Нагаржуна гэгээн, явдлын дээд нь Зандрагоомий гэгээн, шалгадаг ухааны дээд нь Дигнага (Ловон Чоглан) гэгээн, төв үзэл, шалгадаг ухааны хос арсланг эрхшээгч Шантаракшита гэх зэргээр салбар ухааныхаа чиглэлээр тодорсон мэргэдүүдээ дотооддоо магтан дуулсан байдаг. Мөн түүнчлэн Бурхан багшийн номлолын гол утгыг маш гүнзгий гарган тайлбарлаж, түгээн дэлгэрэх нөхцлийг бүрдүүлсэн гол мэргэдүүдээ “Ертөнцийн зургаан чимэг” хэмээн алдаршуулсан байх бөгөөд тэдгээр нь Бурхан багшийн “Ширчиндо” судрын гол утгыг зохиосон Нагаржунай, Асанга, Дигнага нар багтаххаас гадна Нагаржуна гэгээний номын гол утгыг тайлбарлан дэлгэрүүлсэн Арьяандэв, Асанга гэгээний номын гол утгыг тайлбарлан дэлгэрүүлсэн Басубанду, Дигнагын номыг дэлгэрүүлэн тайлбарласан Дармагирди нар мөн багтана. Түүнчлэн бурханы шашны шинэчлэлийн нэг болсон шарын шашны хөгжилд Богд Зонхов гэгээний оруулсан хувь нэмэр их юм. Одоо 17 их бандида нарын эрдэм бүтээлээс жишээ баримт болгон товчхон дурдая. Үүнд:

1. Шүтэн оршихуйн ухаанаар мэргэшиж, дээд хөлгөний төв үзлийг хөгжүүлсэн Хутагт Нагаржуна (Лүдүв) нь Бурхан багшийг нирван дүр үзүүлснээс хойш 400 жилийн дараа тодорсон бөгөөд “Билиг үндэс” тэргүүтэн нотлолын зургаан чуулган хэмээх цуврал, “Төвийн магтаалын аймаг”, “ Их хөлгөний оюун судлагдахуун”, “ Зүүд чандмань эрдэнэ”, “Бодийн чуулган”, “Нууцын хураангуйн тайлбар”, Тутарга будааны судрын тайлбар” , “Тантарын бүхэн түүвэр”, ”Бодь сэтгэлийн тайлбар”, “Үүсгэлийн зэрэг хураангуйг бүтээх арга”, “Төгсгөлийн зэргийн таван зэрэг” тэргүүтэн судар, тарнийн олон ном, анагаах ухааны холбогдолтой “Зуун найрлага” шаштир зохиосон байдаг.

2. Дамжлага тасрахад дөхсөн их хөлгөний сургаалыг сэргээн дэлгэрүүлсэн Асанга гэгээн (Пагва Тогмид) нь “сэтгэл төдийтний тогтсон тааллын үзэл онолыг шингээсэн Са дэ на, Дон намни, Саян ойш, Дон ла баво дүйва, Ши дува, Намдан дүйва, То дүва зэрэг “Газрын таван аймгийн ном” хэмээн нэрлэгдсэн номуудыг туурвижээ.

3. Нотлохуйн ухааны зуун үүдийг нээгч Ловон Дигнага (Ловон Чоглан) 500 төрөлдөө бандидагийн төрөл авч байсан гэгддэг. Тэрбээр нотлохуйн ухааны 108 боть ном зохиогоод тэдгээрийнхээ утгыг Шалгадаг бүхний хураангуй (Цадма гүндүй) номдоо хураангуйлсан байна.

4. Хутагт Нагаржунагийн манлай шавь Арьяандэв гэгээн (Пагвалха) нь төв үзлийн “Дөрвөн зуунтын тайлбар толь” туурвиж, Бурхан багшийн айлдсан нууц тарнийн увдис Сандуйн ёсны номлолыг тодруулж, тарнийн ёсонд суралцах гарын авлага болгосон юм. Арьяандэв гэгээний номхотгосон тэрсүүд үзэлтэн Мүдэгдаян (хожим нь Ловон Бавуу нэрт болсон) Буддын сургаалыг шимтэн судалж, Бурханы урьдын 34 төрлийн цадиг түүхийг анх бичсэн төдийгүй үйлийн үрийн тухай “Дурьдлыг ойр агуулах дөрөв” зэрэг маш олон бүтээлийг туурвижээ.

5. Наландарын хийдийн 500 бандидагийн мэдлэгийг нийлүүлсэнтэй тэнцэхүйц их мэдлэгтэн, “хоёр дахь бүхнийг айлдагч” хэмээн хүндлэгдсэн Басубанду гэгээн (Ловон Егнэн) Майдар гэгээний зарлигийн дагуу олон судар, шаштирт тайлбар зохиохын сацуу “Зод зава” хэмээх 8 бүлэгт номыг бичжээ. Түүний шавийн тоо 60,000 хүрсэн гэдэг бөгөөд тэдний дотор багшаасаа илүүтэйгээр Винайн ёсонд мэргэшсэн Гунапрабха, Авиддармын ёсонд илүү мэргэшсэн Лодойдамба, Шалгадаг ухаанд илүү мэргэшсэн Ловон Дигнага, Билиг барамидын ёсонд илүү мэргэшсэн Вимуктисена нар байжээ.

6. Шалгадаг ухааны өндөр зэрэгтэн Дармагирди гэгээн (Чойдаг) нь Дигнага гэгээний зохиосон Цадма гүндүй номын тайлбар болгож “Шалгадаг ухааны долоон аймаг” хэмээх (“Цадма Нам дэл”, “Цадма дэдүн” гэх мэт) цувралыг бүтээсэн. Мөн буруу үзлийн хамгийн дээд болсон Дамцигшоннурварватай ном хаялцан буулган авч Бурханы шашинтан болгож байжээ.

7. Хамаг юмс оноосон дан нэрийдэл төдий болохыг шүтэн гарахуйн туйлын гүн нарийн утгаар тодруулан тайлбарласан Буддапалита гэгээн (Санжайжан) нь Нагаржуна гэгээн, Арьяндэв гэгээн, бандида Ловон Бавуу тэргүүтний шаштир зохиолуудад олон тайлбар, номлол туурвиж, хэтрүүлэгч төв үзлийн цуутай багш нарын нэг байжээ.

8. Үнэнээсээ бодьтой төрсөн тэргүүтэн үзлийн хязгаарыг хорьж, төв үзлийн ёсыг номлогч Бхававивэка гэгээн (Ловон Лэгданжэд) нь үнэн шалгадаг ухаанд зохилдонгуй гадна үзэгдлийг таалсан үнэмлэхүй тогтсон тааллын ёсыг байгуулсан байна.

9. Төв үзлийг асар гүн дэлгэрүүлэгч Ловон Чандрагирди (Балдандаваадагва) нь хутагт Нагаржунагийн “Далан нотлол”-ын тайлбар, “Билэг Үндэс” номын үгийн тайлбар “Үгийг тодруулагч” утгын тайлбар, “Төвд орохуй”, Арьяндэв гэгээний “Дөрвөн зуут”-ын тайлбар, “Төв таван цогцос”, тарнийн номын ёсны “Нууцын хураангуйн үндэс дамжлагын тайлбар тодорхой зул”, “Нууцын хураангуйн зургаан бэлтгэл гишүүний тайлбар” тэргүүтэн олон ном зохиол туурвисан.

10. Их нигүүлсэхүйн явдал мөрийн ёсонд мэргэшсэн Шантидэва гэгээн (Шивалха) нь “Додэ гүндүй” (“Судрын хураангуй”), “Лава гүндүй” (“Суртгаалын хураангуй”), “Бодьсадын явдалд орохуй” (Жонжүг) тэргүүтэй бодьсадын агуу явдлыг үзүүлсэн шастируудыг туурвижээ.

11. Ханчэн бодьсадва нэрээр алдаршсан Шантаракшита гэгээн (Ханчэн Шиваанцо) нь хаан Тэсрэнзэндэн, Ловон Бадамжунай нартай хамт Төвдөд Буддын сургаалыг дэлгэрүүлж, энэтхэг хэлээс төвд хэл рүү бүтээлүүдийг хөрвүүлэх их үйлсийг зохион байгуулжээ. Тэрбээр төв үзэл, шалгадаг ухааныг хослуулан эзэмшсэнээрээ шагшин гайхагдаж байжээ. Түүний шавь Лочин Бяруузана, Гамалашила нар нь ихэд алдаршсан.

12. Мэргэн бүтээлч Гамалашила гэгээн (Бадма Нанцүл) нь Хуушаан Махаяна тэргүүтний оргүй хоосныг бясалгах нь “Хоосон чанар” хэмээн тодорхойлсон “Юу ч үгүйн үзэл”-ийн бурууг няцааж Буддын сургаалын үнэн зөв ойлголтыг сэргээсэн. “Төв үзлийн үзэгдэл” (Ума нама), бясалгалын гурван зэргэмж (Гомрим дамбуу-анхдугаар зэргэмж, Гомрим гава-бясалгалын дунд зэргэмж, Гомрим тама-бясалгалын эцсийн зэргэмж) цуврал бүтээлүүд туурвисан.

13. Билиг барамидын ёсонд илүү мэргэшсэн Вимуктисена гэгээн (Пагва Долдэ) нь Бурханы айлдсан “Нити” судар, түүнд хийсэн Майдарын гэгээний тайлбар “Ондогжан” шастир хоёрыг дүйцүүлж харьцуулсан тайлбар болох “Нитийн гэгээ” бүтээлийг туурвижээ.

14. Их гурван билгийн чанадад хүрэхүйн дээдийг номлогч Харибадра гэгээн (Ловон Сэнгээсамбуу) нь “Ондогжан” шастирын хамгийн шилдэг тайлбар “Утгыг тодруулагч” (Дэлва донсол), “Жадамбын их тайлбар” (Жадамба дэлчин), “Нитийн Нанва” номонд “Нити Ливүү Жава”, “Доо дүд” судрын тайлбар “Дүдийн Гандид доглаа” -г тус тус зохиосон.

15. Хааны төрийн багш, винайг эрхшээсэн эзэн Гунапрабха гэгээн (Ёндон-Од)-ийн туурвисан “Винайн судрын үндэс” (Дүлваан до зава) хэмээх алдарт зохиол нь одоо ч винайн ёсны гол гарын авлага болсоор байна. Мөн “Гурван зуутын тайлбар” (Дүлвийн сүмжава) зэрэг бусад бүтээлүүдийг туурвижээ. Тэрбээр “Винайн буман аймаг” (Дүлва бумдэ) номыг цээжлэн, өдөр тутмын уншлага болгож чанд хэрэгжүүлдэг мэргэн багш байсан бөгөөд түүнд гэлэн сахилтай 5000 багш шавь орж байдаг.

16. Ариун гурван суртгаалын эрдэм бүхнийг эрхшээгч, винайг сахигчийн дээд Сахъяапрабха гэгээн (Шагжа-Од) нь “Агуу явдлын тайлбар”, “Гэрэл төгөлдөр тайлбар” зэрэг винайн ёсны маш олон тайлбар зохиож, тэдгээр нь Данжуурт багтсан ажээ.

17. Балдан Адиша (Жову Адиша) гэгээн нь Буддын сургаал номлол, гүн зарлиг ёсыг ангилж гурван төрөлхтний мөрд тааруулан зохиожээ. Төвдөд Бурханы шашныг дэлгэрүүлэх явцдаа ”Бодь мөрийн зул“ хэмээх зохиолоо туурвижээ.

Г. Уламжлат анагаах ухаан ба Зурхайн ухаан Монголын болон Дорнын уламжлалт анагаах ухаан, бас Зурхайн ухаан нь Буддын эрдэм мэдлэгийн салбараас ахуй амьдралд хурц ширүүн маргаангүйгээр өргөн хэрэглэгдэж байгаа салбаруудын сонгодог жишээ билээ. “Оточ манрамба” их сургууль, “Шинэ анагаах ухаан” их сургууль, “Ач” их сургууль зэрэг дээд боловсролын байгууллагууд нь Монголын уламжлалт анагаах ухааны мэдлэг, туршлагыг орчин үеийн залууст өвлүүлэн эзэмшүүлж байна. Уламжлалт анагаах ухааны 108 боть хэвлэгдэж буйн зэрэгцээ М.Амбага доктор “хий, шар, бадганы онол”-ыг европ анагаах ухаантай харьцуулан судалж, “Шинэ анагаах ухаан” концепцийн түвшинд хөгжүүлээд байгаа билээ. Монголын уламжлалт анагаах ухаан Польш зэрэг европын орнуудын эмнэлэгийн практикт нэвтэрч эхлээд байна. Зурхайн ухаан нь нийт монголчуудын цаг тооны бичиг, нэн чухал зан үйлүүдийн огноо оновчлон сонгох, цаг агаарын байдлын зарим тандалт шинжилгээ болон төрсөн он, жил, гараг эрхсийн хоорондох шүтэн барилдлагыг тогтооход өргөн ашиглагдаж байна. Иймд уламжлалт анагаах ухаан болон зурхайн ухааны мэдлэгийн үнэн хийгээд практик ач холбогдлыг дахин дахин дурдах нь илүүц юм.

Д. Буддын бясалгалын ач холбогдлыг орчин үеийн тархи судлал хийгээд сэтгэл судлалын салбарт үнэлж буй байдал Мэдээлэл технологийн зуунд амьдарч буй бидний хувьд сайн мэдээлэл олох, түгээх нь ихээхэн хүчин чармайлт шаардана. Мэдээллийн замбараагүй их урсгалд бид туйлдан зүдэрч, бүр стресс ядаргаанд орох нь бий. Түүнээс гадна хүний сэтгэлд өдөрт дунджаар 60,000 орчим бодол эргэлдэх бөгөөд тэдгээрийн 80 хувь нь сөрөг хандлагатай байдаг ажээ (Б.Мөнхбаатар, 2020). Мэдээ мэдээлэл, бодол нь хүний дотоод ертөнцөд үргэлж “давалгаа” үүсгэж, тэр нь заримдаа жаргал, зовлон гэх хоёр туйлын аль нэг рүү савчуулна. Гэтэл одоогоос хоёр мянга таван зуу гаруй жилийн өмнө Бурхан багш мэдээлэлтэй зөв ажиллах арга замы нээжээ. Тодруулбал, түмэн үйл явдал, буман бодолд байнга өртөөд өөрийгөө үймүүлээд байх бус, харин ч эсрэгээр нь, элдэв бодлоо цөөлөх, өөрийгөө гаднаас нь ажиглах дадал олсноор сэтгэл хөдлөлдөө үл автах замаар сэтгэл оюуныг тодорхой хугацаанд амрах, мөн түүнчлэн сайн төвлөрсөн ухаанаар задлан шинжлэх бясалгал хийж танин мэдэхүйн өндөр түвшинд хүрч, сэтгэлийн элдэв өнгөнд үл хууртах амгалан төлөвт хүрч болохыг нотлон харуулжээ. Амар амгалан байдал нь дотоод сэтгэлийн төлөв мөн бөгөөд түүнийг зөвхөн гадаад ертөнцийн тоглоомоор олж авах боломжгүй юм. Харин гадаад юмс үзэгдэл хийгээд дотоод оюун сэтгэлийн мөн чанарыг нарийвчлан танин барьснаар онох ажээ. Бясалгалыг нөгөө талаас нь харвал “хүн өөрөө өөрийгөө боловсруулах” технологи мөн тул бясалгалаар хүн өөрийгөө сурган хүмүүжүүлэх чадвартай болно. Төвчхондоо, “Өөртөө бодь сэтгэлийг бадраах” замаар номын лагшин буюу гэгээрсэн сэтгэлийн төлвийг оноход хичээнэ гэсэн үг юм. Буддын бясалгалын агуулга нь ядам бурхан, сургаалын багш, үзэгдэл юмс, шүтэн барилдлага, хоосон чанар, бодь сэтгэл, сайн мөр гэх зэргээр тоо томшгүй олон янз байж болох ч ямарваа нэг бясалгалыг энэрэн нигүүлсэх сэтгэлийн үүднээс, бусдын төлөөх буяны зорилгоор хийнэ. Иймд

хамаг амьтны тусын тулд буяны сэтгэл хөгжүүлэх тангараг санваар авсан хүмүүс өөрийн санваараа нүдний цөцгий мэт хамгаалах учиртай байдаг. Ийм байдлаар олон жил бясалгал бүтээл хийсэн хүмүүсийг орчин үеийн сэтгэл судлаачид ихэд сонирхон судлах болсон билээ. Учир нь бясалгагч хүн сэтгэлийн мөн чанар, унаган төрхөө онож таньсан, сэтгэлийн үйл нь зөв төлөвшсөн байх боломжтой. Тухайлбал, хүний зан чанар, ааш авир, хандлага, үйл үйлдэл, бодол санаа, сэтгэлгээ, ухаарал, жаргал, зовлон, уур омог, ач тус, атаа жөтөө зэрэг наян дөрвөн мянган сэтгэлийн зүйл нь барьцгүй, ямагт хувьсан өөрчлөгдөж, ашиг сонирхлын таашгүй хямралт төлөвт оршдог болохыг ухаарч мэддэг байна. Тэр гэхийн тэмдэггүй сэтгэлийн түмэн өнгө хийгээд оршихуйн хуйлралыг нийтлэг түвшинд нь дүгнээд харвал батгүй, утгагүй, зүүд зэрэглээ мэт “хоосорч” харагдана. Танин мэдэхүйн энэ түвшинд гарч харсан хэн ч ижил дүгнэлтэнд хүрэх тул уг дүгнэлт нь объектив шинжтэй бөгөөд билиг билгүүний түвшний шинжлэх ухаанч танин мэдэхүй мөн болно. Иймд өөрийн болоод өрөөлийн зан авирыг цөөрөмд туссан тэргэл сарны дүрс мэт тодоор харж, зарим гэмийг мэдсэн Ноён хутагт Данзанравжаа “Зарим мэргэд номыг мэдээд алдрыг хайна, зарим ноёд эрхийг олоод дайсныг хураана, зарим баяд эдийн төлөө өөрөө сүйднэ, баян бол дайсныг ч аргадна, гуйлгачин бол эхийгээ ч орхино” зэргээр атгаг сэтгэлийн авир төрхийг илтээр гаргасан буй. Билиг билгүүний толинд харагдаж буй тэрхүү муу сэтгэлтэйгээ бид тулж ажиллах шаардлагатай бөгөөд Богд Зонхов “Аргамжаа, чөдөргүй ардаг догшин, аргамаг, сэтгэлийн хүлэгт амгай, хазаар, ташуур тааруулж аль хүссэнээрээ залах нь гэгээрэл мөн” хэмээн томъёолсон байна.

Хүмүүний сэтгэл өөртөө ил, өрөөлд далд байх тул хэн нэгэн хүн өөр хүний сэтгэлийг гаднаас нь барьж, ямар түвшинд хөгжсөн буйг мэдэх боломжгүй юм. Бясалгал нь сэтгэл-дотоод ертөнцийн танин мэдэхүйн үйл учир сэтгэл дотроо л үлдэх бөгөөд бясалгалын эрдэм нь дотоод ертөнцдөө олон гайхамшигийг мэдрүүлнэ. Өөрийн бясалгалаар бусдын муу явдлыг засах нь үгүй. Гэвч бясалгалын гайхамшигт үр дүнгээс танин барихын тулд орчин үеийн тархи судлалын салбарт бясалгагч хүний тархийг судлахад ихээхэн анхаарч эхлээд байгаа билээ. Тархины тодорхой мужууд нь өөртөө харгалзах тов тодорхой үүрэг бүхий үйл үйлдэлтэй. Тархи ажиллах үед нейронуудын хооронд холбоос үүсэх-салах үйл явц тасралтгүй явагдах бөгөөд ямар холбоосууд үүсэх эсвэл салах нь хүний оюун сэтгэлийн туршлага, дадал зуршлаас хамаарна. Тархины үйл ажиллагааг соронзон резонансын дүрсээр (fMRI) судлах арга нь хүний тархины мужууд дахь нейроны идэвхжлийг хянах боломж олгожээ. Нейронуудын идэвхжил буюу холбоосын төрөл өөрчлөгдөх байдлыг нейроны /тархины уян хатан чанар (neuro/brain plasticity)-аар тодорхойлно. Бясалгал нь тархи судлалд дараах чухал үр дүнг өгчээ (Joseph Loizzo, 2014). Үүнд: Бясалгал нь нейроны уян хатан чанарыг сайжруулж, бие хийгээд тархины эрүүл байдлыг хангах ба түүнд бясалгалаар хөгжүүлж буй анхаарлын төвлөрөл, анхаарлын тэнцвэржилт, асарах энэрэх сэтгэл зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг байна. Бясалгал нь стрессээс улбаатай кортизолын ялгарлыг багасгана. Нейроны сүлжээг бэхжүүлэн, танин мэдэхүйн чадварыг сайжруулаад, насжих явцын гэм согогийг багасгана. Бясалгалыг тархины уян хатан чанартай холбон судалснаар хүний тархины үйл ажиллагаа нь туршлагаасаа хамааран гүн гүнзгий өөрчлөгдөх боломжтойг илрүүлжээ.

Сэтгэл судлалын салбарт бясалгалын ач холбогдлыг бас үнэлэх болсон байна. Бясалгал нь хүний стрессийг бууруулах, айдсаа хянах, сэтгэл хөдлөлөө тэнцвэржүүлэх, өөрийгөө танин мэдэх, анхаарлаа хөгжүүлэх ба төвлөрүүлэх, зөрчил тэмцлээс зайлсхийх зэрэг чадварууд болон амгалан төлвийг олоход тусална. Ийнхүү тархи судлал хийгээд сэтгэл судлалын салбарт

Буддын бясалгалын ач тус болон бодитой үр дүнг хүлээн зөвшөөрөөд байна. Цаашид эдгээр гурван салбарын шинжлэх ухаанч хамтын судалгаа илүү олон тодорхой үр дүнд хүрэх нь зайлшгүй юм.

Е. Хүн өөрийгөө төгс хөгжүүлж авч явах зөв зам мөрийн тухай мэдлэг Төгс хөгжих боломж хүн бүрд байдаг бөгөөд хэрхэн яаж, ямар арга замаар тийш хүрэх вэ? гэдгийг Шагжамуни Буддагийн практик туршлага зааж өгнө. Иймд Бурхан багшийн сургаалын цөм нь мөрийн үнэн мөн болой. Хүн тэрхүү замаар өөрөө л явж, өөрийгөө хөгжүүлэх ёстой. Бурхан хэн нэгний нүгэлийг усаар угаахгүй, амьтны зовлонг мутраар арилгахгүй, өөрийн мэдсэнээ бусдад юүлэхгүй, зөвхөн ном зааснаараа гэтэлгэн тусалдаг². Ном гэдэг нь гэгээрсэн буюу ухамсраа сэрээсэн хүний сонгосон зөв зам мөр юм. Будда бээр “Би эцсийн үнэнийг олох зам руу Таныг хөтөлж чадна” гэдэг л надад хамгийн чухал юм” хэмээн дурдсан байдаг. Богд Зонховын “Бодь мөрийн зэрэг” бүтээл нь зөв зам мөрийн тухай цогц тайлбарыг агуулдаг тул түүнээс эхлэн суралцах нь зүйтэй. Номын мөрөөр замнагч хуврагыг гаднаас нь өнгөц харвал “номхон дөлгөөн” зан байдал харагдах боловч дотоод ертөнцөд нь “орж” харвал ариун шагшаабадыг сахих, бясалгал бүтээл хийх, билиг билгүүнийг онох гээд нөр их хичээнгүй үйлсийг мэдрэх болно. Мөр нь дөрвөн зүйл бөгөөд ялангуяат дуут, маш гэтэлгэх, зэтгэр үгүй хийгээд барилдлага хэмээмүй (Басуванду). Мөн түүнчлэн номын мөр, үзэхүй мөр, бясалгалын мөр, чуулганы мөр, найрлагын мөр гэх мэт ялгалыг хэрэглэх нь бий. Бас бусдын тусыг бүтээгч бодсавдын арван газраар ч мөрийг илэрхийлнэ. Ханьцашгүй дээд түвшинд сэтгэлийн боловсрол эзэмшсэн хүний зам мөр янагуух түвшинд илэрхийлэгдэх хэлбэрийн хувьд ялгаа олонтой байвч чинагуух түвшиндээ нэг л зам мөр буй. Зам мөрийг илэрхийлсэн зарим хэлбэр, үе шатлалаас жишээ байдлаар дурдая. Юуны өмнө “бурханы арван явдал”-аар илэрхийлэх нь бий (Алтангэрэл судар). Үүнд: а). Орчлон хийгээд нирваны алинд ч үл оршин хамаг амьтдын тусыг үйлдэхэд үл уйсах; б). атгагт үл баригдан аль нэгэн хязгаарт туйлшралгүйгээр тус хүргэх; с). амьтанд эцэс хойдод тулах үгүйгээр номыг дэлгэрэнгүй үзүүлэх; d). зөнгөөрөө бүтсэн бинаваадад морилох; e). бинаваадыг соёрхох нь амьтны тус хэргийг бүтээж буй хэрэг мөн; f). тус тусын ухаан хийгээд сав ямар болохыг машид болгоож номыг үзүүлэх; g). асрахуй ба нигүүлсэнгүйгээр хоёр үгүй тэгшид таалах; h). үргэлжид аглагт баясах хийгээд хуран үймээн бүхнийг тэвчээд, хүсэл багыг сайшаах; i). амьтны үйл хийгээд явдлыг болгоогоод тэдгээрийн санаанд зохилдуу найруулгаар татах, орчлонгоос гэтэлгэх; j). амьтны явдал бүтээлийг болгоогоод их нигүүлсэнгүйгээр авран зохиох эдгээр болой. Бясалгалын зарим төрлийн үе шатыг илэрхийлсэн жишээ болгож бясалгалын эхний бэлтгэл шат “Амирлан оршихуй” бясалгалын 10 дэд үе шатыг товч дурдая. Үүнд: а). Дотоод сэтгэлдээ агуулах буюу 1-р самади нь гадны зоригдол бүгдээс сэтгэлээ хураагаад увдисыг сонссоны дагуу дотоодын зоригдолдоо тушаах. б). Үргэлжлүүлэн агуулах буюу 2-р самади нь зоригдолдоо сэтгэлийг алгасаралгүйгээр удаан тогтоох. с). Дахин агуулагч буюу 3-р самади нь өчүүхэн төдий дурьдалаар сэтгэлээ алгасарахыг түргэн мэдээд эргэж зоригдолдоо тушаах. d). Ойр агуулах буюу 4-р самади нь сэтгэлээ санамсарын хүчээр зоригдол руугаа ихээс нь хураагаад улам сайн тогтоох. e). Номхруулан үйлдэгч буюу 5-р самади нь хүчтэй мэдэмсэрт шүтээд самадийн эрдмээр баясахыг номхруулах. f). Амирлуулан үйлдэгч буюу 6-р самади нь хүчтэй мэдэмсэрт шүтээд нэн алгасаралыг хорих. g). Нэн амирлуулан үйлдэгч буюу 7-р самади нь тачаах сэтгэл, сэтгэлийн

² ལྷུབ་རྣམས་ཐེག་པ་རྒྱ་ཡིས་མི་འཇུག་ཞིང་། འགྲོ་བའི་སྐྱབས་བཟུང་ལྷུག་གིས་མི་སེལ་ལ། ཉིད་ཀྱི་རྟགས་པ་གཞིན་ལ་སློ་མིན་ཏེ། ཚེས་ཉིད་བདེན་པ་བརྟན་པས་གྲོལ་བར་མཛད།།

амгалан бус байдал, мунхрах нойр тэргүүтнийг амирлуулан үйлдэх. h). Нэгэн үзүүртэйгээр үйлдэгч буюу 8-р самади нь нарийн живэх, догширохын барцадгүйгээр самацийг үргэлжлүүлэн бясалгах.” i). Тэгш агуулах буюу 9-р самади нь шамдалгүйгээр самади өөрөө аяндаа урган буух. j). Шинай буюу амирлан оршихуйг олох нь 10-р самади юм. Судраас бусад зүйлийг дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Ё.Буддын онолын мэдлэг Буддын мэдлэг нь танин мэдэхүйн төдийгүй практик ач холбогдол арвинтай. Бурханы эрхэм зарлиг нь төгс мэдэх, илт онох, бясалгах, тэвчих зэрэг эрдмийг агуулна. Мэдлэгийн томъёолол, хэрэглэсэн нэр томъёо нь шинжлэх ухааныхаас эрс ялгаатай ч тэдгээр нь ойлголт, ухагдахуун, хөтөч үзэл, зүй тогтол, жам ёсыг өөрөө оновчтой тусгасан байдаг. Тухайлбал, “Мөнх бусад мөнх бий, зовлонд ч жаргал бий, нигүүлсэхийн угаас хатууг үйлдэх нь бий, нэн үзэсгэлэнтийн угаас хорсох нь бий; Мунхагийн үр нь амьтныг гагцхүү зовлонд л хөтөлнө; Эндүүрлийн мананг арилгаваас элдэв сэтгэлийн үймцээн анирлаж, энэрэл, нигүүлсэл, хүлцэнгүй, тэвчээр дэлгэрнэ. Эдгээр нь хоёр үгүй болой. Эс хүсвээс хэзээ ч бурхан болохгүй” хэмээн Шагжамуни Будда айлдсан бол “Алимад үнэхээрийг үзсэн нь үнэмлэхүй бол эндүүрэлтийг үзсэн нь янагуух мөн” хэмээн (Чандракирти) тодорхойлсон буй. Эдгээр товч өгүүлэмжүүдийг бүрэн гүйцэд ойлгохын тулд сонсох санах аргачлалаар тус бүрт нь анхаарлаа төвлөрүүлээд, нарийн шинжлэн бясалгах хэрэгтэй болно. Шагжамуни Буддагийн нээсэн оршихуйн олон мэдлэгт шүтэн барилдах жам ёс, дөрвөн үнэн, хоосон чанарын онол, янагуух ба чинагуух хоёр үнэний тухай онол, гэгээрлийн тухай онол, билиг барамид, бодьсадвын арван газар, хутагтын найман мөр гэх зэрэг сэтгэлийн боловсролын арга зам нугууд ч хамаарна. Философичид Буддын сургаалыг өвөрмөц өгүүлэгч, судрын аймагтан, сэтгэл төдийтөн, төв үзэлтэн хэмээн дөрвөн тогтсон тааллаар ялган авч үзэх нь бий. Дотоодын мэргэдүүд нь Буддын онол, сургаалыг цагийн уртад үргэлжлүүлэн өвлөж, олон талаас нь тайлбарладаг. Тухайлбал, “Билгийн мэлмийтэн нар бодосыг дүрс хөрөг мэт үзэж орон хэмээхийн балчигт үл шавардана; Нялхас дүрсэд тачаамуй, дундчууд тэмцлээс хагацмуй, дээд оюун төгсөгчид тийн бөгөөд тонилмуй; Орон үгүй бол тачаангуй үгүй” (Нагаржуна) буюу “Алимад долоон зүйлээр үгүй бөгөөд тэдгээр нь эрдэм, гишүүн, тачаангуй, бэлгэ чанар, мод тэргүүтэн хийгээд эрдэмт тачаагч, бэлгэдэх орон, гал тэргүүтэн тэргэний шинжлэлээр долоон зүйлд буй бус болой” (Чандракирти) мөн түүнчлэн “Дүрс би бус, би дүрс лүгээ төгөлдөр бус, дүрсэд би үгүй, би-д дүрс үгүй. Тэр мэт дөрвөн зүйлээр хамаг цогцыг мэдэгдэхүй” (Чандракирти), “Мэдэгдэхүүн үгүй бөгөөс мэдлийг арилгах нь амар хялбар хэмээн бурхад номловай. Мэдлийг хаахын тулд анханд мэдэгдэхүүнийг хаан зохиосон буй” (Чандракирти), “Өөрийг ухах нь бүтээх амуй за” (Чандракирти), “Алины тул алинаар орныг эдлэсэн түүнээс өөр дурдах над буй бус. Тиймийн тул би бээр үзвэй хэмээн дурдах болмой. Энэ бээр ертөнцийн томъёоны ёсон буй” (Чандракирти) буюу “Сэрэхүй нь эдлэгч болой. Хуран мэдэх нь бэлгэдэн баримтлахуйн чанарт болой. Тийн мэдэхүй нь өөр өөр тийн ухагч болой. Сэтгэлийн төрөн түгэхүй ч тэр буй” (Васубанду) буюу “Алимад өөрөө өөрийн чанараар эс бүтвээс түүнийг бусад бээр хэрхэн төрүүлмүй. Тиймийн тул бусдаас бүтсэн ангид нөхцлүүд нь төрүүлэгч бус. Ямарваа зүүдний орон дор шүтсэн жаргалан зовлонд орон үгүй. Түүнчлэн алимад дур шүтэж алимад болох тэр хийгээд тэр үгүй. Шүтээд барилдаж болсон тэр эс төрсөн буюу. Бодос хоосон болбоос төрөх үгүй бөгөөд түрдэх үл болмуй” (Нагаржуна) буюу “Сэтгэл үүсгэх нь бусдын тусын тул, үнэхээр туулсан бодь хүсмүй. Мөн чанараар өвөрчлөн үгүйн тул дүр тэргүүтэн үл оршимуй. Тэдгээр ч ангид бус мөн чанар нэг тул түүний мөнх бус тэргүүтэн дор үл оршмой. Мөн чанарын

хоосон тул тэдгээр ангид бус мөн чанар нэг хэмээвэй” (Майдар). (Wisdom of the hour of death) сударт мөнх бусыг үзүүлэх тэр цаг мөчид бодьсадва нар юуг эрхэмлэн бясалгах талаар “үхлийн айдас түгшүүрээс өөрийгөө чөлөөлөх, юунд ч сэтгэл үл хоргодох, Будда бурханыг хаанаас ч үл хайх, алив зүйл хоосон чанартайг ойлгох, их нигүүлсэхүй сэтгэл үүсгэн бясалгах” хэмээн өгүүлсэн байдаг. Эрхшээлийг олсон бодьсадва нар “Гурван цагийг мэдэх, Бурханы номыг мэдэх, номын чанар ялгал үгүй хийгээд хязгаар дунд үгүйг мэдэх, хамаг амьтныг огоот мэдэх, хамаг номуудыг илтэд мэдэх, ертөнцийн хамаг орныг дэлгэрэнгүйд дүүргэх, ертөнцийн хамаг орныг гийгүүлэн үйлдэх, ертөнцийн хамаг оронд адистэдийг оршуулах, Бурханы хязгаалал үгүй бэлгэ билгийг өгүүлэн үйлдэх эрдмээр эзлэгдсэн Ялж төгс нөгчсөн бурхадын арван оронд орших” эрдэмтэйг онцлон дурдсан (Ганжуур, Боть 23) байдаг бол төгс хөгжсөн хүний их нүгүүлслийг зургаан ихэсийн нүгүүлсэлтэй буюу бүхнийг ялгаварлалгүйгээр жигд гэрэлтүүлэх нар, сайн муу бүгдийг ялгалгүй агуулагч огторгуй, бүхнийг ялгалгүй үүрч явах дэлхий, бохир мууг ариутгагч гал, ус, салхины үйлтэй зүйрлэх нь бас бий (Тарва чинбо). Ийнхүү Буддын эрдэм ухааныг Ганжуур, Данжуурын 330 гаруй ботиос хайж, эзэмших бүрэн боломжтой юм.

Дүгнэлт

1. “Ялж төгс нөгчсөн Бурхан” хэмээх ойлголт нь сэтгэлийн боловсролыг төгс эзэмшсэн хүнийг илэрхийлж байна.
2. Буддын нотлохуй ухаан хийгээд бясалгалын арга нь мэдлэг олох, зөв бурууг ялган нотлох, ойлгуулах, түгээн дэлгэрүүлэх, буруу мэдлэг, дадал, хандлагын төөрөгдлөөс хүнийг аврах объектив шинж чанартай танин мэдэхүйн аргууд мөн.
3. Цогт Наландра хийдийн арван долоон их бандида тэргүүтэй мэргэдийн бүтээл туурвил нь объектив мэдлэг, туршлагыг өвлөх, арвижуулан баяжуулах шинжлэх ухаанч үйл ажиллагаа мөн тул Буддын ухаан нь эпистемологийн нэг салбар юм.
4. Буддын бясалгалын арга технологийн танин мэдэхүйн ач холбогдлыг сэтгэл судлал, тархи судлалын салбарт хүлээн зөвшөөрч, салбар хоорондын хамтын судалгаа хийгдэж, зохих үр дүнгээ өгч байна.
5. Шагжамуни Буддагийн анхлан нээсэн практик туршлага нь хүнийг сэтгэлийн төгс хөгжил рүү чиглүүлэх зөв аргачлал бөгөөд тэрхүү аргачлалыг зөв хэрэглэсэн хэн ч ижил үр дүнд хүрэх тул объектив арга зам юм.
6. Буддын ухааны онолын мэдлэг нь изотерик мэдлэг огт биш бөгөөд шинжлэх ухаантай нэгэн адил танин мэдэхүйн салбар мөн.
7. “Шашин хэмээн ойлгогдох сүсэг бишрэлийнх нь бүрхүүл”-ийг нь нээж, Буддын сургаалын цөм онолыг шинжлэх ухаанч агуулгаар нь зөв судлах шаардлагатай байна.
8. Буддын ухаан нь шинжлэх ухааны мэдлэгийн сул талыг, тухайлбал, хүний дотоод сэтгэлийн тухай мэдлэгийг нөхөн гүйцээх чадвартай бөгөөд шинжлэх ухааны танин мэдэхүйтэй шүтэн барилдсан танин мэдэхүйн өвөрмөц салбар мөн.

Ашигласан ном, судар

1. Булган Т. Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл. УБ. 2016.
2. Дондог Х. Их хөлгөний судлагдахууныг шинжилсэн дүн. Орхон Их сургуулийн эрдэм шинжилгээни бичиг, 2020.

3. Joseph Loizzo. Meditation research, past, present, and future: perspectives from the Nalanda contemplative science tradition. Advances in meditation research: Neuroscience and Clinical Applications, ANNALS OF THE NEW YORK ACADEMY OF SCIENCES, 2014.
4. Дондог Х. Билиг ухаанаар нотлох арга аргачлалын тухай. Орхон Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг, 2019.
5. Мөнхбаатар Б. Буддын бясалгал ба сэтгэл судлал, УБ. 2020.
6. Дондог Х. Шүтээнээ тунгаахуй нь өөрийгөө танихуй мөн. Баруун Монгол, түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, түүх, хэл, соёл сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019 он, х94
7. Васубанду. Илт номын үгсийг бүлэглэн үйлдсэний тайлбар. УБ. 2009.
8. Дунд бодь мөрийн зэрэг. УБ. 2020.
9. Бодьсадвын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар. УБ. 2009.
10. Хутагтын орны дотоодын номлолоос гарсан шинжлэх ухаан болон үзэл онолын хураангуй. Дунд боть. УБ. 2016.
11. Чандракирти. Дундад орохуйг шүлэглэсэн
12. Нагаржуна. Ухааны жаран шүлэгт
13. Нагаржуна. Хоосон чанарын далан шүлэгт
14. Wisdom of the hour of death (འདུལ་ལྔ་ཡི་ཤེས་)
15. Наландра хийдийн 17 их бандида нарын намтар
16. Очироор огтлогч судар
17. Миларайвын мянган дуулал
18. Майдар гэгээн. Илт онолын чимэг
19. Тарва ченбо судар
20. Асанга. Их хөлгөний хураангуй.
21. Алтангэрэл судар.
22. Ганжуур (кирил). 23-р боть. х34.

4.2. Өөрийгөө танихад шүтээний гүйцэтгэх үүрэг

Хураангуй

Шүтээн нь хүний үнэт зүйл болон шүтэх зүйлтэй холбоотой. Хүн бүрт үнэт зүйл, шүтэх зүйл буй. Энэ хоёр нь давхцаж нэг зүйл болох, эсвэл цаг хугацааны явцад ялгарах, үнэт зүйл нь шүтээн болох, мөн эсрэгээр ч өөрчлөгдөж болно. Үнэт зүйл нь хүнс, эд хөрөнгөөс эхлээд аав ээж, үр хүүхэд, ах дүү, найз нөхөд, хань ижил, багш гэх зэргээр улсын ерөнхийлөгч хүртэл яригдах тодорхой зүйлс байх. Түүнчлэн, эх орон, ард түмэн, шим ертөнц, мэдлэг чадвар, оюун ухаан, соёл иргэншил, төрийн сүлд, далбаа гээд илүү ерөнхий эсвэл хийсвэр ч байж болно. Харин шүтэж бишрэх зүйлийн хувьд бол урлаг спортын одуудаас авхуулаад бүр ертөнцийн эзэн гэгч ч байна. Заримдаа ихээхэн ээдрээ учруулдаг уг асуудлын мөн чанар нь “Шүтэж бишрэх эрэлт хэрэгцээ хүнд төрөлхийн заяасан байдаг”-т оршино. Уг хэрэгцээндээ би хэрхэн хандаж байгаа вэ? гэдэг нь чухал сэдэв юм. “Даган дууриах, шүтэн бишрэх зүйлээ оновчтой олж чадсан уу, үгүй юу гэдгээс хүний амьдралын гол шугам ямар байх нь хамаарна” гэсэн судлаачдын

таамаглалын хүрээнд энэхүү өвөрмөц асуудлыг авч үзсэн болно. Ухаант хүн амьдралын явцад өөрийгөө өөрчлөн сайн сайханд тэмүүлдэг. “Хүнийг өөрчилье гэвэл өөрийн тухай ойлголтоо өөрөө мэдэж өөрчлөхөд хүргэх хэрэгтэй” хэмээн А.Маслоу хэлсэн/1,2/ ажээ. Иймд юу шүтэж буйгаа эргэн харж, дүгнэн үзвээс бусдын дунд өөрийн байр суурийг ойлгох нэгэн боломж нээгдэх юм.

Дууриаснаар шүтээнээ олохгүй

Бусдыг дууриан хөлд орох, хэлд орох зэрэг нь нийтлэг ёс. Даган дууриах арга барил багшаас бичиг үсэг сурах, мэдлэг олох, мэргэжил эзэмших, гэрлэх, амьдралаа авч явах, ажил хөдөлмөрийн дадлага суух зэргээр урт удаан цаг үед биднээс салахгүй явсаар. Цаашилбал, урлагийн болон бусад одуудыг дууриан шүтэх зэргээр хэлбэр төрөл нь улам бүр олширдог болохыг ямар ч нотолгоо баримтын шаардлагагүйгээр мэдэж, мэдэрч болно. Гадаад орны соёлыг хуулбарлан дууриах, өөрийн уламжлалт соёлоо орхих, дутуу эзэмших, гадны шашины олон чиглэлийг дууриан шүтэх нь мөн л энэ технологийн эргэлзээтэй нөлөө мөн.

Монголын уламжлалт шашин бол хүний сэтгэл зүйн судалгааны үр дүнд суурилсан бөгөөд Бурханы сургаал нь өөрийгөө танин мэдэхийг хүн бүрт уриалдаг байна /29,30,31/. Гэвч уг сургаалыг биечлэн уншиж, өөрийгөө таних, засах, залах байтал бусдаар уншуулан бэлэнчлэх сэтгэхүйд дулдуйдаад “ажлаа бүтээлгэх” болсон мухар сүсэгт автаж туйлширсан практик өдийг хүртэл оршсоор байна. Хэрвээ судар, шаштируудыг өөрсдөө уншиж эхэлбэл өөрийнхөө учрыг олохоос гадна бусдын жаргал зовлонг нэвт шувт мэдрэх боломж нээгдэх боломж бий.

Дууриах технологийн ноён оргил нь өнөөдөр Монгол орон даяараа “хотын соёл”-ыг ухамсаргүй хуулбарлах гэсэн хандлага болжээ. Хэрэв хотын соёлыг нарийвчлан судалж үзвэл манай уламжлалт соёл иргэншилтэй эсрэг тэсрэг шинжтэй бөгөөд монголын хүн амын тоо, байгалийн нөхцөл, хүнийх нь удамшсан чадвар, давуу тал, унаган байгалиас авах өвөрмөц таашаал зэргийг нягт нямбай тооцож, өөрийнхөө онцлогт нийцүүлсэн, дэлхийн технологийн дэвшлийн давуу талыг нутагшуулсан “Монгол төрхтэй хот” байгуулах шаардлагатайг ойлгон ухаарч болно.

Монголчууд байгалийн өнгө аясад дасаж, сав шим ертөнцийн оршихуйн жамыг таньж, түүнд зохицох байдлаар амьдралын дархлаагаа бүтээсэн үндэстэн. Монгол дархлаа нь байгалийн жамаар тогтож, монгол хүний үйл ажиллагаанд илэрч, монголчуудын тусгаар тогтнолыг баталгаажуулж буй оршихуйн чадвар хийгээд оюун сэтгэхүйн өвөрмөц чадамж мөн /16,32/. Тухайлбал, ороо бусгаа цагийн эрсдлийг тооцож бэлтгэх, хаврын хуйсгануур арилж зуны налгар цаг ирэх эсвэл налгар намрын дараа өвлийн хүйтэн жаварт хайруулах зэрэг дөрвөн улирлын сэлгээг ухаарах, гурван зуд давж малчин ухаан жинхэнээрээ суух, улирлын хэмнэлд тааруулан говь, хангай, хээрийг хослуулан нүүх, амьдралын дөрвөн бэрхийг ухаарах явцад тогтон бэхжсэн монгол ухааны дархлаа нь байгалийн жамыг дагаж цэцэглэсэн унаган ургамал мөн /7,8/. Монгол дархлаа нь эх байгалтайгаа тэнцвэртэй орших монгол соёл иргэншлийг бүтээсэн. Энэ ухаан нь орчин цагийн синергетикийн шинжлэх ухааны нээсэн зүй тогтлуудтай

бүрэн нийцдэг. Синергетикийн ухаан (Хакен, Пригожин, Манделброт, Арнольд, Том, Arthur Coulter, Н.Ulrich)-аар бол алив системийн тогтвортой төлвүүд буюу аттракторууд өөр хоорондоо санамсаргүй сонголтоор холбогддог, хөгжлийн нэг төлвөөс нөгөө рүү систем шилжихдээ уймарсан хаос төлвөөр дамждаг, жолоодлогын параметрийн утгаас хамаарч системийн төлөвт гэнэтийн үсрэлт, сэгсрээ, салаа зам, шилжилт гарах гэх мэт ерөнхий зүй тогтлууд бий /9-15/. Энэ нь уламжлалт монгол ахуйн динамик шинжтэй нягт нарийн нийцдэг.

Дууриах нь хүнд заяасан инстинкт мөн ч түүндээ хөтлөгдөн өөрийн бодол, судалгаа, сэрэмж, анхаарал, ухааралгүйгээр явах нь насанд хүрсэн, зохих түвшний боловсрол эзэмшсэн хүний хувьд төөрөгдөл болно. Тухайлбал, бусдын шүтээнийг өөрийнх болгон дууриах нь хүүхдийнх гэмээр гэнэн зан. Дэлхийн хүн амын олонхи нь хот сууринд амьдардаг бөгөөд хот нь нийтлэг дэд бүтцээр тэжээгддэг “хүн сүрэг”-ийн ухаамсаргүй урсгал тул түүний сул тал нь “Жалын дуу”-гаар хулжих /38/ адил нийтийн жишиг урсгалыг ухамсаргүй дагах эрсдэлд оруулдаг. Гэвч тэрхүү урсгалд автсан ч гэсэн өөрийн ухаанаа эс гээх нь үнэ цэнэд хүргэнэ. Юунд итгэх, яагаад итгэх, юуг нь дууриах, юуг нь өөрийнхөөрөө хийх, өөрчлөх нь бүтээлч хүний шинж мөн.

Шинжлэн судлах нь өдөр дутмын дадал болох хандлага илэрч буй нь

Шинжлэх ухааныг тусгай арга барил эзэмшсэн судлаач хөгжүүлж ирсэн уламжлалтай ч, өнөө цагт шинжлэх ухаан материаллаг объектийг судлахын зэрэгцээ материаллаг бус хийсвэр зүйлийг, тухайлбал, хүний дотоод ертөнцийг судлах болжээ. Карл Юнг /3,4,5,6/-ын судалгааг үзэхэд Буддын гүн ухаанаас суурь санааг авч, хүний дотоод ертөнцийг судлахад ерөнхий арга зүй болгон хэрэглээд, шинжлэх ухааны сэтгэл судлалд томоохон хувь нэмэр оруулсан байна. Буддын гүн ухааныг “оршихуйн сэтгэл судлал” хэмээн нэрлэж болох ба амьдралын ухаарал нь хүн өөрт нь нээлт болох, улмаар өөрийгөө таньсан тэр зүйл нь сайн муу үйлийн ертөнцөд баримжаа болох ач холбогдолтой юм. Энэ утгаараа оршихуйн сэтгэл судлалыг шинжлэх ухааныхан сонирхох болсноор тэрхүү салбарын судалгаа нь жирийн хүний өдөр тутмын ажил болох хандлагатай боллоо.

14-р Далай ламын санаачлагаар сүүлийн 30 орчим жил зохион байгуулагдсан “Mind & Life” хэлэлцүүлэг нь дэлхийн шинжлэх ухааны тэргүүлэх салбарын судлаачидтай мэдээлэл солилцож, олон бодит үр дүнд хүрсэн билээ. Түүний нэг нь “Буддын шашины шинжлэх ухаан” нэрт бүтээл юм. Түүнийг Гандантэгчилэн хийдийн Дашчоймбол дацангийн шунлайв, гавж С.Гантөмөр монгол хэл рүү хөрвүүлсэн билээ /28/. Энэ ном нь Буддын сургаалын дотор шинжлэх ухааны мэдлэг байгааг батлан, бидэнд нээн харуулав. Далай ламтан тэрбээр “Өнөөгийн шинжлэх ухаан, Буддын сэтгэл судлал хоёрыг хослуулваас хүмүүн төрөлхтний мэдлэг боловсролын нэгэн шинэ салбарыг үүсгэж чадна” хэмээжээ. “Өрнөдийн орнуудад өдгөө Буддын шашины судалгаа хурдацтай хөгжиж, зарим алдартай их сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүртэл орж байгаа нь... бидний хоцрогдсон хэмээн үздэг, арц хүжээр утах, гаднаас нь залбирах төдийд шүтдэг Буддын сургаалийг өөдөөс чинь заах болох вий гэдэгт итгэл улам

ихэссээр” хэмээн гавж С.Гантөмөр уг номын удиртгалд тэмдэглэжээ. Шашин хэмээх бүрхүүлээр хучигдсан сэтгэлийн танин мэдэхүйн гүн сургаалыг үл анзаарч явсаар бид цаг их алджээ. Уламжлалт мэдлэгтэй Монголчууд түүнийгээ мэдэхгүй, өнгийж харахгүй байхад түүнийг нь огт мэдэхгүй өрнөдийнхөн аль хэдийнээ сэжүүр олоод судалж эхэлжээ. Ийнхүү дотоод сэтгэлийн мөн чанар, харилцаа, ухаалаг хэрэглээ, ухаалаг оролцоо, ухаалаг оршихуй руу шинжлэх ухаан хандах болов. Орчин цагийн шинжлэх ухааны энэ онцлогийг тооцон, урьд нь хүний амьдралаас хол хөндий байсан шинжлэх ухаанч шинжилгээний аргыг өөрийн санаачлагаар эзэмшиж, оюунаар сэтгэлийнхээ онцлог, оршихуйн хийсвэр талыг танин барих нь тухайн хүнд өргөн боломж нээх юм. Уг боломжийг бодит хэрэг болгосноор өдөр тутмын ажил үйлс, хөлс зүтгэлийн цаанаас таны шүтээн аяндаа тодрохыг үзэх болно. Товчхондоо хүний шүтээн нь Бурхан биш, бас буг ч биш болохыг ухаарах бололцоотой юм.

Микро ертөнц хоосон чанарыг илт өгүүлсээр

Гэрлийн хоёрдмол шинж нь физик боловсролоор олгодог жирийн мэдлэгийн нэг. “Хоёрдмол шинж” гэдэг нь гэрэл нэг талаас “бөөм”, нөгөө талаас “долгион” болохыг хүлээн зөвшөөрч буй хэрэг. Гэрлийг “барьж” илрүүлэхэд тодорхой нөхцөл хэрэгтэй байдаг. Нэг нөхцөлд гэрэл “бөөм” болж “баригдана”. Нөгөө нөхцөлд “долгион” болж “баригдана”. Хэрэв энэ хоёр нөхцлийн аль нэг нь бүрдээгүй бол гэрэл “юу ч биш” буюу тэр гэх тодорхой зүйл биш болж, хоёрдмол шинжтэй гэх үгээр илэрхийлэгдэнэ. Буддын ухааны үүднээс бол гэрлийн “хоёрдмол шинж” нь “хоосон чанар” хэмээх ойлголтонд хамаарах аж. Өөрөөр хэлбэл, долгион, бөөм хоёрын аль нэг нь мөн гэж хэлэх боломжгүй байгаа учраас долгион ч алга болсон, бөөм ч бас алга болсон мэт болж, тэр хоёрын чанар тус тусдаа хоосорсон хэрэг юм. Гэвч гэрэл устаагүй байгаа нь ойлгомжтой тул тэр хэмээн онож баригдахгүй “хоосон чанар”-ын төлөвт оршиж буй хэрэг болно.

Өнөөгийн квант физикийн онолын судалгаа нь масс энергийн холбоогоор илэрч буй хоосон чанар, эгэл бөөмийн хоёрдмол шинжээр нотлогдож буй хоосон чанарт тус тус баримжаалан торсион орны судалгаа руу чиглэх болов. Судлаачдын таамагласнаар бол торсион орон нь хүний бодол санаа, мэдээллийг зөөдөг физик орон бөгөөд хэд хэдэн өвөрмөц шинж чанартай/33/. Тухайлбал, мэдээлэл нь локал бус шинжтэй буюу бүхий л сав ертөнцөд оршдог, мэдээлэл дамжуулагч торсион бөөм нь гэрлээс тэрбум дахин их хурдтай юм. Мөн түүнчлэн нэгэнт үүссэн мэдээллийн торсион бөөм нь устдаггүй гэжээ. Хэрэв эдгээр таамаглал ул үндэстэй болвоос хүний бодол хадгалагдахаас гадна ертөнцийн хаана ч хүрэх, бүртгэгдэх, хэрэглэгдэх боломжтой гэсэн мөрдлөгө гарна. Мөн түүнчлэн хүн өөрийн болон өрөөлийн бодол санааг мэдэх, ойлгох, өөр хоорондоо хуваалцах боломж нь нээгдэх юм.

Бүхний шүтээн өөрчлөгддөг болох нь

Хүн төрөлхтөнд нийтлэг шүтээн нь наанадаж дөрвөн том өөрчлөлтийг туулж яваа нь илт. Үүнд: 1. Бөө мөргөлийн, 2. Бурханы, 3. Шинжлэх ухааны, 4. Пост модерн үеүд хамаарна.

Хүн байгалийн сүр хүчин дор амьдрахуй цагт нар сар хиртэх зэрэг байгалийн онцгой үзэгдлүүдийг их л айн чичирч хүлээн авдаг байсан нь илэрхий бөгөөд тэдгээрт тайлбар хийх, аргадах байдал нь уул усны эзэн, бөө мөргөлд хүргэж байсан нь ойлгомжтой юм. Харин хүний амьдралын нөхцөл, амьдрах арга сайжирснаар хүн өөрөө байгалийн хүчин зүйлийг ашиглах, өөрчлөх, бүтээх хүч чадалтай нь тодорхой болж ирсэн тул “Ихээхэн ид шид, хүч нөлөөтэй хүн”-ийг санаандаа дүрсэлж, түүнийгээ “Бурхан” хэмээн нэрлэж шүтэх болсноор “Бөө нь Бурханаар солигдох” хандлага гарчээ. Хүний танин мэдэхүй улам бүр өсч, оюун ухааны хүчин чадлыг биширч, амьдралын технологи эрс өөрчлөгдөн, хиймэл техник, хиймэл ганган барилга, орон байр, хоол хүнс зэргүүд түрж ирмэгц танин мэдэхүйн ухаанаа дээдлэн “Шинжлэх ухааныг шүтэх” болсноор Бөө мөргөл, Бурхан хоёр ард хоцрох хандлагатай болсон байна. Шинжлэх ухаан нь техник технологид хязгааргүй шахам нөлөө үзүүлэхээс гадна нийгмийн чиглэлд нөлөө нь түрж орсноор 19-р зууны сүүл 20 дугаар зууны дунд үе хүртэл “изм”-үүд цэцэглэх болжээ. Иймд олон -измүүд өөрийгөө харуулж, эцэст нь нийгмийн хөгжилд тэдгээр нь дараа дараагаар хүчгүйгээ харуулж, нэр хүнд нь шалдаа буутал унасан билээ. Тухайлбал, хамгийн сүүлчийн “Марксизм, коммунизм, социализм, империализм”-ийн сүйрэл орчин үеийнхэнд ойлгомжтой байгаа биз ээ. -Измүүдийн сүйрэл нь нийгмийн шинжлэх ухаан нэр хүндийг эрс унагаснаар “Пост модернист” хандлага “Нийгмийн шинжлэх ухааны шүтлэг”-ийг халах болжээ.

Пост модерн хандлагын нэг давуу тал нь хүн өөрийнхөөрөө байхыг дэмждэгт оршино. Хүн өөрөө өөрийгөө хариуцах нь юу юунаас чухал гэдгээр уг давуу талыг тайлан уншиж болно. Өөрийгөө бүрэн хариуцахыг эрхээ эдлэх хэмээн ойлгож бас болох ажээ /17-19/. Өөрийгөө олох, таних нь дотоод ертөнцөө мэдэх үйл явц юм. Өөрийгөө олсон, өөртэйгээ харилцаж сурсан хүн бэрхшээлээс шантрахгүй, хүчтэй байдаг. Монголчуудын уламжлалт соёл иргэншил нь айл өрх өөрөө өөрийгөө хариуцахтай шууд холбоотой байжээ. Тэдний үндсэн бизнес нь мал өсгөхтэй холбоотой бөгөөд “Мал маллах гэдэг нь малыг жаргаах юм” (Хөдөлмөрийн баатар Намхайнямбуу) хэмээн ухаарч, амьдралын суурь шүтээнийг мал, бэлчээр, хур бороо, малчин, мал маллах ухаантайгаа холбон цогцоор нь харж иржээ. Эдгээр таван гишүүний шүтэн барилдлагаас уламжлалт монгол оршихуйн “хоосон чанар” тодрон харагдах бөлгөө.

Дотоод ертөнцөө тандахуй

Хүний тунгаахуй чадвар өөрийг нь ямагт өргөж, өндийлгөж явдгийг ухаарах нь зүйтэй юм. Түүнийг “Хүн хөлөөрөө бус, толгойгоороо явдаг” зэрэг сургааль үгсээс ургуулж ч болно. Хүний дотоод ертөнцийг Буддын сургаальд гүн гүнзгий танин мэдсэн байдаг ч тэр ухаан нь “Шашин” гэсэн далбаан дор орших тул бурханы шашинд хамааралгүй хүн “Түүн рүү өнгийж хардаггүй” байна. Гэвч нийгмийн шинжлэх ухааны хямрал нүүрэлсэн, унаган байгальтайгаа орчин үеийн хотожсон соёл зөрчилдөж, мөхлийн ирмэгт өөрийгөө ойртуулсаар буй өнөө үед гарцыг сэтгэлийн ертөнцөөс хайх болжээ. Учир нь хүний тархи, зүрх хоёр хослон ажиллаж чадвал тогтвортой хөгжилд хүргэх нигууртай аж. Квант физикчид “хоосон чанар”-ыг оносноор Шинжлэх ухаан, Буддын ухаан хоёр харилцан ойлголцох үүд хаалга ч нээгдэж байна.

Буддын шинжлэх ухаанд хүний дотоод ертөнцийн боловсролыг сав шим ертөнцийн ёсыг таних, түүнийг хүлээн авахтай холбож тайлбарласан байдаг. Тухайлбал, “Төрсний эцэст үхэх мөн, хураасны эцэст барагдах мөн, өндрийн эцэст нурах мөн, нөхөрлөсний эцэст салах мөн” хэмээн ертөнцийн жамаас томъёолсон буй/34/. Түүнийг нарийн тунгааваас “Асар их атхаг нь мунхаг мөн” /36/, “Хүсэл багатай нь амгаланд хүргэнэ” эсвэл “Ханах мэдэл нь эрхэм дээд баялаг мөн” гэх зэрэг ухааралд хүрэх бөлгөө. Зарим сайн номлолоос энд цухас дурдвал: Сүжгийн ёсоор сонссон ном эрдэм авах гээхийн ухааны түлхүүр болно/35/. Иймд сонссоноос гарсан ухааныг магнайн нүд мэт эрэх хэрэгтэй гэжээ. Мөн түүнчлэн эрдэм ном сурахдаа шавийн савны гурван гэмийг тэвчихийн чухлыг сургасан буй /34/. Гурван гэм нь ам нь хөмөрсөн, ёроол нь цоорхой эсвэл хир буртагтай сав шиг байхыг хэлнэ. Мөн түүнчлэн сайн үйл шуурганд үл эвдрэх, галд үл шатах, шороонд үл дарагдах, усанд үл урсах зэрэг чухал шинжтэй гэнэ. Сайн үйл сэтгэлээс эхтэй бөгөөд өөрийн сэтгэл өөртөө ил тул ертөнцийн жам лугаа зохилдуулан дахин дахин шинжил хэмээжихүй/35/.

Буддын ухаанаар оносон дотоод ертөнцийн танин мэдэхүй нь шинжлэх ухааны сэтгэл судлалаас өөр ойлголт, хандлага, сэтгэлгээгээр өрнөх бөгөөд тэдгээрийг өөр хооронд нь ойлголцуулж, нэг хэлээр ярьдаг болгох нь шинжлэх ухааны судалгааны зорилгод хамаарч буй. Дараах мөрүүдийг уншихад дотоод ертөнцийн ухааны хэллэг юу болох нь илт харагдана. Үүнд /37/:

Хэзээ ч өрөөсгөлөөр үзэхгүй нэгэн зэрэг
Хэлбэрэлтгүй шүтэн барилдлагыг таних зуур
Магад мэдлийн орны баригдал бүгд эвдэрвээс
Мадаггүй үнэн үзлийн шинжлэл төгссөн нь тэр буй...
Эсвэл
Басхүү үзэгдлээр буй хязгаарыг арилгаж
Батгүй хоосноор үгүйн хязгаарыг огоорч
Хоосон чанар шалтгаан үрд ургах ёсыг мэдвэл
Хотол туйлшрагч үзлийн эрхэнд үл орюү гэх мэт.

Дүгнэлт

Шүтээнийг тойрсон дээрх харьцуулсан мэдээлэл, шинжилгээний дүнгээс ургуулан дараах дүгнэлтүүдийг хийж болно. Үүнд:

1. Өөрийн шүтэж бишрэх унаган эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж буйгаар хүмүүс хоорондоо ялгарах ажээ. Зарим хэсэг нь бурханыг эсвэл ертөнцийн эзнийг өөрийн шүтээний байранд залдаг бол нөгөө хэсэг нь тодорхой шүтэх бишрэх зүйлгүй төөрөлдөж явах нь бий. Эдгээр нь өөрийн байр сууриа олох байдлын туйлширсан хоёр хэлбэр мөн.
2. Шүтээнээ зөв олох гэсэн эрмэлзэл тэмүүлэл нь хүнд өөрийгөө онож таних, сайн муу үйлийг ялгахад тусалдаг.

3. Шүтээн нь заавал шашинтай холбоотой байх албагүй. Өөрийнхөө давуу тал, бүтээлч танин мэдэхүй хийгээд үр дүнг ч шүтэж болох нь оршихуйн гүнзгий танин мэдэхүйн сургаалуудаас урган гарч байна.
4. Хотын соёл нь нийтийн эрэлт хэрэгцээг нийтлэг дэд бүтцийн үйлчилгээгээр дамжуулан хангадаг боловч хувь хүн түүнд шууд нөлөөлөх боломж хомс юм.
5. Пост модернист хандлага нь хувь хүн өөрийгөө таних, цаашилбал, нийгмийн нийтлэг монополь урсгалын сул талыг хүн өөрөө нөхөх боломжийг олгож байна.
6. Монгол мэргэд сав шим ертөнцийн жамыг ойлгож, хүний гадаад хийгээд дотоод ертөнцүүдийн шүтэн барилдах ёсын дагуу эх дэлхийтэйгээ тэнцвэртэй орших чадамжийг бүтээсэн байна.
7. Шүтээнийг өвлөж авах эсвэл өөрөө бүтээх нь өөрт тустай.

Ном зүй

1. А.Маслоу. Toward a psychology of being. 2013, 1962. Start Publishing LLC.
2. А.Маслоу. Self-actualization and beyond, 1965.
3. C. G. Jung. Analytical Psychology: Its Theory and Practice. The Tavistock Lectures. – London a. Henley, 1968. – 224 с.
4. Jung, Carl G., (1985), Man and His Symbols. Paidos.
5. Jung, Carl G., (2016), Writings on Spirituality. Trotta
6. Jung, Carl G., (2013), Modern Man in Search of a Soul, DeBolsillo
7. Х.Цоохүү. Монгол хүн Та хэн бэ? 2011.
8. Х.Дондог. Монголоо эрсэн монгол, 2010.
9. Mandelbrot B (2002) The Fractal Geometry of Nature. Institute of Computer Science p: 6
10. Prigogine IR (2000) The end of certainty. Time, chaos and new laws of nature. Regular and Chaotic Dynamics p: 208.
11. Self-organization and management of social systems: insights, promises, doubts, and questions, Berlin Heidelberg New York Tokyo 1984, editors: H.Ulrich and G.J.B.Probst
12. N.Arthur Coulter, Jr., M.D. Human Synergetics, 1976.
13. Hermann Haken: From the Laser to Synergetics. A scientific Biography of the Early Years. Springer 2015.
14. Винер Н. Кибернетика или управление и связь в животном и машине.
15. М. Сов.Радио, 1968.
16. Хакен Г. Синергетика. Иерархия неустойчивостей в самоорганизующихся системах и устройствах. М.: Мир, 1965.
17. Монголын нууц товчоо. 1990.
18. Сорхугтан. Хөх Монголыг төрөөр бадраах хутагтай нэурит засгийн алтан дээд үнэний аялгуу, 2009.
19. Сорхугтан. Хөх Монголыг нүүдлийн соёлоор бадраах хутагтай их засгийн алтан дээд гэрээ, 2009.
20. Сорхугтан. Хөх Монголыг ний хэмээр бадраах хутагтай дөрвөн нэурит их засгийн алтан дээд үнэний аялгуу, 2008.
21. Erich Fromm. The art of being. 1994.
22. Erich Fromm. The Sane Society. 2003.
23. The method, meditations, and selections from the principles of Descartes. William Blackwood & Sons. Edinburg and London. 1879.

24. Erich Fromm. To have or to be? The Nature of the Psych. 2005.
25. B.Russel. Our Knowledge of the External World. 1929
26. Erich Fromm. The art of Loving. 2006.
27. Erich Fromm. Escape from Freedom. 1994.
28. Levi-Strauss, Claude. 1963. Totemism. Penguin Books
29. С.Гантөмөр. Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: шинжлэх ухааны хэсэг, Боть 5. УБ. 2016.
30. Т.Булган. Буддын философийн дэвтэр. УБ. 2010.
31. Т.Булган. Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл, УБ, 2016.
32. Ч.Жүгдэр. XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ. 1984.
33. Х.Дондог. Монгол дархлаа нь бидний үнэт зүйл мөн. “Монголчуудын үнэт зүйлс” ЭШ-ний хурлын илтгэл, СУИС, 2019.
34. А.В. Бялко. Торсионные мифы. Журнал "Природа" №9, 1998
35. Агийванчүгдавга. Урьд одуулах суртгаал. Т.Булган, Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл, УБ, 2016, х 39-64.
36. Оюуны суртгаал чухал хэрэгт элдэв эш хэмээх оршвой, Зохиогч Цүлтэм, Т.Булган, Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл, УБ, 2016, х 76-101.
37. Бодь мөрийн зул оршвой, Зохиогч Адиша, Т.Булган, Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл, УБ, 2016, х 163-179.
38. Бодь мөрийн гурван эрхэм хэмээх оршвой, Зохиогч Богд лам Зонхава Лувсандагва, Т.Булган, Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл, УБ, 2016, х 181-1186.
39. Сайтар номлолын усны шаштир хос ёсны давалгааны эрхис зуу төгс хэмээ оршивой, Зохиогч Гончигдамбийдонмэ, Т.Булган, Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалын эмхэтгэл, УБ, 2016, х 279-313.

4.3. Их хөлгөний судлагдахууны шинжилгээ

Хураангуй

Буддын ухаан нь танин мэдэхүйн салбар бөгөөд түүний хуримтлуулсан мэдлэг, чадвар, туршилага нь орчин үеийн сэтгэл судлалаас хэтийдсэн ажээ. Буддын ухааны судалгааны гол объект нь хүний сэтгэл юм. Сэтгэл нь утгыг онох ба түүнийг нарийвчлан ялгах талаасаа гол сэтгэл ба нөхөр сэтгэл хэмээн ангилагдана. Барих бие, үзэгдэх дүрс үгүй ч сэтгэлийг дээдийн номын “толинд” харж болдог нь гайхамшиг. Юуны өмнө өөрийн сэтгэлийг хардаг ч, тэр нь бусдынхтай адил мөн чанартай тул бусдын сэтгэлийг харсантай утга нэг болно. Бүхний шүтээн тийн мэдэхүй нь сэтгэл бөгөөд түүнийг энэхүү өгүүллийн хүрээнд судлах явцад их хөлгөний судлагдахуун тодорч, түүнийг шинжлэх ухааныхтай жиших боломжийг нээсэн юм. Их хөлгөний судлагдахуун нь мэдэгдэхүүний орон, түүнийг онохуйн мөр, мөрийн үр гэсэн гурван хэсгийн цогцоос бүрдэж буй нь илт байна.

Түлхүүр үг: Мэдэгдэхүүний орон, мэдэгдэхүүний бэлгэ чанар, үлэмж шагшаабад, үлэмж сэтгэл, үлэмж билиг, тэвчсэн үр, тэвчсэн үрийн бэлгэ билиг.

Удиртгал

Энэхүү өгүүллийн хүрээнд Асанга хутагтын “Их хөлгөний хураангуй” бүтээлийн агуулгад задлан шинжилгээ хийж, үр дүнг “их хөлгөний судлагдахуун” хэлбэрээр тодруулан ялгасан болно.

Ялж төгс нөгчсөн бурхадын зарлиг арван зүйл ялгалаар үлэмж хэтэрсэн болой³ хэмээн Асанга хутагт онцлон тэмдэглэсэн байна (Асанга, 2005). Тэдгээр нь мэдэгдэхүүний орон, мэдэгдэхүүний бэлгэ чанар, мэдэгдэхүүний бэлгэ чанараа орохуй, мэдэгдэхүүний бэлгэ чанараа орохуйн шалтгаан хийгээд үр, мэдэгдэхүүний бэлгэ чанараа орохуйн шалтгаан хийгээд үрийн бясалгахуй, үлэмж шагшаабад, үлэмж сэтгэл, үлэмж билиг, тэвчсэн үр, тэвчсэн үрийн бэлгэ билиг ажээ⁴. Үүнийг нягтлан үзвээс их хөлгөний судлагдахуун нь мэдэгдэхүүний орон, түүнийг онохуйн мөр, мөрийн үр гэсэн гурван хэсгээс бүрдэж буй нь илт байна. Арван зүйл үлэмж ялгалын эхний гурав нь мэдэгдэхүүний оронд хамаарах бөгөөд дараах тав нь онохуйн мөрийг тодруулж, сүүлчийн хоёр нь мөрийн үрд хамаарна. Арван орон нь их бодийг бүхнээ бүтээн үйлдэгч бөгөөд хамгийг айлдагч бэлгэ билгийг олохуйд харшлалгүйгээр зохилдох тул тэдгээрийн үе зэргийг үзүүлснээр хамаг их хөлгөн огоот төссөн болох ажээ⁵. Уламжлал ёсоор их хөлгөний номыг гурван зүйлээр буюу шүтэн барилдаж болсныг үзүүлэхүй, шүтэн барилдаж болсон номуудын бэлгэ чанарыг үзүүлэхүй ба номлож дууссан утгыг үзүүлэхүй бээр номлогдохуй.

Судлагдахууны шинжилгээ

1. Мэдэгдэхүүний орон

Мэдэгдэхүүний орон нь бүхний шүтэн тийн мэдэхүй бөгөөд түүнийг зөв оносноор шүтэн барилдаж болсонд мэргэшинэ хэмээн номложээ. Бүхний шүтэн тийн мэдэхүй (БШТМ) нь алин бүхнээс нисванист хамаг номын авъяаснаа шүтээд хөрөнгө огоот барих лугаа төгссөн тул түүний өөрийн бэлгэ чанар нь төрөхүйн шалтгааны бэлгэ чанар болой. Хотол номуудын орон буйн тул хамаг амьтан гаслангаас нөгчснийг олох боломжтой. Хотол номын хамаг хөрөнгөт тийн мэдэхүй нь бүхний шүтэн бөгөөд төрөлхтөн бүхнээс нисванист хамаг номыг шалтгаан болон үрийн боднаа барилдуулах тул бүхний шүтэн хэмээн тодотгосон байна. Бүхний шүтэн тийн мэдэхүйгээс бус сэтгэлийн бие өрөөсгөлийг үл зорих бөгөөд тиймийн тул бүхний шүтэн тийн мэдэхүйг ямагт сэтгэл мөн хэмээн таалвай. Бүхний шүтээний ялгал нь бүхний шүтэн тийн мэдэхүй мөн бөгөөд амьтан нугууд түүний мөн чанараа барилдах тул авахуй тийн мэдэхүй ч болох аж. Түүнийг сэтгэл хэмээхүй ч буй. Номын авъяасын хөрөнгийг хотол хураасан тул сэтгэл болно. Авахуй тийн мэдэхүй, сэтгэл, бүхний шүтэн тийн мэдэхүй, язгуурын тийн мэдэхүй, орчлон хэзээдийн цогц, сансрын гишүүн нь нэгэн утгат болой. Эс мунхрагсад бүхний шүтээний ялгавар түүнийг бүхний шүтэн тийн мэдэхүй мөн хэмээн огоот бариад машинд агуулсан нь үлэмж сайн болой хэмээжээ. Вишайг машинд ухах нь тийн мэдэхүй болой. Вишайн орныг амсах нь сэтгэл тул сэтгэлийн утга тус бүр болой. Сэтгэлийн тийн мэдэхүй нь хотол атхаг болой. Хотол атхаг нь хязгаарлал үгүй зүйлт тийн атхагууд бөгөөд маш атхагийн тул болой. Хамаг хөрөнгөтөөс сэтгэл ба тийн мэдэхүй үүснэ. Тийн мэдэхүй нь даруйтын орон ба нисванист оронг үүсгэх тул сэтгэл нь хоёр зүйл болой. Тэр нь өөрийг өгүүлэхүй авъяасын хөрөнгөөс болсон хийгээд хамаг тийн ухахуйн өгүүлэхүйн авъяасын хөрөнгөөс болсон болой. Сэтгэлийг буян, буян бус, эш эс үзүүлсэн хэмээн ангилсан ч буй.

Гэмийг машинд ангилсан байна. Үүнд: Нисванист сэтгэл үгүй болвоос эс хольцсон мунхаг үгүйн гэм гарч, хоёр үгүй өрөөсгөл харшлах ба би хэмээн баримтлахуй үгүй гэм болно.

³ Асанга, Их хөлгөний хураангуй, УБ, 2005, х1.

⁴ Дурдсан арван зүйл нь тус бүр биеэ даасан ухагдахуунууд тул урт нэрийнх нь үг тус бүрийг салгаж үзвэл эндүүрэл болно.

⁵ Асанга, Их хөлгөний хураангуй, х3.

Тавуулаа адил үгүйн гэм болох ч бий. Магадлах үг үгүйн гэм ч бий. Хуран мэдэхүй үгүй тэгш оролдохуйн гэм болон түрдэхүй тэгш оролдохуйн гэм ч буй. Нисванист бус гэм ч бий. Хуран мэдэхүй үгүйд төрөхүйн үргэлжлэл, би хэмээн баримтлах үгүйн гэм болмой. Эс хольцсон мунхаг нь үнэхээр утгат орохуй сэтгэлийн тотгор насад болсон лугаа хэв хэзээ бүхнээ гарахуй мөн. Дүрсэт хийгээд дүрс үгүйд эдлэгч нисванис мэт нь түүдээд эш эс үзүүлсэн болой. Сэтгэл нь нисванист мөний тул түүдээд эш эс үзүүлсэн мөн. Дүрсэт ба дүрс үгүйд эдлэгч сэтгэл нь амирлан ахуй бээр хамтадсан бөлгөө.

Ширвакууд хамаг мэдэгдэхүүнийг мэдэхүйд харьяат бус болой. Иймд бүхний шүтээн тийн мэдэхүйг тэдгээрт үл номложээ. Бодьсадва нар хамаг мэдэгдэхүүнийг мэдэхүйд харьяат тул тэдгээрт үзүүлжээ.

Бүхнээс нисванист номын хөрөнгө гарахуйд БШТМ-г хамаг хөрөнгөч хэмээнэ. Авьяасаар огоот эзлэгдснээр номыг баригч хэмээгдэнэ. Тачаангуй тэргүүтний авьяас гарах шалтгааны бэлгэ чанар нь тачаангуй тэргүүтэн сэтгэл болой. Энэ нь цэцгийн үнэр гарахын шалтгааны бэлгэ чанар нь цэцэг агуулсан гүнжид болохтой адил юм. БШТМ-д оршигч бүхнээс нисванист номын хөрөнгүүд нь эд ангид ч бус, тус бүр бус ч бус бөлгөө. Бүхний шүтээн тийн мэдэхүй ба бүхнээс нисванист ном тэдгээр нь нэгийн шалтгаанд нэг нь болох ажээ. Үлгэрлэвээс, зулын дөл ба гол хоёр нэгэн нэгэндээн шүтэлцэж, үл унах мэт. Элдэв зүйл авьяасаар хольцсон БШТМ нь элдэв зүйл цаглашгүй номуудыг үзүүлэх бөгөөд энэ нь их хөлгөнөө нарийн дээд гүн шүтэн барилдаж болсон болой. Үүнийг элдэв зүйлд урвуулагч үрийн будгаар бөс даавууг олон дүрээр харуулахтай зүйрлэж болно.

Заан мэт БШТМ-н мөн чанар, шалтгаан, үрийг мэдэхэд хялбар бус. Хоёр зүйл тийн ялгалт буйгаас мөн чанарын тийн ялгалт, гоо ба гоо бусын тийн ялгалт болой. БШТМ-д шүтэж ном нугууд гарсан нь мөн чанарын тийн ялгалт юм. Гоо ба гоо бусын ялгалт нь шүтэн барилдаж болсон арван хоёр гишүүн алимад тэр мөн. Эхний тийн ялгалтын мунхагууд төрөлх шалтгаанаас болсон, эрхэт бээр хувилсны шалтгаанаас болсон, өөрийн шалтгаанаас болсон, шалтгаан үгүй ба нөхцөл үгүйн шалтгаанаас болсон хэмээн атхаглана. Хоёрдугаар тийн ялгалтын мунхрагсад өөрт үйлдэгч ба идэгч хэмээн атхаглах ажээ. Тэр нь заан үл мэдэх сохор хүмүүс зааныг тэмтрээд өөр өөрийнхөөрөө төсөөлөх мэт. БШТМ-н мөн чанар нь тийн боловсролын тийн мэдэхүйн хамаг хөрөнгөч бөгөөд түүгээр гурван орон дахь хамаг биетэн ба хамаг амьтныг хураасан болой. Хамаг хөрөнгөч тийн боловсролын тийн мэдэхүй үгүй бөгөөс бүхнээс нисванис ба маш арилсан үл болмуй. Зургаан зүйл хөрөнгө байх бөгөөд тэдгээр нь гадаад, дотоод, тодорхой бус хоёр, янагуух чанар, дээд утга юм. Зургаан тийн мэдэхүй нүгүүд эзлэхүй, зорилго, даруйтын нөхцлүүдээр төрмүй. БШТМ үгүй болвоос нисванисын бүхнээс нисванис, үйлсийн бүхнээс нисванис, төрөхүйн бүхнээс нисванис үл болмой.

БШТМ-н маш ялгалыг гурван зүйл, бас дөрвөн зүйлээр ч хийдэг. Гурван зүйлээр хийсэн нь илт өгүүлэхүй авьяасын ялгал, би хэмээн үзэхүй авьяасын ялгал, сансрын гишүүний авьяасын ялгал юм. Дөрвөн зүйлээрх ялгал нь орхилго бээр сайтар ялгахуй, тийн боловсролоор сайтар ялгахуй, шалтгаанаар сайтар ялгахуй, ямагт бэлгэ чанараар сайтар ялгахуй болой. Бэлгэ чанараар сайтар ялгахуй нь ерийн бэлгэ чанар, ер бусын бэлгэ чанар, сэрэхүй үгүй төрөхүй хөрөнгийн бэлгэ чанар, сэрэхүй лүгээ сэлт төрөхүй хөрөнгийн бэлгэ чанар хэмээн ангилагдахаас гадна муу орныг авахын бэлгэ чанар, машид судалсны бэлгэ чанар гэж ч хоёр ангилагдана.

2. Мэдэгдэхүүний бэлгэ чанарыг танихуй

Мэдэгдэхүүний бэлгэ чанарыг гурван мөн чанараар барих ба тэдгээр нь бусдын эрхэт, хотол нэрийдсэн, огоот бүтсэн гурав юм⁶. Гурван мөн чанарын ёсон тус бүр бус, тус бүр бус ч бус болой. Үүнийг танин оносноор гүтгэхүй, муушаахуйн хязгаар гэмийг бүрмөсөн тэвчихэд мэргэших боломжтой. Бусдын эрхэтийн бэлгэ чанар нь аль бүхний шүтээн тийн мэдэхүйн хөрөнгөт үнэхээр бус хотол атхагаар⁷ хураасан тийн ухагч юм. Тэрбээр үнэхээр бус хотол атгагаар хураасан буй бус⁸ хийгээд эндүүрэхүй утга үзэгдэгч орон аль бүхий тэр болой. Юуны тулд бусдын эрхэт болов хэмээвээс өөрийн авъяасын хөрөнгөөс төрсөн бус, харин нөхцлийн эрхэт болой. Өөрөө оршин үл чадахын тул бусдын эрхэт хэмээгдьюү. Бүхнээ нэрийдсний бэлгэ чанар нь ямар нэг утга үгүй боловч тийн ухахуйн төдийхөн⁹ утга үзэгдэхийг илэрхийлнэ. Түүнийг зүүд тэргүүтэн үлгэрээр жишиж болох бөгөөд сэрмэгц “тийн ухахуй төдийхөн” барагдаж, тэр ямагтыг мэдсэнээр төрөх болно¹⁰. Оршихуйн утга үгүй үзэгдэл, сэтгэлийн тийн мэдэхүй хотол атхагт дүрээр төрөх шалтгаан мөн тул түүнийг бүхэн нэрийдсэн хэмээжээ. Бас өөрийн бэлгэ чанар үгүй бөгөөд бүхнээ атхаглахуй төдийд зорихын тул бүхэн нэрийдсэн хэмээгдьюү. Мөн хотол атхаг буй болоод хотол нэрийдэгдэхүүн буй бөгөөс бүхэн нэрийдсэн мөн чанар болох ажээ. Огоот бүтсний бэлгэ чанар нь алимад бусдын эрхэтийн бэлгэ чанар мөн боловч түүнд утгын бэлгэ чанар огт үгүй болой. Юуны тул огоот бүтсэн хэмээмүй хэмээвээс ашид үгүйн бэлгэ чанар огоот бүтсэн ба бусцар үл урвахуйн тул огоот бүтсэн болой. Маш арилсан зорилго болсон хийгээд хамаг буянт номын дээд мөн тул дээд утгын огоот бүтсэн хэмээгдьюү. Бусдын эрхэтийн мөн чанар нь зүйлээр бөгөөс бусдын эрхэт болой. Зүйлээр бус бөгөөс тэрхүү хотол нэрийдсэн болой. Аль нь ч биш бөгөөс тэрхүү огоот бүтсэн болой.

Эндүүрэхүйн шалтгаан хийгээд эндүүрэхүй нь дүрсийг тийн ухахуй хийгээд тийн ухахуйг дүрсэт хэмээн таалмуй. Учир нь тийн мэдэхүй нь зорилгыг тийн ухахуйн төдийхний маш ялгалт тул самадийн эдлэхүй вишайн дүрс хөрөг сэтгэлээс ангид бус болой. Үнэн хэрэгтээ дүрсийг нөхцөл болгож дүрсийг үзэвч дүрс хөргийг үзвэй хэмээн сэтгэдэг. Тэр мэт төрсөн сэтгэл түүнээс утга тус бүр болон үзэгдэнэ хэмээн номложээ. Тэдгээр сэтгэлийг тэгш агуулваас мэдэгдэхүйн дүрс хөрөг машид хөөрсөн тэргүүтэн түүнийг сэтгэн үзэхүй бөгөөд машид хөөрсөн тэргүүтэн тэргүүтэн бус утга үгүй болой. Ийнхүү тийн ухахуй бүгд тийн ухахуйн төдийхнөө оршиж буй хэрэг болно. Хамаг шүтээн болон гарахуй элдэв зүйл нь утгын төдийд үзэгдэх ба атхагт үзэгдэх гэсэн хоёр төрөл буй. Таван эрхтний эдлэхүй вишайн орныг сэтгэлээр амсах бөгөөд сэтгэл хэмээвээс эдгээрийн шүтээн болой. Тийн мэдэхүйн зургаан чуулган нь сэтгэлийн төрөн түгэхүй болой. Сэтгэлийн тийн мэдэхүйн тийн ухахуй шүтээн лүгээ сэлтийг үзэл хэмээн ухагдахуй.

Бодьсадва дөрвөн ном лугаа төгсвөөс тийн ухахуй бүгдийг утга үгүй хэмээн дотроо багтаамуй. Нэгдүгээрт, тийн мэдэхүй үл зохилдох шалтгааныг мэдэх, үлгэрлэвээс, бирд, адгуус, хүн, тэнгэр нар нэгэн бодосыг тийн ухахуй нь тус бүр байх мэт. Хоёрдугаарт, зорилго үгүй тийн ухахуйг зорьж буйг мэдэх, үлгэрлэвээс, нөгчсөн, ирээдүй, зүүдэн, дүрс хөргийг зорих мэт. Гуравдугаарт, хичээл үгүйеэ ч тэдэр буруу үгүйеэ болохуйг мэдэх буюу утгат бөгөөс утгад зорьсон тийн мэдэхүй хичээл үгүйеэ түүнийг ямагт мэдэхүйн тул тэдэр буруу

⁶ Энэ гурав нь тус бүр хоёр үгээр илэрхийлсэн ухагдахууны нэрүүд болой.

⁷ “Үнэхээр бус хотол атгаг” нь ухагдахууны нэр юм. Нэр томъёог цаашид тэр бүр онцлохгүй болохыг анхаарна уу.

⁸ “Буй бус” нь нэр томъёо мөн.

⁹ “Тийн ухахуйн төдийхөн” нь ухагдахууны нэр болой.

¹⁰ “Тэр ямагтыг мэдсэнээр” нь ухагдахууны нэр болой.

үгүйеэ болно. Дөрөвдүгээрт, өмнөх гурван зүйл мэдэхүйг даган зохилдож мэдсэнээр бодьсадва болон дияанч нарт бишрэхүйн эрхээр тэр тэр мэт тэдгээр утга үзэгдэх ба амирлан ахуйг олсон егүзэр ном дор үлэмж үзэхүйг хичээгчидээ сэтгэлд үйлдсэн төдийд утга үзэгдэхүй ба тийн атхаг үгүй бэлгэ билиг олсон түүнээ оршигчдод хамаг утга үл үзэгдмүй хэмээн номложээ. Тэр мэт бөгөөс гурван зүйл мэдэхүйг даган зохилдохуй хийгээд дээрх учир шалтгаан нугууд бээр утга үгүйеэ бүтсэн болой.

Утга нь утгатайяа бүтсэн болвоос мэдэх атхаг үгүй үл больюу. Тэр үгүйн тул бурханы хутгийг олох зохис үгүй болой. Утга үгүйн тул тийн ухахуй үгүй.

Бусдын эрхэтийн мөн чанар хоёр зүйл бөгөөд авъясын хөрөнгө бусдын эрхэт, бүхнээс нисванис хийгээд машид арилсаны мөн чанар огоот бүтсэн бусдын эрхэт юм. Мөн бүхнээ нэрийдсэний мөн чанар ч хоёр бөгөөд мөн чанараа бүхнээ атхаглах ба ялгалд бүхнээ атхаглах билээ. Огоот бүтсэний мөн чанар ч бас хоёр зүйл бөгөөд өөрийн чанараар огоот бүтсэн хийгээд маш арилсан огоот бүтсэнээр огоот бүтсэн болой.

Бүхнээ атхаг нь дөрвөн зүйл бөгөөд мөн чанарт бүхнээ атхаглахуй, ялгалд бүхнээ атхаглахуй, судалсан ба эс судалсан болой (С.Гантөмөр, 2016). Мөн чанар хэмээвээс төрөхүй үгүй, түрдэхүй үгүй, бүхнээс нисванист бус, машид арилсан бус болой. Билиг барамидыг хамаг утга хэмээвээс үл зохилдохын зүг ба ерөндөг лүгээ сэлт хэмээн ухахухуй.

Бусдын эрхэт ба огоот бүтсэний мөн чанар үгүй болвоос бүхнээс нисванис ба машид арилсан үгүйн гэмт болох билээ. Үгүйн зүйлийг үзүүлсэнээр хотол нэрийдсэний мөн чанарыг ухмуй. Илбэ, зэрэглээ, зүүд, сүүдэр, дүрс хөрөг, хадны цуурай, усан дахь саран, хувилгаан мэтээр бусдын эрхэтийн мөн чанарыг ухмуй (Очироор огтлогч, С.Гантөмөрийн орч.). Машид арилсан дөрвөн зүйл ном буюу мөн чанарын машид арилсан, хир үгүйеэ маш арилсан, олсон мөр машид арилсан дөрвийг үзүүлсэнээр огоот бүтсэний мөн чанарыг ухмуй. Болсонд шүтэж илбэ тэргүүтнийг үзүүлэв. Нэрийдсэнд шүтэж үгүйг үзүүлэв. Дөрвөн машид арилсанд шүтэж огоот бүтсэнийг үзүүлэв.

Бусдын эрхэтийн мөн чанарт бусад эндүүрэн хэр мэт үгүй эдлэлийн вишай болгомуй сэжгийг (эргэлзээ гайхширлыг) няцуулахын тулд түүний мөн чанарыг илбэ тэргүүтнээр үзүүлсэн болой. Сэтгэл ба сэтгэлээс болсон утга үгүй нугууд ямар мэт болмой хэмээх сэжгийг няцуулахын тулд зэрэглээ мэтээр үзүүлэв. Утга үгүй бөгөөс хүсэхүй ба үл хүсэхүйн чухал эдлэл ямар мэт болмой хэмээх сэжгийг няцуулахын тулд зүүдэн мэт болой. Утга үгүй бөгөөс үйл буян ба буян бус нугуудын үр хүсэхүй ба үл хүсэхүй ямар мэт илт бүтэх болмой хэмээхүй сэжгийг няцуулахын тулд дүрс хөрөг мэт болой. Утга үгүй бөгөөс ямар мэт тийн мэдэхүй элдэв зүйл болмой хэмээхүй сэжгийг няцуулахын тул сүүдэр мэт болой. Утга үгүй бөгөөс ямар мэт нэрийтгэлийн өгүүлэл элдэв зүйл болмой хэмээхүй сэжгийг няцуулахын тулд тэр хадны цууриан мэт болой. Утга үгүй бөгөөс ямар мэт үнэхээр баригч самадийн эдлэлийн вишай болмой хэмээхүй сэжгийг няцуулахуйн тулд усан дахь саран мэт болой. Утга үгүй бөгөөс бодьсадва сэтгэл тэдэр буруудсан амьтны үйлийг бүтээхийн тул санаснаархүү ямар мэт төрмүй хэмээхүй сэжгийг няцуулахын тул хувилгаан мэтийг үзүүлвэй.

Бусдын эрхэтийн мөн чанар хотол нэрийдсэн ба огоот бүтсэний мөн чанар мөний тул орчлон ба нирваныг ялгал үгүй хэмээн таалжээ. Бусдын эрхэтийн мөн чанар тэрхүү хотол нэрийдсэний хувиар орчлон болой. Огоот бүтсэний хувиар нирван болой. Ном нь бүхнээс нисванис (хотол нэрийдсэн), машид арилсан (огоот бүтсэн), тэр хоёрын харьяат (бусдын эрхэт) гэсэн гурван болой хэмээжээ. Утгын үлгэр нь алт бүхий шороо бөлгөө. Шороон махбод нь шороо ч биш, алт ч биш, харин аль альных нь харьяат болой. Галаар хүрэлцвээс алт үзэгдмүй.

Үүнтэй адилаар тийн ухахуй нь хотол нэрийдсэн ч биш, бас огоот бүтсэн ч биш. Харин тийн мэдэхүйд тийн атхаг үгүй бэлгэ билгийн галаар хүрэлцсэний тул тийн ухахуй тэр үнэхээр огоот бүтсэний мөн чанар болон үзэгдмүй. Хотол нэрийдсэний мөн чанараа үл үзэгдмүй (Т.Булган, 2010).

Бусдын эрхэтийн мөн чанар огоот бүтсэний хувьд мөнх болой. Хотол нэрийдсэний мөн чанарын хувьд мөнх бус болой. Хоёулангийн хувь бээр мөнх ч бус, мөнх бус ч бус (хоёр үгүй) болой. Тэр мэтчилэнг гурван мөн чанар хэмээмүй. Алины тул тэр мэт үзэгдэх болсон, тиймийн тул “буй” хэмээн өгүүлнэ. Ямар мэт үзэгдсэн түүнчлэн үгүй, тиймийн тул “үгүй” хэмээнэ. Өөр лүгээ мөн чанар үгүйн тул, өөрийн бодод үл оршихын тул, барьсан ёсоор тэр үгүйн тул мөн чанар үгүй хэмээжээ. Мөн чанар үгүй бээр хойд хойдод шүтэж, түрдэх үгүй, угаас амирласан ба төрөлх нирван бүтвэй. Бас дөрвөн таалал ба дөрвөн хажуу тааллаар бурханы хамаг зарлигийг дотроо багтаагдахуй.

3. Мэдэгдэхүүний бэлгэ чанараа орохуй

Мэдэгдэхүүний бэлгэ чанарт орохуй нь тийн ухахуйн төдийхөн бөгөөд түүнийг ухсанаар түйтгэр нугуудаас сэтгэл машинд ангижрах болно хэмээжээ. Буян хийгээд бэлгэ билгийн чуулганыг сайтар туурвисан бодьсадва үзэхүй мөр, бясалгалын мөр ба эцэст хүрсний мөрд ороод хамаг номыг тийн ухахуй төдийхнөө даган дурсахуйд бишрэх ба түүнийг ямар ёсоорхүү сайтар онох ба хамаг түйтгэрийн ерөндөгийг бясалгах болой. Алинаар ормой хэмээвээс сэрэмж бээр орох болой. Хүмүүн болон амьтан нугуудыг бурхан болгосугай хэмээх нь сэтгэл судлах анх болой. Барамидын бясалгалыг огоот төгсгөсүгэй хэмээх нь сэтгэл судлах хоёрдугаар болой. Буян лугаа төгөлдөр бөгөөд сац хүссээр хотол төгссөн биеийг олох нь сэтгэл судлахуй гутгаар болой. Могой хэмээх оюун мэт зургаан зүйлд үнэхээр утгыг ялгаваас тийн ухахуй төдийхөн оюун ч машинд шинжлэгдэхүүн болой. Тэр мэт бодьсадва нь сэтгэлийн өгүүлэл үзэгдэгч утгын бэлгэ чанарт орноор хотол нэрийдсэн мөн чанарт орох болой. Тийн ухахуй төдийд орсноор бусдын эрхэтийн мөн чанараа орох болой. Тийн ухахуй төдийхөн хуран мэдэхүй ч няцаж огоот бүтсэний мөн чанарт орох болой. Тэр цагт утга бээр хуран мэдэхүйг машинд эвдсэн бодьсадва түүнд утгад үзэгдэхүй бүгд гарахын завсар үгүй болой. Тийнхүү хамаг утга тийн үл атхаглах нэрд оршсон тэр цагт бодьсадва түүний зоригдохуун ба зоригч тэгширснээр тийн атхаг үгүй тэгш бэлгэ билиг төрьюү. Тиймийн тул бодьсадва энэ огоот бүтсэний мөн чанараа орох болой. Номын төвийг сайтар оносон тэр түүний үзэхүй мөр болой. Даган олсон мэдэхүй тэр нь БШТМ бүхнийг машинд төрүүлэхүй ба тийн ухахуйн хамаг бэлгэс илбэ мэт тэргүүтэнд хамагаа үзэхүй бээр өөрийн чанараар тэдэр буруу төрмүй. Тиймийн тул бодьсадва тэр илбэ үйлдсэн номуудад илбэчин мэт шалтгаан үр сэлтийг үзүүлэхүйд ч хэв хэзээд тэдэр буруу үгүй болой. Тэрбээр дөрвөн самадид оршсон бөлгөө. Утга үгүйеэ өчүүхэн хүлцэнгүйн цагт үзэгдэл олсон самадийн илчит орон буй. Их хүлцэнгүйн цагт гэгээн түгэхүй самадийн үзүүрийн орон болой. Утга үгүйд магадлахуйн цагт даган одохуй самадийн хүлцэнгүйн орон бөлгөө. Хуран мэдэхүйг машинд эвдэх цагт даруйтын самадийн номын дээд орон болой. Эдгээр самадийг илт онохуй ба ойрсол хэмээнэ.

Үзэхүй мөрийг олсон бодьсадва нар бурханы гурван биеийг олохын тулд бясалгалын мөртэй барилдах бөлгөө. Ширвакийн ил онолоос бодьсадвын ил онол арван ялгалаар ялангуяа үлэмж хэмээн ухагдахуй. Тэдгээр нь зорилгын ялгал, чухал батадсны ялгал, онолын ялгал, нирваны ялгал, газрын ялгал, огоот арилсны ялгал, сацууд олсны ялгал, төрөхийн ялгал, төрөн

гарахын ялгал, үрийн ялгал болой. Бодьсадва тэгш агуулахуй бээр сэтгэлд дүрс хөргийг үзвээс л утга бээр хуран мэдэхүйг няцуулж, өөрөө хуран мэдэхүйг магад баримуй. Баригдахуй үгүйг сайтан оноод баримтлах үгүйг ономой. Тиймийн тул зорилго үгүйеэ хүрэлцьюу. Утгийн дүр өгүүлэхүйн шалтгаанаар болсныг ономой. Өгүүлэхүй төдийд утгыг түүгээр мэдэж, тэр мэтээр сэтгэлийн төдийд оршьюу. Түүгээр хоёр бэлгэ чанараас ангижирснаар номын төв илт болмой. Сэтгэлээс өөр үгүй хэмээн оюунаар оноод тиймийн тулд сэтгэл ч үгүй хэмээн оноюу. Оюун лугаа төгсөгчид хоёуланг үгүй хэмээн ухаж, түүн лүгээ эс төгсвөөс номын төвд оршмуй. Дуртгалын үндсийг атхагийн төдий хэмээн мэдэж, эрдмийн далайн чанадыг үзүүлэн түргэнээ одьюу.

4. Мэдэгдэхүүний бэлгэ чанараа орохуйн шалтгаан ба үр

Мэдэгдэхүүний бэлгэ чанараа орохуйн шалтгаан болон үр нь зургаан барамидыг оноон бүтээхэд оршино. Бодьсадва нь эд таваар нугуудад бүхнээ тачаал үгүй, шагшабад нугуудад унал үгүй, зовлон нугуудад хямрал үгүй, бясалгалд зальхай үгүй бөгөөд зургаан барамидад шүтээд, тийн ухахуйд орох болой. Зургаан барамид нь үл зохилдохын зүг ба ерөндөгийг тэгш агуулсан, бурханы хамаг номыг үнэхээр бүтээхийн шүтээн орон, хамаг амьтныг огоот боловсруулан үйлдэхүй лүгээ зохилдох бөлгөө. Найман зүйл арилсан санааны хамаг бэлгэ чанар нь чуулган, хүлцэнгүй, зорилго, сэтгэлд үйлдэхүй, ерөндөг, мөн чанар, тэмдэг, тус эрдэм болой. Үл хэтрэхүйн шалтгааны ерөндөг нь өглөг барамид ба шагшабад барамид бөгөөд үл хэтрэхийн шалтгаан нь эд агуурсанд тачаахуй ба гэрт тачаахуй болой. Дэвшин няцахын шалтгааны ерөндөг нь хүлцэнгүй барамид ба хичээнгүй барамид бөгөөд няцахын шалтгаан нь орчлонгийн амьтан буруу бүтээлээс болсон зовлон ба өнө уртад цагаан зүгт барилдуулахуй бээр огоот уйдахуй болой. Дэвшиж няцал үгүй хомсдохын шалтгааны ерөндөг нь дияан барамид ба билиг барамид бөгөөд хомсдохын шалтгаан нь тийн алгасангуй ба цалхай билиг болой. Тийн үл алгасахуйн дөрвөн барамид буюу өглөг барамидаар амьтанд тус хүргэх ба шагшабад барамидаар амьтнаа хор үл үйлдэх ба хүлцэнгүй барамидаар хорлохуйд үл хайхрах ба хичээнгүй барамидаар үл үйлдэхүйеэ болохын тул тус хүргэхийн шалтгаан эдгээрээр амьтан нугуудыг огоот боловсруулан үйлдэхүй болох больюу. Түүний хойно тэгш эс агуулсан сэтгэлийг тэгш агуулах ба тэгш агуулсан сэтгэлийг тийн тонилгон үйлдэхийн тулд увдислан үйлдэхүй нүгүүдийг огоот боловсруулах бөлгөө. Эдгээрийн бэлгэ чанарыг зургаан дээдээр ухмуй. Дээд орон нь бодь сэтгэл орон мөний тул болой. Дээд бодос нь хотол хамгаа эдлэхийн тул болой. Дээд тусгайлан үйлдэхүй нь хамаг амьтнаа туслахуй хийгээд амарлиулахыг тусгайлан үйлдэхийн тул болой. Дээд мэргэн арга нь тийн атхаг үгүй бэлгэ билгээр огоот барихын тул болой. Дээд машид арилсан нь нисванис хийгээд мэдэгдэхүүний түйтгэрээр түйтэгдэл үгүйеэ үнэхээр бүтэхүйн тул болой. Ийнхүү барамидын үе зэргийг үзүүлж буй нь урьд барамид нугууд түүний хойно гарахуй лугаа зохилдохуйн тул болой. Барамид нугууд нь ертөнц дахин, ширвак, братикабудд нарын өглөг тэргүүтэн хамаг буянаас хэтэрхий болоод чанад одох болой. Харам хийгээд өгөхийг дарах ба их эд таваар ба буяны чуулганыг олуулахын тул өглөг болой. Цалхай шагшабад ба муу заяаг амарлиулан үйлдэхүй ба амар амьтан ба самадийг олгуулахын тул шагшабад болой. Хилин ба өшлөхүйг барагдуулан үйлдэхүй ба өөр ба бусдыг амирлуулахын тул хүлцэнгүй болой. Зальхай ба хилэнц нүглийн номуудаас ангижруулан үйлдэхүй ба буяны номыг цаглаш үгүй машид арвижуулан эцэст хүргэхийн тулд хичээнгүй болой. Тийн алгасангуйг арилгах ба сэтгэлийг дотогш ахуйг бүтээн

үйлдэхийн тул дияан болой. Үзэл болсон ба хамаг цалхай билгийг арилгах ба үнэхээр хамаг зүйл номуудыг сайтар мэдэхүйн тулд билиг болой. Эдгээрийн бясалгалыг товчлон таван зүйлд хураамуй. Үүнд: хотол явдалд барилдахуйг бясалгахуй, бишрэлийг бясалгахуй, сэтгэлд үйлдэхүйг бясалгахуй, мэргэн аргыг бясалгахуй, үйл бүтээхүйг бясалгахуй тус тус орно. Үйл бүтээхүйг бясалгах нь алин бурхадын зохиол жавхлантайяа бүтсэн үргэлж тасрал үгүй бөгөөс барамид нугуудыг огоот төгсгөхүй цагт барамидыг бясалгах болой. Сэтгэлд үйлдэхүйг бясалгах нь амтшихуй, даган баясахуй, илт баясахуй сэтгэлд үйлдэхүй, үл ханахуй санал, өнө үргэлж санал, баясахуй санал, тус хүргэхүй санал, их мөн чанарын санал, буяны санал лугаа зургаан саналаар огоот эзлүүлж бясалгах болой. Эдгээр зургаан санаагаар огоот эзлүүлсэн нь амтшилын сэтгэлд үйлдсэн бясалгал болой (Шантидэва, 2009).

Эдгээр барамидын маш ялгалыг гурав гурван зүйлээр хэмээн ухагдахуй. Өглөг нь номын, эд агуурсын, аюулгүй болой. Шагшабад нь боохуй, буян номыг хураахуй, амьтны тус үйлдэхүй бөлгөө. Хүлцэнгүй нь хор үйлдэхүйд үл хайхрахуй, зовлонг даган авахуй, ном дор магад шинжлэхүй билээ. Хичээнгүй нь хуягийн, барилдлагын, үл мятрах бөгөөд үл хямралдаад буулан үл барихуй болой. Дияан нь оршил, илт бүтээхүй, үйл бүтээхүй гурав бөлгөө. Билиг нь тийн атхаг үгүй барилдлага, тийн үл атхаглахуй, тийн атхаг үгүйн даган олсон гурав болой (Зонхов, 2020)

Үл зохилдохуйн зүгээр бүхнээс нисванис бүгдийг ямар мэт хуруувай хэмээн ухмуй хэмээвээс, түүний бэлгэ чанар, түүний шүтээн, түүний үрээр болой. Барамид тус бүрийн эрдмийг ямар мэт ухмуй хэмээвээс, орчлонд орчихуй цагт ирээдүйг хураахуй, их төрлийг хураахуй, зүг алин лугаа олон боол нөхдийг хураахуй, үйлийн их хязгаараа барилдлага бүтсэнээр огоот барихуй, хор үгүй, өчүүхэн нисванисыг огоот барихуй, урилахуй, шасдир, хамаг ухааны оронд мэргэжихүйеэ огоот барьсан, ил өндрийн гэм үгүй, бодь зүрхэнд хүрэхээ янар хамаг амьтны тус үйлдэхүйд чухал оршихуй нь бодьсатва нарын тус эрдэм болой. Эсрэг тэсрэг тийн магадыг ямар мэт ухмуй хэмээвээс, ялж төгс нөгчсөн заримуудад хамаг барамидыг өглөгийн аялгуу бээр үзүүлвэй. Заримуудад шагшабадын аялгуу бээр үзүүлвэй. Заримуудад хичээнгүйн аялгуу бээр үзүүлвэй. Заримуудад дияаны аялгуу бээр үзүүлвэй. Заримуудад билгийн аялгуу бээр үзүүлвэй.

5. Шалтгаан, үрийн бясалгал

Мэдэгдэхүүний бэлгэ чанарт орохуйн шалтгаан, үрийн бясалгал нь бодьсатвын арван газар бөгөөд тийн арилсан үлэмж санаагаар арван газарт гурван туулшгүй галавт бясалгахыг хэлнэ.

Бодьсатва нарын арван газар нь:

1. Маш баясгалант. Ямагт эн тэргүүнээ өөр бусдын тусыг бүтээхүй чадал олсны тулд маш баясгалант болой.
2. Хир үгүй. Цалхай шагшабадын хирийг холдуулсны тул хир үгүй болой.
3. Гэрэл үйлдэгч. Самади ба тэгш оролдохуй буурал үгүйн орон бөгөөд их номын гэгээний орон болсны тул гэрэл үйлдэгч болой.
4. Гэрлийн сацралт. Бодийн зүгийн ном нугуудын хамаг түйтгэрийг түлсний тул гэрэл сацралт болой.
5. Машид судлахуй бэрх. Үнэн ба ертөнцсийн мэдэхүй хоёр эсрэг тэсрэг үл зохилдохуй бээр түүнийг бүтээхүй бэрхийн тул машид судлахуй бэрх болой.

6. Илт болсон. Шүтэн барилдаж болсныг мэдэхийн орон мөний тул, билиг барамидад оршил илт болгохын тул илт болсон болой.
7. Холд одсон. Барилдлагаас болсон явдлын хязгаараа одохын тул холд одсон болой.
8. Үл хөдлөхүй. Бэлгэ ба илт хуран үйлдэгч бүгд бээр үл хөдлөхүйн тул үл хөдлөхүй болой.
9. Сайн оюут. Өөр өөртөө үнэхээр ухахуй анх мэдлийг олсны тул сайн оюут болой.
10. Номын үүлэн болой. Холицолдсоноо зорьсон хамаг номыг мэдэхүй тогтоол хийгээд самадийн хаалганаа бүхний дотор агсан үүлэн мэтээр огторгуй мэт ахуй их түйтгэр бүрхэхүй ба номын биеийг огоот төгсгөсний тул номын үүлэн болой.

Эдгээр газрыг олсныг ямар мэт ухмуй хэмээвээс, дөрвөн зүйлээр ухагдахуй. Бишрэлийг олсноор газарт бишрэхийн тул болой. Явдлыг олсноор анх газраа маш төгсгөсөн номын арван явдлыг олохын тул болой. Онолыг олсноор анх газарт номын чанарыг онож, бүгдийг онохын тулд болой. Бүтээлийг олсноор эдгээр газар дахь бясалгалын эцэст одохын тул болой.

Арван газрын мэдэгдэхүнн номын төв ямар мэт хэмээвээс, анх газраа хамагаа одохын утгат хэмээн мэдэгдэхүй. Хоёрдугаарт дээдийн утгат болой. Гуравдугаарт шалтгаан лугаа зохилдохуй утгын дээд болой. Дөрөвдүгээрт огоот барих бусын утгат болой. Тавд үндэс тус бүр үгүйн утгат болой. Зургадугаарт бүхнээс нисванист ба машинд арилсан бусын утгат болой. Долдугаарт элдэв ном тус бүр үгүйн утгат болой. Наймдугаарт хомсдохуй үгүй болоод үлэмж үгүйн утгат ба бэлгэ-дүр эрхшихүй орны утгат ба амарлихуйд эрхшихүй орны утгат болой. Есдүгээрт бэлгэ билигт эрхшихүй орны утгат болой. Аравдугаарт үйлд эрхшихүй орны утгат ба тогтоол хийгээд самадийн хаалганд эрхшихүй орны утгат хэмээгдьюү.

Эдгээр газрын бясалгалыг ямар мэт ухмуй хэмээвээс, бодьсадвын газар, газраа амарлин ахуй, үлэмж үзэхүйг бясалгахдаа таван зүйлээр бясалгах бөлгөө. Тэдгээр тав нь холицуулан бясалгахуй, бэлгэ үгүйеэ бясалгахуй, жавхлантайяа бүтсэнээ бясалгахуй, бадруулан бясалгахуй, булилан барил үгүйеэ бясалгахуй бөгөөд энэ тавыг бясалгаснаар бодьсадва нарын таван үр илт бүтээх бөлгөө.

Зургаан барамид дээр нэмж дөрвийг бясалгах бөгөөд мэргэн аргын барамид нь урд зургаан барамидаар буяны үндсийг хурааснаа хамаг амьтан лугаа ерөнхий болгож, дээр үгүй үнэхээр туулсан бодит огоот зорихын тул болой. Ерөөл барамид нь хойт төрөлд элдэв ерөөлийг илт бүтээхүй бээр барамидын нөхцлийг хураахуй тул болой. Хүчин барамид нь өөр өөрөөр ухахуй хийгээд бясалгалын хүчээр зургаан барамидыг үргэлж тасрал үгүйеэ хотолд эдлэхийн тул болой. Бэлгэ билгийн барамид нь зургаан барамид нугуудыг маш агуулах бөгөөд бэлгэ билгээр номыг төгс эдлэн амсахуй ба амьтныг огоот боловсруулан үйлдэхүй тул болой. Арван газрын бясалгалыг таван бодгал огоот төгсгөх бөгөөд тэдгээр нь бишрэлээр эдлэгч, үлэмж амарлисан санаанаа эдлэгч, бэлгэд эдлэгч, бэлгэ үгүйд эдлэгч, илт хуран үйлдэхүй үгүйеэ эдлэгчид мөн.

6. Үлэмж шагшаабал

Үлэмж шагшаабал нь бодьсадвын санваар бөгөөд бодьсадвын гурван суртал нугуудыг огоот төгсгөн үйлдэхэд чиглэнэ. Үлэмж шагшаабадын ялгал нь маш ялгалын ялгал, ер суртал, ер бусын ялгал, ахуй ихийн ялгал, гүний ялгалаар ялангуяат хэмээн ухах болой. Дөрвөн зүйл ялгалаар бодьсадва нарын шагшаабадын санваар ялангуяат хэмээн ухагдахуй. Маш ялгалын ялгал нь боохуй шагшаабал, буянт номын хураангуй шагшаабал, амьтны тусыг үйлдэхүй шагшаабал болой. Бодьсадва нарын шагшаабал нь бие, хэл, сэтгэлийн болой. Ширвакууд нь ямагт бие, хэлний болой.

7. Үлэмж сэтгэл

Үлэмж сэтгэл нь баатархан явахуй ба огторгуйн сан тэргүүтэн самади нугууд бөгөөд зургаан зүйл маш ялгалаар ухагдана. Үлэмж сэтгэлийн ялгалыг зургаан маш ялгалаар ухагдахуй. Тэдгээр нь зорилгоор, элдэв зүйлээр, ерөндөгөөр, үйлд болохуй бээр, илт бүтээхүй бээр, үйлээр сайтар ялгахуй болой. Арван зүйл бэрх явдлыг илт бүтээхүйн тул бөгөөд тэдгээр нь аман авахуй, үл няцахуй, илт зүглэхүй, үл халдахуй, бишрэхүй, онохуйяа, дотроон багтаахуй, үл ялгах бүхнээс нисванис үгүй, барилдуулахуй болой.

8. Үлэмж билиг

Үлэмж билиг нь тийн атхаг үгүй бэлгэ билиг бөгөөд түүний мөн чанарыг тодруулан үйлдэх мөн. Мэдэгдэхүүн лүгээ ялгал үгүй аль тэр мэдэл нь атхаг үгүй болой. Машид шинжлэгдэхүүн үгүйн тулд хамаг номууд мөн чанараар алины тул атхаг үгүй хэмээн таалмуй. Таван зүйл орныг огоот тэвчихийн тул үл оршихын ёсоор огоот төгсгөн үйлдмүй. Тэдгээр тав нь би хэмээн баримтлахуйн орныг, тийн атхагийн орныг, орчлон хийгээд нирваны хоёр хязгаарын орныг, булилан барихуй орныг, нирваны төвийн орныг тус тус огоот тэвчих болой (Лувсанбалдан (Оргиочийн лам), 2009).

9. Тэвчсэн үр

Тэвчсэн үр нь оршил үгүй гаслангаас нөхчсөн мөн бөгөөд оршил үгүй нирван алимадыг онох болой. Бодьсадва нарын тэвчихүй нь оршил үгүй нирван алимад болой. Түүний бэлгэ чанар нь алин нисванисыг огоот тэвчихүй лүгээ сэлт ба орчлонг огоот үл тэвчихүйн орон бөгөөд орон урвасан болой. Орчлон нь бусдын эрхэтийн чанар бөгөөд бүхнээс нисванисын хувьд харъяат болой. Нирван нь тэрхүү машид арилсны хувьд харъяат болой. Орон нь тэрхүү хоёулангийн хувьд харъяат бөгөөд бусдын эрхэтийн чанар болой. Бусдаа урвасан нь алин бусдын эрхэтийн мөн чанар мөнхүү түүний ерөндөг төрвөөс аль бүхнээс нисванисын хувь няцаад машид арилсны хувьд урвах болой. Урвасан нь зургаан зүйл болой. Онож урвасан нь газарт орсон бодьсадва нарын бөгөөд зургадугаар газар хүртэл тэр ямагт ба тэр ямагт бус үзэгдэл чухал оршихын тулд болой. Бясалгалаар урвасан нь түйтгэрт нүгүүдийн бүгд аравдугаар газар хүртэл хамаг бэлгэс үл үзэгдэх ба тэр ямагт үзэгдэхийн тулд болой. Үр огоот төгс урвасан нь түйтгэр үгүй нүгүүдийн бөгөөд хамаг бэлгэс үл үзэгдэх ба маш тийнхүү арилсан тэр ямагт үзэгдэхүй ба хамаг бэлгэс эрхшил олсны тулд болой. Урвасан доорд нь ширвакууд бөгөөд бодьгалын би үгүйг онохуй ба орчлонгоос машид буруу зүглэхүй бээр орчлонг маш огоот тэвчихийн тул болой. Урвасан ахуй эх нь бодьсадва нарын бөгөөд номын би үгүйг онохуй ба мөнхүү түүнийг амарлиснаа үзэхүй бээр бүхнээс нисванисыг тэвчээд огоот үл огоорохуйн тул болой. Ахуй их урвасны тус эрдэм нь гэвэл өөрийн орон урвасны шалтгаанаар орчлонгийн хамаг номд эрхшил олсны тул бөгөөд хамаг амьтанд хамаг амьтны биеийг үзүүлэхүй бээр номхотгохуй элдэв уран аргыг илт үзүүлэхүй ба гурван хөлгөнүүдэд номхотгон зохиохуй болой. Орчлон хийгээд нирваныг адил мэдэхүй цагт орчлон нь нирван болох тул орчлонг тэвчих бус, үл тэвчих бус, түүний тул нирваныг ч олох бус, үл олох бус бөгөөд тэр мэт тэвчихийн ялгалыг үзүүлж бүрүн.

10. Тэвчсэн үрийн бэлгэ билиг

Тэвчсэн үрийн бэлгэ билиг нь бурханы гурван биеийн мөн чанар бөгөөд тэдгээр нь мөн чанарын бие, төгс жаргалангийн бие, хувилгаан бие ажээ. Мөн чанарын бие нь аль түүнчлэн ирэгсдийн номын бие бөгөөд хамаг номд эрх орчуулахуй орон мөний тулд болой. Төгс жаргалангийн бие нь аль бурханы элдэв нүгүүдийн мандлыг сайтар ялгахуй ба номын биед шүтсэн бөгөөд бурханы огоот арилсан орон ба их хөлгөний номын төгс эдлэлийг эдлэхийн тул болой. Хувилгаан бие нь аль номын биед шүтсэн бөгөөд Түшида орноо оршисноос эхэлж егүүтгэхүй ба мэндлэхүй ба хүслийг эдлэхүй ба илт гарахуй ба тиртиг нарын дэргэд ажрахуй ба бэрхийг эдлэхүй ба илт туулсан бодьчид ба номын хүрднийг эргүүлэхүй ба их пари нирваныг хамагаа үзүүлэхүйн тул болой. Бурхадын бэлгэ чанар нь номын бие бөгөөд таван бэлгэ чанарт хэмээн ухагдахуй. Орон урвасны бэлгэ чанар нь хамаг түйтгэр бүхнээс нисванисын хувьд харьяат бусдын эрхэтийн мөн чанар машид няцваас л маш арилсны хувьд харьяат бусдын эрхэтийн мөн чанарт болсны тул болой. Цагаан номын өвөрчлөлийн бэлгэ чанар хэмээвээс зургаан барамидыг огоот төгсгөөд арван эрхийг олсны тулд болой. Өглөг барамид огоот төгссөн тул насанд эрхшисэн, сэтгэлд эрхшисэн, хэрэгт эрхшисэн болой. Шагшабад барамид огоот төгссөний тул үйлд эрхшисэн, төрөлд эрхшисэн болой. Хүлцэнгүй барамид огоот төгссөн тул бишрэхүйд эрхшисэн болой. Хичээнгүй барамид огоот төгссөн тул ерөөлд эрхшисэн болой. Дияан барамид огоот төгссөн тул таван зөн билгээр хураасан рид хувилгаанд эрхшисэн болой. Билиг барамид огоот төгссөн тул бэлгэ билигт эрхшисэн, номд эрхшисэн болой. Хоёр үгүй бэлгэ чанар нь буй ба үгүй, хоёр үгүй бэлгэ чанараар хамаг ном бод үгүй ба хоосон чанарын бэлгэ чанарт бод мөний тулд болой. Сэтгэш үгүй бэлгэ чанар нь маш арилсан түүнчлэн чанар тэр тус тус өөрөө ухагдахуун ба ертөнцөд үлгэр үгүй ба шинжлэлтний эдлэлийн вишай бусын тул болой. Мөнх бэлгэ чанар нь маш арилсан түүнчлэн чанарын бэлгэ чанар ба эртний ерөөлийн хүчин ба үйл огоот эс төгссөний тул болой (Жадамба судар, 2014).

Дүгнэлт

1. Их хөлгөний судлагдахуун нь мэдэгдэхүүний орон, түүнийг онохуйн мөр, мөрийн үр гэсэн гурван цогц хэсгээс бүрдэж байна.
2. Арван зүйл үлэмж ялгалын гурав нь мэдэгдэхүүний оронд хамаарна.
3. Арван зүйл үлэмж ялгалын тав нь онохуйн мөрийг тодруулж өгдөг.
4. Арван зүйл үлэмж ялгалын хоёр нь мөрийн үрийг тодорхойлдог.

Ашигласан ном

1. Асанга. (2005). Их хөлгөний хураангуй ба Абхидхарма бүхнээс түүсэн.
2. Жадамба судар. (2014). Бугат Л.Алтангэрэлийн шинэ орчуулга.
3. С.Гантөмөр. (2016). Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: шинжлэх ухааны хэсэг, Боть 5. УБ.
4. Билгийн зүрхэн судар (2010).
5. Т.Булган. (2010). Буддын философийн дэвтэр.
6. Шантидэва. (2009). Гэгээрлийн зам (Бодичарьяаватара).

7. Лувсанбалдан гавж (Оргиочийн лам). (2009). Бодьсадвын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар. Т.Булганы орчуулга.
8. Богд Зонхов. (2006). Бодь мөрийн зэрэг (Ламрим).
9. Шүтэн барилдлагын магтаал сайн номлолын зүрхэн хэмээх оршивой. (2006). МБШТөв Гандантэгчэнлин хийд.
10. Очироор огтлогч хэмээх их хөлгөн судар. С.Гантөмөрийн орчуулга.
11. Дармапада. (2007).
12. Сорхугтан. (2008). Хөх Монголыг ний хэмээр бадраах хутагтай дөрвөн нэүрит их засгийн алтан дээд үнэний аялгуу.
13. Х.Дондог. (2010). Монголоо эрсэн монгол
14. Богд Зонхов. (2020). Дунд бодь мөрийн зэрэг.

4.4. Дүйра буюу нотлох арга аргачлалын тухай

Нотлох ухааны суурийн тухай

Билиг ухааны сургааль нь Монголчуудын уламжлалт сэтгэлгээний соёлд хамаарна. Ганжуур, Данжуурын олон боть судрын агуулгыг Алтангэрэл, Доржжодба, Билгийн зүрхэн, Жадамба зэрэг их хөлгөн судрууд болон Бодь мөрийн зэрэг, Шүтэн барилдлагын магтаал, Гэгээрлийн зам, Дармапада зэрэг бүтээлүүдээр дамжуулан уншиж, өргөө гэртээ шүтэн залж ирсэн түүхтэй. Монголчууд өрх гэрийн өндөр соёлтой, айлын засаглалтай (Сорхугтан. 2008) хүчирхэг гүрнийг байгуулж, дэлхийн талыг захирч явсан удаатай. Тэрхүү соёлыг социализмын үед гээгдүүлснээр гадныхан түүнийг эзэмшээд бидэнд эргүүлээд заах шахам болж буй (С.Гантөмөр) нь хачирхалтай. Иймд одоо дахин сэргээх боломжийг ашиглах ёстой (Х.Дондог. 2010) юм. Өнөөгийн Монголын нийгмийн ороо бусгаа цаг үед өөрөө өөрийгөө танин зөв залж явах ухаан нэн эрэлт хэрэгцээтэй бөгөөд тэр нь билиг ухаан мөн билээ. Билиг ухаан нь оршихуйг бүхлээр нь танин мэдэх хандлага, зохист оршихуйн ухаан мөн. Өөрөөр хэлбэл, алив объектийг бутаргаж задлахгүйгээр түүний оршихуйн илрэл, уг шалтгаан, нөхцөл, бусадтайгаа уялдах, холбогдох байдал, дотоод хийгээд гадаад шүтэлцээ, хүртэгдэх, танигдах, ойлгогдох, таалагдах, үл таалагдах зэрэг байдлыг нь олон талаас нь зэрэг танин мэдэх замаар түүнд нийцтэй, тэнцвэртэй, харилцан хүндэтгэлттэй орших ухаан юм (Т.Булган, 2010). Оршихуйн ухаан нь юуны өмнө бодит юмс, хүний ухамсар хоорондын нарийн төвөгтэй, төөрөгдөлтэй асуудлыг нотлохуйн арга ухаанаар цэгцэлж, өөртөө зөв баримжаа олж, уужуу тайван амьдрахад тусална. Тухайлбал, дөрвөн итгэмжийн онолын хүрээнд итгэмжийг ном-бодьгал, утга-үг, магад утга-татах утга, билиг-гийн мэдэл гэсэн дөрвөн хос тус бүрийн дотор алинд илүү итгэх ёстойг хэлж өгснийг жишээгээр дурдая. Ярьж хэлж буй хүний алдар нэр, гавъяа шагнал, цол хэргэм зэрэгт бус, түүний эрдэм номонд нь илүү итгэмжлэх хэрэгтэй, эсвэл үгийн утга найруулга, яруу байдалд бус утганд нь илүү итгэмжлэх хэрэгтэй гэх мэт (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Дөрвөн итгэмжийн онол.

<i>Итгэмжлэх дөрвөн зүйл</i>	<i>Үл итгэмжлэх дөрвөн зүйл</i>	<i>Тайлбар:</i>
Ном	Бодьгал	Яруу алдар тэргүүтнийг үл дагах
Утга	Үг	Үгийн найруулгад үл татагдах

Магад утга буюу өгүүлэх утга	Татах утга	Үндсэн утгыг барих, туйлын зүй тогтлыг харах хэрэгтэй.
Билиг билгүүн	Тийн мэдэл	Сэтгэлийн атгаг мэдэл бодолд үл автах

Дараагийн нэгэн чухал ойлголт бол мэдэгдэхүүний орон юм. Орны орших ёсыг нотлохуйн ухаан буюу учир шалтгааны ухаанаар мэднэ. Оюун ухаанаар танин барьж буй зүйл нь мэдэгдэхүүн болно. Мэдэгдэхүүний бэлгэ чанар нь орон болой. Ерөнхий ухамсар нь орныг оносон ухамсар ба орныг эс оносон ухамсар гэж хоёр хуваагдана. Тухайлбал, хэтрүүлэх ба гүжирдэх нь орныг эс оносон ухамсарын хоёр төрөл юм. Хэтрүүлэх нь байхгүйг байгаад үзүүлэхийг хэлдэг бол гүжирдэх нь байгааг байхгүйд үзүүлэхийг хэлдэг.

Оюун ухаан тухайн утгаа онохдоо нотолгоо, эсвэл үнэн үгэнд харгалзах шаардлагатай эсэхийн үүднээс оронг гурав хуваан үзнэ (С.Гантөмөр, 2016). Үүнд:

1. Үзэгдэх ил бологч орон нь нүдний мэдлээр дүрсийг үзэх мэт, галыг өөрийг нь харах мэт зүйл.
2. Өчүүхэн далд бологч орон нь утаа харсан нотолгоогоор холын даваан дээр гал байгааг мэдэх мэтээр бодит хүчний даган жишигчээр нотлогдох зүйл.
3. Машид далд бологч орон нь төрөлхтний хуурмаггүй үгэнд тулгуурлах буюу итгэмжилсэн даган жишигчээр нотлогдох зүйл.

Эдгээр гурван орноор нотлогдож буй байдлыг “гурван ажиглалаар ариуссан” гэж хэлдэг.

Машид далд бологч оронд эшийг шалгагч нотолгоо болгохдоо дараах шаардлага тавигдана (Т.Булган, 2010):

- Эшийн утга нь илт мэдэл ба нотлохуй ухаанаар үл үгүйсгэгдэх
- Эшийн үг нь ил далд ба урьд хойтын зөрчилгүй
- Эшийг номлогчид өөр хэрэг зорилго байхгүй г.м.

Дараагийн бас нэгэн чухал ойлголтуудад нотлохуйн дөрвөн ухаан орно. Үүнд:

1. Жам ёсны нотлох ухаан. Жам ёсны ухаан гэдэг нь юмс үзэгдэл өөрийн жамаар орших мөн чанар юм. Жишээ нь гал халаадаг, ус норгодог гэх мэт. Бодит юмс өөрийн үргэлжлэлийг үүсгэх нь жам ёсонд бас орно. Гал халуун байх нь ч түүний жам ёс мөн гэх мэт. Жам ёсны ухаанд тулахын цагт мэдүүлэн үйлдэгч буюу тодруулсан номлолын хязгаар гүйцнэ.
2. Үйлчлэл үзүүлэхүй буюу нөлөөллийн нотлох ухаан. Үйл үйлдэх ухаан нь өөрийн үйлийг үйлдэх мөн чанар юм. Тухайлбал, “нүд дүрсийг харах”, “гал юмыг халаах, шатаах” гэх мэт. Уг шалтгаан, нөхцөл шалтгаан, тэдгээрийн дан болон хам үйлчлэлээр үр дагаврын онцгой ялгамжаа үүсгэхийг энд бас хамааруулна.
3. Хамаарлын нотлох ухаан. Хамаарлын ухаан нь хоёр төрөл байна. Үүнд: төрлийн хамаарал нь үр дагавар нь өөрийн уг шалтгаан, нөхцөлд хамаарахыг илтгэнэ. Тухайлбал, тариа үрээс ургана. Нэрийтгэлийн хамаарал нь нэгж-бүхэл, гишүүн-чуулган гэх зэргийг хамарна. Аяганы хэлтэрхий, үгийн үсэг гэх мэт.
4. Зохистойн нотлох ухаан. Үр дагаврын онцлогыг уг шалтгааных нь чадамжаар тайлбарлах, эсвэл одоогийн байдлаар нь ирээдүйн байдлыг нь гаргаж хэлэх хоёр багтана. Тааруулан нотлох ухаан нь үйлдэхүйгээс мөнх бус болохыг, утаа байгаагаас гал байгааг нотлох зэргийг хамаарна.

Мэтгэлцээний үед асуултын хариултыг дөрөв ангилж үзсэн байдаг. Үүнд:

1. Нэг чигт эш үзүүлсэн – нэг тал руу нь шийдсэн хариулт.
2. Нэн ялгаад эш үзүүлсэн – Мөнх бус бүгд дүрс мөн үү? гэвэл торж тулагчид нь дүрс мөн, мэдрэмж сэрэхүйтнүүд нь дүрс биш гэх мэт нэн ялгаад хариулах.
3. Асуугаад эш үзүүлсэн – Энэ мод урт уу, богино уу? гэвэл юунд харгалзуулаад асуув? хэмээн асуугаад, хэрвээ түүнээс богинуудад харгалзуулбал урт мөн, харин түүнээс уртуудад харгалзуулбал богино мөн.
4. Орхиж эш үзүүлсэн – түр хариулт эс өгөх гэх зэргээр дөрөв хуваана.

Мөн түүнчлэн нотолгооны үед гарч болох алдааг “үг, ухамсар, утга гурвын гэм” хэмээн ангилдаг. Үүнд:

- Гурвалсан ёс нь утгандаа оршивч мэтгэлзэгч ба хойдын мэтгэлзэгчийн шалгагчаар эс нотлогдвоос ухамсрын гэм мөн.
- Гурвалсан ёс нь утгандаа шалгагчаар эс нотлогдвоос утгын гэм мөн.
- Гурвалсан ёсыг илүү эсвэл дутуу өгүүлвээс үгийн гэм мөн.

Нотолгооны арга, аргачлалын тухай

Орны орших ёсыг нотлохуйн ухаан буюу учир шалтгааны ухаанаар мэднэ. Билиг ухааны уламжлалд нотлохуйн ухаан нь ном хаялцах урлаг (дүйраны нотлох арга) болж хөгжиж ирсэн түүхтэй. Нотлох ухаанд сургахдаа бусдын ёсыг няцаах, өөрийн ёсыг агуулах, маргааныг шийдэх гэсэн гурван аргачлалыг хэрэглэдэг. Энэ ёс нь нотлохуйн ухаанд сэтгэлээс бологчийг задлах хамгийн чухал нэг арга, судалгаанд орохуйн зам, утгыг бүрэн гүйцэт мэдэж авах боломж гэж үзнэ. Дараах хялбаршуулсан сэдвүүдийн хүрээнд сургалтыг явуулдаг байсан ажээ (С.Гантөмөр, 2016). Үүнд:

1. Улаан цагаан өнгө
2. Бэлгэ чанар ба бэлгэдэхүүн
3. Нэг ба салангад
4. Ерөнхий ба зүйл
5. Эдийн ном ба эсрэг ном
6. Харшлахуй ба барилдахуй
7. Үгүйсгэл ба бүтэхүй г.м.

Ямар нэгэн утгыг судлахдаа бусдын буруу үзэл баримтлалуудыг дурьдаад тэдгээрийг няцааж, түүний дараа өөрийн үзэл баримтлалуудыг илэрхийлж, түүнд бусдаас өөнтөглөвөөс тэдгээр өө сэвийг няцааж, өөрийн үзлээ хамгаалж үлдэх байдлаар хандана.

Нотолгоонд дараах хосуудыг ялгах хэрэгтэй гэж сургасан байдаг. Үүнд:

1. Байгаа гэж эс нотолсон ба байхгүй хэмээн нотолсон хоёрын ялгааг гаргах
2. Утга түүнийг эс олсон ба утга түүнийг байхгүй хэмээн олсон хоёрын ялгааг гаргах
3. Утга түүнийг мөн гэж эс нотолсон ба биш хэмээн нотолсон хоёрын ялгааг гаргах
4. Утга түүнийг мөн гэж эс оносон ба түүнийг биш гэж оносон хоёрын ялгааг гаргах.

Дүйраны нотлох аргаар мэтгэлцэх үед үгийн утгыг гурван гол хэсэг буюу нотолгоо, тодруулга, мэтгэлцээний суурь гуравт хуваагаад хэтрүүлгийн ёсоор тулгахын үүднээс няцааж, нотолж үйлдсэнээр хоёр талын мэтгэлзэгч хоорондын маргаан нь туйлын үр дүнтэй болно.

Нотлол нь гурвалсан ёс болой. Тэр нь зүгийн ном, дагах магадлал, буцах магадлал лугаа гурав. Зүгийн ном нь дуу байгаа тохиолдолд “Үйлдэхүйн нотолгоогоор дуу мөнх бусыг нотлох”-ын дагах магадлал нь “үйлдэхүй зөвхөн мөнх бусад буй”, “үйлдэхүй ба мөнх бусын барилдлагыг

мэдсэн” байхад бүтнэ. Харин буцах магадлал нь “үйлдэхүй мөнхөд байхгүй”, “үйлдэхүй ба мөнх бусын барилдлагыг мэдсэн” байхад бүтнэ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Нотолгооны хүснэгт “Дуу номт, мөнх бус мөн шүү дээ, үйлдэхүй мөн учираас”

<i>Номт</i>	<i>Нотлогдохуун ы ном</i>	<i>Үгүйсгэгдэхүүни й ном</i>	<i>Нотолго о</i>	<i>Нотлогдохуу н</i>	<i>Үгүйсгэгдэхүү н</i>
Дуу	Мөнх бус	Мөнх	Үйлдэхүй	Дуу мөнх бус	Дуу мөнх

Гурвалсан ёсыг нийтлэг байдлаар хэрэглэнэ. Тухайлбал, дүрс мөнх бус хийгээд агшинт хэмээх далд юмсыг мэдэхэд гурвалсан ёс бүрдсэн алдаагүй нотлолыг шүтэх хэрэгтэй юм. Учир шалтгааныг нотолгоо болгоно. Жишээ нь, утаа нь гал байгаагийн нотолгоо болно. Нотлон үйлдэгч, нотолгоо, учир шалтгаан, нотлол, мэдэн үлдэх зэрэг нь нэг утгатай.

Хэтрүүлгийн утга төгөлдөр бүтэц нь зөв нотолгооны гурвалсан ёс үүсгэнэ. Хэтрүүлгийн жишээ (Хүснэгт 3): Дуу номтоо, эс үүдсэн мөн үү? Мөнх мөний тул.

Хүснэгт 3. Хэтрүүлгийн жишээ

<i>Суурь</i>	<i>Тодруулга буюу хэтрэх зүйл</i>	<i>Нотолго о</i>	<i>Андгай /баримтлал</i>	<i>Бодит алба</i>	<i>Эсрэг ном</i>	<i>Эсрэг нотолгоо</i>
Дуу	Эс үүдсэн	Мөнх	Дуу үл үйлдэхүй	Мөнх мөн бол үйл үйлдэхүй мөн байх албатай	Үйлдэхүй	Мөнх бус

Тодруулгад “зөвшөөрөв” эсвэл “яагаад” гэж хариулна. Нотолгоонд “нотолгоо эс бүтэв” эсвэл “албагүй” гэж хариулна. Мөн “алба харшлав” эсвэл “эргэлзэв” гэсэн хариултауд бий.

Хэтрүүлгийн аргаар нэг талыг буюу нэг хязгаарыг баригч буруу атгагыг буцаана. Хэтрүүлэг нь гурван нөхөр шууд харшилсныг ухамсрын оронд тодорхой үзүүлдэг. “Нотолгоо эс бүтэв”, “Албагүй”, “тийм” гэсэн гурван хариултын алийг ч хэлж хариулж чадахгүй болсон тохиолдолд “гурван нөхөр шууд харшилаа” хэмээн өгүүлнэ. Тэр цагт зөв хэтрүүлэг болно. Хэтрүүлгээр арилгах буруу атгаг нь голлон олдмол хэтрүүлэгч хийгээд гүжирдэгчүүд мөн.

Хэтрүүлэг гэдэг нь “тэгж хэтрэх болно” гэж өгүүлэх замаар цаад мэтгэлцэгчийн буруу баримтлалыг зөрчилд хүргэх байдлаар бурууг нь үзүүлэх арга юм. Жишээ нь, цаад хүн “Дууг мөнх” хэмээн эргэлзээгүй хүлээн зөвшөөрсөн гэе. Тэгвэл “Дуу номт, үл үйлдэхүй мөн үү, мөнх мөн учраас” гэж хэлнэ. Гэтэл цаад хүн “дуу нь шалтгаан нөхцлөөр үйлдэгдсэн”-ийг мэдэх учраас “үл үйлдэхүй” биш гэдгийг зөвшөөрөхгүйд хүрнэ. Өөрөө өөртэйгээ зөрчилдөж, буруу атгагаа ойлгоно. “Дуу номт, үл үйлдэхүй мөн үү, мөнх мөн учраас”.

Хэтрүүлгийг дотор нь зөв хэтрүүлэг, буруу хэтрүүлэг гэж хоёр ангилна. Зөв хэтрүүлгийг дараах байдлаар хоёр ангилна. Үүнд:

- Нотлон үйлдэгчийг шидэгч (эсрэг утгандаа гурвалсан ёсыг бүрдүүлсэн)

Жишээ: дуу мөнх, иймд тэр үл үйлдэхүй байх албатай, мэтгэлцэгч нь дууг үйлдэхүй гэдгийг мэддэг. Түүнийг “Дуу номт, үл үйлдэхүй мөн үү, мөнх мөн учраас” гэсэн хэтрүүлгээр хэлнэ. Ингэснээр “Дуу номт, мөнх бус шүү дээ, үйлдэхүй мөн учраас” гэсэн зөв найруулгын нотолгооны гурвалсан ёсыг ухамсрын оронд нь шидэж буй хэрэг юм.

- Нотлон үйлдэгчийг үл шидэгч (эсрэг утгандаа гурвалсан ёсыг эс бүрдүүлсэн)

Жишээ: Бодьгал нь “дууг үйлдэхүй гэж шалгагчаар нотолж”, “мөнх гэдгийг хүлээн зөвшөөрлөөр нотолсон”, “Үйлдэхүй байхад мөнх бус байх албыг шалгагчаар нотолсон” байгаа бол түүнд “Дуу номт, мөнх бус мөн үү, үйлдэхүй мөн учраас” хэмээсэн хэтрүүлгийг хэлэх мэт.

- Буруу хэтрүүлэг нь “Хуран үйлдэхүй мөн үү?”, “Хуран үйлдэхүй мөн учраас”, “Хумх номт, бодит мөн үү, бодит мөн учраас” гэх мэтээр дутуу, алдаатай хэлбэрүүдээр илэрдэг.

Хэтрүүлгийг мөн нарийвчлан бодитой дөрөв, чанх буруу дөрөв гэж бүлэглээд нийтдээ “хэтрүүлгийн магадлалын найман алба” нэрээр задлан шинжилнэ (Хүснэгт 4).

Хэтрүүлгийн найман албын нэрийг хүснэгтээс уншихдаа бодитой дагах алба, чанх буруу дагах алба, бодитой уруу алба, чанх буруу уруу алба, бодитой буцах алба, чанх буруу буцах алба, бодитой харшилах алба, чанх буруу харшилах алба хэмээн хүснэгтийн мөр баганыг хосоор нийлүүлж уншина.


Хүснэгт 4. Хэтрүүлгийн магадлалын найман алба

	Бодитой 4 алба	Чанх буруу 4 алба
Дагах	Нотолгоо мөн бол тодруулга мөн байх албатай. <i>Хумх номт, мөнх бус мөн үү, <u>үйлдэхүй мөн учраас.</u></i>	Нотолгоо мөн бол тодруулга биш байх албатай. <i>Хумх номт, мөнх бус мөн үү, <u>үл үйлдэхүй мөн учраас.</u></i>
Уруу	Тодруулга мөн бол нотолгоо мөн байх албатай. <i>Хумх номт, <u>мөнх бус мөн үү</u>, үйлдэхүй мөн учраас.</i>	Тодруулга мөн бол нотолгоо биш байх албатай. <i>Хумх номт, <u>мөнх бус мөн үү</u>, үл үйлдэхүй мөн учраас.</i>
Буцах	Тодруулга биш бол нотолгоо биш байх албатай (Эсрэг ном нь мөн бол эсрэг нотолгоо нь мөн байх). <i>Хумх номт, мөнх бус мөн үү, үйлдэхүй мөн учраас. <u>Мөнх мөн үү</u>, үл үйлдэхүй мөн учраас.</i>	Тодруулга биш бол нотолгоо биш нь биш байх албатай (Эсрэг ном нь мөн байхад эсрэг нотолгоо нь биш байх). <i>Хумх номт, мөнх бус мөн үү, үл үйлдэхүй мөн учраас. <u>Мөнх мөн үү</u>, үйлдэхүй мөн учраас.</i>
Харшилах	Нотолгоо мөн бол тодруулга биш байх албатай. <i>Хумх номт, мөнх бус мөн үү, үйлдэхүй мөн учраас. Хумх номт, мөнх мөн үү, <u>үйлдэхүй мөн учраас.</u></i>	Нотолгоо мөн бол тодруулга биш нь биш байх албатай. <i>Хумх номт, мөнх бус мөн үү, үл үйлдэхүй мөн учраас. Хумх номт, мөнх мөн үү, <u>үл үйлдэхүй мөн учраас.</u></i>

“Мөн бишийн дөрвөн тал” гэсэн аргачлалаар дүйраны нотлохуйн ухааны үүднээс мэдэгдэхүүний орныг ялган шинжилдэг. Тэдгээр дөрөв нь гурван тал, дөрвөн тал, харшлахуй, нэг утгат зэрэг юм. Гурван тал ба дөрвөн талыг тооцох ёс нь хоёр зүйлийн хооронд ямар ялгаа

байгааг тодотгох арга юм. Түүнийг математикийн олонлогийн харьцаанд харгалзуулан орчин үеийн хэлээр тайлбарлаж болно.

Жишээ 1: Хүн ба төвд хүн хоёрын ялгааг гурван талаар илэрхийлнэ (Зураг 1).



- Төвд хүүхэд бол тэр хоёрын хоёулангийнх нь тал. Энэ нь математикийн хэлээр $A \cap B$ хоёр олонлогын огтлолцолд харгалзана.
- Энэтхэг хүн нь хүн мөн боловч төвд хүн биш тал. Иймд энэ нь $A \setminus B$ олонлогын B -тэй огтлолцохгүй үлдэх хэсэгт харгалзана.

- Хумх зэрэг амьгүй зүйл нь тэр хоёрын алиных нь ч тал биш. Энэ нь $A \cup B$ болон $B \cup A$ олонлогын нэгдлийн үгүйсгэл болсон олонлогт харгалзана.

Жишээ 2: Модны мужаан ба төвд хүн хоёрт дөрвөн тал буй (Зураг 2).

- Төвдийн мужаан нь тэр хоёулангийнх нь тал. Энэ нь $A \cap B$ олонлогуудын огтлолцолд харгалзана.
- Энэтхэг мужаан бол өмнөх нь мөн боловч хойтох нь биш. Энэ нь зөвхөн $A \setminus B$ олонлогийн B -тэй огтлолцоогүй хэсэгт харгалзана.
- Төвдийн балчир хүүхэд өмнөх нь биш ч хойтох нь мөн. Энэ нь $B \setminus A$ олонлогийн A -тай огтлолцоогүй хэсэгт нь хамаарна.
- Багана зэрэг нь тэр хоёрын алиных нь биш. $A \cup B$ болон $B \cup A$ олонлогуудын нийлбэрийн үгүйсгэл болсон олонлогт хамаарна.

Жишээ 3. Харшлахуй нь хоёулаа мөн байх жишээгүй тохиолдол. Энэ нь хоёр олонлогийн хоосон огтлолцолд хамаарна. Тухайлбал, адуу үхэр хоёр, цагаан улаан хоёр, мөнх мөнх бус хоёр.

Жишээ 4. Нэг утгат нь албатайн найман үүдийг бүрдүүлэгч язгуурууд юм. Тухайлбал, үүдсэн болон мөнх бус хоёр, гал болон халуун бөгөөд түлэгч хоёр. Албатайн найман үүдийн шаардлагыг хангаж байгаа хоёр зүйлийг нэг утгатай хэмээн үзнэ. Энэ нь математикийн хэлээр “эквивалент” тохиолдолд харгалзана.

Албатайн найман үүдийг дөрөв багцална.

- Мөнийн хоёр тэнцүү алба
- Бишийн хоёр тэнцүү алба
- Байгаагийн хоёр тэнцүү алба
- Байхгүйн хоёр тэнцүү алба

Мөн түүнийг задлаад найм болгож шинжилнэ. Жишээ нь, үүдсэн ба мөнх бус хоёрын хувьд:

- Үүдсэн мөн бол мөнх бус мөн байх албатай
- Мөнх бус мөн бол үүдсэн мөн байх албатай
- Үүдсэн биш бол мөнх бус биш байх албатай
- Мөнх бус биш бол үүдсэн биш байх албатай
- Үүдсэн байвал мөнх бус байх албатай
- Мөнх бус байвал үүдсэн байх албатай
- Үүдсэн байхгүй бол мөнх бус байхгүй албатай
- Мөнх бус байхгүй бол үүдсэн байхгүй албатай.

Өөрөө мэдээд дараа нь бусдад мэдүүлэх арга замыг билиг ухаанд “Онолын найман үг утга” хэмээн нэрлэдэг. Үүнд:

А. Өөрийн мэдэгдхүүнийг магадлах арга:

1. Илт мэдэл (үнэн ба хуурмаг)
2. Даган жишигч (үнэн ба хуурмаг)

Б. Өөрөө мэдээд бусдыг мэдүүлэх арга:

3. Үгэн нотолгоо (үнэн ба хуурмаг)
4. Цөхрөөгч буюу хэтрүүлэг нотолгоо (үнэн ба хуурмаг)

Нотолгооны ангилал

Нотолгооны ангилал нь билиг ухааны сэтгэлгээний нэг онцлог мөн. Тэдгээр ангилал нь үнэн хэрэгтээ танин мэдэхүйн хүрсэн түвшнийг харуулах бөгөөд шууд практик хэрэглээтэй нь илт байдаг. Билиг ухаанд нотолгоог маш олон талаас нь ангилж, тэдгээр тус бүрийн онцлог, тавигдах шаардлагыг дэлгэрэнгүй авч үзсэн буй. Нэр томъёоны хувьд ч олон төрөл бөгөөд зарим тохиолдолд хэд хэдэн нэр томъёо нэгэн утгатай ч бий. Жишээ нь, эс зоригдох нотолгоо, үгүйсгэх нотолгоо хоёр нэг утгатай.

Үгэн нотолгоо нь хоёр талд эргэлзэх тээнэгэлзээг арилгана. Үгэн нотолгооны үүрэг нь гурвалсан ёсыг нэгэн зэрэг дурьдсан мэдлийг үүсгэхэд оршино. Зөв үгэн нотолгоо, нэн ариун нотлох үг, бусдын тусыг даган жишигч нар нэг утгатай. Үнэн зөв нотлон үйлдэгчийг өгүүлсэн тул зөв үгэн нотолгоо болно. Зөв нотолгооны гурвалсан ёсыг өгүүлсэн тул нэн ариун нотлох үг болно. Бусдын нотлогдохууныг онох тусыг үйлдэх, өөрийн үр даган жишигчийн шалтгаан мөн тул бусдын тусыг даган жишигч гэнэ. Үгэн нотолгооны далд өгүүлэмж нотлогдохууныг дараах байдлаар тайлбарлана. Утааг хараад алсын даваанд гал байгааг мэднэ. Утаа нь нотлон үйлдэгч бөгөөд алсын даваанд байгаа гал нь нотлогдохуун мөн. Утаатай даваа нь мэтгэлцээний суурь буюу жишихийн суурь болно гэх мэт. Зөв үгэн нотолгоонд дөрвөн шаардлага тавигддаг. Үүнд:

1. Уг шалтгааны онцлог өөрийн үзүүлсэн утгыг мэдсэн шалгагчийг өмнө нь олсон.
2. Өгүүлэгдэхүүний онцлог өөрийн үзүүлэгдэхүүн болсон гурвалсан ёсыг илүү дутуу үгүйгээр өгүүлсэн.
3. Шинж чанарын онцлог үг, ухамсар, утга гурвын гэмээс хагацсан.
4. Үйлдлийн онцлог өөрийн үр даган жишигчийг үүсгэн үйлдэгч байх гэх мэт.

Зөв үгэн нотолгоог хоёр ангилна. Үүнд:

1. Ном зохилдон найруулсан – Жишээ, нотолгоо хоёрыг нотлогдохууны номтой язгуур зохилдуулан найруулсан байна. Жишээ: “Алин үйлдэхүй мөн аваас мөнх бус мөн байх албатай. Жишээ нь, хумх мэт. Дуу ч үйлдэхүй болой”.
2. Ном үл зохилдон найруулсан – Жишээ, нотолгоо хоёрыг үгүйсгэгдэхүүний номтой язгуур үл зохилдуулан найруулсан байна. Жишээ: “Алин мөнх мөн аваас үл үйлдэхүй мөн байх албатай. Жишээ нь, хуран эс үйлдсэн огторгуй мэт. Дуу нь үйлдэхүй болой”.

Зөв нотолгоог мөн чанарын үүднээс дараах байдлаар дэлгэрэнгүй ангилна. Үүнд:

1. Үрийн зөв нотолгоо
 - a. Бодит шалтгааныг нотлох – “Утаат даваанд номт, гал байгаа шүү дээ, утаа байгаа учраас”. Энд утаа нь галын үр мөн.
 - b. Өмнө одсон шалтгааныг нотлох – “Агаар мандлын хөх утаа номт, өөрийн шалтгаан гал өмнө одсон шүү дээ, утаа мөн учраас”.

- c. Ерөнхий шалтгааныг нотлох – “Утаа номт, өөрийн шалтгаантай мөн шүү дээ, хааяа төрсөн учраас”
 - d. Онцлог шалтгааныг нотлох – “Дүрсийг баригч эрхтний мэдэл номт, өөрийн эзэнт нөхцөл ба тэр даруйтын нөхцөлөөс өөр өөрийн нөхцөл байгаа шүү дээ, өөрийн эзэнт нөхцөл ба тэр даруйтын нөхцөл бүрдсэн төдийгөөр үл төрөх хийгээд хааяа төрдөг учраас”
 - e. Онцлог номыг даган жиших – “Аман доторх бөөн бурмын дээр номт, өмнөх бурмын амтаар одоогийн бурмын дүрсийг үүсгэх чадамж байна үү дээ, одоогийн бурмын амт байгаа учраас.
2. Мөн чанарын зөв нотолгоо
- Мөн чанарын нотолгоо нь нотолгоо, ном хоёр нэг мөн чанартай байх хамтатгалын нотолгоо болно. Жишээ нь, “Дуу номт, мөнх бус мөн шүү дээ, үйлдэхүй мөн учраас. Үүний үйлдэхүй мэт.
- a. Ялгааг харгалзуулагч – “Лавайн дуу номт, мөнх бус мөн шүү дээ, хичээлээс гарагч мөн учраас. Үүний хичээлээс гарагч мэт.
 - b. Ялгааг арилгагч – “Дуу номт, мөнх бус мөн шүү дээ, бодит мөн учраас. Үүний бодит мэт.
3. Эс зоригдох нотолгоо
- a. Шалтгаан эс зоригдох - “Гал үгүй шөнийн далайд номт, утаа байхгүй шүү дээ, гал байхгүй учраас”. Үүний гал байхгүй мэт. Шалтгаан болох гал нь байхгүй гэсэн үг юм.
 - b. Түгэн үйлдэгч эс зоригдох – “Мод байхгүй хадан хэрмэнд номт, агар байхгүй шүү дээ, мод байхгүй учраас. Энд “мод нь агарын түгэн үйлдэгч” бөгөөд тэр нь байхгүй байна гэсэн үг.
 - c. Мөн чанар эс зоригдох – “Хумх шалгагчаар эс зоригдсон газарт номт, хумх байхгүй шүү дээ, хумх шалгагчаар эс зоригдсон учраас”. Энд хумх буйн мөн чанар үгүйсгэгдсэн байна.
 - d. Бодит үр эс зоригдох – “Утаа байхгүй, бүрхүүлгүй хүрээнээ номт, утааны торолтгүй чадамж бүхий бодит шалтгаан байхгүй шүү дээ, бодит үр утаа байхгүй учраас”.

Харшлагчийн нөхөр зоригдох зөв нотолгоог мөн дараах хэлбэрээр задалж ангилна. Үүнд:

- 1. Хамт үл оршин харшлагчид шүтсэн – “Их хүчит галаар түгэн бүрхсэн зүүн сууринд номт, тэсгим хүйтний үр үргэлжлэн оршихгүй шүү дээ, их хүчит галаар түгэн бүрхсэн учраас”.
 - a. Шалтгаан харшлан зоригдох
 - b. Түгэн үйлдэгч харшлан зоригдох
 - c. Мөн чанар харшлан зоригдох
 - d. Харшлагчийн үр зоригдох
 - e. Үр харшлан зоригдох
 - f. Уг лугаа харшилсан үр зоригдох
- 2. Харилцан гэвчин харшлагчид шүтсэн
 - a. Магадтайгаар харгалзахыг хорьсон – “Хумх номт, өөрийн эвдрэх өөрөөс хойш гарсан бусад шалтгаан нөхцөлд үл харгалзана шүү дээ, өөрөө бүтсэн төдийгөөсөө магад мөн учраас”
 - b. Харгалзахаар магадлалыг хорьсон – “Улаан даавуу номт, өөрөө бүтсэн төдийгөөр өнгөний магадлалгүй шүү дээ, өөрийн өнгөтэй болох нь өөрөөс хойш гарсан уг шалтгаанд харгалзах учраас”

Дээр өгүүлсэнчлэн “Гал хүйтнийг хорлох ёс”-ыг таньсанаар “тэвчээрийг бясалгаснаар уурыг хорлох”, “мөнх бусыг оносон ухамсраар мөнхөд барихыг хорлох” зэргээр жишиж “зөв ухамсраар чанх буруу ухамсарт хорлох” ёс тэргүүтнийг мэдэж болно.

Нотолгоог нотлогдохууны номын үүднээс хоёр ангилдаг. Үүнд:

1. Үгүйсгэх зөв нотолгоо – “Дуу номт, мөнхөөр хоосон шүү дээ, үйлдэхүй учраас”. Үүний үйлдэхүй мэт, ном нь мөн бол үгүйсгэл нь мөн байх.
2. Хамтатгах зөв нотолгоо – “Дуу номт, бодит мөн шүү дээ, тусыг үйлдэж чаддаг учраас”. Үүний тусыг үйлдэж чаддаг мэт, ном нь мөн бол хамтатгал нь мөн байх албатай. Үрийн нотолгоо болон мөн чанарын нотолгоо нь хамтатгах нотолгоо мөн.

Харин нотлох ёсны үүднээс бас хоёр ангилна. Үүнд:

1. Томъёоллыг нотлох - “Дуу номт, мөнх бус шүү дээ, үйлдэхүй учраас”. Үүний үйлдэхүй мэт, ном нь мөн бол бэлгэдэл нь мөн байх албатай.
2. Утгыг нотлох - “Дуу номт, агшинт мөн шүү дээ, үйлдэхүй учраас”. Үүний үйлдэхүй мэт, ном нь мөн байхад бэлгэ чанар мөн байх албатай.

Мөн түүнчлэн нотлогдохууны үүднээс гурав ангилдаг. Үүнд:

1. Бодит хүчний - “Дуу номт, мөнх бус шүү дээ, үйлдэхүй учраас. Жишээ нь хумх мэт”. Үүний үйлдэхүй мэт.
2. Итгэмжлэлийн – “Өглөгөөр төгс эдлэл, шагшаабадаар амгалан хэмээх эшлэл номт, өөрийн үзүүлэгдэхүүн утганд хуурмаггүй мөн шүү дээ, гурван ажиглалаар ариуссан эшлэл мөн учраас”.
3. Алдарын – “Туулайт номт, түүнийг сар хэмээх үгээр өгүүлж болно шүү дээ, бодлын оронд байгаа болохоор”. Үүний бодлын оронд байгаа мэт. Энэ алдрын орон дохионоос гарсан утга мөн учраас тийм болой.

Эцэст нь, мэтгэлзэгчийн үүднээс бас хоёр ангилна. Үүнд:

1. Өөрийн тусын - “Дуу номт, мөнх бус шүү дээ, үйлдэхүй учраас” гэх нотолгоогүйгээр дуу өөрөө мөнх бус мөн тул шалтгааныг санасны хүчээр үйлдэхүй тодорч мөнх бусыг нотлох мэт.
2. Бусдын тусын - “Дуу номт, мөнх бус шүү дээ, үйлдэхүй учраас” гэсэн нотолгоо авсаны улмаас үйлдэхүйгээр мөнх бусыг нотолно.

Буруу нотлол

Гурван ёс бишийг буруу нотолгоо гэнэ. Билиг ухааны сэтгэлгээний бас нэгэн онцлог нь буруу нотолгоог ихээхэн дэлгэрэнгүй ангилж, шинжилдэгт оршино. Энэ нь мөн л танин мэдэхүйн гүнзгий түвшинг нь илэрхийлдэг.

Юуны өмнө буруу нотолгоог дараах байдлаар хоёр ангилна.

1. Зүгийн ном нь нотлогдох
2. Зүгийн ном нь эс нотлогдох

Мөн түүнчлэн буруу нотолгоог дараах байдлаар дэлгэрэнгүй ангилна. Үүнд:

1. Харшлах нотолгоо - “Дуу номт, мөнх шүү дээ, үйлдэхүй учраас”. Үүний үйлдэхүй мэт.
2. Эс магадлагдах нотлол
 - а. Нийт бусын эс магадлагдах - “Дуу номт, мөнх бус шүү дээ, сонсогдохуун учраас” хэмээхийн сонсогдохуун мэт.

б. Бодит эс магадлагдах - “Дуу номт, мөнх шүү дээ, мэдэгдэхүүн мөн учраас” хэмээхийн мэдэгдэхүүн мэт.

с. Үлдэгдэлт эс магадлагдах - “Дуу номт, мөнх бус шүү дээ, мэдэгдэхүүн мөн учраас”

3. Эс нотлогдох нотлол гэх ангилал нь 14 төрөл бий.

Нотолгооны ангиллыг нэгтгэн “НОТЛОЛЫН ХҮРД” (Дигнага) хэмээх матрицаар есөн төрөл (Хүснэгт 5) болгосон байдаг. Ингэхдээ, зохилдох зүг ба үл зохилдох зүг гэсэн хоёр үндсэн үзүүлэлт бүрд түгэн үйлдэгч, ерөөсөө байхгүй, хоёр байдалтай гэсэн гурван дэд үзүүлэлтийг харгалзуулсан байна.

Хүснэгт 5. Нотлолын хүрд

	Үл зохилдох зүгт түгэн үйлдэгч	Үл зохилдох зүгт ерөөсөө байхгүй	Үл зохилдох зүгт хоёр байдлаар орох
Зохилдох зүгт түгэн үйлдэгч	1. <u>Бодит эс магадлагч</u> “Лавайн дуу номт, мөнх шүү дээ, мэдэгдэхүүн мөн учраас. Зохилдох жишээ огторгуй, үл зохилдох жишээ хумх.	2. <u>Зөв нотолгоо</u> “Дуу номт, мөнх бус шүү дээ, үйлдэхүй мөн учраас. Зохилдох жишээ хумх, үл зохилдох жишээ огторгуй.	3. <u>Бодит эс магадлагч</u> “Лавайн дуу номт, хичээлээс гарагч мөн шүү дээ, мөнх бус учраас. Зохилдох жишээ хумх, үл зохилдох жишээ гялбаа ба огторгуй.
Зохилдох зүгт ерөөсөө байхгүй	4. <u>Харшлах нотолгоо</u> “Лавайн дуу номт, мөнх шүү дээ, үйлдэхүй учраас. Зохилдох жишээ огторгуй, үл зохилдох жишээ хумх.	5. <u>Нийтийн бусын эс магадлагч</u> “Дуу номт, мөнх шүү дээ, сонсогдохуун мөн учраас. Зохилдох жишээ огторгуй, үл зохилдох жишээ хумх.	6. <u>Харшлах нотолгоо</u> “Лавайн дуу номт, мөнх шүү дээ, хичээлээс гарагч мөн учраас. Зохилдох жишээ огторгуй, үл зохилдох жишээ хумх ба гялбаа.
Зохилдох зүгт хоёр байдал орох	7. <u>Бодит эс магадлагч</u> “Лавайн дуу номт, хичээлээс гарагч биш шүү дээ, мөнх бус учраас. Зохилдох жишээ гялбаа ба огторгуй, үл зохилдох жишээ хумх.	8. <u>Зөв нотолгоо</u> “Лавайн дуу номт, мөнх бус шүү дээ, хичээлээс гарагч мөн учраас. Зохилдох жишээ хумх ба гялбаа, үл зохилдох жишээ огторгуй.	9. <u>Бодит эс магадлагч</u> “Лавайн дуу номт, мөнх шүү дээ, хүрэлцэхүйт биш учраас. Зохилдох жишээ огторгуй ба нарийн тоос, үл зохилдох жишээ үйл ба хумх.

Дээрх хүснэгтийн мөр болон баганын нэр томъёог дараах байдлаар тайлбарлана. Үүнд:

1. Зохилдох зүгт түгэн үйлдэгч – “Нотлогдохууны ном мөн байхад нотолгоо мөн байх албатай”
2. Зохилдох зүгт ерөөсөө байхгүй - “Нотлогдохууны ном мөн байхад нотолгоо биш байх албатай”
3. Зохилдох зүгт хоёр байдалд орох - “Нотлогдохууны ном мөн байхад нотолгоо мөн байх албагүй”
4. Үл зохилдох зүгт түгэн үйлдэгч – “Үгүйсгэгдэхүүний ном мөн байхад нотолгоо мөн байх албатай”

5. Үл зохилдох зүгт ерөөсөө байхгүй - “Үгүйсгэгдэхүүний ном мөн байхад нотолгоо биш байх албатай”
6. Үл зохилдох зүгт хоёр байдлаар орох - “Үгүйсгэгдэхүүний ном мөн байхад нотолгоо мөн байх албагүй, бас биш байх ч албагүй”

Дүгнэлт

1. Билиг ухааны ойлголт, нэр томъёо, найруулга нь шинжлэх ухааны ухагдахуун, найруулгатай тохирохгүй байгаа учраас тэдгээрийн хооронд “орчуулга” буюу харилцан ойлголцох арга хэрэгтэй юм.
2. Билиг ухааны нотлох сэтгэлгээ, логик сэтгэлгээ хоёрт зөрчилдөх зүйл үгүй байна.
3. Хэтрүүлгийн суурийг логикийн суурьтай харьцуулбал илүү өргөн хүрээний ойлголтуудыг хамарч байна.
4. Билиг ухааны андгай буюу баримтлал нь бодит оршихуйн жам ёсыг хамарч буй нь математик логикоос ялгарах нэг онцлог юм.
5. “Гал хүйтнийг дарах ёс”-оор жишин “тэвчээрээр уурыг дарах”, “мөнх бусыг оносон ухамсраар мөнхөд барихыг засах” зэргээр “зөв ухамсраар чанх буруу ухамсарыг арилгах” ёс тэргүүтэн нь оршихуйн алдаа төөрөгдлийг засах ерөнхий аргачлалын ач холбогдолтой юм.
6. Билиг ухааны танин мэдэхүй бол шинжлэх ухааны танин мэдэхүйтэй нэгэн ижил үнэ цэнэтэй бөгөөд тэдгээр нь харилцан бие биеэ нөхөх шинжтэй байна.

Ном зүй

1. Билгийн зүрхэн судар (2010).
2. Жадамба судар. (2014). Бугат Л.Алтангэрэлийн шинэ орчуулга.
3. С.Гантөмөр. (2016). Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: шинжлэх ухааны хэсэг, Боть 5. УБ.
4. Т.Булган. (2010). Буддын философийн дэвтэр.
5. Шантидэва. (2009). Гэгээрлийн зам (Бодичаръяаватара).
6. Асанга. (2005). Их хөлгөний хураангуй ба Абхидхарма бүхнээс түүсэн.
7. Лувсанбалдан гавж (Оргиочийн лам). (2009). Бодьсадвын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар. Т.Булганы орчуулга.
8. Богд Зонхов. (2006). Бодь мөрийн зэрэг (Ламрим).
9. Шүтэн барилдлагын магтаал сайн номлолын зүрхэн хэмээх оршивой. (2006). МБШТөв Гандантэгчэнлин хийд.
10. Очироор огтлогч хэмээх их хөлгөн судар. С.Гантөмөрийн орчуулга.
11. Дармапада. (2007).
12. Сорхугтан. (2008). Хөх Монголыг ний хэмээр бадрах хутагтай дөрвөн нүүрит их засгийн алтан дээд үнэний аялгуу.
13. Х.Дондог. (2010). Монголоо эрсэн монгол

4.5. Буддын шинжлэх ухааны товч агуулга

Хураангуй

Буддын шинжлэх ухаан нь дотоодын шашиндаа суурь бодот юмсын онол хэмээн нэрлэгдэх бөгөөд тэрхүү орон бодот юмсын оршихуйд нь мэдэгдэхүүний орон, мэдэгч оюун, оюун оронтойгоо холбогдох ёсон, оюуны орныг таних арга-нотлохуй ухааны онол, орныг мэдрэгч бодгалийн тухай агуулга тэргүүтэн багтах ажээ. Буддын үзэл онолын тийн агуулгыг шашинаас нь тусгайлан авч үзэж чадваас ач тустай хэмээн Дээрхийн гэгээнтэн 14-р Далай лам айлдсан буй. Тухайлбал, “бүх юмс шүтэн барилдаж гарсан” гэх үзэл онолоор тухайн зүйлийг олон зүгт харгалзан оршихыг үзэхийн цагт тэр зүйл нь ганцхан шалтгаан болон ганцхан нөхцөлөөс үүдсэн гэх туйлирсан санаагаа залруулж чадна гэжээ. Тиймээс ганжуур данжуур бүгдийн өгүүлэгдэхүүнийг шинжлэх ухааны ухагдахуун, үзэл онолын ухагдахуун, номыг анхааран авах хэсэг хэмээн гурав ангилан судалваас өнөө цагт илүү ач холбогдолтой хэмээн Гэгээнтэн дахин онцолсон буй.

Түлхүүр үг: мэдэгдэхүүний орон, нотлохуйн ухаан, шүтэн барилдлага, дөрвөн итгэмж, тоосны найман эд, бүдүүн нарийн мэдэл, гэгээн гэрэл.

Судалгааны арга зүй

Аяга тахимлагууд ба мэргэд нар бээр

Алтыг хайлуулах, таслах, цувих мэт

Ажин шинжлээд миний зарлигийг

Авч үйлдээрэй, сүсэглэсний тулд бус хэмээн Буддын сургаал, судар шаштируудад олонтоо дурдсан буй.

Ийнхүү бурхны сургаалын цөм нь догма биш, шинжлэн танихуй юм. Утгыг судлахдаа илт мэдэл хийгээд мэдрэхүйг нотлохуй ухаан, эш зарлиг хоёроос илүү чухалд тооцдог. Эндүүрэлгүй нотолгоо нь эцэстээ өөрийн хуурмаггүй бодит мэдрэмжид тулах хэрэгтэй хэмээн үздэг. Ийнхүү илт мэдэл, нотлохуй ухаан, эш онол гэх дарааллаар алив шинжлэлд хандана (С.Гантөмөр, 2016).

Буддын шинжлэх ухааны судлаач болон ер судлаач хүнд дөрвөн итгэмж хэрэгтэй гээд түүнд 1. номлосон сургаалыг голлон шинжлэх 2. үгээс илүүтэйгээр утгыг голлон шинжлэх 3. утга хоёр зүйл байваас зарлигласан утгыг бус магад утга буюу юмсын зүй тогтлыг голлон барих 4. магад утга түүнийг илт мэдлээр мэдрэн үзэхийн чухлыг тус тус багтаасан байна. Дөрвөн итгэмжийн онолыг хураангуйлан дараах Хүснэгт-1-д оруулсан болно.

Итгэмжлэх дөрвөн зүйл	Үл итгэмжлэх дөрвөн зүйл	Тайлбар:
Ном	Бодгаль	Яруу алдар тэргүүтнийг үл дагах
Утга	Үг	Үгийн найруулгад үл татагдах
Магад утга- өгүүлэх утга	Татах утга	Магад утга болох юмсын туйлын зүй тогтлыг харах
Билиг билгүүн	Тийн мэдэл	Сэтгэлийн атгаг мэдэл бодолд үл автах

Нотлохуйн ухаанаар аливааг нухацтай шинжилнэ. Нотлохуйн ухааныг их багш Дигнага (V зуун), Дхармагирди (ҮШ зуун) нар төгс номын ёс болгон боловсруулсан ажээ. Нотлохуйн

ухаанд 1. жам ёсны нотлох ухаан 2. хамаарлын нотлох ухаан 3. үйлчлэл үзүүлэхүй нотлох ухаан 4. зохистойн нотлох ухаан тус тус багтана.

Бодит юмс өөрийн үргэлжлэлийг үүсгэх нь жам ёс юм. Иймд *жам ёсны нотлох ухаан* түүнд тулгуурлана. Гал яагаад халуун бэ? гэж асуувал түүний мөн чанар буюу халуун байх нь түүний жам хэмээхээс өөр шалтгаан үгүй.

Хамаарлын нотлох ухаан хоёр төрлийн хамаарлыг ашиглана. Үүнд: 1. Төрлийн хамаарал. Үр дагаврын төрөл нь уг шалтгаан болон нөхцөл шалтгаанаас хамаарна гэсэн үг бөгөөд уг үрийн хамааран бүтэх ухааныг энд өгүүлнэ. 2. Нэрийтгэлийн хамаарал. Энэ нь хумх болон хумхын хэсэг хоёр нь нэг нэгэндээ харгалзах мэт нэрийтгэлийн суурь ба нэрийдэгч хоёрын харилцан хамаарал бөгөөд хэсэг хэсэгтний хамаарал ч гэж хэлэх нь бий.

Үйлчлэл үзүүлэхүй буюу нөлөөллийн нотлох ухаан. Уг шалтгаан, нөхцөл шалтгаан, тэдгээрийн дан болон хам үйлчлэлээр үр дагаврын онцгой ялгамж үүсгэнэ. Шалтгаан-нөхцөл буюу үр хөрөнгө - нөхцөлийн нийлэмж өөр бол өөр л үр дагаварт хүргэнэ. Тухайлбал, шороо барьцалдуулах-хатууруулах, ус нэгтгэх, гал боловсруулах, хий арвидуулах зэрэг үйлчлэл үзүүлнэ хэмээн үздэг.

Зохистойн нотлох ухаан. Үр дагаврын онцлогийг уг шалтгааных нь чадамжаар тайлбарлах, эсвэл одоогийн байдлаар нь ирээдүйн байдлыг нь гаргаж хэлэх ухаан юм. Жишээ нь, төрсөн бол мөнх бус байх ёстой гэх мэт. Үр дагаварт олон төлөв байдаг ба шалтгаанд ч бас олон чадамж бий.

Нотолгоонд дараах хосуудыг ялгаж өгдөг жамтай. Үүнд:

1. Байгаа гэж эс нотолсон ба байхгүй хэмээн нотолсон хоёрын ялгааг гаргах
2. Утга түүнийг эс олсон ба утга түүнийг байхгүй хэмээн олсон хоёрын ялгааг гаргах
3. Утга түүнийг мөн гэж эс нотолсон ба биш хэмээн нотолсон хоёрын ялгааг гаргах
4. Утга түүнийг мөн гэж эс оносон ба түүнийг биш гэж оносон хоёрын ялгааг гаргах.

Нотлохуйн ухаан буюу дүйра нь сургалтад зориулсан хялбаршуулсан сэдвүүдийг боловсруулсан байдаг. Үүнд улаан цагаан өнгө, бэлгэ чанар ба бэлгэдэхүүн, нэг ба салангид, ерөнхий ба зүйл, эдийн ном ба эсрэг ном, харшлахуй ба барилдахуй, үгүйсгэл ба бүтэхүй гэх мэт сэдвүүд ордог. Эдгээр сэдэвт тулгуурлан бусдын ёсыг няцаах, өөрийн ёсыг агуулах, маргааныг шийдэх гэсэн гурван замаар нотлох аргачлалд сургана. Энэ ёс нь нотлохуйн ухаанаар сэтгэлээс бологчийг задлан шинжлэх арга, судалгаанд орохуйн зам, утгыг бүрэн гүйцэд мэдэж авах боломжийг нээж өгнө. Ямар нэгэн утгыг судлахдаа бусдын буруу үзэл баримтлалуудыг дурдаад тэдгээрийг няцааж, түүний дараа өөрийн үзэл баримтлалуудыг илэрхийлж, түүнд бусдаас өөнтөглөвөөс тэдгээр өө сэвийг няцааж, өөрийн үзлээ хамгаалж үлдэх зэрэг арга аргачлалд сурна. Мэтгэлцээ нь тов тодорхой бүтэц, яшгтал мөрдөх дүрмээр явагдана. Дүйраны нотлох аргаар мэтгэлцэх үед үгийн утгыг гурван гол хэсэг буюу нотолгоо, тодруулга, мэтгэлцээний суурь гуравт хуваана. Хэтрүүлгийн жишээ: Дуу номтоо, эс үүдсэн мөн үү? Мөнх мөний тул. Тодруулгад зөвшөөрөв эсвэл яагаад гэж хариулна. Нотолгоонд нотолгоо эс бүтэв эсвэл албагүй гэж хариулна. Мөн алба харшлав эсвэл эргэлзэв гэсэн хариултууд бий.

Асуултын хариулт дөрвөн төрөл буй. Үүнд:

1. Нэг чигт эш үзүүлсэн хариулт буюу нэг тал руу нь шийдсэн хариулт.

2. Нэн ялгаад эш үзүүлсэн хариулт буюу Мөнх бус бүгд дүрс мөн үү? гэвэл торж тулагчид нь дүрс мөн, мэдрэмж сэрэхүйтнүүд нь дүрс биш гэх мэт нэн ялгасан хариулт.

3. Асуугаад эш үзүүлсэн хариулт буюу Энэ мод урт уу, богино уу? гэвэл юунд харгалзуулаад асуув? хэмээн асуугаад, хэрвээ түүнээс богинуудад харгалзуулбал урт мөн, харин түүнээс уртуудад харгалзуулбал богино мөн гэх мэт хариулт.

4. Орхиж эш үзүүлсэн хариулт буюу түр хариулт эс өгөх гэх зэргээр дөрөв буй.

Мөн бишийн дөрвөн тал хэмээх аргыг мэдэгдэхүүний орныг эцэслэн шийдэхэд түгээмэл хэрэглэнэ. Тэдгээр дөрөв нь гурван тал, дөрвөн тал, харшлахуй, нэг утгат зэргээр бүтнэ. Гурван тал ба дөрвөн талыг тооцох ёс нь хоёр зүйлийн хооронд ямар ялгаа байгааг шийдэх арга юм. Мөн, бишийн багц арга нь зургаан тохиолдлыг нягтлан шалгадаг. Үүнд:

1. Ерөнхий мөн бөгөөд зүйл биш нь мэдэгдэхүүн.

2. Зүйл мөн бөгөөд ерөнхий биш нь багана, хумх... гэх мэт.

3. Хоёуланг нь мөн бологч нь хумх гэх мэт.

4. Хоёулангийн аль нь ч биш нь туулайн эвэр гэх мэт.

5. Хумх нь өөрөө алтан хумхын ерөнхий мөн бөгөөд бодит зүйл мөн учир ерөнхий ба зүйл хоёулаа мөн.

6. Хумхын ерөнхий нь дүрс мөн, дүрсийн ерөнхий нь бодит мөн, бодитын ерөнхий нь оршихуй мөн гэх мэтээр түгэлт ихтэй нь ерөнхий, түгэлт багатай нь зүйл мөн. Эдгээр зургаа болой.

Албатайн найман үүдийн шаардлагыг хангаж буй хоёр зүйлийг нэг утгатай хэмээн үзнэ. Албатайн найман үүд нь мөнийн хоёр тэнцүү алба, бишийн хоёр тэнцүү алба, байгаагийн хоёр тэнцүү алба, байхгүйн хоёр тэнцүү албыг тус тус агуулна. Жишээ: Үүдсэн ба мөнх бус хоёрын хувьд: Үүдсэн мөн бол мөнх бус мөн байх албатай. Мөнх бус мөн бол үүдсэн мөн байх албатай. Үүдсэн биш бол мөнх бус биш байх албатай. Мөнх бус биш бол үүдсэн биш байх албатай. Үүдсэн байвал мөнх бус байх албатай. Мөнх бус байвал үүдсэн байх албатай. Үүдсэн байхгүй бол мөнх бус байхгүй албатай. Мөнх бус байхгүй бол үүдсэн байхгүй албатай юм.

Суурь бодит юмсын ангилал

Дотоодын номлолуудад суурь бодит юмсыг ангилах нь хэд хэдэн янз байдаг. Тэдгээрийг товч дурдъя.

Нэгдүгээрт, бүх юмсыг цогц, язгуур, төрөн түгэхүй хэмээн гурав ангилсан бий. Цогц нь дүрсийн цогц, сэрэхүйн цогц, хуран мэдлийн цогц, хуран үйлдэхүйн цогц, тийн мэдлийн цогц хэмээн тав задарна. Үүнийг таван цогцын онол гэнэ. Язгуур нь зоригдол-орны зургаан язгуур, шүтээн-эрхтний зургаан язгуур, шүтэгч-тийн мэдлийн зургаан язгуур гээд нийтдээ арван найман язгуур болж задарна. Зоригдол орны зургаан язгуур дүрсийн язгуур, дууны язгуур, үнэрийн язгуур, амтны язгуур, хүртэхүйн язгуур, номын язгуур юм. Шүтээн-эрхтний зургаан язгуур нь нүдний язгуур, чихний язгуур, хамрын язгуур, хэлний язгуур, биеийн язгуур, сэтгэлийн язгуур болой. Шүтэгч-тийн мэдлийн зургаан язгуур нь нүдний тийн мэдлийн язгуур, чихний тийн мэдлийн язгуур, хамрын тийн мэдлийн язгуур, хэлний тийн мэдлийн язгуур, биеийн тийн мэдлийн язгуур, сэтгэлийн тийн мэдлийн язгуур болой. Энэ нь арван найман язгуурын онол юм. Төрөн түгэхүй нь дүрсийн төрөн түгэхүйгээс номын төрөн түгэхүй хүртэл

гадаад зургаа, нүдний төрөн түгэхүйгээс сэтгэлийн төрөн түгэхүй хүртэл дотоод зургаа, нийт арван хоёр зүйл төрөн түгэхүй болой.

Хоёрдугаарт, мэдэгдэхүүний таван суурийн онолоор бас ангилсан бий. Үүнд:

1. Үзэгдэл дүрсийн суурь
2. Гол сэтгэлийн суурь
3. Нөхөр сэтгэлийн хэлбэрийн суурь
4. Төгөлдөр бус хуран үйлдэхүйн суурь
5. Хуран эс үйлдэгчийн суурь тус тус багтана.

Гуравдугаарт, гурван бэлгэ чанарын үүднээс ангилсан буй. Үүнд:

1. Бусдын эрхт
2. Бүхэнд бүтэгч
3. Бүхэн нэрийдэгч болой.

Дөрөвдүгээрт, юмсыг суурь, мөр, үрийн үүднээс ангилсан байдаг.

Эдгээр ангиллуудын үүднээс болон ерөнхий танин мэдэхүйн үүднээс Буддын шинжлэх ухааныг хураангуйлан үзэх эсвэл дэлгэрэнгүйгээр Ганжуур, Данжуураас судлах боломжууд хэнд ч нээлттэй бий.

Дотоодын үзэл онол буюу философи

Үзэл онол нь суурь юмсын зүй тогтлыг судалсны үр дүн буюу эцсийн нэгэн зангидмал үзэл юм. Үзэл онолын ухааны гол арга зам нь бодитой үзэх мэдрэмжийг гол болголгүй, нотолгооны аргаар няцаах, агуулах, таслан шийдэх гурвын үүднээс өмнөх хойдох үзлийн илэрхийллийг зөрчилгүй болгож, алдаагүй нотолгооны замаар баталгаа хайгаад, суурь бодит юмсын зүй тогтолд эцсийн номлолыг үйлдэх тэр мөн (Т.Булган, 2010) хэмээжээ.

Мөнх бус хэмээх нь. Аливаа бодит юмсын эвдрэл нь хожуу гарсан уг шалтгаанд хамаарахгүйгээр өөрийг нь анх үүсгэгч уг шалтгаан түүнийхээ эрхээр эвдрэх мөн чанартайгаар үүссэн тул өөрөө бүтсэн төдийгөөсөө л агшин ч зогсолгүйгээр хувиран өөрчлөгдөнө. Тэрхүү чанарыг мөнх бус хэмээнэ. Үүнийг нягт ажиглаваас, бидний нүднээ харагдаж байгаа бүдүүн өөрчлөлтөөр жишиж болох юм.

Цувирагч бүхэн зовлонт хэмээх нь. Эс амарлисан ухамсар болон түүнтэй уг, үр аль нэгний үүднээс холбогдсон юм уу эсвэл түүний эрхэд орсон бүгдийг хамаарна.

Гаслангаас гэтэлвээс амарлих нь. Их багш Дхармагирди сэтгэл дэх нисванисын хир ариуссаныг амарлихуй хэмээн зарлигласан бөгөөд тэр нь нотлохуйн ухаанаар даган жишин нотлогдох тул сүсэг бишрэлтэй холбон тайлбарлах шаардлагагүй юм.

Би үгүй. Энэ онолоор голлон үзэгдэх байдал ба орших байдал хоёр өөр хоорондоо үл зохилдсон зүй тогтлыг илэрхийлж байгаа юм. Бүх дотоодынхон мөнх, хуваагдашгүй, өөрийн эрхт би-г нийтээрээ үгүйсгэдэг. Би-үгүй утга нь шүтэн барилдлага мөн. Жишээ нь: нэрлэгч ба нэрлэгдэхүүн, мэдэл ба мэдэгдэхүүн, үйл ба үйлдээчин тэргүүтнийг харилцан харгалзан бүтэх төдийгөөр л илэрхийлж чадна. Хэрвээ өмнө байгаа энэхүү дөрвөлжин ширээ нэрлэгч бодолд үл харгалзан ширээ өөрийн талаасаа дангаараа (бие даан) ширээ байж чаддаг бол ямар ч үед ширээ гэгдэх тэр заагийг заавал ширээний талаас нь нотлон буулгах боломжтой болно. Гэтэл тийм зүйл байхгүй тул ухамсраар илэрхийлэгдэх төдий мөн болох нь гарцаагүй нотлогдоно хэмээн үзжээ. Тиймээс орнууд оронтод байдлаа таниулж, оронт бээр ч түүнчлэн орны байдлыг танин үйлдэнэ. Жишээ нь, Га үсэг гэхэд л түүний хэлбэр дүрс, бичих үзэг, бэх, цаас, бичээч, үсэг

зохиогчийн урлан ургуулсан санаа бодол, бас Га хэмээн нэр зүүгч, үсгийг танин үйлдэгч, хэрэглэх орчин тэргүүтэн байхгүйгээр тухайн үсэг орших боломжгүйн адил. Бүх юмсын оршихуй ёс иймэрхүү мөн тул тэдгээрийн үндсэн чанар нь ч бүхий л талаасаа бусдад хамаарсан мөн чанартай хэмээн номлосон билээ.

Буддын дөрвөн тогтсон таалал. Таалал бүгд хоёр үнэний онолыг хүлээн зөвшөөрдөг нь адилхан ч тодорхойлох ёс нь өөр байдаг. Товчилбоос, үнэмлэхүй үнэн нь (жинхэнэ) оршихуй ёсны онол бөгөөд янагуух үнэн нь үзэгдэх ёсны онол мөн. Төв үзэлтэн ба сэтгэл төдийтөн хоёулаа үнэмлэхүй орших ёсыг зөвхөн хоосон чанар хэмээн үзсэн байна. Тухайлбал, сэтгэл төдийтөн гадаад утгад бүтэхүйгээр хоосон, бас баригдахуун баригч хоёроор ч хоосон гэдэг. Төв үзэлтнүүд үнэнээсээ бүтсэн зүйл тоосны төдийд ч оршихгүй хэмээн номложээ. Янагуух үнэн нь одоо бидэнд үзэгдэж байгаа сав шим, төрөх устах, арвидах хомстох, уг үр, жаргал зовлон, сайн муу тэргүүтэн эдгээр зүйлүүд мөн. Бидэнд харагдаж байгаа цэцгийн шавар сав нь янагуух тул тэрхүү шавар савыг хэрхэн харагдаж буйн дагуу өөр дээр нь хайваас олдох зүйл үгүй тул утгандаа өөрийн чанараар хоосон, харагдаж байвч хоосон, хоосон боловч харагдагч мөн учир хоёр үнэн нь нэгэн мөн чанартай, зөвхөн нэрийн төдийд л тусгаарыг Төв үзэлтнүүд тогтоосон байна. Товчилбоос Буддынхан юмс үзэгдлийн мөн ёсыг номлохдоо хэтрүүлэг ба гүжирдлэг хоёрыг орхиод зөвхөн юмсын үнэн зүй тогтлыг л ямарчлан танин барих хэрэгтэй хэмээн үзжээ.

Дотоодын номын дөрвөн үнэн суурь. Дөрвөн үнэн нь уг үр, жам ёсны зүй тогтлын дагуу нотлон буулгасан байдаг. Түүнийг номлохдоо зовлонг үл хүсэх нь бидэнд цаанаасаа л байдаг ба зовлонгийн мэдрэхүйн суурь нь ч хуран үйлдэхүйн зовлон мөн тул анхдугаарт зовлонгийн үнэнийг, зовлон ч уг шалтгаанаас гарах ёстой тул хоёрдугаар үнэн бүхэн гарахуй буюу зовлонгийн уг үр хоёрыг эхлээд таниулжээ. Тэр уг шалтгаан нь ч эцэстээ үл мэдэхэд тулах хийгээд үл мэдэхүйг арилгаж болно хэмээн нотолсноор гуравдугаар үнэн хорихуй, хорихуй нь ч уг шалтгаангүйгээр ирэхгүй тул түүнийг олох арга замын үнэн буюу гэгээрлийн уг үр хоёрыг дараа нь номлосон байна. Тиймээс Дөрвөн үнэний үндсэн суурь нь уг үрийн шүтэн барилдлагын оршихуй мөн.

Их багш Дхармагирди хорихуйн үнэнийг таниулахдаа зовлонгийн уг шалтгаан үл мэдэх мунхгийг арилгаж болно гэсэн учир шалтгаанаар нотолсноос бус Бурханы эш зарлигт тулгуурлах хэрэгтэй хэмээн номлоогүй ажээ. Тэгээд ёсоор дараалсан арван хоёр шүтэн барилдлагаар зовлон, бүхэн гарахуй хоёрыг, ёсноос буцах арван хоёр шүтэн барилдлагаар хорихуй, мөр хоёрыг гүнзгийрүүлэн номлосон байна. Жаргал, зовлон гэдэг нь дотоод мэдрэхүйн мөн чанартай учраас дотоод мэдрэхүйгээс салангид жаргал, зовлонг тайлбарлах боломжгүй тул мэдрэхүйн дээрх уг үрийн дамжлагыг нягтлан үйлдсэн ажээ. Бурханы сургаалд ном хэмээхийн жинхэнэ ойлголт нь ирээдүйд олох гаслангаас нөгчихүй мөн тул түүнийг бүтээх арга зам болон тэдгээрийг заасан сургаалуудыг ч ном хэмээн нэрлэнэ гэж үзнэ.

Мэдэгдэхүүний орны ойлголтын жишээ

- Бэлгэ чанар нь тухайн юмны бусдаас ялгарах дахин давтагдашгүй онцлог чанар.
- Шалгагчаар зоригдохуй нь буйн бэлгэ чанар.
- Шалгагчаар оногдохуун нь болгоогдохууны бэлгэ чанар.
- Шалгагчаар нотлогдохуй нь бүтэх суурийн бэлгэ чанар.
- Оюунаар мэдрэгдэхүүн нь орны бэлгэ чанар.
- Оюуны орон бологч нь мэдэгдэхүүний бэлгэ чанар.

- Өөрийн мөн чанарыг хадгалагч нь юмны бэлгэ чанар.
- Тусыг үйлдэх нь өөрийн үр дагавраа үүсгэх мөн.
- Тусыг үйлдэгч нь бодитын бэлгэ чанар.
- Тусыг үйлдэх чадамжгүй зүйлийг тусыг үйлдэж чадагчаар хоосрогч гэнэ.
- Тусыг үйлдэж чадагчаар хоосрогч бодит бусын бэлгэ чанар.
- Агшинт нь мөнх бусын бэлгэ чанар.
- Юм ба агшинт бусын нийлбэр нь мөнхийн бэлгэ чанар. Хуран эс үүдсэн огторгуй зэрэг нь үргэлжийн мөнх мөн. Хумхын огторгуй зэрэг нь хумх байх үед байх боловч тэр байхгүй үед байхгүй тул хаяа оршигч мөнх мөн.
- Бодьтой эс оршивч зөвхөн бодлын хувьд илэрхийлж болох юмс, тухайлбал, бэлгэ чанар ба бэлгэдэхүүн, нэг ба салангид, ерөнхий ба зүйл, ном ба номт (онцлог ба онцлогт), нотлогдохуун ба нотлон үйлдэгч зэрэг ерөнхий нэрийтгэлүүдийг мөнх хэмээн үзнэ.
- Төрсөн нь үүдсэний бэлгэ чанар.
- Эс төрсөн нь эс үүдсэний бэлгэ чанар.
- Төрөх, орших, эвдрэх гурван төлөвт нь хуран үүдсэний бэлгэ чанар.
- Төрөх, орших, эвдрэх гурвыг тодорхойлж үл бологч нь хуран эс үүдсэний бэлгэ чанар.
- Хуран эс үүдсэн юм нь уг шалтгаанаар хуран эс үүдсэн бөгөөд хувирч өөрчлөгдөшгүй төрөх, орших, эвдрэх гурав байхгүй төрөл. Энэ төрөлд багтагч нар нь өөрийн үр дагаврыг үүсгэх чадамжгүй тул бодит бус. Өөрийн уг шалтгаануудын нэгдлээс эс үүссэн тул эс үүдсэн. Агшин агшнаар хувиршгүй юм мөн тул мөнх гэж үзнэ. Бодит бус, эс үүдсэн юм, хуран эс үүдсэн юм, мөнх зэрэг нь утга нэг.
- Хуран үүдсэн юм нь уг шалтгаанаар хуран үүдээд хувирч өөрчлөгдөх төрөл. Бодит, үүдсэн, хуран үүдсэн, мөнх бус зэрэг нь нэг утгатай.
- Мөнх бусыг ангилбаас дүрс, мэдэл, төгөлдөр бус хуран үйлдэгч гурав.
- Нүдээр харж болох хийгээд гараар хүрэлцэж болох мэтийн торж тулагчууд нь дүрс мөн.
- Бодгалийн дотор орших дүрст бус мэдрэгч (ухамсар) төдийн мөн чанартнууд нь мэдэл болно.
- Дүрс мэдэл хоёрын аль нь ч биш боловч тэр хоёрын аль нэгэнд тулгуурлан нэрийдсэн, тухайлбал, гурван цаг мэтийг төгөлдөр бус хуран үйлдэгчид гэнэ.
- Дүрсэнд бологч нь дүрсийн бэлгэ чанар. “Дүрсэнд бологч хэмээх нь хорлолд үйлдэгдэнэ гэсэн үг буюу дүрсийн хорлол алин хэмээвээс, огоот өөрчлөлтийг үүсгэх болой” (Басубанду). Энэ нь дүрс хоорондоо нийлснээр адилгүй өөрчлөлтийг үүсгэх тул хорлол үйлдэж бологч гэжээ. Хоёр зүйлээр дүрсэнд байгч буй (Асанга): эхнийх нь хүрэлцэхээр дүрсэнд байгч буюу торж тулах онцгойрлоор тордог дүрс болох эрхтний мэдлийн орон дүрс. Энд дүрс тэргүүтэй таван утга орно. Дараагийнх нь орныг ажигласнаар дүрсэнд байгч буюу оюунаар өнгө болон хэлбэр тэргүүтний ялгаа орноор ажиглаж болох торшгүй дүрс болох сэтгэлийн мэдлийн орон дүрс мөн. Энд нүд тэргүүтэй таван эрхтэн, номын төрөн түгэхүй дүрсүүдийг оруулна.

Дүрс тэргүүтэй таван төрөн түгэхүй

Шүтээн нүдний эрхтэнд дүрс ургаснаар нүдний мэдэл дүрсийг танин барина. Энэ мэтчилэн таван эрхтний мэдлийн орон болсон дүрснүүдийг дүрс, дуу, үнэр, амт, хүртэхүйн төрөн түгэхүйд ангилна.

Дүрсийн төрөн түгэхүй. Нүдний мэдлийн баригдахуун дүрсийн төрөн түгэхүйн бэлгэ чанар. Ангилбаас өнгө, хэлбэр хоёр. Өнгийг ялгаваас хөх, шар, цагаан, улаан дөрөв үндсэн өнгө, тэдгээрийг хооронд нь их бага хувиар нийлүүлснээр гишүүн өнгүүд гарна. Үндсэн өнгүүд нь гишүүн өнгөнүүдийн уг шалтгаан болно. Үндсэн өнгө бологч нь үндсэн өнгөний бэлгэ чанар, гишүүн өнгө бологч нь гишүүн өнгөний бэлгэ чанар. Гишүүн өнгөд гэгээ, харанхуй, үүл, утаа, тоос, сүүдэр, манан будан, нарны гэрлийн өнгө бүхий найм багтана. Гэвч гишүүн өнгө нь тэдгээр наймын аль нэгэн байх албагүй. Ийнхүү төрөн түгэхүй нь нээлттэй систем юм. Үүл, утаа, тоос, манан будан дөрвийг холоос харвал хана мэт үзэгдэвч, дэргэдээс нь харваас үл үзэгдэх тул тэдгээрийг оршихуй биш гэсэн буруу бодлыг буцаахын тулд хэрэглэсэн бол гэгээ, харанхуй, сүүдэр, нарны гэрлийг өөрийн хаана орших суурь түүнээс тусдаа юм байхгүй хэмээсэн буруу бодлыг буцаахын тулд хэрэглэсэн гэжээ. Хэлбэр бологч нь хэлбэрийн бэлгэ чанар мөн. Ангилбаас, урт ба богино, өндөр ба нам, дөрвөлжин ба бөөрөнхийдүү, тэгш ба тэгш бус найман хэлбэр болно. Дүрсийн төрөн түгэхүй нь нээлттэй систем тул бусад хэлбэр нь дээрх хорин ангиллын аль нэгэнд орох албагүй.

Дууны төрөн түгэхүй. Чихний мэдлийн сонсогдохуун дууны төрөн түгэхүйн бэлгэ чанар мөн. Ангилбаас, эзлэгдсэн махбодоос гарсан (утгыг үзүүлэгч яруу болон яруу бус дуу, утгыг үл үзүүлэгч яруу болон яруу бус дуу) дөрвөн дуу, эзлэгдээгүй махбодоос гарсан (мөн адил утгыг үзүүлэгч яруу болон яруу бус дуу, утгыг үл үзүүлэгч яруу болон яруу бус дуу) дөрвөн дуу, бүгд найм болно. Утгыг үзүүлэгч нь хэлний нэн мэдүүлэн үйлдэгч дуу болой. Эзлэгдсэн эс эзлэгдсэн нь дүрст эрхтнээр эзлэгдсэн эзлэгдээгүйг хэлнэ.

		Яруу дуу	Яруу бус дуу
Эзлэгдсэн махбодоос гарсан	Утгыг үзүүлэгч	Төрөлхтний сайхан авиаг аялгуулах дуу	Хүний ширүүн үгээр загнах дуу
	Утгыг үл үзүүлэгч	Хөхөө шувууны донгодох дуу	Нударга цохих дуу
Эзлэгдээгүй махбодоос гарсан	Утгыг үзүүлэгч	Дуу тоглуулагчаас гарах яруу үг	Дуу тоглуулагчаас гарах ширүүн үг
	Утгыг үл үзүүлэгч	Бивангийн дуу	Хад нурах дуу

Үнэрийн төрөн түгэхүй. Хамрын мэдлийн хүртэгдэхүүн үнэрийн төрөн түгэхүйн бэлгэ чанар. Ангилбаас, сайхан (дотроо тэнцүү ба эс тэнцүү) үнэр ба муухай үнэр (дотроо тэнцүү ба эс тэнцүү) гэж буй.

Амтын төрөн түгэхүй. Хэлний мэдлийн мэдрэгдэхүүн амтын төрөн түгэхүйн бэлгэ чанар. Ангилбаас, амтлаг (чихэр, бурам, бал), исгэлэн (давс, эсгэгч), шорвог (дуршуулагч таван зүйл), халуун (библин, налэшам, гаа), гашуун (цөс, дигд), эхүүн (ар үр, бар үр) гэх нийт зургаа болно. Төрөн түгэхүй нь нээлттэй систем тул цааш нарийвчлан хуваасаар амсах-шингэж дөхөх-шингэж дуусах гурван цагаар нийт 108 төрөлд хуваах нь бий.

Хүртэхүйн төрөн түгэхүй. Биеийн мэдлийн мэдрэгдэхүүн хүртэхүйн төрөн түгэхүйн бэлгэ чанар. Жишээ нь дөрвөн махбод гэх мэт. Ангилбаас, махбодууд (үндсэн) болон тэдгээрээр уг шалтгаан хийсэн дүрс (урвасан махбод) болой. Урвасан махбодын долоон хүртэхүй нь зөөлөн ямагт, ширүүн ямагт, хүнд ямагт, хөнгөн ямагт, хүйтэн, өлсөх, ундаасах болой.

Дотоод дүрс-нүд тэргүүтэй таван эрхтэн

Нүд тэргүүтэй эрхтнүүд нь өөрийн үр дагавар эрхтний тийн мэдлийг үүсгэнэ. Жишээ нь толинд дүрс ургах мэт нүдний эрхтэнд ч өнгө ба хэлбэрийн дүрс ургаад, нүдний тийн мэдэл үүснэ. Мэдлийг үүсгэгч дотоодын тунгалаг дүрсийг нүдний эрхтний бэлгэ чанар гэнэ. Иймд нүдний эрхтэн аль буй хэмээвээс дөрвөн их махбодуудыг шалтгаан болгосон, нүдний тийн мэдлийн шүтээн, тунгалаг дүрс болой. Дүрст эрхтнүүдэд түгэн орших учраас бие хэмээнэ. Нүд тэргүүтэн таван эрхтэн тус бүрд ч тийн мэдлийн шүтээн бологч ба шүтээн адил эрхтэн гэсэн хоёр хоёр буй. Дүрсийг харж байх үеийн нүдний эрхтэн нь шүтээн бологч юм. Харин нойрсох болон нүд аних тэргүүтний үеийн нүдний эрхтэн нь шүтээн адил эрхтний жишээ юм.

Номын төрөн түгэхүйд хамаарах дүрс.

Сэтгэлийн мэдлийн орон болдог дүрс нь номын төрөн түгэхүйн дүрс юм. Дүрс тэргүүтэй таван утга хийгээд нүд тэргүүтэй таван эрхтний аль нь ч биш (биеийг хуваан задалснаар эцэстээ эрхтний мэдлийн орноос хэтрэвч тэдгээр нь дүрс биш болохгүй) дүрсийг номын төрөн түгэхүйн дүрс гэнэ. Зөвхөн сэтгэлийн мэдэлд үзэгдэх, мэдлийн шүтээн эрхтний махбод биш боловч дүрс бологч тэр нь номын төрөн түгэхүйн дүрсийн бэлгэ чанар юм хэмээн их багш Басубанду үзсэн буй. Асанга багш номын төрөн түгэхүйн дүрсийг дараах байдлаар тав ангилсан (Асанга, 2005). Үүнд:

- *Хурснаас тулах дүрс* – бүдүүн дүрсийг задалснаас үүдсэн сэтгэлийн мэдэлд үзэгдэх маш нарийн тоосонцор юм. Хурсан бүхлийг сэтгэлийн мэдлээр хэсэг хэсгээр нь ялгаснаар дүрсийн хамгийн бага хязгаарт тулсан тул хурснаас тулах дүрс хэмээжээ.
- *Ил сийсэн зайт дүрс* – зөвхөн сэтгэлийн мэдэлд цайвартан үзэгдэх завсрын үзэгдэл. Нүдний мэдлээр алсын уулын цайвартах дүрс түүнд багтахгүй боловч түүгээр тамгалагдсан сэтгэлийн мэдэл байж болох.
- *Үнэнхүү авсанаас гарсан дүрс* – нэн мэдүүлэн үйлдэгч бус дүрс гэх мэт. Өөрийг нь анхлан өдөөсөн сэдлээ бусдын оюуны оронд мэдүүлэн үл үйлдэх тул “нэн мэдүүлэн үйлдэгч бус” гэжээ.
- *Бүхэн нэрийтгэлийн дүрс* – Гуа бусыг бясалгаж буй сэтгэлд тодорхой үзэгдэх газар дэлхий хэнгэрцэг ясаар дүүрсэн үзэгдэл зэрэг. Сэтгэлийн мэдэлд зүүдний морь, үхэр, байшин зэрэг таван орон тодорхой үзэгдэх гэх мэт. Зүүдэнд адуу үхэр зэрэг байхгүй тул тэр мэт үзэгдлүүдийг бүхэн нэрийтгэлийн дүрс хэмээжээ.
- *Эрх учралын дүрс* – Гал болон усны барагч самади тэргүүтэнд гал ба ус тэргүүтэн тодорхой үзэгдэх зэрэг. Самади бясалгалын өндөр түвшинд гал ба ус тэргүүтэнд урвуулсан дүрс мөн учраас эрх учралын дүрс гэжээ.

Тэдгээрийн уг шалтгаан болсон үндсэн махбод

Дүрс нь дөрвөн махбод хийгээд тэдгээрийг уг шалтгаан болгон үйлдэх тул дүрс (таван утга болон таван эрхтэн) бүхэн үндсэн ба урвасан махбод хоёрт багтана. Махбод нь шалтгаалан үүссэн дүрс бүгдийнхээ шүтээн болно. Төрөлхтний үндсэнд хамаарсан бол дотоод махбод, эс хамаарсан бол гадаад махбод гэж хуваадаг. Дотоод махбодыг эрхэнд урвуулснаар гадаад махбодыг ч эрхэнд урвуулж болно. Үйлийг ерөөсөө дөрвөн зүйл байна хэмээн үзсэн учраас тэдгээрийг үйлдэх махбодын тоог дөрвөөр тогтоосон байна. Шорооны хувь их бол бэхжүүлэх, усны хувь их бол нэгтгэх, галын хувь их бол боловсруулах, хийн хувь их бол хөдөлгөх үйлүүд тус тус их байна. Иймд дүрс хурсан бүгдэд дөрвөн махбодын хүч хурсан байх учраас түүний бүтцэд дөрвөн махбод бүгд оршино. Гэвч аль их хувьтайгаар нь дагнан нэрлэх тохиолдол ч бий. Харин бага хувьтай нь язгуур (Асанга) хэмээн нэрлэгдэх нь бий. Жишээ нь, хуурай тоосго бол нэг махбод, норгосон тоосго бол хоёр махбод, норгосон бүлээн тоосго бол гурван махбод, норгосон бүлээн тоосгоны хэлтэрхий унах нь дөрвөн махбод болно. Тоосны найман эд гэдгийн эд нь чадамж буюу хөрөнгө мэт нэгэн бөгөөд заавал илэрч байх албагүй тул үзэгдэх үедээ илрэх хийгээд үл үзэгдэх үедээ хөрөнгийн ёсоор оршино. Дөрвөн махбод нь ус, шороо, хий, гал байхаас гадна их нарийвчилсан түвшинд тэдгээр дөрөв жинхэнээрээ биш харин чадамж төдий нь байж болно. Өөрөөр хэлбэл, дөрвөн махбодын эд нь заавал бөөгнөрөн бүтсэн зүйл биш, харин чадамжийн төлөв чанарт оршиж болно.

Төгөлдөр бус хуран үйлдэгч

Хуран үүдсэн юмсыг дүрст юмс, дүрст бус мэдэл, төгөлдөр бус хуран үйлдэгч хэмээн гурав ангилдаг. Төгөлдөр бус хуран үйлдэгч нь дүрст ба дүрст бус мэдлийн алинд ч хамаарахгүй зүйл юм. Сэтгэл лүгээ адил төгөлдөр бус хуран үйлдэхүйн цогц байж болно. Бэлгэдлийн суурь, тухайлбал, хумхын төрөх, орших, эвдрэх гурван төлөв, түлээчний мод таслах, уг үрийн дараалан гарах горим, хүнд эрдэм байгаа зэрэг нь төгөлдөр бус хуран үйлдэгч бас мөн. Мөн цаг, жил, сар, хоног, бодгаль, амь, хумханд ус хадгалах зэрэг үйлүүд, зүүн, урд, баруун, хойт зүг зэргүүд түүнд хамаарна.

Уг ба үрийн ойлголт

Хуран үйлдэхүй бүгд өөрийн уг шалтгаанд шүтээд гарах нь ёс юм. Өөрийн үр дагаврыг үүсгэгч нь уг шалтгааны бэлгэ чанар. Арван зүйл шалтгааныг дурдъя. Үүнд: гаргах шалтгаан (жишээ нь: гурван нөхцөл бүрдэх), оршихуйн шалтгаан (жишээ нь: дөрвөн идээ), тулгуур шалтгаан (жишээ нь: газар шороо), тодруулагч шалтгаан (жишээ нь: зул), хувиргагч шалтгаан (жишээ нь: гал), хорих шалтгаан (жишээ нь: эм тан), олгогч шалтгаан (жишээ нь: эмчилгээ), ойрын шалтгаан (жишээ нь: бодит шалтгаан)-өөрийн үрийг шууд бодитой үүсгэнэ. Гал нь утааны бодит шалтгаан мөн. Холын шалтгаан (дамжих шалтгаан) – өөрийн үрийг дамжин үүсгэнэ. Түлээ бол утааны дамжих шалтгаан мөн. Мэдүүлэгч шалтгаан (жишээ нь: утаа), чухал авах шалтгаан (жишээ нь: үр) – өөрийн чухал үрийг өөрийн эдийн үргэлжлэл болгон голлон үүсгэгч эсвэл чанар болон онцлог ялгамжаа хоёроос чанарыг голлон үүсгэгч нь чухал авах шалтгааны бэлгэ чанар болно. Шавар бол шавар хумхын чухал авахуй мөн. Хамтран үйлдэгч шалтгаан (ялгамжааг үүсгэгч) бас байна. Заримдаа хоёр ч төрлийн шалтгааныг нэг зүйл үүсгэж болно. Жишээ нь тос барагдах нь зул жаргахын үүсгэгч ба мэдүүлэгч хоёр шалтгаан зэрэг

болно. Дотоодын сургаалд шалтгааныг уг/чухал авах (тусгай) ба нөхцөл/хамтран үйлдэгч (нийтлэг) хэмээн хоёр хувааж сургасан. Уг гэдэг нь тухайн юмсын гол үүсгэн үйлдэгч буюу чухал авах шалтгаан юм. Нөхцөл гэдэг нь уг түүнийг өөрийн үр дагавраа үүсгэхийн нөхөр болгодог хамтран үйлдэгч нөхцөл мөн. Чухал авагч нь голлон мөн чанарыг үүсгэгч бол хамтран үйлдэгч нь голлон ялгааг үүсгэнэ. Ийнхүү гадаад дотоодод бүх бодит юмс чухал авагч ба хамтран үйлдэгч нөхцөл хоёрын нийлбэрт шүтээд үүсдэг.

Өөрийн шалтгаанаар үүсгэгдэхүүн нь үрийн бэлгэ чанар. Шавар хумх, алтан хумх, ногоо зэрэг нь чухал үр мөн. Харин шаварчин, алтны дархан, үр суулгагч, ус бордоо тэргүүтэн нь хамтран үйлдэгч үр мөн. Хумх өөрийн уг шалтгааны үр боловч өөрийн үр дагаврын уг мөн.

Оюуны мэдэгдэхүүн лүгээ холбогдсон орны бусад ойлголтууд

Бэлгэ, бэлгэдэл, суурь гурав. Мэдэгдэхүүнийг мөнх ба мөнх бус хэмээн хоёр ангилахаас гадна ба бэлгэ, бэлгэдэл, суурь хэмээн гурав ангилна. Жишээ нь, хумх бэлгэдлийн суурь, мэдэгдэхүүн нь бэлгэдэл, оюуны оронд үйлдэж бологч нь бэлгэ чанар мөн. Бэлгэ чанар нь язгуур үл зохилдсоныг арилгасан байхын тулд доорх гурван гэмээс хагацсан байх ёстой. Үүнд: 1. эс түгэхийн гэм, тухайлбал, арцыг модны бэлгэ чанарт тавих (арцны түгэлт бага тул) 2. хэтрэн түгэхийн гэм, тухайлбал, газраас ургасныг модны бэлгэ чанарт тавих (мод биш ургамал ногоо бас буй тул) 3. бэлгэдлийн сууриндаа эс оршихын гэм, тухайлбал, хумхыг модны бэлгэ чанарт тавих (хумх модонд таарахгүй тул). Бэлгэ чанарыг тодорхойлохдоо дан ганц үйлчлэлийн талаас нь, эсвэл үйлчлэл ба чанар хоёрыг хавсран илэрхийлэх талаас нь хандана. Тухайлбал, “Нурууг тулах үйлийн талаас нь багана” гэж үзэх, “Өөрийн үрийг үүсгэгч талаас нь угийн бэлгэ чанарыг тодорхойлох” нь үйлчлэлийн жишээ болно. Харин “халуун (чанар) хийгээд түлдэг (үйлчлэл) нь галын бэлгэ чанар”, “Хөнгөн (чанар) хийгээд хөдөлдөг (үйлчлэл) нь хийн бэлгэ чанар” гэх мэт.

Сав шим ертөнц

Хутагт Асанга сав шим ертөнцийг гурван нөхцөлийн үүднээс тайлбарлажээ. Тэдгээр нь

1. хөдлөлгүй нөхцөл
2. мөнх бусын нөхцөл
3. чадамжит нөхцөл болой.

Хөдлөлгүй нөхцөл нь сав шимийн ертөнцүүд зөвхөн шалтгаан байснаар бүтэхээс, ямар нэгэн бүтээгчийн сэтгэл хөдлөлөөс бүтсэн зүйл биш хэмээн нотолдог. Энэ нь Буддын ухааны үндсэн гол чиг юм. Тэр нь шинжлэх ухааны үндсэн чиглэлтэй ч маш таарч байна. Дотоодын номлолд ертөнцийн орон эхлээд тогтож (үүсэж), дараа нь оршиж, тэгээд эвдэрч, эцэст нь хоосон болно хэмээн үздэг бөгөөд хоосны үед (бүх дүрс) агаар мандлын маш нарийн тоос буюу хоосны тоос болно. Тэгээд тэдгээрээс дахин шинэ ертөнцийн орон бүтэх тул үүсэл, оршил, эвдрэл, дахин хоосон гэсэн дараалсан дамжлагын хүрд үүгээр хязгааргүй үргэлжилнэ. Хоосны үеийн агаар мандлын маш нарийн тоосыг “Цагийн хүрд”-нээс огторгуйн тоос хэмээн нэрлэсэн хийгээд бүхий л дүрст юмсын уг язгуур болох ба бараг чадамж төдийд орших тул ил тодорхой бүхэл байдлаар биеэ даан орших зүйл байхгүй гэж үзнэ. Тэдгээр огторгуйн тоосны хүчинд тулгуурлаад дөрвөн махбод нь нарийн оршихуйн дарааллаас бүдүүн оршихуйн дараалал руу үүсэх хийгээд дахин оршихуйн бүдүүн хэлбэрүүдээсээ оршихуйн нарийн хэлбэрүүдийг дамжин алгуур задарсаар эргээд огторгуйн тоосны мөн чанарт шингэх тул маш нарийн огторгуйн тоос

нь ертөнцийн үүсэл эвдрэлийн бүхий л дамжлага дарааллын үндсэн шалтгаан болж байна. Буддын ухаанаар гаднын сав ертөнцийн үүсэл нь дотоод шимийн амьтантай холбоотой хийгээд шимийн амьтны эдүгээ бидэнд ил байгаа бүдүүн бие нь өөр нарийн зүйлтэй холбоотой ба нарийн тэр нь ч эцэстээ ялгах боломжгүйгээр хосолсон асар нарийн хий сэтгэлээс бүтэх ёсыг номлосон тул бидний бие цогцос бээр агуу ертөнцийн орон түүнийг нарийн хувилбараар бэлгэдэн оршдог юм.

Дүрс (биет)-ийг их багын хэмжээ, эрхтэнд танигдах ёсны үүднээс ялгаж нарийн бүдүүн хэмээн хуваадаг. Бүдүүн юмс үзэгдлүүд нарийныг хураах буюу нэгтгэснээс үүснэ. Бүдүүн дүрсэнд том нь сав ертөнцийн газар дэлхий мэт хийгээд жижиг нь нарны гэрлийн тоосонцор тэргүүтэй их, бага элдэв төрөл байна. Нарийн дүрс нь олон төрөл бөгөөд хамгийн нарийн нь маш нарийн тоосонцор юм. Дүрст юмс дөрвөн их махбодыг уг шалтгаан болгон үүссэн. Сав шимийн ертөнц анх тогтох цагт огторгуйн зүг бүрд орших мөнхийн бөгөөд хуваагдашгүй дөрвөн махбодын маш нарийн тоосонцоруудаас сав шим ертөнц дараалан үүссэн. Түүний эцсийн үндсэн шалтгаан нь мөнх, хуваагдашгүй нарийн тоосонцор гэж үздэг. Дүрст зүйлс тоосны найман эдийн нэгдлээс бүтнэ. Тоосны найман эдийн дөрвөн махбод нь шороо, ус, гал, хий байдаг бол урвасан дөрвөн махбод нь дүрс, үнэр, амт, хүрэлцэхүй юм. Маш нарийн тоосонцорт хуваагдашгүй маш нарийн эдийн тоос, хуваагдагч маш нарийн хураах тоос хоёрыг оруулдаг.

Ертөнцөд үүсэх үе, орших үе, эвдрэх үе, хоосон орших үе гэсэн дөрвөн үе байдаг. Галав нь мөн нэгэн адил эвдрэх галав, хоосрох галав, тогтох галав, орших галав төрөлтэй. Хоосон ахуй үест огторгуйн хоосон тоосоор суурь хийгээд шинэ ертөнц бүтнэ. Сав ертөнц эвдэрсний дараа орших маш нарийн тоосонцруудыг хоосон тоос хэмээнэ. Шороо, ус, гал, хий, огторгуй, билиг билгүүний гэсэн зургаан төрлийн хоосон тоос бий.

Ертөнцийн орон дотор хүмүүн бидний оршин байгаа тив нь замбуутив юм. Дөрвөн тив, бага тив, сүмбэр уул, нар, сарыг багтаасан ертөнцийг “нэгж ертөнц” болгон авах нь бий. Нэг мянган нэгж ертөнцийг нийт мянганы дээж ертөнцийн орон (НМДЕО) гэнэ. Нэг мянган НМДЕО-г хоёрдугаар мянган буюу завсрын ертөнцийн орон гэнэ. Нэг мянган завсрын ертөнцийн оронг гурван мянгын их мянган ертөнцийн орон гэнэ.

Цаг хугацааны тухай ойлголт

Цаг хэмээх нь төгөлдөр бус хуран үйлдэгч зүйл мөн. Иймд цаг нь хуран үйлдсэн юмсын гараагүй байгаа, гараад дуусаагүй байгаа, гараад дууссан гурван ахуй үест нэрийдэн агуулах төдий бөгөөд дангаараа орших, биеэ даасан бодит нэгэн зүйл байхгүй юм. Зүйлчлэн өгүүлэгчийн ёсонд гурван цагийг тодорхойлохдоо бодит зүйл бусдад урвах, бэлгэ чанар бусдад урвах, ахуй үес бусдад урвах, бусад бусдад урвах хэмээн номлосон ажээ. Харин судрын аймагтан, сэтгэл төдийтөн, төв үзэлтэн нар гурван цагийг тодорхойлох ёс нь адилхан. Тэд нь өнгөрсөн, ирээдүй хоёрыг бодит биш, мөнх гэж үзээд, одоог бодит зүйлтэй нэг утгатай хэмээжээ. Өөрийн үгүйсгэгдэхүүн бодит зүйл рүү эвдэрсэн хувь нь өнгөрсний бэлгэ чанар. Төрөөд устаагүй нь одоогийн бэлгэ чанар. Төрөөгүй хэсэг нь ирээдүйн бэлгэ чанар. Судрын аймагтан, сэтгэл төдийтөн, өөрийн үест гуравт өнгөрсөн ирээдүй хоёрыг байхгүйн үгүйсгэл гэж үзэлгүйгээр бишийн үгүйсгэл хэмээнэ. Өнгөрсөн, ирээдүй, одоо хэмээх нь харгалзах суурь өөр

өөрт харгалзаад бодлоор нэрийдсэн болон алдаршсаны үүднээс тавихаас өөрийн бэлгэ чанарт гурван цагийг тавихгүй.

Цагийн нэгжүүдийг их багш нар өөр өөрөөр сонгон сэтгэж байсан. Өөрийн мөн чанараасаа бүтсэн агшин байхгүй хэмээн үздэг. Их багш Басубанду цагийн хуваагдашгүй хамгийн богино нь “цагийн хязгаарын агшин” гэж үзжээ. Түүний хэмжээг нас бие гүйцсэн нэгэн төрөлхтний нэг инчдэх хугацааг жаран таван хэсэг хуваасны нэг хэсгээр илэрхийлнэ гэжээ. Цааш нь тодорхой тоон харьцаагаар агшин, хурам, хором, хоног, сар гэх мэт нэгжүүдийг тооцох болжээ. Харин их багш Дхармагирди нэг маш нарийн тоосны байраа солих буюу эргэн хөлбөрөх хугацааг “цагийн хязгаарын агшин” хэмээсэн. Гэтэл их багш Чойшэйжи хүч төгөлдөр төрөлхтний инчдэх хугацааг гурван зуун жаран найман хэсэгт хуваасны нэг хэсгийг “цагийн хязгаарын агшин” гэжээ. Шалтгаан нөхцөл байгаа учраас хувьсан өөрчлөгдөх боломжтой. Агшин агшнаар өөрчлөгдөх нарийн хувиралт байдаггүй бол бүдүүн хувиралтууд илэрч чадахгүй. Иймд агшинт нь мөнх бусын бэлгэ чанар юм.

Хүний бие бүрэлдэх

Дотоодын номлолуудад төрлийн оронд ураг барилдаад, умайд хүний биеийн бүрэлдэх дарааллын тухай тодорхой номлосон байдаг ажээ. Энэ насны төрөл нь урьд төрлөөсөө энд ирсэн гэж үзнэ. Сансар нь төрлийн сансар, өмнө үеийн сансар, үхлийн сансар, зуурдын сансар хэмээх дөрвөн төрөл байна. Төрөх нь өндөгнөөс төрөх, умайгаас төрөх, бүлээн чийгээс төрөх, хувилж төрөх гэсэн дөрөв буй. Эцгийн цагаан дусал, эхийн улаан дусал, зуурд гурваас шалтгааны чуулган бүрдвээс сүнс эхийн умайд орох болно. Умайд бие бүрэлдэх дарааллыг судар аймгаас, цагийн хүрдний дандараас, эмийн номоос тус тус номлосон буй. Судрын аймагт гучин найман долоо хоногийн турш умайд бие алгуур бүрэлдэх ёсыг зарлигласан. Бие нарийнаас бүдүүн болох үесийг мэлмэлзүүр, нялцагнуур, нитэгнүүр, чийрэгжүүр, хөл гар ургахуй хэмээн таван шатаар үзүүлжээ. Цагийн хүрдний номлолд өгүүлснээр эхийн умайд орсон дусал, цус, сүнс гурвын нэгдмэл хөрөнгө алгуур бойжоод, судал ба хийнүүд нь дараалан бүтэж, биеийн хэсгүүд нь ургаж, эрхтэн нь тогтох тэргүүтнийг загас, яст мэлхий, зэрлэг гахай, арслантай адилтган зарлигласан байна. “Найман гишүүний шимийн хураангуй” номлол нь эмийн номлолыг нарийн үзүүлсэн ажээ. Эмийн номд биеийн чухал авагч шалтгаан эцэг эхээс өвлөсөн эсүүд, бодит байдалдаа сүү ус нийлсэн мэт оршивч, ялгаж ойлгох боломжтой хэмээжээ. Тухайлбал, эцгээс өвлөсөн эсээс яс, тархи, нугас үүснэ. Эхээс өвлөсөн эсээс мах, цус, зүрх, уушги, дэлүү, бөөр зэрэг таван цул, бас зургаан сав эрхтэн үүснэ.

Бие сэтгэлийн холбоо

Эхийн умайд ураг тогтохтой нэгэн зэрэг дүрст, сэрэхүй, хуран мэдэл, хуран үйлдэхүй, тийн мэдлийн таван цогцос бүтнэ. Бие нь сэтгэлийн ухамсар, бодлын нөхцөл төдийг үүсгэх боловч тэдгээрийг өөрчлөхгүй. Харин эсрэгээр сэтгэлийн ухамсар нь биед өөрчлөлт үзүүлнэ. Тухайлбал, бусдад туслахыг хүссэн асрахуйн сэтгэл үүссэнээр биеийн цус тунгалагшиж, царайны өнгө тодорч, харваас үзэсгэлэнтэй болно. Ханьцашгүй нууц тарнийн номлолуудад нарийн хийн бие хийгээд тийн мэдлийн барилдлагыг сайтар номлож, тийн мэдлүүдийг хийн унаатан хэмээн номлосон. Энэ нь үлгэрлэвээс, хөлгүй нүдтэй, хөлтэй сохор хоёр нэг нэгнээ шүтээд өөр газар оронд зорчих чадамжтай болдог мэт юм. Ийнхүү хий ба тийн мэдлүүд

барилдваас орныг танихын чадал төгөлдөр болмуй. Хий сэтгэлийн орох судал нэг байдаг. Иймд сэтгэлээ тогтоон бариваас хийг эрхэндээ хураах бөгөөд хийг эрхэндээ хурааваас сэтгэлийг эрхэндээ хураана. Биеийг ариусгаваас судал ариусах, судлыг ариусгаваас хий ариусах, хий ариусваас сэтгэл ариусна хэмээжээ. Бие, сэтгэл хамтдаа орших нь жам ёс бөгөөд тэр хоёр нь хэзээ ч хагацашгүй нарийн хий сэтгэлийн туйл болсон ялгажгүй шинж чанарт юм.

Эрхтний мэдэл ба сэтгэлийн мэдэл

Мэдэл нь мэдрэмжийн шинж чанар төдийд бүтсэн боловч оюунд баригдсан зүйлийг өөртөө ургуулж, тодруулах чадамжтай байдаг. Мэдлийг оронт ухамсар хэмээн тодотгох нь ч бий. Ханьцашгүй тарнийн номлолуудад мэдлийг гэнэтийн мэдэл, угийн мэдэл хэмээн хоёр хуваадаг ажээ. Гэнэтийн мэдэл нь эрхтний болон сэтгэлийн эрхтэнд шүтсэн мэдлүүд юм. Бие үгүй болоход гэнэтийн мэдэл хаагдаж, угийн мэдэл үлдэнэ. Гэнэтийн мэдлийг дотор нь эрхтний мэдэл, сэтгэлийн мэдэл хэмээн хоёр ангилна. Нүдний мэдэл дүрсэнд зорино. Чихний мэдэл дуунд, хамрын мэдэл үнэрт, хэлний мэдэл амтанд, биений мэдэл хүртэхүйд чиглэнэ. Дүрс, дуу, үнэр, амт, хүртэхүйг таван утга, бас зоригдол нөхцөл болно. Таван эрхтэн нь эзэнт нөхцөл болно. Сэтгэлийн мэдлүүдийн эзэнт нөхцөл нь сэтгэлийн эрхтэн юм. Сэтгэлийн мэдлийн тодруулагч чанар нь даруйтын нөхцөл болно. Харах хүсэл, сонсох хүсэл зэргийн сэдэл нь сэтгэлийн мэдэл юм. Нүдний мэдэл нь элдэв цэцгийн баглааг харах үед олон төрөл цэцгүүд нийлээд нэг л бүхэл болж үзэгдэнэ. Харин аль нэгэн цэцгийг нь онцлоод санаа бодолдоо бодохын цагт эрхтний мэдлээс хэтрээд сэтгэлийн мэдэл рүү шилжинэ. Сэтгэлийн мэдэлд өнгөрсөн, бас ирээдүйн бодлоор элдэв үзэгдэл ургаж болох ч эрхтний мэдэлд тийнхүү ургаж чадахгүй. Сайн мууг ялгах оюун ч сэтгэлийн мэдэлд хамаарна.

Эрхтний мэдлүүд нь бүгд атгаг үгүй ухамсар юм. Харин сэтгэлийн мэдэлд атгаг болон атгаг үгүй оюун хоёул байдаг. Орныг шууд мэдрэх нь атгаг үгүй мэдэл болно. Харин тухайн оронтой адил төстэй зүйлийг баригдахуун болгож мэдрэх нь атгаг мэдэл буюу бодол болно. Тухайлбал, одоо үед өчигдрийн хоолыг дурсан санах бодол. Мөн нүдээ аниад сэтгэлдээ ургуулан сэтгэлийн мэдэл нь атгаг мөн.

Сэтгэл ба сэтгэлээс бологч

Сэтгэл, ухамсар, тийн мэдэл гурав нь утга нэг юм. Орныг мэдэх үйлийн талаасаа ухамсар, орны байдлыг нарийвчлан ялгах талаасаа тийн мэдэл, тийн мэдэхүйн авьяас хураах талаасаа сэтгэл болно. Сэтгэлийг ангилваас нүдний тийн мэдлээс сэтгэлийн тийн мэдлийг хүртэл зургаа байна. Сэтгэл нь тийн мэдэл тул хийн унаатай юм. Хийн унаа нь нарийн бүдүүнтэй байх учир түүнийг үндэслэн сэтгэлийн нарийн бүдүүний онцлогийг ялгаж үздэг.

Орны шинж чанарыг таних нь гол сэтгэл (сэтгэл)-ийн үйл, харин орны ялгааг нь нарийвчлан таних нь нөхөр сэтгэл (сэтгэлээс бологч)-ийн үүрэг юм. Сэтгэлээс бологчийг дөчин зургаа, тавин нэг, далан тав, далан найм, ерэн дөрөв, нэг зуун арван хоёр, нэг зуун арван долоо, нэг зуун арван ес гэх мэтээр олон янзаар ангилах нь бий. Мөн дэд ангиллууд бий. Тухайлбал, сэтгэлээс бологчийг задлан үзвээс, бүхэнд одогч тав, орны магадлалт тав, арван нэгэн буян, үндсэн зургаан нисванис, ойрын хорин нисванис, бусдад урвагч дөрөв, нийтдээ тавин нэг гэх мэт.

Сэтгэлийн нарийн бүдүүн ба үхлийн явц

Хүний бие, сэтгэл, мэдэл, хийн унаа нь тус бүрдээ нарийн бүдүүнээр ангилагдана. Тэдгээр нь өөр хоорондоо бас нягт шүтэн барилдлагатай. Хүний амьд байх үеийн мэдэл нь бүдүүн мэдэл, үхэх үеийн мэдэл нь нарийн байна. Хүн сэрүүн байх үеийн мэдэл нь бүдүүн, зүүдний үеийн мэдэл нь нарийн, гүн нойрны үе нь ч бас нарийн мэдэлтэй байна. Хүн үхэхийн цагт биеийн дөрвөн махбодын чадамж доройтож, илч алгуур хураагдаад, эрхтний мэдлүүд хаагдаж, эцэст нь ганцхан сэтгэлийн мэдэл орших ба сэтгэлийн мэдэл ч бүдүүнээсээ эхлэн нарийн хүртэл дараалан хаагдаж, эцэстээ нарийн үхлийн сэтгэлд тулна. Нарийн түвшиндээ хий сэтгэл хоёр нэг мөн чанартай. Мөн бие нь бүдүүн нарийнтай байх бөгөөд гар, хөл тэргүүтнийг бүдүүн бие, биеийн судал, хий, дусал гурав нь нарийн бие, дөрвөн хоосны сэтгэлийн унаа болсон хий нь машид нарийн бие болно. Хүний таван эрхтний тийн мэдлүүдийг бүдүүн сэтгэл гэнэ. Үндсэн ба ойрын нисванисууд нь нарийн сэтгэл болно. Дөрвөн хоосны шинж чанар болсон сэтгэлүүд нь машид нарийн сэтгэлүүд юм. Тэр дөрвийн дотроос дөрөвдүгээр хоосон гэгээн гэрлийн сэтгэлийг машид их нарийн сэтгэл гэж үзнэ. Бие, сэтгэл хамтдаа орших нь жам ёс бөгөөд тэр хоёр нь хэзээ ч хагацашгүй нарийн хий сэтгэлийн туйл болсон ялгашгүй шинж чанарт юм. Нарийн хий сэтгэлийн оролт нэг, шинж чанар нь ялгашгүй бөгөөд орныг тодруулсан хэсэг нь мэдэл, хөдлөх хэсгийг нь хий гэж үзнэ. Иймд хий нь тийн мэдлийг хөдөлгөж үйлдэх утга юм. Тийн мэдэл нь дангаараа орон луу очих чадамжгүй бөгөөд хийтэй хамт оршвоос оронд зорчих чадамжтай болно.

Үхлийн явцад махбод, хий сэтгэлийн шингэх дарааллыг авч үзье. Үхэхийн цагт эхлээд усан махбод нь гал махбодыг доройтуулан үйлдэж, улмаар шороон махбод нь усанд шингээд үл үзэгдэх болно. Тэгээд усан махбод ч хийгээр хатаж үйлдэнэ. Хий нь огторгуйд дараалан шингээд үл үзэгдэх болох цагт төв судлын зангилаа өөрөө тайлагдаад ро, жан хоёрын хийн гүйлт хаагдаж, хий төвд орж шингэвээс гэнэтийн орны үзэгдлийн атгаг бүгд хаагдах тул цацралын хязгаар бүгдээс хагацсан хоосон огторгуй мэтийн байдалт, гэгээн гэрлийн мөн чанарын сэтгэл өөрөө аяндаа ургана. Үүнийг үхлийн гэгээн гэрлийг илт үйлдэх хэмээн номложээ. Шороо усанд шингэх үеийн гадаад шинжид гар хөл нарийсах, өнгө зүс алдах, хараа тодорхой бус болох зэрэг илрэх бол дотоод шинжид зэрэглээ мэт үзэгдэл ургана. Ус галд шингэх үеийн гадаад шинжид биеийн чийг хатах, ам хатах, нүдний чийг хатаж хөдөлгөөн багасах орно. Дотоод шинжид утаа мэтийн үзэгдэл ургана. Гал хийд шингэх үеийн гадаад шинжид биеийн илч хураагдаж, гар хөл хөрч халууныг үл мэдрэх, хүн танихгүй болох илрэнэ. Дотоод шинжид галт хорхой үсрэх юм уу, галын оч үсчих мэтийн үзэгдэл ургана. Хий тийн мэдэлд шингэх үеийн гадаад шинжид амьсгал тасрах ба дотоод шинжид зул гэлбэлзэн бадрах мэтийн үзэгдэл ургана.

Бүдүүн тийн мэдлүүд нарийн тийн мэдэлдээ шингэх болсноор дөрвөн хоосны үзэгдэл ургаж, ганцхан хамт төрсөн нарийн хий нь ухамсрын шүтээнийг үйлдэнэ. Хий гэгээнд шингэнэ хэмээх нь мөн чанарын атгагийг бодитоор хөдөлгөн үйлдэгч хийнүүд тийн мэдлийн унаа болох чадамжаа алдаад, түүний чадамж нь гэгээний хийд юүлэгдэх мэт болохыг хэлнэ.

Дөрвөн хоосон нь:

1. Хоосон. Мөн чанарын наян бүхэн атгаг өөрийн унаа хийн хамт үзэгдэлд шингэх үе бөгөөд үүлгүй огторгуйд сарны гэрэл ургах мэтийн үзэгдэл гарна.

2. Машид хоосон. Цэлмэг огторгуйд нарны гэрэл ургах мэт улаан юм уу, улаан шаргал үзэгдэл ургана.

3. Их хоосон. Цэлмэг огторгуйд завсрын харанхуй түгэх мэт хар мөрт үзэгдэл ургаж, дурьдал доройтон одно.

4. Бүхэн хоосон. Үүрийн цэлмэг огторгуй мэтийн үзэгдэл ургах ба тэр нь үхлийн гэгээн гэрэл юм хэмээжээ. Үхлийн гэгээн гэрэлд хүний сүнс ихэнхдээ гурав хоногийн турш оршино. Харин егүзарва нарын хувьд хоногийн тоо олон цөөний магадлалгүй гэжээ.

Орныг танин мэдэх ухамсрын чадамжийг хөгжүүлэх нь.

Оюун оронд хандах ёсны үүднээс түүнийг долоо ангилах нь бий. Үүнд:

1. Буруу мэдэл буюу үл мэдэхүйн эрхээр хэтрүүлэх, гүжирдэх мэтийн чанх буруу ухамсрууд.

2. Тээнэгэлзэл буюу нэг талыг барьсан их хүчит буруу атгагуудыг хэтрүүлгээр буцаах.

3. Төсөөлөл буюу үнэн зөв нотолгооны гуравласан ёс тэргүүтэй учир шалтгааныг санах.

4. Даган жишигч/шалгагч буюу нотлогдохуунд баттай магадлалыг олсон.

5. Шийдсэн мэдэл/жич мэдэл буюу магадлалыг олоод дадуулсан ухамсар.

6. Илт мэдэл буюу утгын ерөнхийн саадгүйгээр орныг тодорхой үзсэн.

7. Үзээд үл магадалсан буюу үзэвч түүнийг нарийн тодруулаагүй ухамсар тус тус багтана.

Орныг танигч ухамсрын чадамжийг хөгжүүлэхэд ухамсрыг зоригдолд нь төвлөрүүлэх, оюун санааг засах аргууд чухал юм. Оюун санааг засах аргуудыг хураангуйлваас хоёр болой. Нэгд, шунал тэргүүтэй нисванис зэрэг муу ухамсрын язгууруудын хүчийг алгуур бууруулж засах хэрэгтэй болно. Хоёрт, асрал, нигүүлсэл, билгүүн зэрэг сайн язгуурын ухамсруудыг алгуур дээш хөгжүүлэн дадуулж үйлдэх болно. Их багш Асанга нисванисийн зургаан шалтгааныг дурдсан буй. Үүнд: 1. Шүтээн буюу нисванисын хөрөнгө нь нөхцөл бүрдмэгц өөрийн сэтгэлд нисванисыг төрүүлэх суурь. 2. Зоригдол буюу сэтгэлд зохистой эсвэл зохисгүй оронтой тулахад нисванис төрнө. 3. Хуран үймээн буюу муу нөхрийг даган суралцах. 4. Номлол буюу уур тачаалыг хөдөлгөх үг. 5. Дадал буюу урьдын нисванисыг дахин дахин дадуулсан зуршил. 6. Сэтгэлийн үйлдвэр буюу муу ухамсрын язгууруудын тухай дахин дахин нэхэн бодох юм. Нисванис тэргүүтэй гэм алдаа бүхний ёзоор нь мунхагт тулна хэмээжээ. Мунхгийг зам харгуй мэтийн бүдүүн оронд мунхарсан, уг үрийн ёсонд мунхарсан, авал орхилын оронд мунхарсан, орны оршихуй ёсонд чанх буруугаар мунхарсан зэргээр олон ялгаж үзнэ. Алив мунхралын ерөндөг нь зөвхөн тухайн утгын үнэн зүй тогтлыг мэдсэн билгүүн мөн хэмээжээ. Мөн түүнчлэн хорлох сэтгэлийн ерөндөг нигүүлсэнгүй, уурын ерөндөг тэвчээр, атаархлын ерөндөг даган баясах, хүсэл тачаалын ерөндөг гуа бусыг сэтгэлдээ үйлдэх, тийн атгагийн ерөндөг амьсгал авах гаргахыг бясалгах, омгийн ерөндөг цогц орон төрөн түгэхүйн тийн ялгааг санах, үл мэдэхийн ерөндөг сонсохыг шүтэх, живэхийн ерөндөг сэтгэлээ өрнүүлэн магтах, догшрохын ерөндөг үхэл мөнх бус, уйсал гансралыг санах гэх мэтээр нарийвчлан номложээ. Тухайлсан ерөндүүд нь тухайн нисванисуудын толгойг дарж чадах боловч бүрэн арилгаж чадахгүй. Тиймээс нисванис бүхнийг бүрэн арилгах ерөндөг нь юмс үзэгдлийн оршихуй ёсыг оносон билгүүн юм хэмээжээ.

Үнэн зөв нотлохуйн ухааны үүднээс орныг судлахад сонсох, санах, бясалгах гурвын билгүүнүүд дараалан гарах болно (Б.Мөнхбаатар, 2020; Б.Дарамбазар, 2018; Ц.Бат-Итгэл, 2022). Тэр гурвын төлөв чанарыг дээшлүүлэх замаар оюун ухааныг өөрчлөх ёстой юм. Дотоод сэтгэлд өөрчлөлт оруулах нь гадны юмсыг урлаж засах мэт биш, алив оронд хандах байдал, үргэлжийн

сэтгэлийн байдал, мэдрэмж, мэдрэхүйн дадал зуршил, дуршил тэргүүтэнд өөрчлөлт оруулах байдлаар явагдана. Сэтгэлийн мөн чанар нь тодорхой гэрэлт бөгөөд муу хирүүд нь зуурдынх юм. Уур тэргүүтэй нисванисууд сэтгэлийн мөн чанарт оршсон бус, гэнэтийнх мөн тул ерөндгийн хүчээр тэдгээрийг сэтгэлээс арилгаж болно хэмээн номлосон буй.

Дүгнэлт

1. Буддын ухаан нь сав шимийн ертөнцүүд ямар нэгэн бүтээгчийн сэтгэл хөдлөлөөс бүтдэггүй, харин зөвхөн шалтгаан нөхцөл байснаар бүтдэг хэмээн нотолдог.
2. Буддын танин мэдэхүйн үндсэн аргуудад нотлохуйн ухаанаар шинжлэх, мөн бишийн дөрвөн талыг шинжлэх, дөрвөн итгэмжийг эрэмбэлэн баримтлах, сонсох, санах, бясалгах тэргүүтэн тус тус багтана.
3. Суурь бодит юмсын ангилал нь цогц, язгуур, төрөн түгэхүй гурваар, мэдэгдэхүүний таван сууриар, гурван бэлгэ чанараар, суурь, мөр, үрийн үүднээс гэх зэргээр олон төрөл буй.
4. Буддын философи нь дөрвөн тамгад суурилан дөрвөн тогтсон тааллын хүрээг хамардаг.
5. Сэтгэл, ухамсар, тийн мэдэл гурав нь утга нэг юм. Орны шинж чанарыг таних нь гол сэтгэлийн үйл, харин орны ялгааг нь нарийвчлан таних нь нөхөр сэтгэлийн үүрэг юм.
6. Бие, сэтгэл, мэдэл, хийн унаа нь тус бүрдээ нарийн бүдүүнээр ангилагдана. Үхлийн явцад махбод, хий сэтгэл нь бүдүүнээсээ эхлэн нарийн руу хэрхэн шингэх дарааллыг ургах үзэгдэлтэй нь уялдуулан нарийвчлан авч үздэг.

Ном зүй

1. Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: Шинжлэх ухааны хэсэг, Боть 5. 2016. Түвд хэлнээс орчуулсан С.Гантөмөр.
2. Зонхова Лувсандагва, Их бодь мөрийн зэрэг, УБ., 2006.
3. В. Alan Wallace. The Attention Revolution: Unlocking the power of the focused mind. 2006.
4. Б.Мөнхбаатар, Буддын бясалгал ба сэтгэл судлал, УБ., 2020.
5. Б.Дарамбазар, Багшийн егүзерийн бясалгалын хөтөлбөр, УБ., 2018
6. Ц.Бат-Итгэл, Бясалгалын сургалт, 2022-05-29-өөс 2022-06-06. УБ. Батцагаан дугана.
7. Судар бичгийн алтан сан, УБ. 2013.
8. Шантидева, Гэгээрлийн зам (Бодичарьяаватара), НЕПКО хэвлэлийн газар, 2009, х144.
9. Ширнэн (Билгийн зүрхэн) судар, Цогт цагийн хүрдэн төв.
10. Асанга. (2005). Их хөлгөний хураангуй ба Абхидхарма бүхнээс түүсэн.
11. Жадамба судар. (2014). Бугат Л.Алтангэрэлийн шинэ орчуулга.
12. Т.Булган. (2010). Буддын философийн дэвтэр.
13. Лувсанбалдан гавж (Оргючийн лам). (2009). Бодьсадвын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар. Т.Булганы орчуулга.
14. Шүтэн барилдлагын магтаал сайн номлолын зүрхэн хэмээх оршивой. (2006). МБШТөв Гандантэгчэнлин хийд.
15. Очироор огтлогч хэмээх их хөлгөн судар. С.Гантөмөрийн орчуулга.

4.6. Гадаад, дотоод ертөнцүүдийн танин мэдэхүйг харьцуулсан шинжилгээ

Хураангуй

Буддын судлалыг Буддын шашин, Буддын гүн ухаан, Буддын шинжлэх ухаан, Буддын зам мөрийн технологи хэмээн дөрвөн чиглэлээр авч үзэж болно. Гэхдээ нэг хандлагыг нөгөөгөө халах байдлаар бус, эсрэгээр нь, харилцан нөхцөлдүүлэх байдлаар, дөрвөн талыг өөр хооронд нь уялдуулан, шүтэлцүүлэн авч явах нь чухал. Эхний хоёр хандлага нь судалгаанд түгээмэл байдаг бол удаах хоёр нь танин мэдэхүйн салбарт сүүлийн 30 гаруй жилд тодорсоор буй. Энэ өгүүллийн хүрээнд Буддын шинжлэх ухаан ба шинжлэх ухааны танин мэдэхүйн үзүүлэлтүүдийг жишээгээр төлөөлүүлэн тогтолцоо, логик нотолгоо, хийсвэрлэл, таамаглал, технологи, нэр томъёоны түвшинд харьцуулан авч үзсэн болно. Ингэснээр Буддын танин мэдэхүй нь шинжлэх ухааны иж бүрэн шинжтэй болох нь илт харагдаж, хоёр салбарын танин мэдэхүй нь өөр хоорондоо харшлах зүйлгүй, харин ч нарийн шүтэн барилдлагатай болох нь нотлогдож байна.

Түлхүүр үгс: хоосон чанар, мэдэгдэхүүний орон, төрөн түгэхүй, Уг үрийн долоон увидас, хуран эс үүдсэн, маш нарийн эдийн тоос, маш нарийн хураагч тоос, үхлийн гэгээн гэрэл, гурван ертөнц.

Удиртгал

Танин мэдэхүйн гол зорилго нь асуудал шийдвэрлэх, алив бэрхшээлийг даван туулах гарцыг хайх замаар хууль, зүй тогтлыг нээх, үнэт зүйл, эрхэм санаа, ертөнцийн үнэн дүр төрхийг бүтээхэд оршино. Харин танин мэдэхүйн хэрэглээ нь судалсан үзэгдэл, объектыг зөв ашиглах, сайжруулах, бүтээгдэхүүн хийх, олшруулах, технологи боловсруулах, техник бүтээх, түүнийг эзэмших, удирдах, түүхий эд боловсруулах, хэрэглээний зүйл үйлдвэрлэх зэрэг өргөн цар хүрээг хамардаг. Ийм жишгээр хүмүүс өөрийн хувийн хэрэгцээг аль болох сайн хангах сонирхлоор ажилладаг ч хүний хэрэгцээ хангагдахын хэрээр илүү ихийг мөрөөдөж, хэрэглэгээ нь олон хувилбартай болж, бүр илүү их хэрэгцээ үүсдэг байна (Michael Solomon, 2006). Өссөн хэрэгцээгээ хангахын тулд байгалийн нөөцийг илүү ашиглах, эрдэс түүхий эдийн нөөцийг нь ашиглаж хомсдуулах, байгалиас авч хэрэглэсэн зүйлсийн оронд хог хаягдал ирж, их үйлдвэрлэлээс илүү их хог хаягдал гарч ус, агаар, хөрсгүг бохирдуулах зэргээр байгалийн тэнцвэрийг алдагдуулахад хүрч байна. Илүү хэрэглээ, хог хаягдал, бохирдлын асуудал нь илүү ихээр танин мэдэхийг шаардаж байна. Мөн түүнчлэн материаллаг үйлдвэрлэлийн технологи хөгжих явцад цэргийн зэвсэг техник сайжирч, дайны гамшгийн аюул өсөх болсон. Бас материаллаг нөхцөл байдал сайжрахын зэрэгцээ нийгмийн хөрөнгөжсөн ба ядуу давхарга хоорондын тусгаарлал ихсэж, дундаж давхарга нь дээшээ бус доод давхарга руу уусах хандлага ч илэрдэг. Иймд хэрэглээнд суурилсан нийгмийн ээдрээтэй асуудал нь давхраажилт, ядуурал зэрэг үзэгдлийг судлах, шалтгааныг тодруулах, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах гарцыг шаардаж байгаа юм.

Танин мэдэхүй нь материаллаг хэрэглээнд ашиглагдахаас гадна оюуны хэрэглээнд түгээмэл хэрэглэгдэнэ. Танин мэдэхүй хэрхэн өрнөж, хэн ямар үр дүнг яаж хүртэж буй нь харилцан адилгүй юм. Хүний танин мэдэхүйн эрэл нь гадаад ертөнцийн танихуй, өөрийгөө танихуй, дотоод ертөнцөө танихуй, далд ертөнцийн танихуй гэсэн олон чиглэл өнгө аясаар явж ирсэн. Гэвч танин мэдэхүй хүний дотоод ертөнцийг юу юунаас илүүтэйгээр бүтээдэг (Sudhir Kakar, 1978). Дотоод ертөнц нь мэдээ мэдээллийн сангаас эхлээд боловсрол-сэтгэлгээний хэв маяг, төрөл бүрийн загвар, төсөөлөл, хандлага, үнэт зүйл-шүтээн, зан заншил, үйлийн зуршил тэргүүтэн өргөн хүрээний ойлголт юм. Хүмүүс өөр хоорондоо өөрсдийн дотоод ертөнцөөрөө

дамжин харилцдаг тул нийцэх хийгээд үл нийцэх зүйл их бий. Танин мэдэхүй нь хүнээсээ тусдаа биш, хүнтэйгээ адил биш, харин бие биеэ нөхцөлдүүлсэн нэгэн цул гэж үзэх нь оршихуйн зөв баримжаа болно. Өнөө үед дэлхий нийтээр дотоод ертөнцийн танин мэдэхүй буюу ухамсар-сэтгэл-тийн мэдлийн боловсрол ихэд хоцрогдолтой байна. Бие-оюун-сэтгэлийн боловсролыг цогц байдлаар олгох чиглэл албан боловсролын тогтолцоонд эрс үгүйлэгдсээр буй. Дотоод ертөнцийн боловсрол (товчоор сэтгэлийн боловсрол) ахуй орчин-өрх гэр-үе тэнгийнхний хүрээнд (informal) урсгалаар олгогдсоор байна. Гэтэл нийгмийн ахуй орчин нь мансуурал-донтолт, ижил-саармаг хүйстэн, улс төр-намчирхал-үзэл суртал, стресс-уур хилэн, уруу таталт-самуурал, нийгмийн байгууллын өөрчлөлт-шилжилтийн гажуудал, олон соёлын түрэлт-үнэт зүйлийн хямрал, сошиал-ёс бус мэдээллийн сан тэргүүтнээр ихээхэн бохирдож буй билээ. Албан боловсролын хүрээнд сэтгэлийн боловсролыг хамруулах хэрэгцээ чухал байгаа ч түүний агуулга, арга зүй, сургалтын зохион байгуулалт, хүний нөөц бэлэн биш юм. Сэтгэлийн боловсрол нь сэтгэлийн хат-урвалтгүй байдал-тэгш хандлага, өөрийн сахилга бат-удирдлага, төвлөрөл-ажиглан шинжлэл-ухаарал, асрал-нигүүлсэл тэргүүтэн олон хэмжээстэй. Сэтгэлийн буюу хүний дотоод ертөнцийн танин мэдэхүйд Буддын танин мэдэхүйн ололтууд голлох байр суурьтай (Билгийн зүрхэн судар, 2010; Asanga, 2005; Жадамба судар, 2014) болохыг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Буддын судлалыг хамгийн багадаа дөрвөн талаас нь харж болно. Нэгдүгээрт, Буддын шашин (Богд Зонхов, 2006), хоёрт, Буддын гүн ухаан (Т.Булган, 2010), гуравт, шинжлэх ухаан (С.Гантөмөр, 2016), дөрөвт, зөв зам мөрийн технологи (Шантидэва, 2009; Лувсанбалдан гавж, 2009; Т.Булганы орчуулга. Б.Мөнхбаатар, 2021) гэж үзнэ. Эдгээр дөрвөн талыг уялдуулан, шүтэлцүүлэн авч хандвал алдаа эндүүрэл бага гарна. Аль нэг дээр нь төвлөрөөд Буддын сургаалыг “бүрэн” мэтээр төсөөлж эндүүрэх учиргүй. Буддын шашны шүтээн нь чухаг дээд гурав буюу бурхан, ном, хувраг байдаг ч эцсийн дүндээ тэдгээр нь “ном”-д хураагддаг. Харин зам мөр нь багшид хурна. Танин мэдсэн “номын ухаан”-д итгэж, бас шүтэж сүсэгтэн олон “төрсөн” болой.

Гадаад болон дотоод ертөнцүүдийн танин мэдэхүй хоорондоо нягт харилцан уялдаа холбоотой. Гадаад ертөнцийн танин мэдэхүйд шинжлэх ухаан илүү анхаардаг бол хүний дотоод ертөнцийн танин мэдэхүйд Буддын ухаан илүү анхаарал хандуулж иржээ. Дотоод сэтгэлийн эрдэм нь монголын уламжлалт оюун ухааны салбар бөгөөд Буддын шашинтай нягт сүлэлдэж ирсэн түүхийг нь хэн ч үл үгүйсгэнэ. Шөнийн одод, үүрийн шүүдэр, өглөөний үүл, үдийн зэрэглээ, үдшийн гялбаа нугуудтай оршихуйн түмэн өнгийг зүйрлэн ухаарч, таньж явсан (Очироор огтлогч судар) мэргэдүүдийн уламжлал тасраагүй билээ. Бид уламжлалт тэрхүү ухаанаа орчин үеийн шинжлэх ухаантайгаа авах гээхийн ухаанаар холбох ёстой (Х.Дондог, 2010). Гадаад ертөнцийн танин мэдэхүй нь техник-технологийн шийдлийг өгдөг бол дотоод ертөнцийн танин мэдэхүй нь сэтгэлийн боловсрол буюу хүний өөрийн удирдлагын системийг зөв төлөвшүүлэх, зөв ажиллуулах боломжийг олгодог. Гадаад, дотоод ертөнцүүд харилцан шүтэлцээтэй тул шинжлэх ухаан, Буддын ухаан хоёр харилцан шүтэлцээтэй байх нь чухал (Шүтэн барилдлагын магтаал, 2006). Хүний дотоод ертөнцөд буй гэм нь гаднах нийгмийн гажуудлыг үүсгэх суурь болох тул хүний гэм, нийгмийн гажуудлыг засахын тулд техник-технологийн боловсролыг сэтгэлийн боловсролтой хослуулж өгөх нь зүйтэй юм.

Бие сэтгэл хоёр харилцан шүтэлцэх хуулийн дагуу материаллаг танин мэдэхүй нь дотоод сэтгэлийн танин мэдэхүйтэй шүтэлцэнэ. Сэтгэл нь материаллаг зүйлийн танин мэдэхүй дээр суурилдаг буюу байгаа зүйл дээр сэтгэл голчлон үүснэ. Сэтгэл нь материаллаг оршихуйд шүтэж

байгаа болохоор сэтгэлийн танин мэдэхүй нь материаллаг ертөнцийн танин мэдэхүйтэй "гарахуйн барилдлагатай". Сэтгэлийн мэдэл нь эрхтний мэдэлтэй бас "гарахуйн барилдлагатай". Эдгээр нь хоёр танин мэдэхүйн дотоод шүтэн барилдлагыг илэрхийлж буй хэрэг юм. Нөгөөтэйгүүр, хоёр танин мэдэхүй хоорондын уялдаа холбоогоор шийдэгдэх асуудал хуримтлагдсаар буй. Тухайлбал, хүний нийгэм хүмүүс өөрсдөөс нь болж үүссэн олон асуудалтай нүүр тулж байна. Үүнд:

1. Энх тайвны асуудал буюу улс хоорондын харилцааны асуудал: улс төрийн мөргөлдөөн, ШУ-технологийн ололтыг дайны зорилгоор ашиглах зуршил.
2. Хүмүүс хоорондын харилцааны асуудал: нийгмийн давхраажилт, нийгмийн бүлэг, шашин хоорондын зөрчил гэх мэт.
3. Экологийн асуудал буюу хүн-байгал хоорондын зөрчлийн асуудал: байгаль хамгаалал-бизнесийн ашиг сонирхлын зөрүү.
4. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, цөөнхийн эрх ашиг зэрэгтэй уялдаатай асуудлууд.

Дээрх асуудлуудын суурь шалтгаанууд нь үнэн хэрэгтээ хүний мөн чанар, хувь хүний дотоод ертөнц, боловсрол, хувь хүн-нийгмийн бүлэг-бизнесийн бүлэглэл зэрэгтэй холбоотой. Эдгээр шалтгаанууд нь “хүн төвтэй”. Иймд асуудлуудын шийдлийг хүнтэй, тэр тусмаа хүний өөрийнх нь оршихуйг удирдаж буй “сэтгэл оюун”-тай холбож үзэх нь зүйтэй. Сэтгэл оюуны танин мэдэхүйг Буддын ухаанаас хайх нь илүү үр дүнтэй.

Танин мэдэхүйн харьцуулалт

1. Танин мэдэхүйг тогтолцооных нь түвшинд харьцуулалт хийж үзье.

Танин мэдэхүйд тогтолцоо нэн чухал байр суурийг эзэлдэг. Тухайлбал, Менделеевийн үелэх системийн санааг анх олсноор шинэ шинэ элементүүдийг урьдчилан таамаглах боломж нээгдсэн төдийгүй таамагласан элементийг эрэх, хайх арга зам нь цөөн хувилбартай, илрүүлэх магадлал өндөртэй болсон. Түүнтэй жишихэд дараах чухал асуултууд урган гарч байна. Үүнд: Буддын ухааны салбарт тогтолцоо байна уу? Байгаа бол бусад салбаруудынхтай харьцуулах боломжтой байна уу? Харьцуулж болж байгаа бол нийтлэг хийгээд ялгарах шинжүүд нь юу байна? гэх мэт. Буддын ухаанаас эдгээр асуултуудын хариултуудыг олж, дараах байдлаар (Хүснэгт 1) харьцуулан харуулсан болно. Эхний багануудад тогтолцооны түвшингүүдийг жагсаасан бол арын багануудад танин мэдэхүйн зарим салбаруудыг жагсаасан байна. Нүднүүдэд харгалзах гол элементүүдийг товч тоочиж оруулсан.

Хүснэгт 1. Танин мэдэхүйн салбаруудын тогтолцоо

	<i>Буддын ухаан</i>	<i>Физик</i>	<i>Математик</i>	<i>Хими</i>	<i>Биологи</i>
<i>Судалгааны объект</i>	Их, дунд, бага гурван төрөлхтний явдал мөр	Физик бие, физик орон, физик үзэгдлүүд	Дүрс, харьцаа, олонлог, функц, тэгшитгэл, тооцоолол, математик загвар...	Химийн бодис, химийн бүтэц, атом, электрон бүрхүүл, химийн урвалууд, ...	Амьд биенийн бүтэц, үүрэг, оршихуй, эс, эд, эрхтэн,...
<i>Үндсэн ойлголтын түвшин</i>	Урд-энэ-хойд төрөл, үйл, нисванис, махбод, ...	Материаллаг цэг, цэгэн цэнэг, идеал хий, ...	Цэг, шулуун, геометрийн дүрс, матриц, тензор	Атом масс, валент чанар, химийн нэгдэл, урвалын хурд,	Бие, эрхтэн, эд, эс, уураг, молекул, бодисын солилцоо, ...

Аксиомын түвшин	Хамаг амьтныг эх хэмээн үзэх, урд-энэ-хойд төрөл буй, ...	Фермагийн зарчим, хамгийн бага үйлчлэлийн зарчим, ...	Хоёр параллель шулуун огтлолцохгүй...,	Цахилгаан сөрөг чанар, валент чанар, химийн хувирал, ...	Удамшил, байгалийн шалгарал, ...
Арга, аргачлал, технологи	Бясалгал, нотлохуй ухаан, системчлэл	Анализ-синтез, туршилт, зүгшрүүлэлт	Логик гаргалгаа, баталгаа, системчлэл,...	Анализ-синтез, туршилт, системчлэл,...	Анализ-синтез, туршилт, систематик,...
Хууль, зүй тогтлын түвшин	Үйлийн үрийн хууль,	Физикийн хуулиуд	Теоремүүд, мөрдлөгүүд	Химийн хуулиуд	Биологийн хуулиуд
Онолын түвшин	Билиг билгүүн, хоосон чанар,...	Онолын физик	Математикийн онолууд	Онолын хими	Онолын биологи
Задаргааны түвшин, салбарууд	Дөрвөн тогтсон таалал, их бага арван ухаан,...	Механик, молекул физик, термодинамик, цахилгаан соронзон, атом, цөм, ...	Алгебр, анализ, арифметик, геометр, тригонометр, магадлал, статистик, ...	Органик ба органик бус хими, физик хими, аналтик хими, биохими, цахилгаан хими,...	Морфологи, генетик, эмбриологи, экологи, таксономи, ургамал, амьтан, ...

Дээрх хүснэгтийг зохиож болж байгаа нь авч үзэж буй салбаруудад тогтолцооны нийтлэг бөгөөд харьцуулагдахуйц шинжүүд байгааг илт харуулж байна. Иймд Буддын танин мэдэхүйн салбар нь тогтолцооны хувьд шинжлэх ухааны салбаруудтай жишихүйц хэмжээнд байна хэмээн үзнэ.

2. Танин мэдэхүйн логик гаргалгааны түвшинд харьцуулъя. Буддын ухаан, шинжлэх ухааны зарим салбаруудын нотолгооны арга зүйг тодорхой жишээгээр харьцуулан харуулав (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Логик гаргалгааны түвшин

Буддын ухаан	Физик	Математик	Биологи
<u>Уг, үрийн долоон увдис:</u> Хамаг амьтныг эх адил үзэхээс эхлээд эхийн ачийг санах, хариулах, асрах, нигүүлсэх, үлэмж сэтгэл, бодь сэтгэл төрөх хүртэлх бясалгалын логик хэлхээ, албатайн найман үүд, ...	<u>Онолын физикийн гаргалгааны арга:</u> Цаг хугацаа, орон зайн нэгэн төрөл, изотроп шинжүүдээс энерги, импульс, импульсын момент хадгалагдах хуулиудын гаргалгаа хийх	<u>Баталгааны арга зүй:</u> Аксиом, лемма, өмнө нь баталсан теоремд тулгуурлан шинэ теорем батлах, томьёоны гаргалгаа хийх логик үе шатууд	<u>Генотип-фенотипийн уялдаа:</u> Генетик мэдээлэл дамжихаас эхлээд мутаци үүсэх, байгалийн шалгарлаар сонгогдох, организмын амьдрах чадвар сайжрах хэлхээ

Дээрх салбаруудыг харьцуулахад Буддын ухааны логик сэтгэлгээ, нотолгооны түвшин бусадтай ижил төстэй байна.

3. Хийсвэрлэлийн түвшинг авч үзье.

Буддын ухаан, шинжлэх ухааны зарим салбаруудын танин мэдэхүйн хийсвэрлэлийн түвшинг тодорхой жишээгээр харьцуулан харуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Онолын хийсвэрлэлийн түвшин

Буддын ухаан	Физик	Математик	Нийгмийн ухаан
Огторгуй мэт хуран эс үүдсэн	Орон зайн нэгэн төрөл шинж, физик вакуум	Олонлогийн нэгэн төрөл шинж	Тэгш оролцоо
Арван зүг ялгал үгүй	Орон зайн изотроп шинж	Эргэлтийн тэгш хэм	Олон ургалч үзэл
Гурван цаг ялгал үгүй	Цаг хугацааны нэгэн төрөл шинж	Цаг хугацааны тэгш хэм	Түүх давтагдах
Маш нарийн эдийн тоос, маш нарийн хураагч тоос, үхлийн гэгээн гэрэл, агшин, билиг билгүүн, хоосон чанар, ...	Гэрлийн хурд, Планкийн тогтмол, виртуаль бөөмс, вакуум, ...	Хязгаарын тухай ойлголт	Шудрага ёс, Хэгэлийн “туйлын үнэн”

Буддын ухааны салбарын онолын хийсвэрлэлийн түвшин нь шинжлэх ухааны салбаруудийнхтай харьцуулахуйц өндөр түвшинд байна.

4. Таамаглалын түвшинг харъя.

Таамаглал нь шинжлэх ухааны танин мэдэхүйн нэгэн чухал хэрэгсэл мөн. Иймд Буддын ухаан, шинжлэх ухааны зарим салбаруудын танин мэдэхүйн таамаглалын түвшинг тодорхой жишээгээр харьцуулан харуулав (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Таамаглалын түвшин

Буддын ухаан	Физик
Хүсэлт, дүрст, дүрс үгүй гурван орон /ертөнц	Энгийн матери (5%), харанхуй матери (27%), харанхуй энерги (68%). Хар нүх, харанхуй матери, саарал матери гэх мэт.
Сансар-нирван, зуурд, тийн мэдэл, ...	Утасны онол (квант гравитаци), сингуляр чанар (цаг хугацаа-орон зай үгүй), ...

Буддын ухаанд хэрэглэдэг таамаглалууд нь онолын физикийн таамаглалуудтай жишихүйц, дотоод хийгээд гадаад ертөнцийн оршихуйд нэн чухал байр суурьтай байгаа нь харагдаж байна.

5. Танин мэдэхүйн технологийн түвшинг харъя.

Буддын ухаан, шинжлэх ухааны танин мэдэхүйн үйл явц нь тодорхой технологиудыг хэрэглэдэг. Буддын ухаанд сахил санваар авч сахих, бясалгах, ажиглан шинжлэх зэргийг голчлон эрхэмлэдэг. Харин шинжлэх ухаанд ажиглах, тэмдэглэх, бүртгэх, харьцуулах, тоо баримт цуглуулах, туршилт сорилыг тусгайлан төлөвлөж хийх, үр дүнг шинжлэх, нэгтгэн дүгнэх, системчлэх, таамаглал дэвшүүлэх, таамаглалаа шалгах, онол дэвшүүлэн тайлбарлах зэрэг аргыг хэрэглэдэг.

Өнгөц авч үзэхэд Буддын ухаан, шинжлэх ухааны танин мэдэх аргууд нь тоо төрлийн хувьд ялгаатай боловч ерөнхий технологийн хувьд “сонсох, санах, бясалгах” гэсэн гурван үе шатуудаараа ижил юм. Гэхдээ сурагч, сонсогч, судлаач нарын тоо нь сонсохоос эхлээд дараа дараагийн шатууд руу эрс буурдаг зүй тогтол аль алинд нь бий. Тухайлбал, багшийн заасныг

сонссон хүний тоо олон боловч агуулгаа эргэн харах, санаж нягтлах, өөрийн болгох, шүүн тунгаах хүний тоо эрс цөөрдөг бол гарын арван хуруунд багтах тооны хүн л бясалгах шат буюу удаан хугацаагаар нягтлан төвлөрөх, бүтээх, нээх, ухаарах түвшинд хүрч ажилладаг. Шинжлэх ухаанд “бясалгал” гэсэн нэр томъёог хэрэглэгддэггүй ч нээлт хийж буй эсвэл шинэ техник технологи бүтээж буй хүмүүс “төвлөрөл, ажиглан шинжлэл, тэгш орохуйн” технологийг ахисан түвшинд хэрэглэдэг нь маргашгүй зүйл юм. Гэхдээ бясалгал дотроо зорилго, объектоосоо хамаараад олон төрөл зүйлтэй байдгийг санах нь зүйтэй.

6. Танин мэдэхүйн нэр томъёоны түвшинд бас авч үзье.

Шинжлэх ухааны салбар бүр өөрийн гэсэн нэр томъёоны системтэй. Нэр томъёо танин мэдэхүйд нэн чухал байр суурь эзэлдэг. Буддын ухаанд ч бусадтай нэгэн адил өөрийн нэр томъёо бий. Тэдгээрээс заримыг нь харьцуулж дараах хүснэгтэд харуулав (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Нэр томъёоны түвшин

	<i>Буддын ухаан</i>	<i>Шинжлэх ухаан</i>
<i>Ерөнхий ойлголт</i>	Цогц, язгуур, төрөн түгэхүй, суурь, үйл, үр, дүрс, мэдэл, төгөлдөр бус хуран үйлдэгч, бусдын эрхэт, бүхэнд бүтэгч, бүхэн нэрийдэгч, шалтгаан, нөхцөл, зовлон, мөнх бус, хоосон, амарлил, шүтэн барилдлага, нүгэл, буян, нисванис, түйтгэр, судал, хий, сэтгэл, атгаг, билиг,	Энерги, дөрвөн хүч, физик орон, таталцал, түлхэлцэл, хий, шингэн, хатуу бие, эд, эрхтэн, молекул, атом, цөм, амьтан, ургамал, бичил биетэн, бактери, вирус, хоёр нутагтан, сээр нуруутан, хэвлээр явагч, масс, цахилгаан цэнэг, ион, координат, ...
<i>Хос ангилал</i>	Эрхтний мэдэл, сэтгэлийн мэдэл, хуран үйлдэхүйн тэгш агуулахуй, амсуургын тэгш агуулахуй, байхгүйн үгүйсгэл, бишийн үгүйсгэл, гарахын барилдлага, чанар нэгт барилдлага, ...	Нэмэх хасах цэнэг, фермион бозон, уурших конденсацлах, лептон кварк, гомоген гетероген, нягт сийрэг, мономер полимер, задрал нэгдэл, кинематик динамик, дамжуулагч тусгаарлагч, хүчил шүлт, ...
<i>Багц ойлголт</i>	Хүртэхүй, сэрэхүй, хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, тийн мэдэхүй, үзэгдэл дүрсийн суурь, гол сэтгэлийн суурь, нөхөр сэтгэлийн хэлбэрийн суурь, төгөлдөр бус хуран үйлдэгчийн суурь, хуран эс үйлдэгчийн суурь	Гэрэл ойх, хугарах, шингэх, сарних, зүйл, төрөл, овог, баг, анги, хүрээ, аймаг, протон, нейтрон, электрон, хүчтэй харилцан үйлчлэл, сул харилцан үйлчлэл, цахилгаан соронзон харилцан үйлчлэл, гравитацийн үйлчлэл, ...
<i>Дэд ангилал</i>	Хийн унааны бүдүүн нарийн, сэтгэлийн бүдүүн нарийн, мэдлийн бүдүүн нарийн, гэгээт билиг билгүүн, түгэгч билиг билгүүн, ойр ологч билиг билгүүн	Эгэл бөөмс: адрон, бозон, фермион. Эгэл бөөмсийн дэд ангилал: фотон, гравитон, мезон, барион, лептон.
<i>Нэгжийн систем</i>	Ертөнцийн орны нэгж, агшин, дөрвөн махбод, тоосны найман эд, маш нарийн эдийн тоос, маш нарийн хураагч тоос...	Үндсэн нэгж: СИ системд: метр, секунд, килограмм, ампер, келвин, моль, кандел... Нэгжийн хураангуй: кило, мега, гига, тера, пета, ...

7. Буддын ухаан ба шинжлэх ухааны сэтгэл судлалыг харьцуулж харъя (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Сэтгэл судлал

	<i>Буддын ухаан</i>	<i>ШУ-ны сэтгэл судлал</i>
<i>Судлаг-дахуун</i>	<ul style="list-style-type: none"> • Гол сэтгэл • Нөхөр сэтгэл/сэтгэлээс бологч • Сэтгэлийн дэлгэрэнгүй ба 	<ul style="list-style-type: none"> • Зөн төлөв ба зан үйл • Бие хүн өөртөө болон бусадтай харилцах, нийгэмших

	хураангуй ангилал	<ul style="list-style-type: none"> • Сэтгэцийн шинж, байдал, үйл явцууд • Сэтгэл хөдлөл, анхаарал, хүртэхүй...
Зарим үр дүн	<ul style="list-style-type: none"> • Бясалгах технологи эзэмшилт • Төвлөрөл-ажиглан шинжлэх чадварын хөгжил • Өөрийгөө таних, өөрийгөө хянах, зөв удирдах чадвар • Асрах-нигүүлсэх сэтгэл • Бодь сэтгэл • Билиг билгүүн 	<ul style="list-style-type: none"> • <u>Онолууд:</u> <ul style="list-style-type: none"> ○ нийгмийн сэтгэл судлал, биховерист онол, психоанализ, хүмүүнлэг онол, удамшлын онол, мотивацийн онол, когнитив онол... • <u>Ойлголт, ангилал:</u> <ul style="list-style-type: none"> ○ хандлага-эмоци-зан төлөв-когници... ○ Меланхолик, сангвиник, холерик, флегматик хэв шинжүүд... ○ Оношлогоо ба зөвөлгөө
Үр дүнгийн онцлог	<ul style="list-style-type: none"> • “Зөв хүн”, “Сэтгэлийн боловсролтой хүн”, “Төгс төгөлдөр хүн”, “Гэгээрсэн хүн”, ... 	<ul style="list-style-type: none"> • “Сэтгэл зүйн оношлогоо-зөвөлгөө-үйлчилгээ” • Хүнийг зөв хөгжүүлэх, удирдах онол
Ерөнхий шийдэх асуудал	<ul style="list-style-type: none"> • “Хүн өөрийгөө дотроос нь таних, хөгжүүлэх, боловсруулах, энэрэх-нигүүлсэх” арга технологийг Шинжлэх ухааны боловсролд нэвтрүүлэх • Хоёр салбарын танин мэдэхүйн технологийг хослуулах 	

8. Шийдэгдээгүй асуудлуудын тухай товч дурдъя.

Танин мэдэхүй гүнзгийрэхийн хэрээр оршихуйн нууцыг тайлах үйл явц улам бүр адармаатай болж, асуудлын тоо олширсоор байна. Гэвч тэдгээрээс энд зөвхөн хоёр салбарын огтлолцолд хамаарах хэдхэн асуудлыг дурдъя.

- Амьтай, амьгүйн зааг хаана байна? (Вирус амьд бие мөн үү? Гүн бясалгалд суугчийн хорин нэг хоногийн оршихуйг хэрхэн тайлах вэ? гэх мэт)
- Хүний нийгмийг оновчтой жолоодож болох уу? (Үйлчилгээний материаллаг дэд бүтэц хөгжиж байгаа хэдий ч...)
- Албан боловсролд сэтгэлийн боловсролыг хэрхэн оруулж өгөх вэ?

Дүгнэлт

Буддын танин мэдэхүй нь шинжлэх ухааны иж бүрэн шинжтэй болохыг шинжлэх ухааны зарим салбаруудтай олон түвшинд харьцуулан дараах баримтуудаар нотолж байна. Үүнд:

1. Өөрийн гэсэн танин мэдэхүйн арга, нотолгооны технологитой.
2. Танин мэдэхүйн шат дараалсан таамаглал, онолын хийсвэрлэлийн түвшингүүдтэй.
3. Танин мэдэхүйн явц, үр дүнг илэрхийлсэн өөрийн нэр томъёоны системтэй.
4. Танин мэдсэн үр дүнгээ хэрэглэж амьдрал практикийн асуудал шийддэг.
5. Онолын мэдлэг, технологийн мэдлэг хоёр нь нягт барилдлагатай.
6. Хоёр салбарын танин мэдэхүй нь өөр хоорондоо харшлах зүйлгүй, харин ч нарийн шүтэн барилдлагатай болох нь харагдаж байна.

Ном зүй

1. Michael Solomon, Gary Bamossy, Søren Askegaard, Margaret K. Hogg, Consumer Behaviour: A European Perspective, Third edition, 2006.
2. Sudhir Kakar, The Inner World: A Psychoanalytic Study of Childhood and Society in India (Oxford India Perennials), 1978.
3. Асанга. (2005). Их хөлгөний хураангуй ба Абхидхарма бүхнээс түүсэн.

4. Жадамба судар. (2014). Бугат Л.Алтангэрэлийн шинэ орчуулга.
5. С.Гантөмөр. (2016). Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: шинжлэх ухааны хэсэг, Боть 5. УБ.
6. Билгийн зүрхэн судар (2010).
7. Т.Булган. (2010). Буддын философийн дэвтэр.
8. Шантидэва. (2009). Гэгээрлийн зам (Бодичаръяаватара).
9. Лувсанбалдан гавж (Оргиочийн лам). (2009). Бодьсавдын явдалд орохуй шастирын дугуйт тайлбар. Т.Булганы орчуулга.
10. Богд Зонхов. (2006). Их бодь мөрийн зэрэг (Ламрим ченбо).
11. Шүтэн барилдлагын магтаал сайн номлолын зүрхэн хэмээх оршивой. (2006). МБШТөв Гандантэгчэнлин хийд.
12. Очироор огтлогч хэмээх их хөлгөн судар. С.Гантөмөрийн орчуулга.
13. Б.Мөнхбаатар, Буддын бясалгал ба сэтгэл судлал, 2021, УБ.
14. Х.Дондог. (2010). Монголоо эрсэн монгол

4.7. Мэдрэлийн шинжлэх ухаан болон Буддын шашин дахь “би”, “чөлөөт хүсэл”, “нийгэм” хэмээх ойлголтууд

Хураангуй

Нейросайенс болон Буддын ухаанд оюуны үйл явцын талаарх ойлголтуудад төстэй зүйл байгааг Эморийн их сургуулийн судлаачид онцлон тэмдэглэжээ. Оюуны олон үйл явцууд нэгэн зэрэг үйлдэгддэг бөгөөд тэдгээрийн дийлэнх олонхи нь шийдвэр гаргалтанд хүчтэй нөлөөлөгч далд ухамсрын үйл ажиллагаа байна. Нейросайенс нь оюуны зэрэгцээ процессуудыг өдөөж буй нейроны механик суурь сүлжээг танин мэдэхэд анхаардаг бол Буддизм нь нэг нэгдмэл цул зүйл мэт “би” хэмээх төөрөгдлийг арилгах замаар нийтлэг сайн сайхан сэтгэл-нигүүлслийг үүсгэх зорилтыг өмнөө тавьдаг.

Түлхүүр үг: нейроны сүлжээ, синапс, таламус, бага тархи, суурь зангилаа, тархины бор гадарга, оюун, шүтэн барилдлага

Удиртгал

Эмори-Түвдийн Шинжлэх Ухааны Хөтөлбөр (the Emory Tibet Science Initiative (ETSI) хөтөлбөрийн хүрээнд барууны судлаачид Буддын ухааны зарчмуудтай танилцах, Буддистууд барууны шинжлэх ухаантай танилцах ажлыг хийж, биечлэн уулзаж асуулт тавьж, хариулт авах байдлаар хамтран ажиллаж байна. Олон тохиолдолд “оюун”, “би”, “ухамсар”, “шалтгаалцал” гэж юу болох, хэрхэн түүнийг авч үзэж буй талаар хэлэлцүүлэг өрнөж байв. Мөн түүнчлэн “унтах”, “мөрөөдөх”, “үхэх”, тэдгээрт хамаарах “ухамсар” зэргийг ихэд сонирхоцгоох болов. Энэ талаар болон “эмоци”, “ой санамж”, “ухамсрын төлвүүд”-ийн тухай Далай лам ч барууны шинжлэх ухааны нэрт эрдэмтэдтэй хэлэлцүүлэг өрнүүлж байна. Ингэснээр бидний ой санамж хэрхэн бүрэлддэг, тархины зарим хэсгийн гэмтэл нь танин мэдэхүй болон зан үйлийг хэрхэн өөрчилдөг талаар орчин үеийн шинжлэх ухааны сонирхолтой баримтуудыг олж мэдэж болдог. Олон жилийн хэлэлцүүлгийн явцад барууны судлаачид болон Буддистууд философийн өөр өөр суурь баримтлал, нэр томъёог ашиглаж байдаг хэдий ч ижил төстэй чухал ухаарлуудыг олж авсаар буй. Энэ өгүүллийн хүрээнд зарим нийтлэг ойлголт ба ухаарлуудыг товч авч үзсэн болно. Гэхдээ энэ нь туйлын үнэнийг илэрхийлэх гэсэн хэрэг биш бөгөөд цаашид төвлөрөх бясалгалаар жинхэнэ нигүүлсэл рүү хүрэх хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах эрмэлзэл юм.

Оюун нь зэрэгцээ олон процесс болох нь

Нейросайэнсын судлаачид нь ерөнхийдөө материалистууд бөгөөд оюун ухааныг нейроны үйл ажиллагаанаас төрнө хэмээн үздэг. Иймээс “нейроны коррелат” хэмээн нэрийдэх зүйлгүйгээр ямар ч оюун хийгээд оюуны үйлүүд боломжгүй юм. Нейроны коррелатууд нь тархин дахь нейроны сүлжээний идэвхжилийн нарийн төвөгтэй үйл явц дундаас бий болох бөгөөд тэдгээрийн үйлдлийн кодоор оюуны үйлдлийг төлөөлдөг. Нейроны сүлжээний талаар мянга мянган өгүүлэл хэвлэгдсэн бөгөөд нейроны сүлжээний үйл явцын талаарх нэлээн хэдэн зарчим томъёологдсон байдаг. Тухайлбал, нейронууд өөр хоорондоо “идэвхжилийн потенциал” хэмээх цахилгаан импульсээр дамжин харилцана. Нейрон бүр синапсын холбоосоор дамжуулан бусдаасаа мянга орчим эрэмбийн импульс хүлээн авдаг. Синапс нь харилцааг дэмжигч “химийн элч” (chemical messenger)-ийг ашигладаг (Kandel et al., 2021). Мөн түүнчлэн нейроны уургуудын оролтоос хамаарсан биохимийн модуляцийг ашигладаг нейроны сүлжээгээр дохио дамжих нь секунд, минут, цагаар хэмжигддэг. Нойр, эмоци, хөөрөл, ой санамж зэрэг нь цахилгаан дохио болон биохимийн модуляцийн процессоос хамаарна. Нейроны сүлжээ нь нэгэн төрөл биш бөгөөд таламус, бага тархи, суурин зангилаа, тархины бор гадарга зэрэг өөр өөр үүрэг бүхий, өөр өөр төрлийн эсүүдийн зохион байгуулалттай дэд системүүдээс бүрдэнэ. Эдгээр дэд системүүдийг тус тусад нь судалж, нейроны коррелатын ерөнхий үүрэг, зан төлөвт хувь нэмэр хэрхэн оруулж буйг тогтоох боломжтой. Тархи нь гаднын импульсээр ажилладаггүй бөгөөд үйл явдал, нөхцөл байдлын талаар урьдчилсан таамаглах байдлаар идэвхжин ажилладаг (Buzsaki, 2019).

Буддизмын дагуу хүн оюун ухаан, бие махбод хэрхэн харилцан үйлчилж, янз бүрийн туршлагыг бий болгодог талаар эргэцүүлэн бодож, ухамсрын өөрчлөгдөж буй мөн чанарыг эргэцүүлэн бодох үед бие-сэтгэц гэж нэрлэгддэг биетийн мөч бүр нь ганц цул биш харин салж болох боловч хоорондоо холбоотой олон агрегатуудаас бүрддэг гэдгийг ухаардаг. Эдгээр таван скандхагийн (цогцос) гадаад ба дотоод хүчин зүйлээс хамааралтай, нөхцөлдүүллийн шинж чанарыг анхааралтай ажиглаж, эдгээр скандхагийн харилцан үйлчлэлийг цаашид анзаарч болно: материаллаг хэлбэр (рупа скандха), мэдрэмж (ведана - туршлагын нөлөөллийн тал, тааламжтай, тааламжгүй, саармаг гэх мэт) үүнтэй холбоотой ойлголт/танилт (самнья - хоолыг амтлах, чихэрлэг, исгэлэн, шорвог гэх мэт ойлголт, шошгын тусламжтайгаар мэдрэхүйн түүхий өгөгдлийг тодорхойлох), сэтгэцийн формац (самскара - сэтгэцийн реактив эсвэл зорилготой тал) ба ухамсар (вигьяна - ухамсарын танин мэдэхүйн тал). Энэхүү нөхцөлт харилцан хамаарал нь хувь хүний туршлагын ертөнцийг бүтээдэг бөгөөд ухамсар нь субъектив мэдэхүйг хариуцдаг.

Нейросайэнсын судлаачид болон Буддистуудын танин мэдэхүйг харьцуулан үзэхэд оюун нь зэрэгцэн явагдаж буй ухамсарт болон далд ухамсарт процессуудын нэгдэл юм гэдэгтэй ойлголт нэг байна. Далд ухамсрын үйл ажиллагааг илт мэдэхгүй ч гэсэн түүний бодит нөлөөг ойлгож тооцох болсон. Буддизмд далд ухамсрын үйл ажиллагааг илрүүлэхэд төвлөрөх бясалгал хэрэгтэй байдаг бол нейросайэнсын судлаачдад нейроны сүлжээний харилцан үйлчлэлцэл түүнийг ойлгоход тусалдаг.

Нэгдмэл цул “би” хэмээх төөрөгдөл

Нейросайэнсын аливаа судлаач тархины нейроны сүлжээн дэх идэвхжилийн дүр байдлыг ажиглаж байхад “би”-г олон хэсгээс нэгэн зэрэг холбогдож буй зэрэгцээ процессуудаас урган гарч ирдэг юм хэмээн таамаглахгүй байж болох талтай. Ер нь “би” хэмээх төсөөлөл хэрхэн үүсдэг вэ? Биеийн оршихуйг оптимизацилахад чиглэсэн бидний тархины эволюци хөгжилтэй холбоотой байж болох юм. Бас биеийн бүхий л хөдөлгөөнийг тооцсон үйл үйлдлүүд, тэдгээрийн үр дагаврыг төлөвлөсөн тархины удирдлагын төв (Buzsaki, 2019) байж болно. Бидний бие нь орчны өөрчлөлтийн нөлөөнд орохын зэрэгцээ түүнд хариу үйлдэл үзүүлэгч элч маягаар ажилладаг. Иймд биеийн төлвүүд, болзошгүй хөдөлгөөнийг тасралтгүй мөрдөх нь нейроны сүлжээ ба дэд системүүдийн үйл ажиллагаанд амин чухал асуудал юм. Бид орон зай, цаг хугацаа, өнгөрсөн үйл үйлдлийн талаарх ой санамждаа ганцхан л биетэй байх ба түүндээ тулгуурлан цаашдын үйл явдлыг таамаглах, түүнийг тархины симуляциар байнга үнэлэх нейроны сүлжээний ажиллагаанд оролцдог. Эдгээр процесс нь нэг нэгдмэл “би” хэмээх төсөөлөлд хүргэнэ. Мөн хүн төрөлхтний хувьд хэл ярианы системд тулгуурлан “би” гэх ойлголттой болно. Энэ "тайлбарлагч"-ийн хүлээн авсан бусад мэдрэлийн сүлжээнүүдийн оролт нь бидний "би" гэсэн ухамсартай ойлголт, бидний үйлдэл хийх шалтгаануудыг бүрдүүлдэг. Хамгийн гол нь ийм учирлал болон үйлдлүүдийн бодит шалтгаанууд нь олон төрлийн дэд системүүдээс үүсэн гарч ирдэг бөгөөд "тайлбарлагч" эдгээр шалтгааныг олж мэдэхээс өмнө гүйцэтгэгддэг. Бас зүүн тархины урд талын кортикал сүлжээ нь Майкл Газзанигагийн (Gazzaniga, 2011) тодорхойлсон "тайлбарлагчийн" үүргийг гүйцэтгэдэг. “Би”-ийн үйл үйлдэлд далд ухамсрын оролцоо их бий (Kahneman, 2011). “Би” бол олон системд тархсан байна. Үнэндээ өөрийгөө танин мэдэх хэд хэдэн өөр системийг тодорхойлсон бөгөөд тэдгээрийг бие биенээсээ үйлдлээр нь тусгаарлаж болно. Үүнд дараахь зүйлс орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Тухайлбал:

- Би – өөрийн амьдралын эпизодик дүр зураг, аялал хөдлөлийн зураглал, сэтгэгдэл
- Би -хувийн шинж чанарын семантик хураангуй дүрслэл -зан ааш, төрх
- Би -өөрийн амьдралын тухай баримтуудын семантик мэдлэг-Би бол монгол хүн, Би бол багш гэх мэт.
- Би -хугацаанд үргэлжилсэн мэдрэмж
- “Би” хувийн эрх мэдэл, өмчлөлийн мэдрэмж: жишээ нь Би бол миний бодол, үйлдлийн шалтгаан мөн гэсэн итгэл үнэмшил буюу сэтгэгдэл.
- Өөрийгөө тусгах чадвар: гүйцэтгэгч агент нь би мөн гэсэн мета дүрслэлийг бүрдүүлж, тэдгээр төлөөллийн үндсэн дээр дүгнэлт хийх.
- Бие махбодийн “би”: Бие махбодыг төлөөлөх, таних чадвар (жишээлбэл, толинд, зураг дээр биеэ таних, зүгээр л хөл рүүгээ хараад биеэ таних чадвар “Энэ бол би байна, за!”)
- Бусад олон төрлийн өөрийгөө танин мэдэхүйн зуучлагч системүүд байдаг. (Klein & Lax, 2010)

Буддын философид “би”-ийн тухай эндүүрлээс болж таван цогцосыг бие даасан, нэг цул “би”-гэсэн эндүүрэл бүрддэг хэмээн үздэг. “Би”-гийн таван цогц бүрийг ажиглан шинжилбээс субъектив дүр төрх нь хэсэг хэсгээр задарч, бие даасан, чөлөөт хүсэл эрмэлзэл бүхий үл өөрчлөгдөгч “би” л чухам бүх юмны цаана суугаад байна гэсэн үзэгдэл нь хуурмаг буруу зүйл болох нь тодордог. Энэ нь юмс үзэгдлийн “анатма” буюу “би үгүй” гэсэн ухааралд хүргэнэ. Бие даасан, чөлөөт хүсэл эрмэлзэл бүхий үл өөрчлөгдөгч “би” хэмээх төсөөлөл нь зовлон бүхний үндэс суурь болдог. “Би” нь бидний бие-сэтгэцийн нэгдлийн өөр хоорондоо харилцан

хамааралтай ч тусгаарлагдмал шинж бүхий системүүдэд суурилсан ерөнхий ойлголт (концепци) юм. Өөрийн сэтгэл, түүний байнгын өөрчлөлтийг ажиглан шинжлэх бясалгал хийснээр сэтгэл хөдлөлөө илүү тэнцвэртэйгээр зохицуулах, өдөөгч хүчин зүйлсэд сохор хариу үйлдэл өгөхгүй байхад хүргэдэг бөгөөд ингэснээр өдөөгч хүчин зүйл, хариу үйлдэл хоёрын хооронд оюуны орон зай үүсгэдэг (Brown, Ryan, & Cresswell, 2007). Хүчтэй дадал зуршилаар элдэв хүчин зүйлсэд (гадна дотны) сохор хариу үйлдэл өгөх нь далд ухамсрын түвшинд явагдах тул бясалгалаар түүнийг хянах боломжтой.

Чөлөөт хүсэл

Тархин дахь нейроны үйл ажиллагаа детерминист шинжтэй юу үгүй юу? Тийм бол тэр нь бидний үйлдлүүд чөлөөт хүсэлтэйгээр үйлдэгддэг эсэхтэй ямар утгаар холбоотой вэ? Бидний сайн мэдэх нэгэн зүйл бол нейроны ажиллагааны динамик нь ихээхэн төвөгтэй шинжтэй ба хаос (эмх цэгцгүй) шинжийг ч өөртөө бас агуулдагт оршино. Иймээс бидний ирээдүйн бодол санаа, үйлдлийг нь бүрэн таамаглах боломжгүй зүйл юм. Бүр тархин дахь молекул болгоны төлөв байдлыг нь тодорхойлж чадсан ч бүрэн таамаглах боломжгүй. Хувь хүнтэй холбогдуулан авч үзэхэд түүний хойшдын зан байдал, ирээдүйн шийдвэр гаргалтыг нь таамаглах боломжгүй юм. Урьдчилан таамаглах боломжгүй байдлыг чөлөөт хүсэл эрмэлзэлтэй холбож болох уу? Үл таамаглах байдал нь гэнэтийн санамсаргүй зүйл, стохастик шинж хэмээн үзвэл тэр нь бидэнд чөлөөт хүсэлтэй гэх сэтгэгдэл төрүүлж чадах уу? Судалгааны баримтуудыг авч үзэхэд тархины нейрон хоорондын синаптик дамжуулалтын үзэгдлүүд нь стохастик шинжтэй тул нейроны процесс нь мөн л гэнэтийн санамсаргүй зүйл юм. Харин үнэндээ чөлөөт гэсэн утгыг нарийвчилж шинжвээс тархи нь оюуны үйлийн үр дүнг гаргахдаа хаалттай бус систем байдлаар бодит ертөнцийн шалтгаант харилцааны нарийн төвөгтэй симуляцийг гүйцэтгэж, ингэхдээ өмнөх хугацааны бүхий л туршлагаудын мянга мянган ой санамжийн нөлөөнд өртөж байдгийг бид чөлөөт байдал хэмээн ойлгодог. Иймээс тархины зарим процесстэй шууд холбоогүй бөгөөд далд ухамсрын автомат нөлөөгөөр өнгөрсөн туршлагаудыг оролцуулсан сонголтыг бид хийх тохиолдлууд байдаг. Амигдала, суурь зангилаа зэрэг хувьслын илүү автомат, урьдчилан программчлагдсан тархины төвүүд болон, неокортекс гэх мэт илүү сайн дурын зориудын ассоциатив сэтгэлгээ хоёрын нөлөөг эхнийх нь илүү хурдтай, сүүлийнх нь удаашралтай байгаагаар ялгаж болно (Каннеман, 2011). Тиймээс, хэрэв эрх чөлөө нь аль болох олон хүчин зүйл, өмнөх туршлагыг (ёс суртахууны боловсрол гэх мэт) харгалзан үзэхийг шаарддаг бол бидний бор гадаргыг хянаж, хангалттай тунгаан бодож байж шийдвэр гаргах ёстой. Энэ утгаараа эрх чөлөөг шийдвэр гаргах үйл явцад өмнөх туршлагыг бүхэлд нь хэрэгжүүлэхэд хангалттай хугацаа үлдээх гэж үйл ажиллагааны хувьд тодорхойлж болно.

Буддын онолоор бол шийдвэр гаргалтыг гадаад болон дотоод маш олон хүчин зүйлээс хамаарна гэж үздэг. Тухайлбал, бидний хуримтлуулсан урьдын үйлийн үр, туршлага, одоогийн нөхцөл байдлын үнэлгээ зэргийг дурдаж болно. Таван цогцосын нэг болох оюун санааны реактив тал болох, метал руу татсан соронз мэт үйлчилдэг сэтгэцийн формаци (самскара) чухал үүрэг гүйцэтгэдэг. “Би” нь ямар нэгэн шалтгаан нөхцлөөс хамааралгүй “чөлөөт” байж чадахгүй. Иймд бие даасан нэг цул “би” гэж үгүй. Санамсарын бясалгалын нэг гол хэсэг болох мэдрэмжийн шинжилгээнээс үзэхэд эхлээд бодол төрж, түүнд тулгуурлан дараа нь концепцийн үржилт (прапанча) явагддаг. Тэрхүү концепцийн үржилт нь бодол, сценари, ассоциацийн нягт сүлжээг бий болгодог. Эдгээр процесс нь гэрлийн хурдаар явагдах ба “би”-гийн төөрөгдлийг

үүсгэж, улмаар түүнд хүлэгдэж, түүний төлөө санаа зовоход хүргэдэг. Ингэснээр ихэнхдээ сөрөг эмоцйн уг шалтгаан болно. Ажиглан шинжлэх бясалгалаар бие-сэтгэцийн бүрдүүлэгч хэсгүүд нь үргэлжийн өөрчлөлтөнд орж, таван цогцосоос өөр “би” гэж үгүй, цогц тус бүр нь ч “би” биш гэсэн үнэнийг олж мэдээд, “би” хэмээх төөрөгдлийг ухаарч, аажимдаа түүнийг даван туулах боломжтой.

Ийнхүү нейросайэнсийн судлаачид болон Буддистуудын ойлголтуудыг харьцуулж үзэхэд шинжлэх ухаан талаасаа “чөлөөт хүсэл” гэдэг нь тархины бор гадаргын тайлбарлагчийн модулиар тодорхойлогдсон когнитив бүтэц төдий зүйл болох нь харагдаж байгаа бол Буддистуудынхаар тэрхүү үүссэн төөрөгдлийг ажиглан шинжлэх бясалгалын явцад өөрийгөө танин мэдэх процессоор даван туулах боломжтой юм.

Оюун ба нийгэм

Энэхүү судалгаа нь тархин дахь олон тооны дэд системүүдийн дундах “нийгмийн төв”-ийг чухал ач холбогдолтой болгон харуулж өгсөн. Нийгмийн зан үйл нь хүний оршихуйд чухал байр суурьтай бөгөөд олон сая жилийн туршид тархины хамт хувьсалд орсоор иржээ (de Waal, 2006). Иймээс хүүхдэд санаа тавих, бусад руу инээж хандах зэрэг нь тархин доторх нейронуудын өвөрмөц сүлжээтэй нягт холбоотой бөгөөд тодорхой хэмжээнд автомат үйл үйлдэл юм. Хүний нийгмийн зан төлвийн нэгэн гайхамшигт хэсэг нь мэдээж хэл яриа мөн. Тархины олон сайн тодорхойлогдсон хэсгүүд нь хэл ярианы мэдрэмж, утга, хөдөлгөөний аспектиудад зориулагдсан үүрэгтэй байдаг, (Kandel et al., 2021). Тархины бор гадарга мэдээллийг хянаад, боловсруулж зохицуулах бөгөөд ёс суртахууны үйл үйлдэл, зан төлөв нь бидний нийгмийн харилцаа ба өсөж торнисон орчны нөлөөгөөр тодорхойлогдоно. Хүүхэд асрах, гэр бүлдээ туслах, багаар ажиллах зэрэг нь хүн амын оршихуйд чухал ач тустай тул нийтлэг шинж мөн.

Буддын онолоор бол юм бүхэн харилцан хамааралтай бөгөөд харьцангуй шинжтэй. Энэхүү нийтлэг шинж нь ямар ч зүйл ганцаар бие даан оршихгүй, ганцаар заяагдаагүй гэсэн дүгнэлтэд хүргэдэг. Үүнтэй уялдан сайн, муугийн тухай ойлголт нь тухайн нийгмийн хэм хэмжээнээс хамаарна. Гэвч хүний аминд хүрэх, хуурах, худлаа хэлэх, хулгай хийх зэргийг нийтээр ёс суртахууны алдаанд тооцдог. Ёс суртахууны харьцангуй мөн чанарын талаарх энэхүү ойлголт нь бусдын зан үйлийг шүүмжлэхгүй, харин хайр, хүндэтгэлд суурилсан жинхэнэ энэрэнгүй сэтгэлийг хөгжүүлэхэд тусалдаг нь гарцаагүй.

Нейросайэнс болон Буддизмын ойлголтууд нь “шүтэн барилдлага” хэмээх нэр томъёоны түвшинд нийлж, өмнөх түүхийн явцад гаргасан шийдвэрийн үр дагавар дараагийн шийдвэрт нөлөөлнө гэдгийн үүднээс “жинхэнэ чөлөөт хүсэл” боломжгүй ажээ.

Дүгнэлт

Нейросайэнс болон Буддизмын аль альных нь үүднээс “би” нь далд ухамсрын оролцоо бүхий олон тооны параллель процесуудаас бүрддэг болох нь харагдлаа. Нэгдсэн нэг цул “би” гэх ойлголт нь бидний ухамсрын нэг хэсэг болох тархины дээд түвшний бор гадаргын “тайлбарлагч” модулиас үүдэлтэй, бидэнд бодитой мэтээр төсөөлөгдөх хуурамч үзэгдэл юм. Энэхүү ухаарал нь чөлөөт хүслийг ойлгоход, мөн шийдвэр гаргахад нийгэм хэрхэн нөлөөлж

буйг ойлгоход чухал ач холбогдолтой юм. Буддистуудын хувьд бүх амьтан харилцан шүтэлцээтэй бөгөөд ажиглан шинжлэх бясалгалын оролцоотойгоор сэтгэл хөдлөлөө тэнцвэржүүлэх чадвар хийгээд нигүүлсэх зан чанарыг өөрсдийн тархинд төлөвшүүлэх боломжтой гэж ухаарсан байдаг. Нөгөөтэйгүүр, шинжлэх ухааны судалгаагаар оюуны болон биеийн түвшинд материаллаг шалтгаант процессуудыг танин мэдэж, түүнд тулгуурласан ёс зүйтэй шийдвэр гаргалтыг хийж болно.

Ном зүй

1. Brown, K.W., Ryan, R.M., & Cresswell, J.D. (2007). Mindfulness: Theoretical foundations and evidence for its salutary effects. *Psychological Inquiry*, 18, 211–237
2. Buzsaki, G. (2019). *The Brain from Inside Out*. Oxford University Press
3. Gazzaniga, M.S. (2011) *Who's in Charge? Free Will and the Science of the Brain*. Harper Collins Publishing.
4. Kahneman, D. (2011). *Thinking Fast and Slow*. Farrar, Straus and Giroux
5. Kandel, E.R., Koester, J.D., Mack, S.H., Siegelbaum, S.A. (2021). *Principles of Neural Science, Sixth Edition*, (McGraw-Hill).
6. De Waal, F.B.M. (2006). *Primates and Philosophers. How Morality Evolved*. Princeton University Press

4.8. Буддын бясалгалын товч агуулга

Буддын бясалгалыг амирлан оршихуйн болон үлэмж үзэхүйн гэж хоёр төрөлд хувааж үздэг. Амирлан оршихуйн бясалгал нь сэтгэлээ тогтоон төвлөрүүлж бясалгана. Харин үлэмж үзэхүйн бясалгал нь амирлан оршихуйн сацуу ажиглан шинжих байдлаар бясалгах болой. Амирлах үлэмж хоёр нь самади бүгдийн хураангуй мөн хэмээжээ. Бясалгалыг багшийн увидасын дагуу нягт нямбай хийнэ. Багшийн удис гэдэг нь тухайн багшийн зааж зөвлөсөн арга аргачлал, зөв зам мөрийн удирдамж юм. Адистэд оршино гэдэг нь өөрийн үндэст урьд өмнө нь байгаагүй эрдэм, сайн онол, чадал багшаас ирж өөрт бодитой төрөхийг хэлнэ.

Бясалгалын зорилго ба үр дүн

Бясалгал нь маш олон боломжийг хүнд нээж өгдөг. Тухайлбал,

- Анхаарлаа төвлөрүүлэх чадварт суралцаж, санамсар-мэдэмсэрийн хяналтыг эзэмшинэ.
- Мэдлийн материаллаг болон сэтгэлийн хэсгийг хооронд нь зааглан ялгаж, сэтгэлийн хэсгийг амарлиулж сурна.
- Өөрийн болон өрөөлийн сэтгэлийг танин мэднэ.
- Сэтгэлтэйгээ ажиллаж сурах, сэтгэлийн хөдлөлийг ажиглах, өөрчлөлтийг нь мэдрэх, сэтгэлийн хөдөлгөөнөө ойлгох, жолоодох чадвар дадал сууна.
- Нисванис буюу сэтгэлийн хирийг арилгах технологи эзэмшинэ.
- Сэтгэлийн амар амгаланг олох чадвар дадал олно. Алив жаргал, зовлонд “хөөрөхгүй, гутрахгүй” байх бэлтгэлтэй болно.
- Тэсвэр тэвчээртэй урт хугацаагаар суух дадал чадвар эзэмшинэ.
- Мэдрэмжийн гурван төрөл (таатай, таагүй, саармаг)-д “тэгш орох” чадвар олно.
- Бусдыг өөртэйгөө адилтгах, улмаар энэрэн нийгүүлсэх, авралын бодь сэтгэлийг мэдэх боломж олно.
- Юмс үзэгдлийн хувьсамтгай чанарыг мэдрэх, онох, харилцан хамаарлыг ухаарна гэх мэт.

- Мөнх, “би” хоёрт чанх буруу барихыг тэвчих боломж олно.
- Ертөнцийн найман номын толгойг тэгшитгэн үйлдэх ёсыг мэднэ.
- Амгалан сэтгэлийн “ид шид”-ийг мэдрэх боломж олно.

Бясалгалын жишээ: амирлан оршихуйн бясалгал

Амирлан оршихуйн бясалгал (С.Гантөмөр, 2016; Alan Wallace, 2006)-ын талаар товч авч үзье. Амирлан оршихуйн бясалгал нь 10 шаттай бөгөөд шат бүрд багшийн увидас хэрэгтэй. Үүнд:

1. Сэтгэлдээ агуулах (1-р самади). Гадна байгаа зүйл (гаднын зоригдол)-ээс сэтгэлээ салгаад дотроо бодох зүйл (дотоод зоригдол) дээрээ тушаана. Анхны оролдлогын үед анхаарлаа амьсгал дээр тогтоохыг зөвлөдөг ч бараг нэг хоёр секундийн дараа гэхэд л таны анхаарал бодол хөтлөгдөн хаа нэг тийшээ явчихсан байгааг та өөрөө анзаарна. Анхаарлаа дахин дахин авчирч, бас дахин дахин алддаг. Энэ үзэгдлийг догшрол гэнэ. Эхний үед бясалгах гэж буй зүйлээс сэтгэл бүр огт тасрах ч тохиолдол гардаг.
2. Үргэлжлүүлэн агуулах (2-р самади). Зоригдолдоо тушаасан сэтгэл нь алгасаралгүйгээр өчүүхэн төдий үргэлжилнэ. Энэ үед анхаарал жаахан тогтох боловч тун удалгүй сэтгэл үймэрч, бясалгаж байсан зүйлээ бас л алдагдана. Нэг минут орчим анхаарлаа алдалгүй барьж чадаж байвал ахиц гарлаа хэмээн бодож болох юм.
3. Дахин агуулагч (3-р самади). Өчүүхэн мэдэмсэрээр сэтгэлээ алгасарыхыг түргэн эргүүлж зоригдол дээрээ тушаана. Таны анхаарал бясалгаж байгаа зүйл дээрээ хэдэн минут тогтож чаддаг болсон байна. Гэхдээ бясалгалын чанарыг сайжруулахын тулд догширол гарсан нийт тоо, тохиолдлыг эрс цөөрүүлэхэд анхаарна. Гэхдээ бясалгаж байгаа зүйл нь бүдгэрч, анхаарал сарниж, нойрмоглох мэт мэлийх аюул (бүдүүн живэх)-аас сэргийлэх хэрэгтэй.
4. Ойр агуулах (4-р самади). Санамсар, мэдэмсэрийн эрхээр сэтгэлээ зоригдол дээрээ бүр сайн тавьдаг болно. Энэ үед сайн анхаарлын хүчээр бясалгаж байгаа зүйл мартагдахаа болино. Бясалгалыг цагаас илүү хугацаагаар үргэлжлүүлж чадна.
5. Номхруулан үйлдэгч (5-р самади). Хүчтэй санамсар мэдэмсэрт шүтээд самадийн эрдмээр баясах болно. Санамсар, мэдэмсэрийн эрхээр сэтгэлээ зоригдол дээрээ бүр сайн тавьдаг болно. Энэ үед сайн анхаарлын хүчээр бясалгаж байгаа зүйл мартагдахаа болино. Бясалгалыг цагаас илүү хугацаагаар үргэлжлүүлж чадна. Бодол, санаа, сэтгэлийн хөдөлгөөн зэрэгт сэтгэлийн бүхий л үзэгдлүүдэд та анхаарлаа хандуулна.
6. Амирлуулан үйлдэгч (6-р самади). Хүчтэй санамсар мэдэмсэрт шүтээд нэн алгасаралыг хорино.
7. Нэн амирлуулан үйлдэгч (7-р самади). Амгалан бус, тачаах сэтгэл, живэх, догшрох тэргүүтнийг амирлуулан үйлдэнэ.
8. Нэгэн үзүүртэйгээр үйлдэгч. Нарийхан ч живэх, догшрохын барцад байхгүй хийгээд самадийг үргэлжлүүлэн бясалгаж чадна. Мэдэхүйд өөрт нь байгаа амгалан болон тунгалгийг нээх явдал чухал.
9. Тэгш агуулах. Шамдалгүйгээр самади өөрөө аяндаа урган бууж ирнэ.
10. Эдгээр есөн шатыг давж туулсны эцэст шинай буюу амирлан оршихуйг олно. Амирлан оршихуйд дотоод сэтгэлийн амгаланг олсон болохоор биеийн амгалан орж ирэн бүх биеэр амгалан түгнэ.

Самади хичээл үгүйгээр ордог болсны эцэст самади арвиждаг. Самади арвижсаны хүчээр дүрсгүй орны самадид хүрч дүрснээс шуналаа хагацаагаад сэтгэл нь огторгуй мэт болно. Шинай нь дияаны 4 орны доод 1-р оронд хүрэх олон бэлтгэл шатуудын хамгийн доод талын

бэлтгэл шат юм. Цаашаа маш олон шат байдаг бөгөөд шат дээшлэх бүрд шид бүтээл чадварууд нь ихсэж бий болно хэмээн сударт дурдсан байдаг.

Багшийн увдис:

Жишээ 1. Амьсгалдаа төвлөрч ажиглах

Амьсгал хамраар орохоос эхлээд хүйс хүрэх, буцаад хамраар гарах хүртэл эргэлтийг мэдэр. Амьсгалын өөрчлөлтийг тасралтгүй сайн ажиглана. Ажиглалт нь үргэлж хурц, тод, эрчтэй байх ёстой. Амьсгал нарийсах, багасах, амьсгалах дуу чимээ үгүй болох, хамрын ойролцоох агаарыг хүртэл мэдэр. Живэлт үүсэхээс сэргийлж, мэдэмсэрийг ажиллуулах хэрэгтэй. Живэлт нь уусал болон будангуйрал гэсэн хоёр төрөлтэй бөгөөд эхнийх нь бие махбодын хувьд нозорох, нойрмоглох тэргүүтэнд хамаатай бол будангуйрал нь оюун ухааны сэргэг байдал буюу хурц, тод, эрчтэй байдал алдагдахад хамаатай. Уусалт үүсэх сэжүүр гармагц нүдээ нээж, хамрын үзүүрийн чигт харж өөрийгөө сэргээнэ. Хүчтэй уусалт үүсээд байвал өөрийгөө чимхэх зэргээр сэргээж бас болно. Догшролт нь элдэв бодол болон гаднын чимээ нөлөөнд автан төвлөрөл алдагдахыг хэлнэ. Бодлын урсгалд автахгүй, тэр мэт саадыг зөвхөн бүртгэх төдийгөөр өнгөрөөх хэрэгтэй. Төвлөрсөн зүйлийнхээ анзаарал-бүртгэл-мэдрэх төдий зүйлийг хийнэ. Төвлөрсөн зүйлийнхээ тухай ургуулан бодох хэрэггүй. Зөвхөн төвлөрлийн объектоо л нарийн ажиглан, түүний хувирал өөрчлөлтийг бүртгэнэ. Бясалгалын үед илрэн гарч буй ямар ч зүйлийн талаар шүүн тунгаахгүй, бие сэтгэлээр хариу үйлдэл үзүүлэхгүй байх ёстой. Хэрэв хүчтэй бодол дахин дахин эргэлдээд байвал түүнд дээр төвлөрч ажиглах, задлан ажиглах хэрэгтэй. Тэгвэл түүний хүч суларна. Тэгээд түүнийг удаашруулаад унтрааж орхино. Бясалгалын үед ажиглан шинжилсэн алив зүйлийн төлөв байдал өөрчлөгдөж, хүч нь бүр сулран арилах, өөр зүйлээр солигдохыг олж мэднэ. Ингэснээр бүх зүйл, тэр бүү хэл өвдөлт ч нэг хэвээр биш, өөрчлөгдөж, солигдох, заримдаа бүр арилж болохыг ч мэдэрнэ. Хэрэв бие чилж өвдөөд байвал тэр өвдөлтүүдийг хамгийн хүчтэйгээс нь эхлэн ажигла. Өвдөлтийн төвийг ол. Төвийг нь сайн ажигла. Өвдөлтийн хатгах, бадайрах, татах, хорсох зэрэг ялгааг олж мэдэр. Түүний хүч нь аяндаа суларч, нэг мэдэхэд алга болж ч мэднэ. Гэхдээ өвчин хэзээ алга болох бол хэмээн хүлээлт үүсгэж хэрэггүй. Бие чилж өвдөхөд хөдлөөд байх хэрэггүй, зүгээр л өвдөлтийг ажигла. Хатгаж байна уу, бадайрч байна уу гэх мэт. Анх бясалгаж буй хүмүүс 5-10 минутаар төвлөрч ажиглаад, 5 минут төвлөрөл-ажиглалтаа завсарлаад суудлаа өөрчлөлгүй чөлөөт-тайван төлөвт сууж болно. Ийм зохицуулалтаар эхлээд нэг цаг сууж сурах хэрэгтэй. Мэдэмсэр, санамсар хоёрыг сэрэмж хэмээн ойлгож болно. Хэрэв төвлөрөл, мэдэмсэр-санамсаргүйгээр “юу ч бодохгүй” бясалгавал оюун ухаан мохоо болно. Амьсгал бол сэтгэл зүй, симпатик болон парасимпатик нервтэй холбоотой.

Жишээ 2. Төвлөрөлийн объектийг солих

Төвлөрөл-ажиглалтын объектоо сольсоноор бясалгалын нэр төрөл өөрчлөгдөнө. Анх бясалгаж байгаа бол төвлөрлийн объектыг “том”-оор авна. Тухайлбал, бүтэн бие дээрээ төвлөрөх, амьсгалын систем дээрээ төвлөрөх гэх мэт. Төвлөрч сураад ирсний дараа төвлөрлийн объектоо жижгэрүүлнэ. Тухайлбал, хамрын хоёр нүхний хооронд буудайн үрийн төдий цэг авч түүн дээрээ төвлөрч ажиглаж болно. Төвлөрлийн цэгээ ургуулан дүрслэн бодох хэрэггүй. Түүнийг зөвхөн мэдэрнэ. Ажиглах, мэдрэх, шинжлэх гурав бол бясалгалын үндсэн механизм мөн. Ажиглаж, мэдэрч чадвал тухайн сөрөг үзэгдэл бүдгэрч уусах, тэр бүү хэл бүрмөсөн алга

болж ч мэднэ. Тухайн зүйлийг задалж ажиж чадвал “уг асуудлын талаарх” ойлголт тодорч, шийдэл-ухаарал аяндаа тодорно. Энэ нь “цэвэр тунгалаг сэтгэл”-ийн “ид шид” юм. Оюун ухаан-бодлын үүсгүүр, матери-дүрсийн үүсгүүр. Сэтгэл тэр хоёрт тулгуурлан тийн мэдэхүй-мэдэл үүсгэнэ. Тийн мэдэхүй буюу мэдэл нь “сэтгэлийн бохирдол” буюу нисванис үүсгэдэг. Түүнийг арилгаж цэвэршүүлэхийн тулд мэдрэмжид тулгуурласан бясалгал хэрэгтэй. Бүр матери, оюун хоёрын хязгаарыг гэтлэх хүртэл мэдрэх хэрэгтэй. Мэдэх ба ойлгох (мэдлэг, ойлголт) нь бага хэрэг, түүнийг бүрэн мэдэрч, өөртөө тултал хэрэгжүүлж, ягшмал зуршилд хүртэл хэрэгжүүлэх хэрэгтэй.

Жишээ 3. Өөрийн биеийг задалж бясалгах

Өөрийн биеийг эрхтнүүдээр нь салган төсөөлж хар, мэдэр. Гоо сайхан, ариун цэвэр зүйл юу байна? Цус, нөж, шээс, баас, яс, арьс, шөрмөс, мах гэх мэт үзэгдэж мэдрэгдэнэ. Гоо сайхан зүйлийг үл үзэх болно. Иймд таашаах, тачаах шуналын үндсийг үл үзнэ. Цул, тогтвортой, өөрийн бие даасан санаа бодол бүхий, мөнх “нэгэн зүйл”, “би” байгаа юм шиг төсөөлж явдаг. Гэтэл задлаад шинжлээд ирэхлээр тийм зүйл үгүй, бүх зүйл “нэгж хэсгүүдээс” бүрддэг нь илэрнэ. Тэр нэгж нь бас дахин задарна гэх мэт.

Жишээ 4. Мэдлийг бясалгах

Мэдлээ мэдэрч, хувьсал өөрчлөлтийг нь ажигла. Эрхтний мэдэл, сэтгэлийн мэдэл хоёрыг ялган ажигла, шинжил. Таашаал тачаал нь сэтгэлийн мэдэлтэй холбоотой өөрчлөгдөхийг үз. Мэдлийн “мөнх бус”-ыг мэдэр. Мэдлийг бясалгаж мэдрэснээр түүний онцлогийг таньж, “байнга өөрийнхөө зөв байлгах” гэсэн зуршлаа өөрчлөх талаар бодоход хүргэнэ. Сэтгэлгээний уян хатан чанар, нарийн мэдрэмжийг хөгжүүлэх арга механизм нь энэ байх болно. Далд ухамсарт бичигдсэн зуршлыг зөвхөн мэдлийн бясалгалаар л өөрчилнө. Мэдлийн бясалгалын үед хуучин зуршил “өөрийгөө илчилж”, уйлах, хашхирах, бие хүчтэй хямрах зэрэг үйлийг хиймээр болж мэднэ. Тэдгээр мэдрэмжинд айж сандрах хэрэггүй. Алив эерэг ба сөрөг мэдрэмжид “тэгш” орж, бүртгэх төдий байдлаар хандаж, хариу үйлдэл үзүүлэхгүй зөнд нь орхиж, хүлээцтэй өнгөрүүлэх хэрэгтэй.

Жишээ 5. Бодлоо бясалгах

Одоо орж ирж буй бодлоо ажигла. Энэ бодолдоо харамсах, гомдох, айж мэгдэх хэрэггүй. Бүү шүүмжил. Бүү эсэргүүц. Бүү хамгаал. Тэгш ор. Эсвэл хуучин бодлоо далд ухамсраас татан гаргаж ажигла. Өнгөрсөн тохиолдлоо бодитоор сэргээж бодоод, түүнтэй холбоотой өөрийнхөө мэдрэмжийг бодитоор сэргээж, түүнийгээ ажигла. Хуучнаа сэргэхээр айх, сандрах, зугтах, мэгдэх, харамсах, гутрах, уймрах хэрэггүй. Зүгээр л бүртгэ. Тэгш ор. Бодлынхоо агуулгыг задлан ажигла. Тэгш ор. Харамссан, гомдсон, гутарсан бүх бодлоо гаргаж ажигла. Тэгш ор. Бүү шүүмжил, бүү эсэргүүц, бүү хамгаал. Ийм байдлаар далд ухамсраа муу бодлоос цэвэрлэ.

Жишээ 6. Бясалгалын таван саадыг бясалгах

Үүнд: 1. Мэдэл, хөл нуруу чилэх өвдөх гэх мэтээр илрэх биеийн саадыг бясалгана. Өвдөлтийг ажигла, шинжил. Түүнийг нарийн ажиглах тусам задарч, уусаж, бүдгэрч, хүч нь суларна. Үүнийг турш, мэдэр, хэрэгжүүл. 2. Сэтгэлийн 5 хор буюу уур, мунхаг, бардамнал, атаа жөтөө, шунал тачаал тэргүүтэн бясалгалын завсрын бодлоор дамжин орж ирж саад болж мэднэ.

Тэдгээр тус бүрийг ажигла, шинжил. Уурласны дараа тайвшрахыг бод. Дэмий уурласан гэх бодол төрөхийг сана. Хэрхэн уурлаж байснаа сана. Уурлах шаардлага бодитой байсан эсэхийг бод. Уурласнаар асуудал шийдсэн эсэхийг бод. Уурыг дахин дахин давтах хэрэгтэй эсэхийг бод. Уурыг тэвчиж болох байсан эсэхийг шинжил. Уурын ач тусыг бусдад магтан дуулах хэрэгтэй эсэхийг сана. Бусад дэмжих эсэхийг бод. Уур биегүй атлаа таныг залж буруу чиглүүлээд байсан эсэхийг шинжил. Уурлах, тайвшрах хоёрын байрыг сольж болох эсэхийг бод. 3. Чамирхал, харамсал хоёрыг ажигла, шинжил. Хэт чамирхах, үнэтэй эд хөрөнгө, өнгө зүсээр гайхуулахыг ажигла, шинжил. Эсвэл хэт харамсах, гутрах, сэтгэлээр унах, уруудахыг ажигла, шинжил. 4. Живэх, догширох хоёрыг ажигла, шинжил. Бүдүүн нарийн живэлт хийгээд бүдүүн нарийн догширолыг ялган мэдэр. Тэдгээртэй “тэмцэх” өөрийн гэсэн аргаа олж мэдэр, ерөндгийг хэрэгжүүл. 5. Тэнэгэлзээ сэжгийг ажигла, шинжил. Тэнэгэлзээ нь хоёр талд эргэлзэгч ухамсар юм. Сэжиг нь сэтгэлийг хямраах, оюун дүгнэлтийг тогтворлох сөрөг шинж чанар юм.

Жишээ 7. Таван цогцыг бясалгах

Таван цогц нь дүрсийн цогц, сэрэхүйн цогц, хуран мэдэхүйн цогц, хуран үйлдэхүйн цогц, тийн мэдэхүйн цогц болой. Цогц тус бүрийг ажиглан шинжилж бясалгана. 5 цогц хоосон, би-үгүйг онон бясалгана.

Жишээ 8. Бодь сэтгэлийг бясалгах

Буяны механизм нь бодь сэтгэл тул хүний сэтгэл түүгээр эзлэгдсэн байх ёстой. Эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусыг бүтээхэд бодь сэтгэл тусална. Амьтны зовлонг мэдэхгүйгээр бодь сэтгэлийг бясалгах боломжгүй. Бодь сэтгэлийн суурь нь уучлах, асрах, энэрэх, даган баясах, тэгш орох сэтгэлүүд мөн. Эс нөхцөлдсөн сэтгэл буюу бусдыг энэрэх эхийн сэтгэлээр бясалгана. Бусдын эрх ашгийг өөрийнхөөс дээгүүр тавивал амар амгаланг олно. Ямар төрөлтэйгээс үл хамааран “Эхийнхээ дэргэд байхад түүний ач хайрыг нь хүртдэг” шиг бодь сэтгэлийн тус их юм. Бодь сэтгэл (БС)-ийн бясалгалаар өөрийн өчүүхэн хүслээ бясалгаж, өөрийн хүслээ таслах ёстой. Бодь сэтгэлээр бүхнийг ерөндөглөнө. Бодь сэтгэлийн бясалгалаар “Бусдын зовлонг өөртөө хүлээн авч боловсруулаад гэгээн гэрэл болгон буцааж тэдэнд түгээдэг”. Иймд БС-ийн бясалгал нь “Хүний зовлонг амар амгалан хийгээд жаргалд урвуулах сэтгэлийн эрдэм”-д суурилдаг. Бодь сэтгэлийн бясалгалын үед анхаарал сарнидаггүй. Гэхдээ “нэг тодорхой объект” дээр байнга төвлөрвөл “Ном бус шунал”-ыг хөгжүүлэх гэмтэй. Иймд “тодорхой хийсвэр” ерөнхий зүйлд төвлөрөх хэрэгтэй. Санамсарын объектоор бодь сэтгэлийг сонгоно. Мэдэмсэрээр БС-ийг манана. Танихгүй бусдын буянаар хувцас, хоол, машин, техник, орон сууц зэргээр хангагдаж буй тул энэхүү шүтэн барилдлагыг суурь болгон БС-ээр бусдын тусыг бясалгана. “Дайсан бол тэвчээрийн багш мөн” тул шүтэн барилдлагын сууринд БС-ийг бясалгана. Өөрийн нүд хилэнцгүй бол өрөөлийн хилэнцийг үзэхгүй.

Жишээ 9. Багшийн егүзерийн бясалгал

Чуулганы орныг урин залаад долоон гишүүнт өргөнө. Соёрхол талбиад шид бүтээлээ айлтгана. Өөрийн өмнийн огторгуйд агуу уужим ишт лянхуан хүйсэнд өөрийн ачит язгуурын багш минь гэтэлгэгч их Зонховагийн байдлаар баруун зүүнээ хөвгүүдийн ахмад хоёр хөвгүүн сэлт эцэг хөвгүүн гурав залрав хэмээн бодно. Тэгээд эргэн тойрон эх болсон хамаг амьтан бараантан сууж байна хэмээн сэтгэнэ. Би хийгээд амьтан огторгуй лугаа сацуу хамаг амьтныг цаг эдүгээгээс эхлээд хэдий бодийн шимийг олох хүртэл цогт төгөлдөр Багш дээдэс нарт итгэмүй

хэмээнэ. Туулсан Бурхан ялж төгс нөгчсөн нугуудад итгэмүй. Дээдийн ном нугуудад итгэмүй. Хутагт хуврагуудад итгэмүй. Гурван орны номын хаан их Зонховагийн бурхдын чуулган нөхөр сэлтэд итгэмүй хэмээн гурвантаа өгүүлээд рашаан бууж ариусах бясалгалыг үйлдэнэ. Эх болсон хамаг амьтны тусад дээр үгүй Багш бурхны хутгийг мөнхүү түргэнээ олж үйлдмүй. Эх болсон хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэж их амгалан бурханы газарт агшин ямагтнаа үүнд байгуулж үйлдмүй. Түүний тулд гүн мөр Багшийн егүзерийг анхааран авсугай хэмээн гурван удаа ялгамжаат сэтгэл үүсгэхийг бясалгана. Тэгээд авралын гурван орон шар гэрлийн байдалтай өөрийн хөмсөгний завсар шингэснээр адистадлаад өөр ямагтаа нэгэн агшинд Гэтэлгэгч Багшийн лагшинд болсон тэрхүү чанарт өөрөө Язгуурын гурван итгэл лүгээ ялгал үгүй гэтэлгэгч Багш тэр нь би байна хэмээх омгийг агуулна. Өөрийгөө Богд лам хэмээн тодруулсны лагшнаас гэрэл цацраад орчин тойронд буй хамаг амьтанд туссанаар хоёр түйтгэрийг авьяас лугаа сэлт ариусгаад тэдгээр бүгд Богд ламын лагшинд хувирав. Бөс гэрэл цацарснаар савны гэрийн гэм бүгд ариусаад арилсан бэлгэ билгийн орон болов хэмээн бодох нь төгсгөх, боловсруулах, ариусгах гурав огоот бүрдсэн сэтгэл үүсгэх үр мөр үйлдэхийн ёсыг бясалгах мөн бөлгөө.

1. Ариун бусыг угаах бясалгал: Мэгзэмийн үүднээс соёрхлыг олонтоо талбиснаар Богд эцэг хөвгүүн гурвын зүрхнээс гэрлэн сум мэт хулсан гуурс гурав төдий гараад нэгэн үзүүртэй болсон цагаан өнгөт өөрийн эсрүний нүх рүү хатгав хэмээн сэтгэнэ. Дахин соёрхол талбиснаар Эцэг хөвгүүн гурвын зүрхнээс бэлгэ билгийн мөн чанарт цагаан рашааны байдлаар сүүн өнгөт урсгал цаглашгүй гуурсны дотуур дамжаад өөрийн эсрүний нүхээр бууж хамаг бие доторхыг дүүргэснээр тэргүүлшгүй төрлөөс хураасан хилэнц түйтгэр, гэм унал, тангараг доройтож тасарсан бүгд утаа тортгийн байдалтай, өвчин ад зэтгэр бүгд аалз, хилэнцэт хорхой, шанаган хорхой тэргүүтний байдалтай шар үсний нүх бүгдээр гадагш гараад, бие бэлгэ билгийн рашаанаар дүүрэв хэмээн сэтгэнэ.

2. Үл мэдэхийг арилгах бясалгал: Дахин соёрхол талбиснаар урьд мэтчилэн хашааны урсгал бууснаар хамаг бие дүүрээд үл мэдэх ба мунхгийн харанхуй бүгд түнэр харанхуйд зул барих мэт агшин ямагтад арилан ариусаж, бие тунгалагшин гэрлийн мөн чанартай тув тунгалаг болов хэмээн бодож бясалгах болой.

3. Лагшингийн үүднээс “их билиг” бүтээнэ. Дахин соёрхол талбиснаар мэдэгдэхүүн бүгдэд оюун ухааны гэгээн дэлгэрэв. Эрхэм зарлиг Ганжуур, тааллын тайлбар Данжуур тэргүүтэн авах гээхүйн орон нугуудыг өөрийн хүчээр ялгаж чадах “Агуу их билиг ухаан”-ыг оллоо хэмээн сэтгэх бясалгалыг алгасралгүй үйлдэнэ.

4. Зарлигийн үүднээс “Тунгалаг билиг”-ийг бүтээнэ. Дахин улбар шар рашааны урсгал бууснаар мунхгийн харанхуй бүхэн арилж, хотол ариуслын хувь хэсэг нарийнаас нарийн нугуудыг эндүүрэлгүй ялгаж чадах “Тунгалаг билгүүн”-ийг олов хэмээн бясалган үйлдэнэ.

5. Хөрөнгийн үүднээс “Түргэн билгүүн” бүтээнэ. Бусад нь урьдахын адил. Рашааны нарийн бүдүүн тоос бүгд хамаг биед түгж, түүнээс гэрэл цацраад бурхан бодьсдвагийн түргэн хамаг айлдлыг хөрөнгө үсгийн байдлаар урин ирүүлээд, биеийн доторх хөрөнгөнд шингэснээр бие ухаан саруул болоод эс оносон, буруу атхаг, эргэлзэх сэжгийн хир бүгд арилав. Эндүүрлийн атхаг төрөнгүүт хорьж чадах “түргэн билгүүн”-ийг олов хэмээн бясалгаж үйлдэнэ.

6. Мутарлагийн үүднээс “гүн билгүүн”-ийг бүтээх. Рашааны нарийн бүдүүн тоос бүгд илд болон ботийн байдалт гэрэл цацраад бурхадын гүн билгүүн бүгдийг боть, илдийн байдлаар биед шингэснээр бие ухаан саруул болоод зарлигийн үг, утганд торох ба мухардах мунхаг бүхэн арилж, эрхэм зарлигийн үг, утганд торж мухардахгүй ойлгох “гүн билгүүн”-ийг оллоо хэмээн бясалгана.

7. Бусад нь урьдах лугаа адил. Номлохын үг утга бүгдийг дотроо багтааж, бусдад ёсчлон заах “номлох билгүүн”-ийг оллоо хэмээн бясалгана. Мөн түүнчлэн

торолтгүй “хэлэлцэх билгүүн”, сайн номлолуудыг “туурвих билгүүн”-ийг тус тус оллоо хэмээн бясалгана.

Жишээ 10. Итгэлийн бясалгал

Чухаг дээд гуравт оюунаа тушааж, аврал эрэлцэх тухайтад энэхүү бясалгалыг хийнэ. Эрдмийг мэдэхэд гурав: бурхны эрдэм, номын эрдэм, хуврагийн эрдэм. Энэхүү гурван эрдэнийн мөн чанарт гурав төгөлдөр ачит багшдаа ханьцашгүй тунгалаг сүжгээр мөргөмү. Аврах чадал гагцхүү Лам гурван эрдэнэд л байгаад магад итгэмү. Багш дор итгэмү хэмээн олонтоо уншиж рашаан бууж ариусах бодлыг бясалгана. Бурхан дор итгэмү хэмээн уншихын үест бурхан чухаг дээдээс рашаан бууж ариусахын бодлыг дээрх лугаа адил бясалгана. Ном дор итгэмү хэмээхийн үест өмнө заларсан авралын орны боть нугуудаас рашаан бууж ариусах бодлыг бясалгана. Хуврага дор итгэмү хэмээхийн үест Бодьсадва, Шарвага, Брадигабуд тэргүүтэн хувраг бүгдээс рашаан бууж ариусах бодлыг бясалгана. Ядамын хот мандал, бурхадын чуулган нөхөр сэлтэд итгэмү хэмээхийн үест ядам бурхадаас рашаан бууж ариуган, тэдний аврал дор багтав хэмээн бясалгана. Цогт итгэл дээдийн номыг тэтгэгч сахиус бэлгэ билгийн мэлмий төгөлдүүдэд итгэмү хэмээхийн үест Баатар дагинас, номыг тэтгэгч бүгдээс рашаан бууж ариусан тэдний авралд багтлаа хэмээн сүслэмүй. Бурхан, ном, хуврагийн чуулганд бодийг хүртэл би бээр итгэмү хэмээхүйд авралын орон бүгдийн лагшнаас рашаан бууж ариусган, чуулганы орон бүгдийн авралд багтлаа хэмээн сэтгэнэ. Миний өглөг тэргүүтэн үйлдсэн буянаар магад амьтны тусад гэгээрэх болтугай хэмээн ерөөхүй сэтгэл үүсгэнэ. Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай. Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийн шалтгаанаас хагацах болтугай. Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай. Хамаг амьтан хол, ойр уригнах, тачаахаас ангид тэгш сэтгэлээр орших болтугай хэмээн цаглашгүй дөрвөн сэтгэл үүсгэнэ. Газар дэлхий хүжээр шүршин цэцэгсээр жигдэлж, сүмбэр уул, дөрвөн тивийг нар сараар чимээд, суу билигт бурхны оронд зорин өргөснөөр, асар ариун орныг хамаг амьтан эдлэх болтугай хэмээн мандал өргөнө. Ум сарва дата гада ядам гүрү радна мандала хам ниряа даяа ми.

Жишээ 11. Базарсадын бясалгал

Ерөндөгөөр дараагүй арвижсаар буй хилэнц уналыг ариусгаж үйлдэхийн тулд хилэнц түйтгэрийг ариусгах тухайтад энэхүү бясалгалыг хийнэ.

Жишээ 12. Мандалын бясалгал

Буяны чуулган хураахын тухайтад энэхүү бясалгалыг хийнэ.

Буддын бясалгалын тухай зарим судлаачдын санал бодол

Бясалгал хэмээн орчуулагддаг Буддын шашны санскрит нэр томьёо сэтгэлийг утга учир, тус эрдэмтэй болгож боловсруулах гэсэн утгыг илэрхийлдэг тул бясалгал зөвхөн нууцлаг учир шалтгаан, оюун санааг сонирхогч хүмүүст зориулагдсан бус, харин бүх хүнд хүртээлтэй хэмээн Санта Барбарагийн Ухамсар судлалын хүрээлэнг үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхийлөгч доктор В.Алан Валлас тэмдэглэжээ. Харин Википедия лавлахад “Бясалгал гэдэг нь анхны утгаараа сэтгэлийн соёл буюу сэтгэлийн хөгжил гэсэн утгатай. Харин дэлхий нийтээр Бясалгал гэж

чухам юу вэ гэдэг талаар яг тогтсон ойлголт байхгүй” гэж бичсэн байна. Хүний сэтгэл өдөрт дунджаар 60,000 орчим бодол төрдөг бөгөөд тэдгээрийн наяд орчим хувь нь сөрөг хандлагатай гэдгийг сэтгэл судлалын салбарынхан онцлон тэмдэглэжээ. Тэгвэл Буддын уламжлалт бясалгалаар хичээллэвэл хүний амар тайван амьдралын үндэс болсон эерэг бодлыг сөргөөс нь ухамсартайгаар ялган таньж, өөрт эерэг бодлыг гүн суулгах чадвар дадал олно хэмээн Монголын сүсэгтний холбооны бясалгалын багш, сэтгэл судлаач Б.Мөнхбаатар лам дурджээ. Бясалгалын зорилго нь сэтгэлийг тайвшруулахад оршдоггүй бөгөөд “хамгийн чухал нь ажиглан шинжлэх бясалгал юм” хэмээн 14-р Далай лам онцолсон байна. Харин “Ажиглан шинжлэх бясалгалын онцлог нь өөрийн оюун санаанд юу болж байгааг, юу болж буйг мэдэхэд оршино” хэмээн Доктор Александр Берзин тодотгосон буй. Бясалгал нь өнөө үед нийгмийн орчинд олон төрөл зүйлээр дэлгэрч, янз бүрийн зорилго, арга аргачлалаар сургалт явагдах болсон билээ. Иймд энэ бяцхан тоймын хүрээнд бясалгалын дотроос Буддын уламжлалт бясалгалыг авч үзсэн болохыг онцлон тэмдэглэе.

Дүгнэлт

“Санаанд үгүй бол оршиж чадахгүй” хэмээн гүн ухаантан Беркли нэгэнтээ хэлсэн буй. Түүнтэй уялдуулан эргэцүүлбээс, Буддын бясалгалын гүн санаа нь зөв зам мөрийг өөртөө нээж, санаандаа хоногшуулан нутагшуулахад чиглэсэн, хүчин чармайлт шаардсан, цаг хугацаа зарцуулсан нөр их хөдөлмөр юм хэмээн дүгнэж болно. Элдэв зүйлийн олон талыг олон түвшинд нэгэн зэрэг харшуулалгүйгээр харж, олсон ухаарлаа санаанаасаа алдахгүй байх, оюун санаагаа энэ чиглэлээр тууштай дадуулах, төвлөрөл хийгээд билиг билгүүний түвшинд хүртэл хөгжүүлэх нь Буддын бясалгалын зорилго ажээ.

Ном зүй

1. Зонхова Лувсандагва, Их бодь мөрийн зэрэг, УБ., 2006.
2. Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: Шинжлэх ухааны хэсэг, Боть 5. 2016. Түвд хэлнээс орчуулсан С.Гантөмөр.
3. В. Alan Wallace. The Attention Revolution: Unlocking the power of the focused mind. 2006.
4. Б.Мөнхбаатар, Буддын бясалгал ба сэтгэл судлал, УБ., 2020.
5. Б.Дарамбазар, Багшийн егүзерийн бясалгалын хөтөлбөр, УБ., 2018
6. Б.Дарамбазар, Итгэлийн бясалгалын хөтөлбөр, УБ., 2018
7. Б.Дарамбазар, Базарсадын бясалгалын хөтөлбөр, УБ., 2018
8. Б.Дарамбазар, Мандалын бясалгалын хөтөлбөр, УБ., 2018
2. Ц.Бат-Итгэл, Бясалгалын сургалт, 2022-05-29-өөс 2022-06-06. УБ. Батцагаан дугана.

4.9. Монголчуудын билиг ухааны өв уламжлал, монгол дархлаа, эрдэмжих зам мөрийн шинжилгээ

Хураангуй

Ахуй орчин нь хүнийг бүтээдэг (Б.Ф.Скиннер) учраас монголчууд хязгааргүй хөх тэнгэрийн дор, захад нь үл хүрэх тал нутгийн дунд үе үеэрээ хөлхөн амьдарч ирсэн нь

оршихуйн орон зай-цаг хугацааны төсөөлөл нь “асар уудам, хэмжээлшгүй их сав ертөнц” гэсэн суурь ойлголттой (энэ нь чинад хязгаарын сэтгэлгээ, билиг ухааны түвшинтэй дүйцэхүйц сэтгэлгээний түвшин юм) холбоотой болоход нөлөөлсөн нь дамжиггүй. Үүнийг хоёрхон жишээгээр баримжаа болгон дурдая.

Нэгдүгээр жишээ. Монгол соёл иргэншлийн язгуур тогтолцоо

Монгол түмэн дэлхийн бусад улс үндэстний нэгэн адил өөрийн гэсэн өвөрмөц соёл иргэншлийг бүтээж, бэлчээрийн мал маллагаанд түшиглэсэн соёл иргэншлийг сонгодог төгс хэлбэрт нь хүртэл хөгжүүлээд хойч үедээ уламжлуулж ирсэн билээ. Ингэхдээ монгол хүний сэтгэлгээ зөвхөн өөрийн өмч хөрөнгө болох мал, бэлчээр хоёроор хязгаарлагдаж байгаагүй. Харин байгалийн шүтэн барилдахуйн жамыг таньж, өөрийн оршихуйгаа хур тундасны эх үүсвэр болох цаг уурын нөхцөл, төдийгүй хамтдаа нийгэмшин оршиж буй бусад малчид, бүтээн туурвисан өв соёл, төрийн удирдлага бодлого зэргийг билиг ухааны нэгэн хараан дор зангидаж ирсэн байдаг. Энэ амжилтаараа дэлхийн суурьшмал соёл иргэншлүүдийн эсрэг туйл, нүүдлийн мал аж ахуйн соёл иргэншлийн сонгодог загвар, стандарт жишиг болж чадсан байна¹¹. Уламжлалт монгол соёл иргэншлийг бүрэн ойлгоход олон чухал асуудлуудыг хөндөх хэрэгтэй



Зураг 1

юм. Тухайлбал, Монгол хүний бүтээсэн соёл иргэншлийн эх ундрага буюу язгуур суурь нь юу вэ? Дэлхийн хоёр зуу гаруй улс үндэстний дотроос их гүрнийг байгуулж, мандаж явсан цөөхөн улсуудын тоонд Монголчууд яагаад багтаж чадсан бэ? Монгол соёл иргэншлийн өвөрмөц онцлог, давуу тал, бахархал нь юу? Энэхүү гайхамшигтай соёл иргэншил өнөө цаг үед ямар байдалд байгаа вэ? Цаашид хэрхэх вэ? гэх зэргээр асууж болно. Эдгээрт зүй зохистой хариулахын тулд монгол соёл иргэншлийн гарал үүслийг илэрхийлж чадах бүтэц буюу язгуур тогтолцооны асуудлыг хөндөх хэрэгтэй юм. Тэрхүү тогтолцоо нь монгол соёл иргэншлийг үйлдвэрлэдэг байх учиртай. Бидний хувьд уг тогтолцоог дараах бүдүүвчээр харуулж болно хэмээн үзэв (Зураг 1). Уг тогтолцоо (систем) нь

зургаан үндсэн элементээс бүрдэх бөгөөд монгол соёл иргэншил (МСИ)-ийн бодлого, менежмент (оюун ухаан) нь өөрийн дотоод зохицуулалт-төв удирдлагын үүргийг гүйцэтгэнэ. Малчин хүн (малчин монголчууд) сайн сайхан оршихын үндэс нь малын сайн сайхан байдал, малын сайн сайхан байдал нь бэлчээрийн сайн сайхан байдлаас шууд хамаарна. Бэлчээрийн сайн сайхан байдал нь хур тундас, түүнтэй хавсарсан цаг уурын нөхцөл байдлаас шууд шалтгаална. Эдгээр дөрвөн элементийн харилцан уялдаа, зохицолдоо, ерөнхий ололт, төлөв байдал, мэдлэг, туршлага, хөгжил дэвшлийн үр дүнд монгол соёл иргэншлийн оюун санааны үнэт зүйл, өв сан бүрэлдэж арвижина. Энэ өв соёл нь эргээд уг тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн үүрэг, ач тусыг илүү ойлгох, ухаарах, чухалд үзэх байдалд хүргэснээр тэдгээрийн синергетик үр дүн улам бүр тодорхой болж, бодлого зохицуулалт, удирдлагын түвшинд нэгтгэн зангидагдана. Бидний дэвшүүлсэн язгуур тогтолцоо нь монголын нүүдлийн сонгодог мал аж

¹¹ Х.Дондог, Монгол соёл иргэншлийн язгуур тогтолцоо, түүний онцлог, тогтвортой хөгжлийн асуудалд, Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойн Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2022.

ахуй (МНСМАА)-г соёл иргэншлийн түвшинд нь хүртэл өргөтгөн авч үзсэн юм. Ингэснээрээ монгол оршихуйн цогц байдал, монгол сэтгэлгээний цар хүрээг бүрэн хамарч, өв соёл, төр, нийгэм, мал, байгал хоорондын шүтэн барилдлагыг монгол хүн хэрхэн ухаарч, хорвоо ертөнцийн жамд хэрхэн уусаж амьдарч явсныг, бас явахыг харуулна.

Хоёрдугаар жишээ. “Монголын нууц товчоо”-ноос: “1205 онд Чингис хаан Мэргэдийн Тогтогогийн Худу, Гал, Чулуун тэргүүтэн хөвүүдийг нэхүүлэн илгээхдээ, Сүбэгээдэйд зарлиг болсон нь: “...Тэднийг жигүүрт болж нисч тэнгэрт гарваас Сүбэгээдэй чи шонхор болж нисч барих бусуу, чи? Тарвага болж хумсалж малтаж газарт орвоос царил болж цохиж эрж гүйцэх бус уу, чи? Загас болж тэр тэнгис далайд орвоос Сүбэгээдэй чи гөлми гувчуур болж шүүж гувчиж авах бус уу, чи?...” гэсэн буй. Үүнээс үзвэл, тэднийг хаанаас ч хамаагүй барьж ирэх ёстой нь илт. “Барьж ирэхгүй бол цаазаар авна” хэмээн дарамтлаагүй, харин “заавал барь” гэсэн далд утга, бас “Арга ухааны дээдийг сүвэгчилж барих ёстой”-г газар-тэнгэр-далай бүхий гурван их сав ертөнцийг багтаасан чинад билгийн түгээмэл арга зүйг сануулах замаар ухуулсан буй. Энэ нь Сүбэгээдэй их жанжин туршлагагүй учраас түүнд сургасан гэвэл алдас болно. Харин хүчирхэг дайснаас гарч болзошгүй далд эрсдлийг наанадаж гурван их сав ертөнцийн хүрээнд сэтгэн тооцож, ямар нэгэн таашгүй хүнд нөхцөлд орвол арга эв сүвэгчлэхэд бэлэн байх сэтгэл зүйн бэлтгэлийг нь хангаж, хийморь болон сэрэмжийг нь сэрээсэн хэрэг болно. Үүнээс үзэхэд, Чингис хааны буюу баатарлаг өвөг монголчуудын сэтгэхүйн орон зайн өргөн цар хүрээний нүүдэл, бэрхшээл саадтай учрахад бэлтгэлтэй байх, түүнд шуурхай дасан зохицож давах ид шидтэй “билиг ухааны монгол дархлаа”-г толгойдоо онож барих боломж цухас харагдана¹².

Дархлаа

Дархлаа нь явцуу утгаараа амьд биеийн оршихуйн үндэс мөн ч, өргөн утгаараа тухайн ард түмний оршихуйн суурь чадвар, бүр өргөн утгаараа хүн төрөлхтний эх дэлхийтэйгээ шүтэлцэн тэсч үлдэх чадвар буюу. Алд биеийн дархлаа нь гадны хорлогч бичил биетний эсрэг тэмцэх цусан арми бөгөөд “ямар нэгэн хэмжээгээр өвчин эмгэгт өртөхгүйгээр дархлаа тогтохгүй” тухай байгалын жам буй. Харин сэтгэл оюуны дархлаа гашуун гашуун зовлонг гаталж байж тогтдог. Монгол дархлаа ч мөн адил жишгээр өөрийн тусгаар тогтнолоо олох-алдах, соёл иргэншилээ тээх-гээх, зан заншилаа мартаха-санах, байгалийн бэрхшээлийн өмнө сөхрөх-босох, нийгмийн сэгсрээнд өртөх-үлдэх, аврах-аврагдах, өөрийн орон зайг булаалгах-буцааж авах зэргийг туулж тогтсон, зовлон-жаргалын мөнхийн хуйлрал дунд удам-соёлоо хадгалах чадвар болж өөрийгөө тунхагласан буй. “Толгойтныг бөхийлгөж, тойгтныг сөхрүүлэн” нэгдэж явсан үе байхад “өвөр хоорондоо эвээ олохгүй зарим нь Ижил мөрөн хүртэл авралын нутаг эрж явсан” үе ч бий. Ийнхүү дэлхийн талыг туулж, холхиж явахдаа оршихуйн жамыг хүссэн ч, эс хүссэн ч, эргэцүүлэн ухаарч явсан нь мэдээж юм. Монгол ухаарал нь өөрийн гэсэн өвөрмөц язгууртай ч Буддын танин мэдэхүйн ухаарлуудтай агаар нэгэн буй. Монгол ухаарал, түүнд суурилсан монгол дархлаа нь халуун хүйтний завсарт сүүний өрөм шиг тогтож, хаврын

¹² Х.Дондог, Монгол дархлаа нь бидний үнэт зүйл болох нь, МУСУИС, СУС-ын хүрээлэн, Монголын соёл, урлаг судлал, 2019, Боть-XXXI, Дэвтэр 1-20, х100-110.

хавсраганд заг лугаа босоо үлдсэн, говийн баян бүрд шиг шимтэй, шаврын цэцэг шиг тоосгүй, монгол ухамсрын охь бөлгөө. Жороор бүтээсэн бус, жамаараа аяндаа тогтсон монгол үндэсний дархлаа нь үр хүүхэддээ өвлөгдөж, “Төр, үр хоёрын мөнх оршихуй (Чингүнжав)”-г баталгаажуулдаг хүч мөн. Тэгвэл уламжлалаа тээж, эрдэм ухаанаа өвлөх, хэрэглэх ямар арга зам бидэнд байна вэ?. Энэ асуултанд зарим хариултыг эрэх замаар “эрдэмжих зөв зам мөр”-ийн тухай судалгааг хийсэн бөгөөд түүний зарим санааг дор товч дурдая.

А. Хүн хэмээх гайхамшиг

Хүн бол ертөнцийн гайхамшгуудын нэг юм. Араа шүд, эвэр туурай, хурд хүч, арьс үс, хатгах өргөс, халдаах хор үгүй атлаа араатны дундаас тодорч, амьтны ертөнцөд хаан сууж чадсан нь түүний ухаан, сэтгэл, хөдөлмөр гуравтай холбоотой. Эдгээр нь хүнийг тодорхойлогч гурван гайхамшигт шинж. Гэвч сайн муу нийлж сав дүүрдэг нь орчлонгийн жам тул сайныг дагасан гурван муу шинж нь тэнэг мулгуу, хорон сэтгэл, ажилгүй залхуу гурав юм. Сайн хүн гэдэг сайн талаа хөгжүүлж, бас түшиж, муу талаа хорьж, бас дарж чадсаныг хэлнэ. Хүний сайн талыг “бурхан” гэдэг бол муу талыг нь “чөтгөр” гэнэ. Иймд хүний оршихуй нь бурхан, чөтгөр хоёрын тэмцэл мөн. Хүмүүс сайн талаараа нийлэхийг эв, муу талаараа тэмцэлдэхийг хагарал гэнэ. Хувь хүн сайн тал нь илт давуу, муу тал нь сүүдэр шиг салахгүй ч босоод ирэхгүй бол боловсролтойд тооцогдоно. Хүний бурхан тал буюу сайн тал нь дийлж, ялж байхад эрдэм мэдлэг шийдвэрлэхүйц эерэг үүрэгтэй.

Б. Хүн эрдэм хоёр

Хүн, эрдэм хоёр хүйн холбоотой. Хүн эрдмийг бүтээнэ. Эрдэм ч хүнийг бүтээнэ. Эрдмийн тус их. Эрдэм хүний бүхий л амьдралыг тодорхойлно. “Чин эрдэмт хонь чоно хоёрыг нэг онгоцноос услах”¹³ гэх зэргээр хүний эрдмийг ардын ур ухаанаар, ид шидтэй адилтган олон талаас нь, янз бүрээр дүрсэлсэн буй. Эрдэмтэй байхын тулд эрдэмжих чадвартай болох, уг чадварыг өөртөө шингээхийн тулд эрдэмжих арга ухаанд суралцах нь зүй ёс билээ. Эрдэмжих чадвар нь юун түрүүнд өөртөө туслах ухааны цагаан толгой болно. Өөртөө тусалж чадаж байгаа бол бусдад тусалж чадна. Товчилбоос, эрдэмжих чадвар нь өөртөө, бас бусдад туслах чадвар болно. “Тусыг үйлдэж чадах нь бодитын бэлгэ чанар”¹⁴ хэмээнэ. Бодит эрдмийг сурснаар хүн хүндээ нөхөр, бие биендээ шүтээн болох зөв зам мөр нээгдэх болой.

Эрдэмжих арга ухааныг хэрхэн эзэмших вэ? Юун түрүүнд өөрийгөө олох хэрэгтэй. Хамгийн чухал нь тухайн хүний бусдаас ялгарах байдал. Бусдаас ялгарах байдал нь үнэн хэрэгтээ тухайн хүний брэнд, үнэлэмжийн суурь мөн. Бусадтай адилхан байхыг бүү хичээ. ХХ зууны манлай, дуурийн эмэгтэй дуучин Х.Уртнасан нэгэн ярилцлагадаа “Өөрийн биеийн муухайг засагдтал, брэнд болтол дуулж чадаж байгаа бол тэр хүн жинхэнэ дуучин” гэсэн байдаг. Дууг таашаасан хүнд дуучны “муухай” нь ч “таатай” тал руугаа уусаад дуучнаа тодосгож эхэлдэг тухай энэ ухаарал нь гайхамшиг. Түүнийг сонссоноос хойш дэлхийн болоод өөрийн орны урлаг, соёлын одууд дотор сул талаа давуу тал, бүр эрдэм чадал болгож чадсан хүмүүс байгааг олж харах мэлмий надад нээгдсэн билээ. Иймд өөрийгөө аль нэгэн салбарт олж,

¹³ Оюунтүлхүүр

¹⁴ Буддын шинжлэх ухааны хураангуй

ухаарал дүүрэн явах нь шид увдис мөн хэмээн хэн нэгэнд урам өгөх боломжтой юм. Хүмүүс өөр хоорондоо ялгаатай ч бас ижил талууд байх тул миний өчүүхэн ухаарал надад тус болдог шигээ бусдад тус болно хэмээн сэтгээд, энэхүү өгүүллийг бичсэн билээ. Өөртөө тохирсон арга, аргачлалаа олж, давуу талаа төдийгүй сул талаа ч амилуулах нь “увдисуудын нууц” мөн. Түүнийг олоогүй цагт хүн “хөлөө сайн олоход” бэрх. Өөрийгөө ухаажуулахын тулд мэргэдийнхээ буурал түүхийн шаргал хуудсуудыг шантралгүйгээр эргүүлж, орчин үеийн шинжлэх ухааны ноён оргилууд тийш дурандаж, гүн ухааны гүнзгий хавцал руу өнгийж, сэтгэлийн нууцлаг ертөнц рүү шагайж байж олсон “хумсын чинээхэн шар тос”-оо та бүхэнтэй хуваалцах нь энэ бичвэрийн зорилго юм.

В. Эрдэмжих арга ухааны өвийг уудлах нь.

В1. ДЭЭДИЙН НОМЫН ДЭЭЖЭЭС

Хүний танин мэдэхүй төгс төгөлдрийн зүгт чиглэдэг. Өөрийгөө сайн зуршлуудынхаа сав болгоход дээдийн номын санаа оршдог. Юм юмыг туршиж үзэх нь зөв ч өөртөө тохирохгүй ганц талыг бариад, түүнээ л нухаад, давтаад байх нь цагийн гарз болно. Нэг талын тун хэтэрвэл хор гэдэг дээ. Бусад хувилбаруудыг эрж хайх нь зүйд нийцнэ. Эрдэм ном сурахад бусдаас сонсох тал чухал ч, өөрөө ухаарах тал бас нэн чухал. Сонсох нь эрдмийн суурь мөн хэдий ч эрдмийн чадамжийн төв нь биш юм. Хүнээс эрдэм сонсох нь үргэлж давамгайлаад, өөрөө хичээн боловсруулах нь байнга дутаад байвал “хоосон эрдэм хураасан” гэмд унана. Уг хоёр талыг тэнцүүлэн авч явбал эрдмийн сурц илүү болно.

Дээдийн ном гэж юу вэ? Хорвоо ертөнцөд бодит, хуурмаг хоёр тал байхад түүний шид бүтээл болсон хүнд ч бас онох, эндүүрэх хоёр тал байх нь жам. Яалтгүйгээр нар дэлхийг зүүнээс баруун тийш тойрч байгаа нь илт байтал үнэн хэрэгтээ дэлхий нарыг тойрдог билээ. Далай байгааг үл анзаарваас түүнд үүссэн сарны дүрс яахын аргагүй сар өөрөө мөн гэж бодогдох гэх мэт. Хүний сэтгэл “жаргал, зовлон хоёрын мэдрэмж”-ээс бүтсэн хэдий ч жаргалаа зовлон, зовлонгоо жаргал хэмээн эндүүрэх нь бий. Жаргал ургуулах гээд зовлонгийн үр тарих нь ч бас байдаг. Тиймэрхүү гүн төөрөгдлийн үед “далай байгааг харуулаад тэнд сар биш, дүрс байгааг ухааруулахтай адилхан” үйлийн гарцыг хүний сэтгэлд үйлдэж үзүүлэх нь тун бэрх ажээ. Сэтгэл хүний амьдралын бүхий л ээдрээг үүсгэдэг ч түүнийг нь тайлах маш хэцүү хэмээх бөлгөө. Энэ л бэрхшээлээс болж хүн төрөлхтний олонхи нь үеийн үед төөрөлдсөөр иржээ. Төөрөгдлөө мэдэхгүй төөрч буй бидэнд буруу юу байхав. Гэвч төөрөгдлийг мэдсэн хэн нэгэн бидэнд туслахаар тэмүүлж байдаг нь бас нэгэн гайхамшиг. Түүнтэй тааралдаж, тосон авахыг хичээх нь бидний үүрэг ч байж мэдэх юм. Төөрөгдлөөс гарахын тулд өөрийн сэтгэлтэй л ажиллах ёстой гэдэг. Сэтгэл нь дангаар байдаггүй. Тэр ухамсар, мэдэхүй, атгаг гэсэн гурван талын гурамсан сүлжээнээс бүтсэн зангилаа юм. Сэтгэлийн төөрөгдлийн тухай, түүнээс ангижрах арга аргачлалын тухай, аргыг амилуулахаар эрс шийдсэн өөрийн хатуу сахилга бат, тангарагийн тухай сургаал, зөв зам мөрийг бүтээж чадсан мэргэдийн ухааныг дээдийн ном хэмээх ажээ. Түүнээс эрдэм сурахын тухайтад өчүүхэн тун төдийг өгүүлсүгэй, би.

Эрдмийн дөрвөн мөр нь сонсох, санах, төвлөрөх, ажиглан шинжлэх ажээ. Энэ нь зөв болой. Иймд нэгэн мэргэн бээр “Сайн мөрийг амьсгалах завгүй мэт бясалгаж яв”¹⁵ хэмээн айлджээ. Бодит эрдмийг бүтээхэд дөрвөн зүйл маш чухал. Үүнд: 1. Хүчтэй тэмүүлэх сэтгэл; 2. Удаан хугацааны хичээнгүй; 3. Нэгэн үзүүрт сэтгэлээр зорих; 4. Шинжлэн таних зуршил тус тус орно. Одоо эрдмийн дөрвөн мөрийг даруулуулан товчилж үзье.

1. Сонсох

Сонсох нь эрдмийн эх. Сонссон төдийгөөр гарах эрдэм ч бий, сонссоноо боловсруулсаар олох эрдэм ч бас бий. “Самади эрдэм бүгд сонссоноос болохыг мэдсэн нь мөр түүний мөн чанарыг мэдсэн билиг мөн”¹⁶ хэмээжээ. Багш мэргэдээс сонсохыг хүсэх нь чухал ч сонсох чадвар хэрэгтэй. Сонсохоор дамжин ирж буй эрдэм нь сонсогчийн зүгээс хүссэн зүйл, сонсох дургүй зүйл хоёроос бүтнэ. Иймд зөвхөн сонсох гэснээ л сонсдог бол сонсохын эрдэм төгс болж чадахгүйд хүрнэ. Сонсох чадвараа хөгжүүлэх, эс сонирхсоноо сонсож эрдмийг барих, зөв зүг чигт одох, практик арга ухаан руу хөрвүүлэх зэрэг нь нэн чухал. Сонсохын цагт дуршлыг ихэтгэн үйлд гэсэн үг бий. Сонсох хүсэл, сонсох чадвар, сонссоноо хүлээн авах сав хэрэгтэй. “Ёсчилон анхаарч эс авбаас сонссоны тус үгүй. Үгсэд мэргэн боловч анхааран эс авбаас усаар автаад цангаж үхэх лугаа адил”¹⁷ гэсэн буй.

Сонсох нь өөртөө мэдүүлэх, өөртөө агуулах сэтгэл бүхний эхлэл. Иймд сонсохгүйгээр бясалгах нь “хүлүүлсэн гартайгаар хаданд авирах мэт” хэмээсэн буй. Сонсголонгийн эх нь багш. “Шид нь сургаалын багшийн хойноос дагах мөний тул сургаалын багш үгүйеэ болбоос шид олохуяа үл болох”¹⁸ гэжээ. Шид нь номыг танин мэдсэний баяр баясал, ухаарлын таатай мэдрэмж юм. Үнэндээ бол сайн багш, сайн шавь хоёрыг олох нь хүний төрлийг олохтой нэгэн адил маш ховор хувь заяа хэмээн сударт бичсэн буй. Хоорондоо учирлаа гэхэд багш шавь хоёр бие биеэ зөв таньж оносон байх нь чухал. Иймд лам багш бээр ч шавийг өнө удаан шинжил, шавь бээр ч лам багшийг өнө удаан шинжил гэжээ. Шудрага оршин, оюун төгс утга хичээгчийг сонсогчийн сав хэмээнэ. Иймд “Мэргэн шулууныг хур мэт шүтэхэд далай мэт үл ханагчийн шавь алт эрдэнээс чухаг” гэжээ. Эрдэм ном сурахад тухайн шавийн сүсэг нэн чухал, сүсэглэхгүйгээр эрдмийг онохгүй, бас бишрэл, дуршил төрөхгүй. Шүтэх буурвал эрдэм буурна хэмээсэн буй. Харин сүслэн бишрэн үйлдвээс адистэд орших буюу номын утга өөрт шингэх боломж бүрдэнэ. Номыг тээгч буюу дамжуулагч багшийг тахиж хүндэлж байж эрдэм номд дуршил төрөх учраас эрдэм төгс багшаа олох нь маш чухал. Бас багшийн зөвхөн сайн талыг харваас сүсэг төрөхөд тустай гэнэ. “Багшийг тахивал хамаг мэдэгчийг ольюу” хэмээжээ. Багшийн номлолыг сонсохыг эс хүсвээс өөрт эрдэм төрөх цаг үгүй тул багшийг шүтэж, сонсоход мэргэших хэрэгтэй болж байна. Энэ бүхний цаана өөрт эрдэм төрөх эсэх нь сэтгэлээс болно хэмээсэн суурь үзэл баримтлал бий. Сэтгэлийг сүсэг жолоодох нь бас бий. Багш шавь хоёрын аль алиных нь сүсэг энд чухлаар тавигдана. Сүслэх сэтгэл буй бөгөөс хол суувч ойр, сүслэх сэтгэл үгүй бөгөөс дэргэд суувч хол хэмээжээ. “Ном хийгээд ном өгүүлэгч хоёулаа эс биширсэн түүгээр билиг буурахын шалтгаан. Тиймийн тул өөрөө аль нотолсон түүнээс сонсон

¹⁵ Д.Данзанравжаа

¹⁶ Тодорхой толь

¹⁷ Тодорхой толь

¹⁸ Тодорхой толь

үйлд, түүний адистэд ормуй. Хэнд сүжиглэсэн тэрбээр түүнийг номхотгомуй”¹⁹ хэмээжээ. Энэ нь сүжиглэсэн багш шавьд байх хэрэгтэйг дахин сануулж байгаа бөгөөд тиймгүй бол эрдмийн далайд өөрийн жолоогүй мэт булгилан төөрөх ажээ.

2. Санах

Санах нь өөрийн санаанаас үл салгах гэсэн утгатай. Сонссоноо эргэж санах нь давтах мөн, бас үл мартаx ч мөн. Сонссоноо мартаx нь өөрийн сахилга бат суларч, давтах үйлээ цалгардуулсантай холбоотой. Өөрийн сахилга бат үгүй бол сонссоноо санаж эрдэм рүү хувирган боловсруулж үл чадна. Иймд эрдэм номын зүг шавь өөрийн “залхуу” ухааныг чиглүүлэн “ташуурдаж”, нэгэн үзүүрт сэтгэлээр тэвчээртэй зүтгэх хэрэгтэй. Давтах дургүй байгаа бол сонсох төдий хэмжээнд өөрийн зорилго байгааг харуулна. Харин сонсохоос цааш давуулан “сонссоноо ойлгох, ухаарах” гэсэн дараагийн зорилгыг тавьж байж давтах үйл утга учиртай болно. Санах нь олон зүйлсийг эхэнд, дунд, адагт гэх зэргээр эрэмбэлж, утга санаа, ач тус, эмх цэгц, харилцан уялдаа, үр нөлөөг нь тодруулахад туслана. Өөрийн сахилгыг тангараг болгон мөрдөж, цагийн хуваарь гарган хатуу хэрэгжүүлэх нь зүйтэй. Өөрийн бие, сэтгэл зүйн таатай үе, санах тогтоох ой санамж сэргэг байх цаг мөч зэргийг тооцож ажлын хуваариа гаргах нь зөв. Санах давтах (үүнийг санамсар гэнэ)-ыг автомат зуршил буюу чадвар болгон хэвшүүлэх хэрэгтэй. Үүний тулд өөрийн муу зуршлын элдэв үзэгдлийг анзааран, түүнийг арилгах нь тустай. Хийнэ, хийнэ гэсээр, эсвэл үүний дараа, түүний дараа гэсээр, эсвэл зүгээр л завгүй, завгүй гэсээр цаг алдвал муу үр дагавартай.

3. Төвлөрөх

Төвлөрөл нь сэтгэлээ тогтоох юм. Уймарсан сэтгэлээр эрдэм ном үзэх гэх нь хуй салхин дотор хийсч явахтай адил. Төвлөрөхийн увдис нь үл хөдлөх, үл хазайх, юмсыг гүн ухаарах, түүнд нэвтрэн орох, түүний шинж чанарыг танин барихад оршино. Эхний ээлжинд төвлөрлийг богино хугацаагаар тогтмол хийх нь илүү үр өгөөжтэй гэдэг. Өдөртөө дор хаяж хоёр удаа хийж хэвшвэл зүгээр (өглөө, оройд, мөн өөрийн завтай, таатай аль ч цагт хийж бас болно).

Төвлөрөх нь тухайн зүйлд анхаарал хандуулахтай холбоотой бөгөөд өмнө өгүүлсэн сонсох, санах хоёрын дараах үе шат юм. Оюун санаа, тухайлбал, номын утгад илт татагдан төвлөрөх нь татах хүч үйлчлэхтэй адил. Төвлөрлийг ухамсрын зургаан хүчээр буй болгоно гэж үздэг²⁰. Эдгээр хүчийг эзэмдснээр зөв зүгт өөрийгөө залж чадна. Мэдэх гэсэн тэмүүлэл нь сонсохын хүчийг үүсгэнэ. Сонсоод таалагдвал үргэлж эргэж дурсах гэсэн санааны хүч үүснэ. Эргэн санах хүчний дараа дурдан санах хүч үүсч, санааг барин агуулах, ойр агуулах сэтгэл төрнө. Дараа нь ухамсарлах хүч үүсч, уг санаанд хүчтэй төвлөрөх сэтгэл үүснэ. Санааг ухамсарласнаар нэгэн үзүүрт сэтгэлээр хичээнгүйлэх хүч үүснэ. Түүний дараа хүчин чармайлт ихээр шаардахаа больж аяндаа уг чухал санаанд ойртон төвлөрөгч дадал төрнө. Ийнхүү тухайн санааг сонсож, дурсан санасны дараа түүнд өөрийн зөнгөөр төвлөрч дадах хүртэл нь сэтгэлийг дасгах үе шатуудыг энд авч үзэж буй хэрэг билээ. Эхлээд мөн бишийг ялган хянамгайлаад, цаашид саад тотгорыг арилгах замаар уг санаанд төвлөрч эхэлдэг бол түүнд дадах тусам саадгүй хүрэх, өөрөө аяндаа хүрэх шатууд руу шилжинэ.

Зөв тогтуун төвлөрлийн гурван гол шинж нь сэтгэл маш тунгалаг орших, бодолдоо нэгэн үзүүрт сэтгэлээр орших, амгалан тайван байх гурав юм. Сэтгэл тунгалаг байх нь бодлоо ил тод барих, тунгаах юм. Нойрмоглох, залхуурах, аажмаар бодлоо гээх зэргээр сэтгэл уусах нь

¹⁹ Тодорхой толь

²⁰ Их бодь мөрийн зэрэг

тунгалаг тодорхой байдлын саад тотгор (үүнийг живэлт гэнэ) юм. Живэлт нь номын агуулгад зорьсон бодол санаа ямар ч тодорхойгүй болж алдагдахыг хэлнэ. Живэхийг арилгахдаа сайн ойлгох, сурахын ач тусыг сэтгэлдээ бодох, түүнтэй холбоотой шүтээн сайн талыг санах гэх мэтийг сэтгэн үйлдэнэ. Нэгэн үзүүрт сэтгэл олсныг сэтгэлийн бясалгал гэх нь бий. Бодолдоо нэгэн үзүүрт сэтгэлээр хандахад догширох буюу сэтгэл санаа сарних, бодлоо гуйвуулах, түүнд атхаглах зэрэг нь саад болно. Догширох нь сэтгэлийг амраахгүй, тогтуун сэтгэлийг уймруулах сөрөг нөлөөтэй. Бодол тунгалаг, сэтгэл төвлөрсөн байхтай хамт сэтгэлээ амгалан тайван байлгах нь тунчиг дэмтэй.

Живэлт, догширол зэрэг саадуудыг арилгах, сэрэмжлэхэд зохих арга, аргачлалыг цаг тухайд нь өөртөө авч сурах нь чухал юм. Сурах, ойлгох гэсэн зүйлдээ сэтгэлээ тогтоох, зорилгоо санах, үл мартаж, түүндээ сэтгэлээ байнга уях замаар байн байн алгасран сарних сэтгэлээ номхруулж болно. Сэтгэлээ хянах нь чухал. Сэтгэл сарнисан, эс сарнисан, сарниж болох, сарнихгүй байхыг мэдэх дадлыг (үүнийг мэдэмсэр гэнэ) өөртөө суулга. Энэ нь үнэндээ бол живэх, догширохыг ухамсарлахуй юм. Ойлгох зүйлдээ хайнга хандвал живж эхэлдэг бол түүндээ хэт гүн анхаарвал догширох гэм гарна гэж үздэг. Тиймээс өөрийн анхаарал, төвлөрөл, хяналтын чанга сулыг тааруулах хэрэгтэй юм. Олон дахин богино хугацаатайгаар ойлгох зүйлээ эргэн харах хэрэгтэй. Гол нь ямар ч үед ямар ч хугацаанд бодол, живэлт, догширол гурав болон санамсар, мэдэмсэр хоёрыг сайн ялган таньдаг байх нь ухамсрын хүч сайн байгааг илтгэнэ. Байнга санамсараа ажиллуулж чадваас живэл догширолыг таних боломжтой байна. Санамсар буюу дурдан санахаа үл мартан живэл, догшролыг онож мэдэхийг ухамсар хэмээнэ. Ухамсарт суралцах гэдэг нь бие, сэтгэлийн янз байдлыг байн байн шинжлэх юм. Живэх догширохыг мэдэх болон санахуйн ёсыг шүтсэнээр алгасарч одох, умартах явдлыг хязгаарлах болно. Дан ганц хичээнгүйг мөрдөөд байвал алжаалын туйл болох тул ухаантай ижилсүүлэн суралцваас их хэргийг бүтээнэ. Сүсэг төрвөөс дуршил төрнө. Дуршил төрвөөс хичээнгүй төрнө. Ийнхүү өөртөө сонирхол (сүсэг), дуршил, хичээнгүй төрүүлэх замаар живэл, догширол үүсэхгүй байх нь нэн чухал.

Бодол сэтгэлгээгээ ямар нэг гэмшилгүй, баясгалантай, машид боловсруулан, амгалан тайвнаар илт барьж үйлдэх хэрэгтэй. Үүнийг тэгш агуулах гэнэ. Сэтгэл амар тайван, зорьсон зүйлс тод томруун, өөрийн зөнгөөр хичээл чармайлтгүйгээр анхаарал дүүрэн оршиж, бүхэнд тэгш хандах нь сэтгэлээ тэгш агуулсны шинж юм. Сэтгэлд живэх ба догшрох байхгүй болсон үед тэгш агуулах боломжтой болно. Тэгш агуулахын таван гэм нь залхуурах, увидас номыг умартах, живэх, догшрох, үйл эс бүтээх болой.

4. Ажиглан шинжлэх

Ажиглан шинжлэхийн амин сүнс нь шүтэн барилдлагыг ойлгож ухаарахад оршино. Шүтэн барилдлагыг ухаарах нь эрдмийн дээд хэмээдэг. Шүтэн барилдсан алив зүйл нь “усан доторх сар” адил²¹ гэжээ. Шүтэн барилдсан гэх нь олон талууд, олон нөхцөл шалтгаанууд нийлсний үр дүнд бий болсон гэсэн утга юм. Сар усан дотор харагдах нь тэнгэрт байгаа сар, түүний гэрэл, ус, усны гадаргуу, гадаргууд тусаад ойх гэрэл, ойсон гэрлүүд нүдэнд ирээд сарны дүрс үүсгэх зэрэг олон хүчин зүйлийн нэгдэл буюу хамтын хүчний үр дүн юм. Үүнтэй нэгэн адил орчлон хорвоогийн бүхий л зүйлс шүтэн барилдлагын үр дагавар ажээ. Шүтэн барилдсан бүх зүйлс өөр хоорондоо нэгэн нийтлэг шинжтэй. Тэр шинжийг нь “хоосон чанар” хэмээн нэрлэдэг. Яагаад гэвэл усан доторх сар, тэнгэрийн жинхэнэ сар хоёрыг өөр хооронд нь андуурах боломж байгааг Та нэг сайн анзаараад үзээрэй. Андуурснаар бид сарны хоосон чанарыг барьж буй хэрэг болно.

²¹ Их бодь мөрийн зэрэг

Ялгаа нь яг юунд байна? Ус хажууд байгааг мэдээд, бас тэр дотор сар байхгүй гэдгийг мэддэгт л байгаа юм. Гэтэл орчлонгийн алив зүйлсийг бид “хажууд байгаа ус шигээ, бас тэнд юу байж болох, юу байж болохгүйг мэддэг шиг”-ээ мэдэж чадахгүй шүү дээ. Иймд үнэн хэрэгтээ “усан доторх сар шиг” зүйлсийг бид бодитой юм шиг бодоод явдаг байж болно. Гэвч “Хэрэв юмсыг хуурмаг буюу хоосон чанараар нь бариад байвал юу болох вэ?” гэсэн асуултыг өөртөө тавьж болно. Дээдийн номын мэргэдээс асуувал, эсвэл судар номоос үзсэн ч гэсэн, “Ер нь хоосон чанарыг барьчихаад л бид чинь бодит гэж бодоод явдаг улс шүү дээ, үүнийг л мунхаг гээд байгаа юм” гэх нь тэр. Энэ бүхний ээдрээг тайлахад “Од эрхэс, бүрэлзэхүй, зул хийгээд хоосон илбэ, шүүдэр, усны хөөс, ба оргүй зүүд, гялбахуй хийгээд үүл мэт хамаг хуран үүдсэн бүгдийг тэр мэт үзэгтүн”²² хэмээсэн сургаалын утгыг ойлгохоос эхэлнэ. Ажиглан шинжлэх бясалгалын аргаар л эдгээрийг ухаарч ойлгох боломжтой гэдэг. Үнэн хэрэгтээ энэ сургаал дотор тоочигдсон шинжүүдийг шүтэн барилдаж буй болсон бүхий л зүйлүүдээс илрүүлж болно. Одоо тэгвэл яах вэ хэмээвээс, юмсын эдгээр талуудыг бас бодитойд тооцож, өөрийн хуучин туйлширсан төсөөллүүдийг тэнцвэржүүлэн, тунг тааруулан саармагжуулах хэрэгтэй юм. Энэ нь биднийг юманд хэт барьцалдан туйлын үнэнд барихаас сэргийлж, олон сайн үр нөлөө үзүүлдгийг үе үеийн мэргэдүүд онцлон тэмдэглэсээр ирсэн бий.

В2. АРДЫН СУРГААЛЫН АЛТАН САНГААС

“Ахмадын сургаал алт” гэдгийн үлгэрээр дорнын их үндэстэн монгол зон олныхоо аман болон бичгэн сургаалаас сурах юм их бий. Хүний бодол санаа, хүсэл мөрөөдөл, эрч хүч, төсөөлөл, сэтгэлгээний цар хүрээ нас насны үеэр өөр өөр байдаг нь илт зүйл. Залуу насанд тоохгүй явсан юм насны бөгсөнд магнаг болохыг үзэж суух нь надад ч бас тохиож байна. Тойроод ирээгүй, дайраад гарсан хүний хувьд нас насны ухаарал ч бас өөр гэдгийг онцлон хэлэе. Манай Монголчуудын хувьд бахархах түүх арвин бий. “Зам бүхэн Ром орно” гэх үе байсан бол “Харгүй бүр Хархорин орно” гэсэн үе ч бас хүн төрөлхтний түүхэнд тохиосон гээд бодоход “Бид ямар ард түмний хойч үе вэ?” гэдэг нь тодорхой. “Толгойтныг бөхийлгөж, тойгтныг сөгдүүлж” явсан өвөг дээдсийнхээ ур чадвар, эрдэм ухааны охийг тунгааж шүүгээд шингээх ухаан бидэнд байх ёстой. Үүнийг нэг амьсгаагаар хийхгүй тул Та бүхэн цаг заваараа сэтгэлээ тогтоон, няхуур бодож байхыг хичээсүгэй.

Эрдмийг холоос, бас ойроос сурч болно гэсэн санаа монгол ардын сургаал, номын мэргэдийн бүтээлд бий. “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдмийг өвөртлөн ирнэ”²³ гэсэн байхад “Хүний хүү эрээд олохгүй эрдэнийг өөрийн хүү өлмий дороосоо олно” гэх юм уу, эсвэл “Монголоосоо сурах зүйл чинь дууссан бол гадагшаа явахтай чинь санал нийлнэ ээ”, “Эрлийн үзүүрт эрдэнэ” гэх зэргээр ардынхаа аман яриа хөөрөө дундаас шүүрдэж олох боломжтой өвгөдийн хатуувтар, бас егөөтэй үгсийн сургамж их. “Үзэх мөрийг олохын цагт өөрөө хадгалуулсан эдээ авахтай адил”²⁴ хэмээсэн нь “юмыг ухаарахын цагт тэрхүү ухаарсан зүйл нь өөрийн юм шиг санагдана” гэх зэргээр буух бөгөөд товчилбоос, “өөрөөсөө эрдмийг олдог” гэж уншмаар байгаа юм. Өөрөөсөө олсон юм өөрийн байхаас өөр яах ч билээ.

Уламжлал гэдэг дан ганц улирсан, бүдгэрсэн зүйлээс бүтдэггүй. Өчигдөр нь миний уламжлал мөн, бас урд төрөл ч мөн. Иймд өөрийнхөө өнгөрснөөс эрдэм гаргах нь чухал. Эрдэм өөрөө гараад ирэх нь ховор, гарч ирэхгүй нь элбэг. Иймд өөртөө ойрхон байж, өөрийгөө уудлах

²² Оёироор огтлогч судар

²³ Д.Нацагдорж

²⁴ Тодорхой толь

нь чухал. Эрдмийн сав болох нь өөрийгөө эрдэмжүүлэх, өөрөөсөө эрдэм олох хоёроос бүтнэ. Эрдмийн сав болохын тулд өөрийгөө шинжиж, эрдмийн зүг шавдуулж “гашуурдах” хэрэгтэй. “Ойд ойрхон хүн арслан барс ярина. Усанд ойрхон хүн загас жараахай ярина” хэмээсэн нь ойр байгаа зүйлээрээ хүн амьсгалдаг гэж буй хэрэг. Иймд өөртөө, бас эрдэмд ойр байх хэрэгтэй. Эрдэм олохын тулд өөрийгөө шигших шаардлагатай. Эрдэмд дурла. “Эрдмээр үл ханагч сурагч алт эрдэнээс чухаг”²⁵ гэдгийг сана.

“Багшаа голбол эрдэм холдоно”²⁶, “Үлгэр сайн бол үйлс сайн”²⁷ гэсэн нь хүнд шүтээн хэрэгтэйг хэлж буй хэрэг. Хүнд үргэлж түших зүйл хэрэгтэй. Биеийн түшиг нь аав ээж, сэтгэлийн түшиг нь шүтээн юм. Иймд багшийг түшиж, шүтэж байж эрдэм номд ойр байх болно. Ном, шүтээн, багш гурав нь нэг л зүйл. Иймд багшийг шүтэхгүйгээр номыг шүтэх нь үл бүтэх санаа мөн. “Сайн муу хоёр нийлж сав дүүрэх” гэдгийн үлгэрээр багш ч гэсэн сайн муу хоёр, ном ном бус хоёрын нэгдэл юм. Алтыг тунгааж олборлохын адил багшаас эрдмийг тунгаан авах нь зүй ёсны зүйл. Цул алтан багшийг эрэх хэрэггүй юм. Энэ хорвоо ертөнцөд багш шиг том цул алтыг хэзээ ч, хэн ч олоогүй гэдгийг санаарай.

Өөрийгөө шинжил, өөрийгөө тань. Өөрөө эрдэнэ биш бол өрөөл эрдэнэ мөн биш нь танд хамаагүй зүйл. Залхуугаа шинжил. Эндүүрлээ шинжил. Ухаарлаа шинжил. Мөрөөдлөө шинжил. Шүтээнээ шинжил. Оюун ухаанаа шинжил. Чадвараа шинжил. Дадлаа шинжил. Олон талаас нь шинжил. Олж зөв шинжил. Үйлээ шинжил. Үзэл бодлоо шинжил. Санаагаа шинжил. Сайн муу алин болохыг шинжил. Сэтгэлээ шинжил. Өөрийн сэтгэл өрөөлд харагдахгүй ч өөрт чинь ил бий. Өөрийн муутай тэмц. Өөрөөсөө бүү зугт, бүү урва. Байгаагаар нь хүлээн авч, өөртэйгээ ажилла, өөрийгөө өөрчил. Хүний боломж, чадамж хязгааргүй, тэдгээрийг дайчил, сайн зүг рүү чиглүүл. Өөрийгөө ургаж буй цэцэгтэй зүйрлээд үз. “Хэнз ногоо нарийхан ч хөрс нэвтлэх хүчтэй”²⁸ -г сана. “Оролдлого сайт оройд нь гарна”, “Тэвчээр бий бол эрдэм бий”, “Гэнэдэхгүй бол гэгээрэхгүй” зэргийг тооц. “Гайтай хүнийг тэмээн дээрээс нохой ноолно” гэж үг бий. Өөрийн сэтгэлийг ариусга, сайн сайхан үйлсийг бод, бүтээ хэмээжээ.

ВЗ. ШИНЖЛЭХ УХААНЫ ШИМ, ГҮН УХААНЫ ОХЬ

“Ертөнцийн ухаан хүнд, хүний ухаан эрдэмд”²⁹ буй. Эрдмээс эрдэм төрнө, эрдэм ч бас өөрийгөө сэлбэнэ. Тухайлбал, физикт сонгодог механикийг квант механик сэлбэж өгсөн бол Ньютоны механикийг харьцангуйн онол өргөтгөж өгсөн юм. Эрдэм хүнээс төрдөг ч эргээд эзнээ сайжруулах увидастай. Эрдэм хүнийг жолоодно. Хүн ямар ухаан бодолтой яваа нь түүний үйл үйлдлийг тодорхойлдог. Иймээс “Хүн хөлөөрөө явдаггүй, толгойгоороо явдаг”³⁰ гэсэн буй.

Эрдэм номын мөр хөөж буй хүний зорилго их. Тэрбээр “өөрийгөө төдийгүй эзнээ нөхөн сэргээх чадамжтай мэдлэг”-ийг буюу “эрдэм мэдлэг” (эрдэмжсэн мэдлэг)-ийг эрэн сурвалжладаг нь нууц биш. Энэ зам мөр амар хялбар биш, бас тийм ч богино биш юм.

Мэдлэгийг танхимийн хичээлээр дамжуулан авах болсон нь шинжлэх ухааны мэдлэг ихээр хуримтлагдсанаас үүдэлтэй. Хичээл нь мэдлэгийг өгөх, авах хоёр үйлээс бүтнэ. Энэ нь ихэнхдээ ярих-сонсох үйлээр дамжиж ирсэн түүхтэй ч мэдлэгийг өгөх-авах урлагийг багш нар хөгжүүлсээр иржээ. “Мэдлэг өгөх урлаг” нь заах арга хэмээн нэрлэгддэг бол “мэдлэг авах

²⁵ Тодорхой толь

²⁶ Тодорхой толь

²⁷ Зүйр цэцэн үг

²⁸ Зүйр цэцэн үг

²⁹ Зүйр цэцэн үг

³⁰ Зүйр цэцэн үг

урлаг” нь суралцахуйн ухаан нэртэй билээ. Зуун оюутан нэг багшийн лекцийг нэг ижил орчинд сонссон ч сурц нь өөр өөр байна. Энэ нь оюутнуудын суралцахуйн ухааны ялгааг илэрхийлнэ. “Толгой ондоо бол ухаан ч ондоо”³¹ тул энэ ялгааг тухайн оюутан өөрийн толгой дотор эрэх хэрэгтэй. Үүнд л энэ өгүүллийн утгын зангилаа байгаа юм.

Шинжлэх ухаан, технологийн хөгжилд давтамж бий. Эхлээд туршилтын мэдлэг олно. Дараа нь онолын мэдлэгийг бүтээнэ. Түүний дараа онолын мэдлэгийг технологийн мэдлэг рүү хөрвүүлнэ. Тэгээд технологийн мэдлэгт тулгуурлан техник, эд хэрэгсэл бүтээнэ. Бэлэн болсон бүтээгдэхүүн хэрэглэгчийн гар дээр очиж, түүний эрэлт хэрэгцээг хангана. Годорхой хугацааны дараа хэрэглэгчийн шаардлага хангахгүй болсон техник технологийг шинэчлэх хэрэгцээ урган гарна. Мэдлэгээ шинэчлэх энэ үйл явц мөн л дээрх тойргийн дагуу явагдана. Онол, туршлага хоёрын хооронд зарим ялгаа бас гардаг. Тухайлбал, гэрлийн хурдыг туршлагаар хэмжихэд секундэд 300 мянга орчим километр гардаг бөгөөд тэр нь харьцангуйн онолын постулат ёсоор тогтмол, хэзээ ч тэр утга өөрчлөгдөхгүй гэж үздэг. Гэтэл “Гэрэл ямар ч хурдтай хөдөлж болно, бүр зогс ч болно. Харин туршилтаар түүний хурдны дундаж илэрдэг”³² хэмээн квант электродинамикийн онолоор тайлбарладаг.

Хүний бүтээсэн зүйл бүхэнд санаалаг, материаллаг гэсэн хоёр тал бий. Санаалаг тал нь шинжлэх ухаанд түшиглэнэ. Шинжлэх ухаан нь сэтгэлгээнд түшиглэнэ. Сэтгэлгээ нь төсөөлөл, загварчлалд тулгуурлана. Загварчлал нь “дэлхийг бөмбөрцгөөр солих” тэргүүтнээс эхлээд геометрийн дүрс, математик томъёо, тэгшитгэл, матриц, тензор хүртэл янз янзаар илэрнэ. Загвар ойлгож мэдэхгүй хүн номын мөрийг баттай хөөхөд бэрхшээлтэй. Сурах эрдмийн мөр загваруудаас бүтнэ хэмээн баримжаалах нь зүйтэй.

Загварын сэтгэлгээ бол шинжлэх ухааны судалгааны үндсэн механизм юм. Судлаач хүн бол суралцагч мөн. Иймд загварын сэтгэлгээг суралцагч хүн өөртөө хөгжүүлэх нь чухал. Уг сэтгэлгээ өөрт байгаа эсэхийг шинжих хэрэгтэй. Энэ өгүүллийн ил болоод далд санаа нь суралцагч өөртэйгээ ажиллаж сурах технологийн эрэл юм. Иймд хаа нэгтээ байгаа догол мөр, өгүүлбэр, үгсээс “өөрийн дутууг нөхөх” ид шид олохыг хичээх нь нэн тустай байх болно.

Загварын талаарх төсөөллийг тодосгохын тулд тоо бүхэн загварын суурь болдгийг авч үзэцгээе. “Өнчин дэр”, “Ганц нүдтэй, ган биетэй”, “Гадас”, “шулуун зураас”, “Өрөөсөн оймс” гэх мэтийн цаана “ганц” гэсэн тооны суурь буйг таахад хялбар буй за. “Арга билиг”, “өдөр шөнө”, “сайн муу”, “сайхан муухай”, “зөв буруу”, “цаас”, “зөөлөн хатуу” гэх мэт нь хоёрын тооны суурьтай. “Тулгын чулуу”, “мах ч биш, өөх биш”, “өдөр ч биш, шөнө ч биш”, “гурвалжин”, “куб” зэрэг нь гурвын тооны суурьтай. “Малын шийр”, “дөрвөлжин”, “Монгол нутгийн улирал”, ширээний зарим төрлийн цаана дөрвийн тооны суурь бий гэх зэргээр баримжаалан “тав”, “зургаа” гээд үргэлжлүүлэн загварын тухай бодол санаагаа хөгжүүлэх боломжтой. Тэрчлэн бүр “хязгааргүй их тоо”-нд харгалзах загварууд ч бий. Тухайлбал, “билгийн чинад хүрэх”, “үнэмлэхүй үнэн” гэх мэт нь түүнд хамаарна.

Холимог загвар ч бий. Жишээ нь, “өдөр гурвалжин, шөнө дөрвөлжин”, хүснэгт нүднийхээ тооноос хамаараад хэдийн ч тооны суурьтай байж чадна гэх мэт. Физикт нэг бодит биеийг “материаллаг цэг”, “абсолют хатуу бие”, “оронт тор”, “цэгэн цэнэг”, “цэнэгтэй бөмбөрцөг” гэх зэрэг олон загвараар төлөөлүүлэн судалдаг. “Бодис атомуудаас бүтнэ “гэж үзэх нь байхад “Бодис дөрвөн махбодоос бүтнэ” гэсэн загварч бий гэх мэт. Загварыг зөв буруу хэмээн

³¹ Зүйр цэцэн үг


³² Ричард Фейнман, АНУ-ын онолын физикч, Нобелийн шагналт.

ялгаварлахаас өмнө түүний үүрэг, ач холбогдлыг үнэлж, дүгнэж үзэх нь зүйтэй. Бидний гаргадаг түгээмэл нэгэн алдаа бол өөрт сонирхолгүй, танил биш, ач холбогдол нь илт биш зүйлсийг шууд үгүйсгэдэг явдал гэдгийг санах нь тустай.

Загвар нь бодит зүйлийн хийсвэр төлөөлөл бөгөөд уг зүйлийг загвараар орлуулан сэтгэх, тооцоолох, харьцуулах оюуны үйлийг судлаачид хийж гүйцэтгэдэг. Энэ санаагаа жаахан тодруулахын тулд хоёр төрлийн загварыг энд товч танилцуулая.

Эхнийх нь монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг одон зурхайн таван махбод (чадамжийн хийсвэр загвар)-ын онол, эмт бодисын амт, чадал, эрдэм (чадамжийн бас нэгэн хийсвэр төлөөлөл) хэмээх чанарууд юм. Монголын уламжлалт анагаах ухаан нь байгаль ертөнцийн юмс үзэгдлийн үүсэх, хөгжих, оршин тогтнох, нөхөх зүй тогтлыг шороо, ус, гал, хий, огторгуй гэсэн 5 махбод тэдгээрийн чадамжит чанар хоорондын уялдаа холбоонд түшиглэн тайлбарласан одон зурхайн таван онолд суурилдаг. Одон зурхайн таван махбод нэг нь нөгөөгөө үүсгэх, нөхцөлдүүлэх, харилцан дайсангах зэрэг дотоод харилцаанд оршино. Уг харьцаа нь махбод тус бүрийн чанар, эрдэм, үйлдэлд үндэслэгдэнэ. Уламжлалт анагаах ухааны ойлголтоор эм (тан) гэдэг нь одон зурхайн таван чадамжит чанартай эмийн 6 амт, 8 чадал, 17 эрдмийн тодорхой хэсгийг агуулсан, өвчнийг анагаан, өвчтний биед туслах ерөндөг (тэнцвэржүүлэх үйл) юм гэх мэт.

Дараагийн танилцуулах загвар нь хүний оршихуй үйлийн “Хөдөлмөрийн хүн” хэмээх бидний боловсруулсан хийсвэр загвар юм³³. Амжилт бүрийн нууц нь өөрийн хяналтанд оршино.



Зураг 1

Өөрийн хяналтыг амьлуулагч нь өөрийн хариуцлага мөн. Хариуцлага нь сахилга бат, сахил санваартай агаар нэгэн буй. “Хөдөлмөр” нь хүний оршихуйг илэрхийлэх бөгөөд нь алив үйл (хөдөлмөр)-ийг “хариуцлага”, “ажил үүрэг”, “үр дүн”, “хяналт шинжилгээ” гэсэн дөрвөн үзүүлэлтээр зангидаж “Хөдөлмөрийн хүн” загвар (Зураг 1)-ыг бид бүтээсэн болно. “Хөдөлмөр” гэдэгт хүний бие, хэл, сэтгэлийн алив үйл бүхнийг хамруулж үзэх нь зүйтэй. Хүн үйлээрээ тодорхойлогдох учраас энэ загвар хүнийг төлөөлнө гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, “хүн бол

дээр дурдсан дөрвөн үзүүлэлт бүхий үйл” юм. “Хяналт шинжилгээ” үзүүлэлт нь бусад гурван үзүүлэлтээ хооронд нь уялдуулж зохицуулах, хүний оршихуйн нэгдмэл цул байдлыг хангах үүрэгтэй. Үзүүлэлт бүр олон үйлийг нэгтгэн ерөнхийлсөн хийсвэр шинжтэй тул оршихуйн тухайн түвшинг төлөөлж буй субъектийн онцлогоос хамаарч “олон төрөл, зүйл”-д хувирах динамик мөн чанартай. Загварын бас нэгэн онцлог нь уг хүн тухайн орон-цагт аль үзүүлэлтээрээ давамгайлан оршиж буйг харуулах чадамжтай. Загварыг илэрхийлж буй гурвалжингийн суурь талд харгалзах дэд гурвалжингуудаар тухайн мөчид хүний төвлөрлийн үзүүлэлтийг тусгаж бас болно. Хүний динамик оршихуй нь “төвлөрлийн солигдол”-оор илэрхийлэгдэх тул тэр динамик төрхийг нь зураг дээрх “эргэлдэгч жижиг гурвалжин”-гаар дүрсэлсэн болно. “Хөдөлмөрийн хүн” загварыг хүний дотод ертөнцөд (өөрөө өөртэйгээ ажиллах үйлд) мөнхүү хэрэглэж болох ба хүн өөрөө өөрийгөө хариуцах, ухааруулах, оршихуйн тэнцвэрээ олох, түүнээ тогтмол хянах

³³ Х.Дондог, “Хөдөлмөрийн хүн” загвараар нийгмийн сэтгэл зүйг шинжих нь, Орхон Их сургуулийн ЭШБ, 2019, №19, х59-77.

зуршлаа хөгжүүлэх “онолын баримжаа” болно. Соёлжиж иргэншсэн өнөөгийн хүн нь дан ганц хувь хүнийхээ шинж төрхөөр оршдоггүй (В.Руссел, 1929), харин гэр бүл, хань ижил, үр хүүхэд, уламжлал, хамт олон, байгууллага, орчин нөхцөл, нийгмийн түвшин гэх зэргээр бүхий л зүйлийн агуулгуудыг нэгэн цаг мөчид өөртөө тодорхой хувь хэмжээгээр тээж оршдог (Erich Fromm, 1994). Иймд хүн, орчин, байгууллага, түвшин гэсэн ойлголтууд хоорондын уялдаа холбоо, харилцааг “Хөдөлмөрийн хүн” гэсэн субъектүүдийн харилцаа гэж үзэж болно. Тэдгээр харилцааны нөлөөлөл, шахалт дарамт, хариу үйлдэл, дасан зохицох байдал (Erich Fromm, 2005) нь “Хөдөлмөрийн хүн”-ий төрх бас мөн. Энэ загвараар нэг хүний оршихуйг шинжлэх төдийгүй хүмүүс хоорондын харилцааг, гэр бүлийн харилцааг, бас нийгмийн давхрага, бүлэглэл хоорондын харилцааг ч үнэлэн шинжлэх боломжтой юм.

Эрдэм номын мөр хөөх нь мөн л сэтгэлгээний загварыг сонгохтой холбоотой зүйл юм. Судалгаа хийж буй хүн оршихуйн ямар хийсвэр түвшинд сэтгэж, тунгааж буйгаа эргэцүүлж байх нь тустай. “Угтаж ухсаныг ухаантай гэдэг”³⁴-ийн үлгэрээр судлаачдын сэтгэлгээ цаашид хэрхэн өөрчлөгдөж, загварын ямар төрөл зүйл гарч ирэхийг төсөөлөн бодож, тэдгээрээс урган гарах үр дүнг ч тооцоолох нь чухал. Хүнд өөрт нь үргэлж сонголт байдаг. Хүний сонголтыг тэр бүр таашгүй. Байгаа юм бүхэн түүний өөрийнх нь сонгосон зүйл юм. Иймд “Хүн өөрийн сонголтоороо оршдог” хэмээн гүн ухаантан Сёрен Кьеркегор хэлсэн ажээ.

Дээдийн номын нийтлэг ач тус нь хүн өөрийн сонгосон ямар ч зам мөрийг эрдэмжих зам мөр болгохыг зөвлөсөнд оршино. Эрдэмжих зам мөрөөсөө буцах, сэтгэл хоёрдох зэргээр тодорхойгүй, ач холбогдол нь ойлгомжгүй болсон бол таны оршихуйд доголдол үүснэ. Өөрийгөө судлах нь эрдэмжих мөрийн жанжин шугам нь мөн. Нэгэнт сурах чиглэлийг эрхэм болгон сонгосон бол сонголтоо өөрөө хүндэтгэж, суралцахад хичээх нь тун сайн хэрэг болно. “Сэтгэж байгаа бол тэр оршиж байна”³⁵ гэдгээр өөрийнхөө оршихуйг өөрийн сэтгэлгээ, сурцаар батлан харуулах нь зөв. Энэ бүхнийг санаандаа хадгалж, бодит үйл хэрэгтээ чиг болгох нь зүйтэй. “Санаанд байхгүй бол оршиж чадахгүй” хэмээн гүн ухаантан Жорж Беркли хэлснийг энд давхар тооцвол мартсан зүйл эргэж сэргэхгүй ч байх эрсдэлтэй юм. Санаанд байлгах нь түүнд төвлөрч, дахин давтаж, шинжилж, ухаарлаа лавшруулсаар байхыг хэлнэ. “Би 10,000 төрлийн цохилт мэддэг тулаанчаас айхгүй, харин нэг цохилтоо 10,000 удаа давтсан тулаанчаас айна” хэмээн Брюс Ли хэлсэн байдаг. Амжилт бэлтгэлээс хамаардаг, бэлтгэл нь давтах, тэвчих, ухаарах, зүтгэхээс хамаарна. “Хүн хэлэхээс нааш ухаарахгүй, цаас чичхээс нааш цоорохгүй” гэсэн бас нэгэн мэргэн үг бий. Харин энд нэгэн нууцыг задлахад, хүнээр биш, өөрөө өөртөө хэлж, өөрийгөө ухааруулдаг байх явдал юм. Энэ бол эрдмийн түлхүүр мөн. Гүн ухаантнууд хүнээр хэлүүлж гэгээрээгүйг санах нь зүйтэй.

Амжилт олохгүй байгаа бол өөрийгөө өөрчлөх, зуршлаа өөрчлөх нь нэн чухал. Учир нь мэдлэг хүнд шингэж ууссаар байгаад түүний зуршил болж хувирдаг жамтай ажээ. Иймд мэдлэг, зуршил хоёр өөр хоорондоо ялгарахын аргагүй зүйл болж байна. “Мэдлэг бол практикаар батлагдсан зуршил юм” хэмээн гүн ухаантан Жон Дюй хэлсэн бол “Зуршлыг өөрчлөхийн тулд шинэ зуршил буюу мэдлэгийг эзэмших хэрэгтэй” хэмээн гүн ухаантан Чарлз Сандэрс Пөрс дурджээ. Зуршил нь хүнийг “автоматаар залаад байдаг”-ийг бид мэднэ. Иймд зуршлаа эргэн харж, түүнтэй ойр дотно байх нь өөрийгөө ухаарах арга зам болж таарч байна. Залхуурах, үл

³⁴ Зүйр цэцэн үг

³⁵ Гүн ухаантан Декарт

тоомсорлох, ялгаварлан гадуурхах, ашиг хонжоо харах зэргийн муу зуршил өөрийн сурлагад хэрхэн нөлөөлж буйг тодруулах нь ач тустай.

Хүн гадаад болон дотоод ертөнцөд оршдог. Иймд сэтгэл зүйчид хүний дотоод ертөнц, оюун санааны амьдралыг судалдаг³⁶. Хүний зорилго чиглэлтэй үйл ажиллагааны үр дүн түүний сэтгэл зүйн бэлтгэлээс ихээхэн хамаарна. Хүн хүндээ туслах сэтгэлтэй заяагдсан. Араатнаас нэг нэгнээ хамгаалах гэж өдөр шөнөгүй хамтран тэмцдэг амьтан хүнээс өөр үгүй. Туслах сэтгэл идэвхжсэн үед хүний чадамж хязгааргүй ихэсдэг. Хүний чадамж хязгааргүй хэдий ч хүн ихэнхдээ түүнд итгэдэггүй, бас сэтгэл зүйн талаас өөртөө байнга хязгаарлалт тавьж, хүчээ бүрэн дайчлах зүрх зориг дутдаг. Хүн муу үйл хийхээс айдаг шигээ сайн үйлийн төлөө хэт их чармайхаас бас айдаг³⁷. Энэ нь бүр зуршил болоод хэвшчихсэн байдаг. Гэвч алдаа гаргахаас айх, бэрх хэмээн төсөөлж шантрах хэрэггүй юм. “Унаж үзээгүй хүн босохын учир мэдэхгүй”, “Эрдэм номыг гүн гэж бүү цөхөр”, “Эр хүн зовоходоо ухаан орно” зэрэг сургаалуудын гүн утгыг мэдэрч, өөртөө урам зориг өгч зүтгэх нь зөв. Бэрхшээл давж байж хүн илүү сайн хөгждөг болохыг санаж яв. Өөртөө итгэл өгч, өөрийн өчүүхэн ч гэсэн амжилтанд урамшиж, эрсдлээс үл айн, бэрхийг давах арга барилд суралцах нь амжилтыг өөр лүүгээ дуудах нигууртай.

Г. Эрдэмжих арга ухааныг нэгтгэн цэгцлэх нь.

Г1. ЭРДЭМЖИХ АРГА УХААНЫ НАЙМАН ЗАРЧИМ

Монголчуудын эрдэмжих арга ухааны өвийг дээдийн ном сургаал, ардын ур ухааны алтан сан, шинжлэх ухааны шим, гүн ухааны охиос уудлан үзэхэд, нэг тодорч, нэг бүдгэрээд, тэнгэрийн түмэн од шиг хол-ойр, төв-зах нь сайн ялгарахгүй, буман янзаар гэрэлтэж, өөрийн эрхгүй барьц алдуулах ажээ. Гэвч налайж бэлчсэн хонин сүрэг шиг бутарсан, налгар намрын тариа шиг ундарсан, их эрдэм ухааны оньсуудыг хүн төвтэй хүрдэн найман зарчимд хураан зангидав. Зарчмаас арга ухаан, шид бүтээл төрнө. Зарчим ганц бол гацаа биш, олон бол дараа биш. Анхааран авбаас олз мөн. Онолын физикт хамгийн бага үйлчлэлийн зарчмаас сонгодог механикийн бүхий л хуулиуд логикоор урган гардаг³⁸. Шудрага ёсны ганц зарчмаас л гэхэд амьдралын сайн сайхан үйлс ундардгийг хүн бүхэн мэднэ. Зарчмуудыг би бүтээсэн бус, билиг ихт мэргэдийн сангаас самар адил цөмж түүгээд, аманд ороход бэлэн болгосон юм. Иймд хүлээн автугай, хичээтүгэй, хэрэгжүүлтүгэй.

Нэгдүгээр зарчим. Өөртөө итгэл өг, өөрөөс эрдэм гарахыг мэдэр.

- Эрдмийг өөрөөсөө олж болно. Хүний чадамж хязгааргүйг сана.
- Өөрөөс ухаарал гарах нь хадгалуулсан зүйлээ буцаан авах мэт.
- Эрдмээр үл ханагч оюунтан алт эрдэнээс чухаг.
- Багшаа бишир, өөрийгөө бишир, бас номоо бишир. Эс биширвээс билиг ухаан буурах шалтгаан болно.
- Эрдэм номыг өөрт ойр агуул.

Хоёрдугаар зарчим. Эрдмийн тусыг сана, өөртөө наа.

- Ертөнцийн ухаан хүнд, хүний ухаан эрдэмд.
- Таньж мэдвэл далай, танихгүй бол балай.
- Чин эрдэмт хүн хонь чоно хоёрыг нэг онгоцноос усална.

³⁶ Сэтгэл зүйч Уильям Джеймс

³⁷ Сэтгэл зүйч Абрахам Маслоу

³⁸ Л.Д.Ландау, ОХУ-ын онолын физикч, Нобелийн шагналт.

- Номгүй хүн сохортой адил.
- Номгүй бандийн цээж харанхуй.
- Сайхан дээл өмссөн хүн сурсан эрдэмгүй бол хөрөг.
- Саруул ухаанаас өөр сайн нөхөр үгүй.

Гуравдугаар зарчим. Чухлыг санаандаа хоногшуул.

- Сайн мөрийг амьсгалах завгүй мэт бясалгаж яв.
- Санаа сохор бол нүд сохор.
- Санаанд байхгүй бол оршиж чадахгүй.
- Сайн хүний санах нь түргэн.
- Хүн хэдий ухаантай ч хэлэхээс нааш санахгүй.
- Өөрөө өөртөө сануулж яв.
- Санаа сайн бол заяа сайн.

Дөрөвдүгээр зарчим. Бүү март, давт.

- Салан баавгайн үлгэрээр нэг эрдмийг сонссод нөгөөг сонсохдоо урдахаа бүү март.
- Уулын бугыг хараад унасан бухаа хаях мэт нэг хичээл, нэг мэргэжлийг хальт үзэж орхиод нөгөө рүү бүү урва.
- 10,000 төрлийн цохилт мэддэг тулаанчаас нэг цохилтоо 10,000 удаа давтан тулаанч илүү аймшигтай.
- Мартсанаа санаж, унтсанаа сэрээж яв.

Тавдугаар зарчим. Өөрийгөө шинж, өөртөө тангараг тавь, бүү шантар.

- Өөрийгөө шинж, муу зуршлаа хая.
- Нэг мөсөн сайн шийд, өөрийгөө үүрэгжүүл, бас хариуцлагажуул.
- Өөрийн тангарагийг нүдний цөцгий мэт хамгаал.
- Эрдмийг гүн гэж бүү цөхөр.
- Хэзээ ч ханахгүй зүйлээс татгалз.
- Хэнз ногоо нарийхан ч хөрс нэвтлэх хүчтэй.
- Тэвчээр байгаа газарт эрдэм бий.

Зургаадугаар зарчим. Төвлөр, ухамсрын зургаан хүчийг эзэмш.

- Сонсохын хүч: Мэдэх гэсэн тэмүүлэл сонсохын хүчийг үүсгэнэ.
- Санааны хүч: Сонсголонтой бол эргэн дурсах санааны хүч үүснэ.
- Дурдан санахын хүч: Санааг барин сэтгэлд ойр агуулах хүч үүснэ.
- Ухамсарлах хүч: Уг санаанд сэтгэлийг төвлөрүүлнэ.
- Хичээнгүйлэх хүч: Нэгэн үзүүрт сэтгэлийг төрүүлнэ.
- Зуршил дадлын хүч: Өөрийн зөнгөөр санаанд төвлөрөх дадал үүснэ.

Долдугаар зарчим. Ухамсраа сэрүүн байлга.

- Нойрмоглох, нозоорох, залхуурах, үл тоох зэрэг гэмүүдээр бодлоо гэжж, мартаж, тодорхойгүй байдалд живэхээс сэргийл.
- Сэтгэл санаа сарних, өөр зүйл сонирхох, бодол гуйвах, уруу татагдах зэргээс сэргийл.
- Зорилгоо байнга санах, түүнээс өчүүхэн төдий хазайх байдлыг мэдэж хорих замаар ухамсраа сэрүүн байлга.

Наймдугаар зарчим. Тунг тааруул

- Идээний бага нь амттай: Сонссоноо даруйхан боловсруул.
- Бага уувал бал, их уувал мал.
- Дэлэндээ байгаа сүү гашилдаггүй: өөрийн төрхөөр бай.
- Цэцэн дэндвэл тэнэгээс дор.
- Ганц хүн арга мөхөс, хоёр хүн арга төгс.
- Мужаан арвидвал байшингийн нуруу хазгай тавигдана.
- Манаа манана гэж унтаад, манаж байна гэж унтаад, маналаа гэж унтах.
- Ухаан сайт хүн ашид өөрийн гэмийг шинжинэ.
- Олныг хэлээд цэцэн болдоггүй.
- Эрүүл биед саруул ухаан оршино.

Д. Дүгнэлт

1. Монгол Үндэстний сургаалуудын гол санаа нь “хүнээр хүн хийж, эрдэмжүүлэхэд” төвлөрч байна.
2. Эрдэм номын мөрийг сонгосон бол тэрхүү шийдвэрээ сахил санваар мэт сахих нь зөв хэмээн сургадаг байна.
3. “Өөрөө өөрийгөө сонсох нь эрдмийн түлхүүр” хэмээн нэгтгэн дүгнэж болохоор байна.
4. Үгийн утгыг тайлах нь ухааны оньсыг мултлахтай адил ажээ.
5. Мэргэдийн санд нийлүүлэхүйц сургамжтай сайн үгсийг хайх нь эрдэмжих мөрд бас хамаарна.

Ном зүй

1. B. Alan Wallace. The Attention Revolution: Unlocking the power of the focused mind. 2006.
2. B.Russel. Our Knowledge of the External World. 1929
3. Erich Fromm. The art of being. 1994.
4. Erich Fromm. The Sane Society. 2003.
5. Erich Fromm. To have or to be? The Nature of the Psych. 2005.
6. Hermann Haken: From the Laser to Synergetics. A scientific Biography of the Early Years. Springer 2015.
7. Jung, Carl G., (1985), Man and His Symbols. Paidos.
8. Levi-Strauss, Claude. 1963. Totemism. Penguin Books
9. Mandelbrot B (2002) The Fractal Geometry of Nature. Institute of Computer Science p: 6
10. N.Arthur Coulter, Jr., M.D. Human Synergetics, 1976.
11. Prigogine IR (2000) The end of certainty. Time, chaos and new laws of nature. Regular and Chaotic Dynamics p: 208.
12. Self-organization and management of social systems: insights, promises, doubts, and questions, Berlin Heidelberg New York Tokyo 1984, editors: H.Ulrich and G.J.B.Probst
13. The method, meditations, and selections from the principles of Descartes. William Blackwood & Sons. Edinburg and London. 1879.
14. A.Маслоу. Self-actualization and beyond, 1965.

15. А.Маслоу. Toward a psychology of being. 2013, 1962. Start Publishing LLC.
16. Асанга. (2005). Их хөлгөний хураангуй ба Абхидхарма бүхнээс түүсэн.
17. Б.Дарамбазар, Багшийн егүзерийн бясалгалын хөтөлбөр, УБ., 2018
18. Б.Мөнхбаатар, Буддын бясалгал ба сэтгэл судлал, 2021, УБ.
19. Б.Хүрэлтогоо. Чингис хааны алтан аялгуун нууц.
20. Билгийн зүрхэн судар (2010).
21. Винер Н. Кибернетика или управление и связь в животном и машине. М.: Сов. Радио, 1968.
22. Жадамба судар. (2014). Бугат Л.Алтангэрэлийн шинэ орчуулга.
23. Жанжаа Хутагт Ролбийдорж, Мэргэд гарахын орон. 2021.
24. Зонхова Лувсандагва, Их бодь мөрийн зэрэг, УБ., 2006.
25. Кастлер Г. Возникновение биологической организации. М. Мир, 1967.
26. Л.Түдэв Монголчууд хэзээ мөхөх вэ?, 1996. http://www.tolgoilogch.mn/_c2oybi0ltl
27. Ландау Л.Д., Лифшиц Е.М. Теоретическая физика, в десяти томах. 1988.
28. Монгол хэлний их тайлбар толь. <https://mongoltoli.mn/>
29. Монголын нууц товчоо. 1990.
30. Очироор огтлогч хэмээх их хөлгөн судар. С.Гантөмөрийн орчуулга.
31. Р.Фейнман. КЭД: Странная теория света и вещества (QED: The Strange Theory of Light and Matter), 1985.
32. С. G. Jung. Analytical Psychology: Its Theory and Practice. The Tavistock Lectures. – London a. Henley, 1968. – 224 с.
33. С.Гантөмөр. (2016). Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй: шинжлэх ухааны хэсэг, Боть 5. УБ.
34. Сорхугтан. Хөх Монголыг ний хэмээр бадраах хутагтай дөрвөн нэүрит их засгийн алтан дээд үнэний аялгуу, 2008.
35. Сорхугтан. Хөх Монголыг нүүдлийн соёлоор бадраах хутагтай их засгийн алтан дээд гэрээ, 2009.
36. Сорхугтан. Хөх Монголыг төрөөр бадраах хутагтай нэүрит засгийн алтан дээд үнэний аялгуу, 2009.
37. Сэмбээжав.Б. Ардыг тэжээхүйн алтан үрэл малын тухай нэрт шаштир. 2011.
38. Т.Булган. Буддын философийн дэвтэр, 2010
39. Тодорхой толь хэмээх сургаал. <https://uhaan.wordpress.com/>
40. Х.Дондог. (2010). Монголоо эрсэн монгол
41. Х.Дондог. Монгол дархлаа нь бидний үнэт зүйл мөн. “Монголчуудын үнэт зүйлс” ЭШ-ний хурлын илтгэл, СУИС, 2019.
42. Х.Дондог. Монголоо эрсэн монгол, 2010.
43. Х.Цоохүү. Монгол хүн Та хэн бэ? 2011.
44. Хакен Г. Синергетика. Иерархия неустойчивостей в самоорганизующихся системах и устройствах. М.: Мир, 1965.
45. Ч.Жүгдэр. XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ. 1984.
46. Шантидэва. (2009). Гэгээрлийн зам (Бодичаръяаватара).

47. Шүтэн барилдлагын магтаал сайн номлолын зүрхэн хэмээх оршивой. (2006). МБШТөв Гандантэгчэнлин хийд.

4.10. Буддын танин мэдэхүйн эрдэм ухааныг дэмжих эрх зүйн асуудал

Хураангуй

Буддын шашин Хүннүгийн үеэс түүхийн явцад гурвантаа дэлгэрч, гурвантаа бүдгэрэхдээ Монголчуудын уламжлалт соёлын арвин өв сантай сүлэлдэн нутагшсан байдаг. Гаднаа ширүүн, дотроо зөөлөн монгол хүнд шим ертөнцийг аргадах, амьтай бүхнийг хайрлан нигүүлсэх сэтгэлийн боловсрол зонхилох байр суурьтай. Дээрхийн гэгээнтэн 14-р Далай ламтан Буддын сургаалын агуулгыг шинжлэх ухаан, гүн ухаан, шашин хэмээн гурван хэсэгт хуваасан нь буй. Гүн ухаан хийгээд шашинтай нь харьцуулахад Буддын шинжлэх ухаан нь дэлхий нийтийн сонорт харьцангуй шинээр хүрч буй агуулга бөгөөд түүнийг “Буддын танин мэдэхүйн ухаанаар нээсэн шинжлэх ухаанч мэдлэг” хэмээн баримжаалан төсөөлж болно. Буддын сургаалыг анхлан судлах хэн бүхэнд зориулсан “Хутагтын орны дотоодын номлолоос гарсан шинжлэх ухаан болон үзэл онолын хураангуй” цувралууд хэвлэгдсэн нь байгаль хийгээд нийгмийн шинжлэх ухаануудтай ойлголцох, судалгааны объект, танин мэдэхүйн хандлага, үр дүнгээ харьцуулах, ололтуудаа харилцан нөхөх, тухайлбал, оршихуйн гол түлхүүр бологч сэтгэлийн боловсролыг шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлэх өргөн боломжийг нээж байна. Буддын шашны шинжлэх ухаан нь сэтгэлийн танин мэдэхүй хийгээд сэтгэлийн менежментийн ухааныг агуулдаг нь Ганжуур, Данжуураас тодорхой харагдана. Сэтгэлийн боловсролыг шинжлэх ухааны түвшинд хүртэл эзэмшүүлэх нь хүн төрөлхтнийг дайны аюул, экологийн сүйрлээс хамгаалах, байгальтай тэнцвэрээ олох магадлалыг өсгөх болно. Монголчуудын оюун ухааны уламжлалт салбарын нэг болох Буддын шинжлэх ухааныг албан боловсролын түвшинд гарган хөгжүүлэхүйц эх сурвалж, ном зохиол, эрдэмтэн мэргэд, материаллаг бааз бүрдэж байгаа нь давуу тал болж байна. Иймд Төр, Шашны харилцааны тухай, Боловсролын тухай, Тусгай зөвшөөрлийн тухай зэрэг хууль эрх зүйн орчны холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулбал төрийн дэмжлэг авах боломж нээгдэх юм.

Түлхүүр үгс: Буддын шашны шинжлэх ухаан, гүн ухаан, сэтгэлийн боловсрол, албан боловсрол

Оршил

Буддын шашны шинжлэх ухаан буюу уг сургаалийн шинжлэх ухааны ач холбогдол бүхий мэдлэгийг европын орнуудад сонирхох болсон нь 30 гаруй жил Дээрхийн гэгээнтэн 14-р Далай ламтны “Mind and Life” хэмээх нээлттэй хэлэлцүүлгийг шинжлэх ухааны нэрт судлаачид хийгээд дээдийн номын мэргэдийн дунд явуулсны үр дүн юм. Уг хэлэлцүүлгийн гол санаа нь шинжлэх ухаан, Буддын сургаал хоорондын харилцан ойлголцол, мэдлэг, мэдээллийг солилцоход оршиж байсан бөгөөд түүний үр шимээр өнөөдөр Буддын сургаалын агуулгыг шинжлэх ухаан, гүн ухаан, шашин хэмээн гурван хэсэгт хувааж үздэг болов. Энэ өгүүлэлд Буддын шинжлэх ухаан гэсэн агуулгыг сонгосон бөгөөд уг агуулга нь Хүннүгийн үеэс дэлгэрсэн Буддын шашин яагаад Монголчуудын соёлын арвин өв сантай гүн сүлэлдсний шалтгааныг тайлах түлхүүр болж байна. Үүнийг ойлгосноор уламжлалт шашныхаа утга учир, гүн ухаан, шинжлэх ухаанч мэдлэгийг өвлөн эзэмших үүд нээгдэж, түүнийг шинжлэх ухааны

түвшинд хослуулан авч явах боломж гарав. Буддын шашин, номын үйл ажиллагааг 1990 оноос сэргээж, Ганжуур, Данжуур хийгээд бусад их хөлгөн судруудад буй дээдийн номын агуулгыг гүнзгий түвшинд ойлгох, амьдралдаа хэрэгжүүлж, бусдад үлгэр жишээ үзүүлэх лхарамба, цограм, гавж зэрэг эрдмийн цол хэргэмтэй гэвшүүд олширч буй нь энэ салбарын хүний нөөцийн бэлтгэл хангагдаж буйг гэрчилнэ. “Уламжлалтай юм ургадаг” жам ёсоор зарим дацангийн уламжлалт сургалтын чанар ба түвшин жилээс жилд сайжирч, шинжлэх ухаантай харьцуулахуйц түвшинд сургалтыг зохион байгуулах болсон нь материаллаг бааз, сургалтын орчин бүрдснийг бас илэрхийлнэ. Иймд шинжлэх ухаан, буддын ухааныг хослуулан эзэмших тухай Далай ламтны эхлүүлсэн нийтлэг хандлагын дагуу Буддын шашны шинжлэх ухааны сургууль болон судалгааны хүрээлэн байгуулах, тэдгээрийг шинжлэх ухаантай хослуулах цаг болсон бөгөөд төрөөс хууль эрхзүйн орчноор дэмжүүлэх хэрэгцээ ч гарч байна.

Буддын сургаалыг судлах хэн бүхэнд зориулан хэвлэгдсэн “Хутагтын орны дотоодын номлолоос гарсан шинжлэх ухаан болон үзэл онолын хураангуй” цувралуудын хураангуйг гавж С.Гантөмөр төвд хэлнээс кирил монгол хэл рүү хөрвүүлж 2016 онд хэвлүүлэн олны хүртээл болгосон билээ. Уг хураангуйд³⁹ суурь бодит юмсын тухай ухагдахуун, мэдэгдэхүүний орон, дүрстийг үүсгэгч нарийн тоосны тухай ойлголт, цаг хугацаа, сав шим ертөнцийн үүсэл ба эвдрэл, хүний бие бүрэлдэх үйл явц ба судал хий, оронт оюуны ойлголт, сэтгэлээс бологчийн тухай дэлгэрэнгүй номлол, ухамсраар орныг таниулах арга нотлол, оюуныг хөгжүүлэх арга зэргийг багтаасан байдаг. Энэхүү товч агуулгаас үзэхэд шинжлэх ухааны танин мэдэхүйг сэтгэлийн танин мэдэхүйтэй хослуулсан томоохон интеграци бүхий салбар буй нь ойлгомжтой юм.

Энэ өгүүллээр Монголын Буддын ухааны арвин уламжлал, хүний нөөц, сургалтын материаллаг бааз, сурах бичиг, эрдэм номын арвин сан хүрэлцээтэй буй болсныг харуулахын ялдамд дээр дурдагдсан синтезийг явуулахад хууль эрхзүйн орчны дэмжлэг хэрэгтэйг үндэслэн гаргасан болно.

Монголын Буддын шашны уламжлал, хийд дацангийн сургалт, мэргэдийн эрдэм ухаан, өв соёлын сан

Монголын оюун ухааны уламжлалт салбарын нэг нь Буддын судар-гарнийн ухаан юм. Бурханы шашныг монголын их хаадууд төрийн шашин болгож, улсын багш буюу төрийн багш, хааны багшийг томилон ажиллуулж, Хүннү, Нирун, Кидан улсын үед ч, бас Өгөөдэй, Хубилай, Богд Жавзандамба хутагт нарын үед ч номын ёс ба төрийн ёсыг хослуулан авч явжээ. Ардын хувьсгалын дараагаар Бүгд Найрамдах Монгол Улсын анхдугаар үндсэн хуулийн төсөл боловсруулах явцад олон жилийн уламжлалаа баримталсан Д.Бодоо, Ж.Цэвээн, Магсар хурц нарын төсөлд Бурханы шашныг төрийн шашин болгох үзэл санаа ч тусгагдаад үгүйсгэгдсэн байв⁴⁰.

Монголчууд Бурханы шашныг Хүннү, Сяньби, Их Юан гүрнүүдээр дамжуулан авч шүтэж, оюун хийгээд соёлын арвин өв санг бүрдүүлсэн нь түүхийн эх сурвалж хийгээд археологийн олдвор, судар номын сангаар нотлогдоно. Тухайлбал, Сяньби, Жужаны үеийн 100 хадан агуйн бурхад, 1330-аад онд баригдсан 64 баганат Их сүмийн туурь, Говь-Алтай аймгийн Чингай балгас, Сарьдагийн хийдийн туурь зэрэг нь бурханы шашны хийд, дугана дацангийн соёлын өвийг харуулдаг. Эрдэм ухааныг дээдэлж ирсэн бидний өвөг дээдэс Ганжуурыг дан алт,

³⁹ “Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй”, Шинжлэх ухааны хэсэг, Боть 5, УБ, 2016.

⁴⁰ З.Лонжид, “Түүхийн тодруулга” нэвтрүүлэг, 2019.

мөнгөөр, эсвэл алт мөнгийг хослуулан бичиж туурвиснаас гадна 9 эрдэнэ, 7 эрдэнэ, 4 эрдэнээр чимэглэн бүтээж байв⁴¹. Бас Жадамба, Доржжодба, Сандуйн жүд судруудыг мөнгөөр бүтээж, Жадамба судрыг 9 эрдэнэ оруулж туурвисан ажээ. Түүнчлэн шунхан Данжуурыг залах үед түүнд зориулсан гэрэлт хөшөөг 1929 онд босгосон байна. Энэ нь мухар сүсгийн илрэл бус, харин Буддын ухааныг ойлгож, бишрэн хүндэтгэдэг гэгээнтэн хийгээд хутагт хувилгаадтай явсны гэрч, монголчуудын номын сүсэг бишрэлийн нийтлэг дүр төрх болно. Монголчууд эрдэм мэдлэгийн салбарт ном, багш, шавь хоорондын шүтэн барилдлагыг гүнзгий түвшинд харж, багш нь шавьдаа эрдэм ухаан, энэрэнгүйн ухаарлаар үлгэр жишээ үзүүлж ирсэн. Ялангуяа, нүүдлийн тархай бутархай байршилтай аж ахуйн нөхцөлд илүү тохирсон шавь сургалтын тогтолцоо нь өнөө цагт ихэд үгүйлэгдэж буй.

Буддын мэдлэг ухаан нь дотоод ухаан, урлахуй ухаан, учир шалтгааны ухаан, тэжээхүй ухаан, дуун ухаан бүхий таван их ухаан, зурхай, зохист аялгуу, илт өгүүлэхүй, эвсүүлэн найруулахуй, дуурайн бүжиг хэмээх бага арван ухааны салбараар өвлөгдөж ирсэн байдаг. Монголчууд бүр 1375 оны үед 229 муж бүхий одот тэнгэрийн зургийг гарган хэрэглэж байсан нь зурхайн ухааны өндөр хөгжлийн харуулах ажээ⁴². Монгол хүн бүрийн хэрэглэдэг цаг тооны бичгийг уламжлалт зурхайн ухаанд тулгуурлан бүтээж хэрэглэсээр ирсэн. 1990 оноос хойш шинэ оны байдлыг зурхайгаар шинжих, оны засал хийлгэх, сүсэгтнүүдэд сургалт явуулах, оршуулгын зан үйлд лам нарыг оролцуулах зэргээр манай сүм, хийдийн үйл ажиллагаа сэргэж байна. Хот, аймаг орон нутагт хийдүүдийг хуучин сууринд нь сэргээх, үйл ажиллагааг нь эхлүүлэх, лам хуврагуудыг бэлтгэх үйл явц өрнөж, шашны хүний нөөц сайжирч байна. Зарим хийд цогц хандлагыг хэрэгжүүлж, хийд-эмнэлэг-дээд сургууль-тангийн үйлдвэр зэргийг сүлжин ажиллуулж ч байна. Дээдийн ном үздэг Төвд, Энэтхэгийн нэрд гарсан хийд, дацангуудад монголын залуус суралцаж байгаа бөгөөд тэдгээрээс түрүүчийнх нь эх орондоо эргэн ирж, ажиллахын зэрэгцээ сүсэгтэн олонд ном айлдах, их дээд сургуулийн сургалтанд хамрагдах, шинжлэх ухааны цол зэрэг авах замаар хос боловсролтой болсоор байна.

Сүсэгтэн олон “нялхсыг угтахаас өтгөсийг үдэх хүртэл” бүхий л явдал үйлдээ Бурханы шашны зан үйлийг үйлдэж буй. Харамсалтай нь, социализмын үед Буддын эрдэм номын сургалт 70 гаруй жил тасарснаас эрдэм мэдлэгийг нь өвлөх, ухаарах боломж хомс байв. Зан үйл нь тасралгүй хадгалагдсан нь сайн тал ч, зарим талаар мэдлэг ухааныг өөрсдөө туйлшруулж ойлгох нь сул тал болж харагдана. Тухайлбал, хэт махчилж материалист туйл руу хазайж, хийсвэр чанарыг орхигдуулах, эсвэл хийсвэр оршихуйг хэт дөвийлгөж идеалист туйл руу хазайн, материаллаг сууриас тасрах нь бий. Гэтэл Буддын шинжлэх ухааны мэргэд хоёр туйлыг зэрэг харж тэнцвэртэй орших амгалангийн эрдэмд суралцсан буй. “Хүн чолгорох хэтрэхийг чадмуй, дунд хэвийг явж үл чадмуй” хэмээн В.Инжаннаши⁴³ онцлон тэмдэглэсэн нь үүнийг хэлсэн аж.

Буддын шашны шинжлэх ухаан нь сэтгэлийн танин мэдэхүй хийгээд сэтгэлийн менежментийн ухааныг агуулдаг болох нь Ганжуур, Данжуураас тодорхой харагдана. Уг сургаал ёсоор сэтгэлийн 84000 гэм буй бөгөөд түүнийгээ танин мэдээд, засаж залруулах ерөндөгийг хэрэглэвээс тэдгээр гэм нь 84000 эрдэм рүү урвах боломжтой хэмээн үзнэ. Түүнийг үе үеийн мэргэд нь батлан харуулсан. Сэтгэлийн гэмүүдийг гарахаас нь өмнө ухаарах, сэтгэлийн тэнцвэрийг олох бясалгалын тогтолцоо ч буй. Мөн гүн бясалгах замаар оршихуйн

⁴¹ “Судар бичгийн алтан сан”, УБ. 2013.

⁴² “Судар бичгийн алтан сан”, УБ. 2013.

⁴³ В.Инжаннаши, Хөх судар, 2009, Боть 2, х 209.

хийсвэр мөн чанарыг онох, танин барих, улмаар туйлшралаас өөрийгөө сэргийлэх арга замыг ч олж авах боломжийг номлодог⁴⁴. Ганжуур, Данжуурыг кирил монгол руу хөрвүүлж гаргасан нь орчин үеийн залуус Буддын сургаалын мөн чанарыг эх зохиолоос нь танин барих өргөн боломжийг нээсэн. Ганжуур, Данжуурын агуулгаас зарим нэг санааг жишээ болгон дурдвал, гадны нөлөөллөөр сэтгэлд буусан мэдээллийг хянаад, эргэн таних замаар ухаарлыг олох (олон сэтгэлийг мэдэж тэдгээрийг хүлж үйлдвээс хамаг шид бүтэх буюу⁴⁵), оршихуйн үйл үйлдэл бүрээс амгаланг олох дадал (нууц авшиг номломуй хэмээвээс алинаас жаргаланг олсон тэр⁴⁶), оршихуйн мөн чанар эцэстээ хийсвэр болохыг ухаарах (хоосны дотор бүгд төрөөд хоосны дотор бүгд шингэюү⁴⁷), сэтгэлийн ойлголтыг өргөтгөн ухаарах (сэтгэл нь сэтгэл бус сэтгэх бөлгөө⁴⁸), өөрийн тунгалаг сүсгийг зөвөөр туйлбартай чиглүүлж, өөрийн үйлийг түүгээр удирдуулж явбаас амжилтанд хүрэх (Өөрийн сүсэглэсэн бурханы барилдлага лугаа төгөлдөр бус, тангарагт үл оршигч хүн их шидэт үл болмуй⁴⁹) зэргээр хоёр гуравхан мөрнөөс нь хүний оршихуй хийгээд сэтгэлийн мөн чанарыг олон аргаар тайлах “оньсолсон товч”-ийг олж харна. Хэрэв шинжлэх ухааны өндөр боловсролтой энгийн иргэд анхаарлаа хүрэлцээтэй хандуулж чадвал оньсон цоожийг тайлж унших боломжтой юм. Гэвч алив сургаал номлолд өөрийн өнгө төрхтэй, дахин давтагдамгүй “хандлагын уламжлал” байдгийг нарийн тооцож, түүнд авах гээхийн ухаанаар хандах нь зүйтэй. Тухайлбал, сургаал бүхэн эхлэлийн цэг, алгасалгүйгээр дамжин замнах мөр, эцэст нь хүрэх мөрөөдөлтэй байдаг. Буддын ухаанд гүнзгий суралцахад багшийн зөвлөмжийг мөрдөн олон жилийг зарцуулах бөгөөд эрдмийн зэрэг дэвийн шатлалтай нь шинжлэх ухааны системтэй төстэй. Буддын ухааны агуулга Ганжуур, Данжуурын 330 гаруй ботиос гадна олон нэмэлт судар номд байгаа нь шинжлэх ухаантай харьцуулахуйц хэмжээнд сурах бичиг, гарын авлагын баялаг сантайг илгэнэ. Тэдгээрт Бурхан багшийн зарлигийг нарийвчлан тайлбарласан, эс бөгөөс шавийн савд нийцүүлэн тухайлсан агуулгатай ч байх. Дээдийн номын суурь баримтлалын онцлог, логикийн хуулийн стандарт бус илэрхийлэл зэрэг нь дан ганц шинжлэх ухааны боловсролтой хүнд шууд ойлгогдохгүй байх нь элбэг. Тухайлбал, “Үзэгдэл бодитой бол тусдаа биш, тусдаа биш бол бодитой ч биш”⁵⁰ гэх юм уу, эсвэл “Хоосон нь дүрс болой, дүрс нь хоосон болой”⁵¹ гэх зэргээр өнгөц харвал логикийн зөрчилтэй ч юм шиг байдаг. Иймд Буддын ухаан, шинжлэх ухааны харьцуулсан судалгаа нэн чухал. Хоёр салбарын эрдэмтэн мэргэдийн эрдмийн харилцаа, ойлголцол, хамтарсан судалгааг дэмжсэн Засгийн газрын тусгай хөтөлбөр ч хэрэгтэй юм.

Монголын уламжлалт анагаах ухааны хөгжил, үйлчилгээний цар хүрээ жилээс жилд өсөн нэмэгдэж буй. Тухайлбал, “Уламжлалт анагаах ухааны 108 боть” төсөл амжилттай хэрэгжиж, тун удахгүй олон нийтэд хэвлэгдэн хүрэх юм. Улаанбаатар болон бусад хот, аймгуудад уламжлалт анагаах ухааны эмнэлэгийн үйлчилгээ нэвтрээд байна. Польш зэрэг европын орнуудад ч хий, шар, бадгана хийгээд таван махбодын онолын мэдлэгтэй монголын уламжлалт анагаах ухааны мэргэжилтнүүд амжилттай ажиллаж, монголд стандартын шаардлага ханган үйлдвэрлэгдсэн эм танг хэрэглэх болов. Уламжлалт эмнэлэгийн судалгааны хүрээлэн,

⁴⁴ Жадамба судар, УБ, 2014

⁴⁵ Ганжуур, 2011, Боть 1, х 333.

⁴⁶ Ганжуур, 2011, Боть 1, х 36.

⁴⁷ Ганжуур, 2011, Боть 1, х604

⁴⁸ Данжуур, 2011, Б16, х 11.

⁴⁹ Данжуур, 2011, Б7, х 359.

⁵⁰ Шантидева, Гэгээлийн зам (Бодичарьяаватара), НЕПКО хэвлэлийн газар, 2009, х 144.

⁵¹ Ширнэн судар, Цогт цагийн хүрдэн төв.

төвүүд нээгдэж, судалгаа тогтмолжиж, анагаахын стандартад нийцсэн үйл ажиллагаа нь олон нийтэд танигдлаа. Уламжлалт анагаах ухааны эмч мэргэжилтнүүдийг дагнасан хийгээд европ шинжлэх ухаантай хосолсон хэлбэрээр бэлтгэдэг их сургуулиуд ч хөгжиж байна. Эмийн ургамалын судалгааны бүтээл, уламжлалт судар номуудыг кирил монгол хэлнээ хөрвүүлэн хэрэглэх болов. Гэвч уламжлалт болон европын анагаах ухааны синтезийг өөрийн инновациар хийж байгаа төр, хувийн хэвшил, хийдийн хамаарал бүхий сургуулиудад хууль, эрхзүйн холбогдолтой бэрхшээл учирч буй. Тухайлбал, уламжлалтаар дагнан мэргэшсэн эмчийг европ эмнэлэгт ажиллахыг зөвшөөрдөггүй. Энэ нь үнэн чанартаа сургалтын зөвшөөрөл хийгээд стандартын шийдэлд зохицуулалтын цоорхой байгааг илэрхийлж буй хэрэг болно.

Хоёр ухааны харилцан ойлголцол, танин мэдэхүй өргөжих нь

Буддын шашны шинжлэх ухаан ба шинжлэх ухааны харилцан ойлголцол нь дотоод, гадаад хоёр ертөнцийн тухай мэдлэгийн шүтэн барилдлагын жам ёсонд суурилна.

Буддын ухаан нь гадаад ертөнцийн хийсвэр мөн чанарт суурилан өөрийн дотоод ертөнцийг тэнцвэртэй авч явах мэдлэг, чадвар, дадал төдийгүй амьтай бүхнийг зовлон жаргалын ижил мөн чанарыг амсан мэдэрч явдаг нэгэн цул оршихуй хэмээн үзэж, бүхнийг энэрэн нигүүлсэх хандлагыг төлөвшүүлнэ. Буддын танин мэдэхүйн суурь хандлага нь гурван эрдэнэд⁵² шүтэх сүсэг, өөрийн ухаарлыг олж барих бясалгалд дулдуйдна.

Өнөөгийн хүн төрөлхтний албан боловсролын сургалт эцсийн дүндээ шинжлэх ухаан, технологи, инновацид хүрдэг бөгөөд бүх нийтээр сургадаг тул шинжлэх ухаан гэж юу болохыг боловсролтой бүхэн мэднэ. Иймд шинжлэх ухааны мэдлэг, хандлага, ололтын талаар энд ярих нь илүүц хэрэг. Зарим сул талыг нь товч дурдая. Шинжлэх ухаан өөрийн судалгааны объект хийгээд хандлагыг бодит оршихуйн зөвхөн материаллаг талаар хязгаарлаж буй нь хүний дотоод ертөнцийг танин мэдэх санаачлагад ихээхэн саад учруулах, тэр талын мэдлэгийг үгүйсгэх сул талтай. Сэтгэл судлалын ухаан байдаг ч бихевиорист хандлагаас холдож чадаагүй байна. Эрик Фромм⁵³, Карл Юнг⁵⁴ зэрэг сэтгэл судлаачид Буддын сургаалаас зарим санааг авч хэрэглэсэн нь салбартаа шинэлэг үр дүн бөгөөд дотоод ертөнцийн танин мэдэхүйн ололт Буддын ухаанд буйг баталж байгаа хэрэг юм. Гэвч уг сургаалын цөм агуулгыг сэтгэл судлалын шинжлэх ухаан руу оруулах үндсэн асуудлыг хөндөөгүй орхисон байдаг.

Буддын болон шинжлэх ухаан нь бие биеэсээ үл хамааран тус тусдаа хөгжиж ирсэн учраас судалгааны хандлага, анализ-синтез хийх байдал, ойлголт нэр томъёо, үр дүнгийн онцлог, түүнийг илэрхийлэн томъёолох хэлбэр, үр дүнг амьдрал практикт хэрэглэх алхам зэргээрээ эрс ялгаатай бөгөөд шууд харилцан ойлголцох боломж хомс юм. Иймд хоёр салбарын мэргэд өөрийгөө болон өрөөлийг гаднаас нь харж ухааран, хоёр төрлийн мэдлэг-хандлагын шүтэн барилдлага нь хийсвэр макро түвшинд системийн шинж үүсгэх хүртэл нь хичээн харах шаардлагатай байна. Ингэснээр шинжлэх ухааны танин мэдэхүй дотоод ертөнц рүү тэлэх, Буддын танин мэдэхүй шинжлэх ухааны ертөнц рүү тэлэх боломж нээгдэх бөгөөд хоёр тал ойлголцох, шүтэлцэн хөгжих явцыг амжилттай хэрэгжүүлснээр 21-р зууны “Сүпер шинжлэх ухаан”⁵⁵ -ы дүр төрх тодрох болно. Юуны өмнө Буддын шашны шинжлэх ухааны агуулга тодорхой хэмжээгээр албан боловсролын агуулга руу орох, эсрэгээрээ шинжлэх ухааны агуулга

⁵² Гурван эрдэнэ нь ном, багш, хувраг болой.

⁵³ Erich Fromm. The art of being. 1994.

⁵⁴ C.G.Jung. (1968). Analytical Psychology: Its Theory and Practice.

⁵⁵ Энэ нэр томъёог би анх хэрэглэж байгаа тул бусдын зүгээс оновчгүй санагдаж болно.

зохих багцаар Буддын сургалтын агуулга руу нэгдэх нь супер шинжлэх ухааны хөгжлийн гарцыг заагч суурь алхамууд юм. Супер шинжлэх ухааны хөгжил нь орчин үеийн шинжлэх ухаан хийгээд буддын ухааны одоогийн төлвийг өөрчилж, тэдгээрийн харилцан уялдаа, шүтэн барилдлагад тулгуурлан гарч ирэх шинэ төлөв тул шилжилтийн үед хямрал, сэгсрээ үүсэх нь синергетикийн шинжлэх ухааны⁵⁶ хууль зүй тогтлын дагуу зайлшгүй. Уг хямрал нь хөгжил дэвшлээс ухрах саатал эсвэл хазайх гажилт биш юм. Тийм ээдрээтэй төлвөөс санамсаргүй сонголт хийх замаар хөгжлийн шинэ горимд шилжихийг шугаман бус стохастик динамик, аяндаа цэгцрэх тогтолцооны мэргэжилтнүүд (Г.Хакен,2015; И.Р.Пригожин, 2000.) нээсэн буй.

Буддын шашны шинжлэх ухаан ба орчин үеийн шинжлэх ухаан хоорондын интегралчлалын эрхзүйн орчны нөхцөл

Их эзэн Богд Чингис хаан “Би дэлхий дахиныг цөм хураавч мөнхүү дэлхий дахины хүнээр эдлүүлэх болой”⁵⁷ хэмээсэн буй. Энэ зарчмыг ертөнцийн ёс, номын ёс, бичгийн ёсыг тулгын гурван чулуу мэт үзэж, тэнцвэртэй хэрэглэн тулснаар Монголчуудын төрт ёсны уламжлал тогтсон буй. Нэгэнт шинжлэх ухаанч мэдлэг, мэдээлэл Буддын шашны сургаалд байгаа болохоор түүнийг орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгтэй хослуулан авч явах эрхзүйн нөхцлийг хангах нь зүйтэй болно. “Орчин үеийн шинжлэх ухаанд нийцэх ямар нэгэн шашин байвал түүнийг Буддизм гэнэ” хэмээн А.Эйнштейн⁵⁸ хэлсэн. Хүн төрөлхтний мэдлэг, үйлчилгээ нь нийтлэг стандартад тулгуурлах соёл хэвшсэн өнөө цагт уг стандарт шаардлагыг хангасан мэдлэг, мэдээллээ хэн нэгэнтэй албан ёсоор төвөггүй хуваалцах нь зүйд нийцнэ. Түүнчлэн хийд, дацангийн сургалтанд ч орчин цагийн шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийг албан ёсоор түгээх нь мэдлэг ухааны тэнцвэрт оршихуйд нийцтэй байх юм.

Монголын Буддын ухааны мэргэд, гавж нар шинжлэх ухааны зэрэг дэв эзэмших нь нээлттэй, цаашид тийм үйл явц өрнөх төлөвтэй. Энэ нь шашны мэргэд буулт хийж буй хэрэг огтхон ч биш бөгөөд мэдлэг ухааныг тэнцвэртэй авч явахуйн чухлыг тэд шинжлэх ухааныхнаас түрүүлж ухаарч буйтай холбоотой хэрэг. Хоёр салбарын хос ухаан эзэмшихийн давуу тал их дээд сургууль, шашны сургуульд ажиллаж буй олон мэргэдийн үйл ажиллагаанаас илт харагдана. Харилцан ойлголцол зөвхөн гүн ухааны хүрээнд яригдахаас хальж, танин мэдэхүй-боловсролын хүрээгээр тэлэх болов. Өрнийн орнуудад Буддын сургаалыг эрчимтэй судлах төдийгүй сургалтанд ч оруулах болсон. Иймд “Тун удахгүй бидний орчин цагийн шинжлэх ухааны өндөр боловсрол эзэмшихээр очдог гадаадын том сургуулиудад бидний хоцрогдсон хэмээн үздэг ... Буддын сургаалыг өөдөөс чинь заах болох нь гэдэгт итгэл улам ихэссээр” хэмээн Гандантэгчилэн хийдийн Дайшчоймпэл дацангийн шунлайв, гавж С.Гантөмөр⁵⁹ тэмдэглэжээ.

“Уламжлалдаа суурилж өрсөлдөх чадвартай байдаг”⁶⁰ -ийг иш үндэс болгон бид Буддын шашны хоёр мянга гаруй жилийн соёлоо өвөлсөн төрийн бодлого, хууль эрхзүйн зохицуулалттай байх шаардлагатай юм. Хос ёсны уламжлал нь VIII Богд Жавзандамба хутагтын тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг удирдан зохион байгуулж, амжилтанд хүргэсэн бодит түүхээр батлагдсан нь саяхан. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4.2-т орсон Буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэх заалтын хүрээнд Буддын шашны шинжлэх ухааны

⁵⁶ Prigogine I.R. The end of certainty. 2000. Time, chaos and new laws of nature. Regular and Chaotic Dynamics.

⁵⁷ В.Инжаннаши, Хөх судар, 2009, Боть 2, х 236.

⁵⁸ 2019 онд Герман улсад болсон “Буддизм ба байгалийн шинжлэх ухаан” лекцийн материалаас.

⁵⁹ “Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй”, Дээдийн номонд дэвсэх үг хэсэгт, Боть 5, УБ, 2016.

⁶⁰ Porter, M.E. On Competition, Boston: Harvard Business School, 1998.

сургалтын байгууллагыг албан боловсролын тогтолцоонд шинээр оруулж өгөх нь сургаалд буй бодит мэдлэгийг ойлгон дэмжих боломжийг бүрдүүлнэ. Судар, тарнийн ухаан хийгээд шинжлэх ухааныг хослуулан мэргэшсэн судлаачдыг бэлтгэх сургалтыг төрийн дэмжлэгээр хэрэгжүүлэх, улмаар Буддын шашны суурь эрдэм ухааныг шинжлэх ухаантай хослуулан авч явах үүрэг бүхий судалгааны хүрээлэнг бас дэмжих хэрэгтэй юм. Сургалтын лицензийн системээр дамжуулан шашны сургалтын харилцааг тодорхой болгон, стандарт мөрдүүлэх нь зүйтэй. Улмаар шашин сүм хийдүүдийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгодог болгож, төр, нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх жишиг бүрдүүлэх хэрэгцээ бий.

Дүгнэлт

1. Монголын уламжлалт Буддын шашны сургаал номлолууд манай ард түмний амьдралд гүн шингэж, уламжлалт анагаах ухаан, зурхай-цаг тооны бичиг, гүн ухаан, шинжлэх ухаан, байгаль экологийн холбогдолтой өв соёлд өдөр дутам илэрч, хэрэглэгдэж байна.
2. Буддын шашны шинжлэх ухаанаар дамжин илэрч буй монголын оюун ухааны уламжлалт салбар нь албан боловсролын тогтолцоонд тусгагдан хууль эрхзүйн зохицуулалтанд орохыг шаардаж байна.
3. Уламжлалт анагаах ухаан, европ анагаах ухааны сургалтын агуулгын стандарт, үйл ажиллагааны уялдаа, мэргэжлийн батламжинд эрхзүйн зохицуулалт хэрэгтэй байна.
4. “Бурханы шашны шинжлэх ухааны сургууль, эрдэм шинжилгээ-судалгааны байгууллага”-ийг Боловсролын тухай хуулинд заагдсан боловсролын байгууллагын жагсаалтанд оруулах нь зүйтэй юм.
5. Буддын шашны шинжлэх ухааны сургалтыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олгож болох тухай заалтыг “Тусгай зөвшөөрлийн тухай” хуулинд нэмэлтээр оруулж, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны төрөлд шинээр зааж өгөх шаардлага байна.

Ном зүй


1. C.G.Jung. (1968). Analytical Psychology: Its Theory and Practice.
2. Erich Fromm. (1994). The art of being.
3. Erich Fromm. (2005). To have or to be? The Nature of the Psych.
4. Hermann Haken: From the Laser to Synergetics. A scientific Biography of the Early Years. Springer 2015.
5. Porter, M.E. On Competition, Boston: Harvard Business School, 1998.
6. Prigogine I.R. The end of certainty. Time, chaos and new laws of nature. Regular and Chaotic Dynamics, 2000.
7. Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй, Шинжлэх ухааны хэсэг, Боть 5, УБ, 2016.
8. В.Инжаннаши, Хөх судар, 2009, Боть 1,2,3.
9. Ганжуур, 2011, Боть 1, х 36.
10. Ганжуур, 2011, Боть 1, х604.
11. Ганжуур, 2011, Боть 9, х333.
12. Данжуур, 2011, Б16, х 11.
13. Данжуур, 2011, Б7, х 359.
14. Жадамба судар, УБ, 2014.

15. З.Лонжид, “Түүхийн тодруулга” нэвтрүүлэг, 2019.
 16. Судар бичгийн алтан сан, УБ. 2013.
 17. Шантидева, Гэгээрлийн зам (Бодичаръяаватара), НЕПКО хэвлэлийн газар, 2009, х144.
 18. Ширнэн (Билгийн зүрхэн) судар, Цогт цагийн хүрдэн төв.


4.11. Социологийн судалгаа

Бэлтгэсэн асуумжийн (Хавсралт 3 а,б,в,г) дагуу с Энэхүү судалгааны боловсруулсан үр дүнг диаграммаар дор харуулав.


Таны хүйс
558 responses



Таны нас
558 responses




Таны боловсрол
558 responses



Амьдарч буй хот, аймаг


558 responses



УБ	289	51.80%
Өм	37	6.60%
Хэнтий	26	4.70%
Да	25	4.50%
Хо	30	5.40%
Дорнод	19	3.40%
Орхон	15	2.70%
Гадаад оронд	12	2.20%
Өвөрхангай	11	2%
БӨ	11	2%
Ар	11	2%
Говь-Алтай	8	1.40%
Увс	8	1.40%
Завхан	8	1.40%
Булган	8	1.40%
Сүхбаатар	7	1.30%
Төв	7	1.30%
Баянхонгор	6	1.10%
Сэлэнгэ	5	0.90%
Хөвсгөл	5	0.90%
Дорноговь	4	0.70%
Дундговь	4	0.70%
Говь сүмбэр	2	0.40%

Та хийсэн сонголтуудад сэтгэл ханамжтай байдаг уу?


558 responses



- 1 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй
- 2 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, бас бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай
- 3 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй, бусдын хийсэн сонголто...
- 4 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй, гэвч бусдын хийсэн сонг...

Хүн бүр өөрийн гэсэн дотоод ертөнцтэй байдаг бөгөөд тэр ертөнцүүд нь өөр хоорондоо эрс ялгаатай байж болно. Та үүнтэй санал нэг байна уу?


558 responses



- 1 ● Санал нэг байна
- 2 ● Зарим талаар санал нийлж байна.
- 3 ● Санал нийлэхгүй.
- 4 ● Мэдэхгүй


Хүмүүс өөр өөрсдийн дотоод ертөнцийг харилцан хүлээн зөвшөөрөх боломжтой юу?

558 responses




Та бие дааж хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай байдаг уу?

558 responses




Та өөрийн сэтгэлийн шүтээнээ олсон уу?

558 responses



Та далд ухамсар (зөн совин, интуици)-ын нөлөөг хэр хэмжээнд хүлээн зөвшөөрдөг вэ?


558 responses



- 1 ● Өөрийн далд ухамсрын нөлөөг хүлээн зөвшөөрнө, бусдын далд ухамсарт итгэхгүй.
- 2 ● Өөрийн далд ухамсрын нөлөөг хүлээн зөвшөөрнө, бас бусдын далд ухамсарыг хүлээн зөвшөөрнө.
- 3 ● Өөрийн далд ухамсарт итгэхгүй, бусдын далд ухамсарт ч итгэхгүй.
- 4 ● Өөрийн далд ухамсарт итгэхгүй, харин зарим хүмүүсийн далд ухамс...

Муу зуршлыг арилгах нь хэцүү юү, хялбар уу?


558 responses



- 1 ● Өөрийн муу зуршлыг арилгахад хялбар, бусдын муу зуршлыг арилгахад хэцүү.
- 2 ● Өөрийн муу зуршлыг арилгахад хялбар, бусдын муу зуршлыг арилгахад ч хялбар.
- 3 ● Өөрийн муу зуршлыг арилгахад хэцүү, бусдын муу зуршлыг арилгахад бас...
- 4 ● Өөрийн муу зуршлыг арилгахад хэцүү, гэвч бусдын муу зуршлыг арилгахад...

Сэтгэлийг ойлгох нь хялбар уу, хэцүү юү?


558 responses



- 1 ● Өөрийн сэтгэлийг ойлгох хялбар, бусдын сэтгэлийг ойлгох хэцүү.
- 2 ● Өөрийн сэтгэлийг ойлгох хялбар, бусдын сэтгэлийг ойлгох ч хялбар.
- 3 ● Өөрийн сэтгэлийг ойлгох хэцүү, бусдын сэтгэлийг ойлгох ч хэцүү.
- 4 ● Өөрийн сэтгэлийг ойлгох хэцүү, бусдын сэтгэлийг ойлгох хялбар.

Сайныг хэлэх нь хялбар уу, хэцүү юу?


558 responses



- 1 ● Өөрийн сайныг хэлэх хялбар, бусдын сайныг хэлэх хэцүү.
- 2 ● Өөрийн сайныг хэлэх хялбар, бусдын сайныг ч хэлэх хялбар.
- 3 ● Өөрийн сайныг хэлэх хэцүү, харин бусдын сайныг хэлэх хялбар.
- 4 ● Өөрийн сайныг хэлэх хэцүү, бусдын сайныг ч хэлэх хэцүү.

Мууг нуух хялбар уу, хэцүү юу?


558 responses



- 1 ● Өөрийн мууг нуух хялбар, бусдын мууг нуух хэцүү.
- 2 ● Өөрийн мууг нуух хялбар, бусдын мууг нуух ч хялбар.
- 3 ● Өөрийн мууг нуух хэцүү, бусдын мууг ч нуух хэцүү.
- 4 ● Өөрийн мууг нуух хэцүү, харин бусдын мууг нуух хялбар.

Өөрчлөх нь хялбар уу, хэцүү юу?


558 responses



- 1 ● Өөрийгөө өөрчлөх хялбар, бусдыг өөрчлөх хэцүү.
- 2 ● Өөрийгөө өөрчлөх хялбар, бусдыг өөрчлөх ч хялбар.
- 3 ● Өөрийгөө өөрчлөх хэцүү, бусдыг өөрчлөх ч хэцүү.
- 4 ● Өөрийгөө өөрчлөх хэцүү, харин бусдыг өөрчлөх нь хялбар.


Сэтгэлийн хир, муу сэтгэл гэдэгт мунхаг, шунал, уур, тачаал, атаархал, омог бардамнал зэрэг орно. Та үүнтэй санал нийлж байна уу ?

558 responses



Та сэтгэлийн хирийг бүрэн арилгаж болно гэдэгт итгэх үү?

558 responses




Та их хэрэглээг хязгаарлаж, өөрчлөхтэй санал нийлэх үү?

558 responses



Та өөрийнхөөрөө байж чаддаг уу?


558 responses



- 1 ● Ихэнх тохиолдолд өөрийнхөөрөө байж чаддаггүй.
- 2 ● Зарим тохиолдолд өөрийнхөөрөө байдаг
- 3 ● Ихэнх тохиолдолд өөрийнхөөрөө байдаг.

Та эмоци буюу сэтгэл хөдлөлөө хянаж чаддаг уу?


558 responses



- 1 ● Ихэнх тохиолдолд би сэтгэл хөдлөлөө хянаж чаддаггүй.
- 2 ● Зарим тохиолдолд би сэтгэл хөдлөлөө хянаж чаддаг.
- 3 ● Ихэнх тохиолдолд би сэтгэл хөдлөлөө хянаж чаддаг.

Та бид байгал орчинтойгоо нэгэн гэр бүл (цул) болж оршдог тул түүнийг хайрлан хамгаалах талаар юу бодож хийдэг вэ?


558 responses



- 1 ● Байгал орчныхоо нэг хэсэг гэдгээ би зөвшөөрнө, харин байгал хамгаалагч нь би биш.
- 2 ● Байгал орчныхоо нэг хэсэг гэдгээ би зөвшөөрнө, яаж хамгаалахаа ч мэднэ, бас хийнэ.
- 3 ● Байгал орчныхоо нэг хэсэг гэдгийг би сайн зөвшөөрөхгүй, байгал хамгаал...
- 4 ● Байгал орчныхоо нэг хэсэг гэдгийг би сайн зөвшөөрөхгүй, гэвч би байгала...

Та өөрийгөө олсон, өөртөө эзэн болж чаддаг хүн мөн үү?


558 responses



- 1 ● Үгүй, би өөрийгөө олсон гэж хэлж чадахгүй.
- 2 ● Би өөрийгөө олсон гэж боддог.
- 3 ● Мэдэхгүй.

Та уламжлал, шинэчлэлийн талаар ямар байр суурьтай байдаг вэ?


558 responses



- 1 ● Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлийг орхиж, орчин үеийн суурьшмал соёл иргэншилтэй байх...
- 2 ● Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлээ орчин үеийн суурьшмал соёл иргэншилтэй хослуулан авч яв...
- 3 ● Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлийг хоцрогдсон хэмээн үзэж...
- 4 ● Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлээ л түшиж амьдрах нь зүйт...

Та өөрийн болон өрөөлийн үйл, үйлдлийг хянадаг уу?


558 responses



- 1 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаг, бусдын үйл, үйлдлийг хянадаггүй.
- 2 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаг, бусдын үйл, үйлдлийг ч бас хянадаг.
- 3 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаггүй, бусдын үйл, үйлдлийг ч хянадаггүй.
- 4 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаггүй, харин бусдын үйл, үйлдлийг хянадаг.

Та бид нийгмийн орчны бүтээгдэхүүн тул түүний хөгжилд хувь нэмэр оруулах талаар юу бодож хийдэг вэ?


558 responses



- 1 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрнө, гэвч нийгмийн орныг би сайжруулж чадахгүй.
- 2 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрнө, нийгмийн орныг сайжруулахад би хувь нэмэр оруулна.
- 3 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрөхгүй, нийгмийн орныг ч би...
- 4 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрөхгүй, гэвч нийгмийн орныг...

Та хариуцлагатай хүн мөн үү?


558 responses



- 1 Өөртөө хариуцлагатай, бусдыг хариуцлагатай байхыг шаардахгүй.
- 2 Өөртөө хариуцлагатай, бусдыг ч хариуцлагатай байхыг шаардана.
- 3 Өөртөө хариуцлага багатай, бусдыг ч хариуцлагатай байхыг шаардахгүй.
- 4 Өөртөө хариуцлага багатай, харин бусдыг хариуцлагатай байхыг шаардана.

Та бид нэг улс үндэстэн тул нийтлэг эрх ашгийнхаа талаар юу бодож, хийх ёстой вэ?


558 responses



- 1 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрнө, харин нийтлэг эрх ашиг надад хамаагүй.
- 2 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрнө, нийтлэг эрх ашиг надад бас хамаатай.
- 3 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрөхгүй, нийтлэг эрх ашиг гэд...
- 4 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрөхгүй, гэвч нийтлэг эрх аши...

Та бусдын хувьд хэр чухал хүн бэ?


558 responses



- 1 ● Өөрийгөө бусдаас илүү эрхэмлэж явах нь зөв.
- 2 ● Өөрийгөө бусадтай адилд үзэж явах нь зөв.
- 3 ● Өөрийгөө бусдаас доорд барьж явах нь зөв.

"Буддын ухаан ба Шинжлэх ухаан: шүтэн барилдлагын шинжилгээ" сэдэвт суурь судалгааны төслийн удирдагч судлаач доктор, дэд профессо...алагдах "Талархалын үгс"-ийг сонгож авна уу.

558 responses



- 1 ● Танд эрүүл энх, аз жаргал хүсэн ерөөе.
- 2 ● Танд найрсаг хамт олон, ажлын амжилт хүсэн ерөөе.
- 3 ● Танд гэр бүлийн халуун уур амьсгал хүсэн ерөөе.
- 4 ● Таны юу санасан есөн хүсэл биелэх...
- 5 ● Таны үр хүүхэд, ач зээ нарт сайн са...
- 6 ● Таны ахмад буурлууд урт насалж, у...
- 7 ● Бидний Монголчууд үүрд мандан ба...

Социологийн судалгааны тоо баримтад тулгуурлан монгол хүний хандлагын дүр төрхийг тодорхойлсон нь

Судалгааны зорилго

Шинжлэх ухааны тогтсон үзэл баримтлалаар хүний авир ааш субъектив шинжтэй гэх. Гэвч хүний дотоод ертөнц болох сэтгэлийг нягтлан шинжвээс түүнд субъектив шинжээр халхавчлуулсан объектив шинж байхыг илрүүлж болно. “Сэтгэл аль буй хэмээвээс, цогц, язгуур, төрөн түгэхүйн авъяасаар огоот халдсан хамаг хөрөнгөч бүхний шүтээн тийн мэдэхүй болой. Тийн боловсролын тийн мэдэхүй ба авахуй тийн мэдэхүй ч мөн бөгөөд тэдгээрийн авъяас хураасны тул болой” (Асанга, 2005). Ийнхүү сэтгэлийг нэгэн утгатайгаар илт тодорхойлж, улмаар судалгааны объект болгон авч үзсэн байна. Сэтгэл нь хүний ухамсраар дамжсан танин мэдэхүйн суурьтай боловч, нэг талаас, хүний сөрөг санаа бодол (мунхаг, шунал, уур, омог, атаархал зэрэг), нөгөө талаас, (таван хороос ангижирсан) тэнцвэртэй эерэг санаа бодлоор илэрхийлэгддэг. Огт дуулаагүй, олж мэдээгүй, таньж дасаагүй үед хүний сэтгэл амгалан тэгш оршихуйн мөн чанартай. Харин сонсож, санаж, дасаж дадсан зүйлтэй



бол хүний сэтгэл түүндээ уягдсанаар амар амгаланг эдлэх нь ихээхэн бэрхшээлтэй болно. Тийнхүү уйман сатаарах сэтгэлийг номхотгох нь үеийн үед шийдэлгүй асуудал байсаар иржээ.

Объектив субъектив хоёрын шүтэн барилдахуй нь шинжлэх ухааны танин мэдэхүйг гүнзгийрүүлэн нарийсгаж байна. Уйраа сэтгэлийг угийн энэрэнгүй хийгээд амар амгалан чанарт нь оруулахын тулд яах хэрэгтэй вэ? гэвэл шинжлэх ухааны танин мэдэхүйг өргөтгөх хэрэгтэй юм. Танин мэдэхүйн харьцангуй буюу янагуух үнэний түвшинг абсолют буюу үнэмлэхүй үнэний түвшинтэй хослуулан сүлэлдүүлэх шаардлагатай. Ингэснээр хүний сэтгэл хоёр түвшний танин мэдэхүйтэй шүтэн барилдаж тэнцвэртэй орших боломжтой болно. Гаднаа уйраа төсөөлөгдөвч, дотроо тунчиг тэнцвэртэй сэтгэл бүхий хүмүүн олон бий. Улс үндэстэн буюу ард түмний нийтлэг шинж төрхөд ч тэнцвэртэй хийгээд тэнцвэргүй дотоод ертөнцүүд бий. Энэхүү таамаглалын хүрээнд өнөөгийн монголчуудын дотоод ертөнцийн нэг чухал үзүүлэлт болох хандлагыг тандах нь тус судалгааны зорилго байв. Субъектив ертөнцөд хөл тавьж хэмжилт хийх нь их эргэлзээтэй хэдий ч энэ өгүүллийн хүрээнд монгол хүний хандлагын төрлүүдийн тоон харьцааг тодорхой тооны үзүүлэлтүүдийн тусламжтайгаар илэрхийлж харуулсан болно.

Асуумж судалгаа Монгол хүний дотоод ертөнцийн тандалтыг 2022 оны 10-р сард бид

Амьдарч буй хот, аймаг
558 responses

УБ	289	51.80%
Өм	37	6.60%
Хэнтий	26	4.70%
Да	25	4.50%
Хо	30	5.40%
Дорнод	19	3.40%
Орхон	15	2.70%
Гадаад оронд	12	2.20%
Өвөрхангай	11	2%
БӨ	11	2%
Ар	11	2%
Говь-Алтай	8	1.40%
Увс	8	1.40%
Завхан	8	1.40%
Булган	8	1.40%
Сүхбаатар	7	1.30%
Төв	7	1.30%
Баянхонгор	6	1.10%
Сэлэнгэ	5	0.90%
Хөвсгөл	5	0.90%
Дорноговь	4	0.70%
Дундговь	4	0.70%
Говь сүмбэр	2	0.40%



социологийн асуумж судалгааны хэлбэрээр Google Form ашиглан онлайнаар орон даяар явуулсан. Энэхүү суурь судалгааны зорилго нь Монголчуудын оюун санаа, дотоод ертөнцийн дүр төрх, оршихуйн ерөнхий хандлагыг тандан судлахад оршиж байв. Асуумжийг боловсруулахдаа хувь хүний нэр хүнд, улс төр-

үзэл суртлаас хамааралгүй, улс үндэстний эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байхаар бодолцсон. Судалгаанд нийт 558 хүн оролцсоннос 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй байв. Нийт оролцогчдын 51.8% нь УБ хотоос, 48.2% нь хөдөө аймаг, орон нутгаас байв (Зураг 1). Оролцогчдын 33.5 хувь нь магистр ба түүнээс дээш боловсролтой, 45.9% нь дээд боловсролтой, 19.2% нь дунд боловсролтой байв (Зураг 2). Насны хувьд 7.5% нь 19 хүртэл настай, 25.6% нь 20-29 настай, 26.5% нь 30-39 настай, 24.4% нь 40-49 настай, 10.6% нь 50-59 настай, 5.4% нь 60-69 настай байсан (Зураг 3).


Дотоод ертөнцийн үзүүлэлтүүдийн шижилгээ

Хүний дотоод ертөнцийг мэдлэг, ойлголт, төсөөлөл, санаа бодол зэрэг хийсвэр ухамсарлаг зүйлс бүрдүүлдэг. Тэгээд бас зүүд, ургуулсан бодол, хүсэл мөрөөдөл ч түүнд багтана. Санаанд байгаа зүйлс нь хүний хэл яриа, үйл үйлдэл, бүтээлийг чиглүүлэн

тодорхойлно. Хүний бүтээсэн бүхэн түүний ухаан санаатай холбоотой. Тухайлбал, аль ч уран барилга инженерийн ухаанаар бүтээгдсэн зураг төслөөс улбаатай. Дотоод ертөнц, оршихуйн гадаад байдал хоёр нь ийнхүү нягт холбоотой болохоор дотоод ертөнцийн судалгаа ихээхэн ач холбогдолтой юм. Хүн нийгмийн амьтан учраас түүний дотоод ертөнцийн судалгаанд “би ба бусад” гэсэн өөр хоорондоо нягт холбоо бүхий хоёр суурь хэмжээсийг марталгүй авч үзэж тооцох шаардлагатай байсныг дурдах нь зүйтэй. Дотоод ертөнцийн төлвийг илэрхийлэх үзүүлэлтүүд судалгааны зорилгоос хамааран олон янз байж болох ч анх удаагийн тандалт судалгааг хийх зорилгын үүднээс дараах үзүүлэлтүүдийг судлаачийн суурь судалгааны эрх чөлөөний эрхээр сонгон авч үзсэн болно. Үүнд:


1. Сэтгэл ханамжийн дөрвөн хандлага

Хүний сэтгэл ханамжийг түүний хандлагын суурь болж чадах үзүүлэлтүүдийн нэг хэмээн таамагласан. Хүн өөрийн хийсэн болон бусдын хийсэн сонголт, бас гаргасан шийдвэрт хэр зэрэг сэтгэл ханамжтай явдаг вэ гэдэг (Зураг 4 ба 5) нь түүний хандлагын өнгө төрхийг илэрхийлэх боломжтой. Мөн түүнчлэн бусдын онцлог байдлыг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх, өөрийнхөө онцлогт итгэх, эс итгэх нь бас хандлагад нөлөөлнө. Энэ талыг өөрийн болон бусдын далд ухамсарын нөлөөг хүлээн зөвшөөрөх, эс хүлээн зөвшөөрөх байдлаар нь тандаж асуусан болно (Зураг 6).




- 1 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй
- 2 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, бас бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай
- 3 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй, бусдын хийсэн сонголто...
- 4 ● Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй, гэвч бусдын хийсэн сонг...

Зураг 4



- 1 ● Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай, бусдын хийсэн алхамуудад сэтгэл ханамжгүй
- 2 ● Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай, бусдын хийсэн алхамуудад бас сэтгэл ханамжтай
- 3 ● Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжгүй, бусдын хийсэн алхамуу...
- 4 ● Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжгүй, гэвч бусад заримын хий...

Зураг 5



- 1 ● Өөрийн далд ухамсарын нөлөөг хүлээн зөвшөөрнө, бусдын далд ухамсарт итгэхгүй.
- 2 ● Өөрийн далд ухамсарын нөлөөг хүлээн зөвшөөрнө, бас бусдын далд ухамсарыг хүлээн зөвшөөрнө.
- 3 ● Өөрийн далд ухамсарт итгэхгүй, бусдын далд ухамсарт ч итгэхгүй.
- 4 ● Өөрийн далд ухамсарт итгэхгүй, харин зарим хүмүүсийн далд ухамс...

Зураг 6

Хүний хандлагыг гадагшаа ба дотогшоо гэх хоёр хэлбэрээр буюу бусдад болон өөртөө хандах байдлаар нь илэрхийлж авч үзсэн нь энэ судалгааны онцлог байсан бөгөөд өөрийн

Дөрвөн хандлага	өөрийнхөд ханамжтай	өөрийнхөд ханамжгүй
бусдынхад ханамжтай	хоёуланд таатай = 73.9	өөртөө таагүй, бусдад таатай = 4.1
бусдынхад ханамжгүй	өөртөө таатай, бусдад таагүй = 18.2	хоёуланд таатай = 3.9


хийгээд бусдын сонголтонд сэтгэл ханамжтай, эсвэл өөрийн сонголтонд сэтгэл ханамжтай харин бусдынхад үгүй, мөн өөрийн сонголтонд сэтгэл

ханамжгүй боловч бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, эсвэл хоёуланд нь сэтгэл

ханамжгүй гэсэн хариултын дөрвөн хувилбараас сонголт хийлгэх байдлаар оролцогчид хариулт ирүүлсэн. Сонголт, шийдэл, далд ертөнцийн нөлөө гэсэн гурван үзүүлэлтүүдийн хариултанд шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэх байдлаар хандлагын дөрвөн хэлбэрийг гаргаж, тэдгээрийн хувь буюу харьцааг дараах байдлаар гаргасан болно (Хүснэгт 1). Ийнхүү өөртөө болон өрөөлд таатай хандах байдал 73.9%, өөртөө болон өрөөлт таагүй хандлага 3.9%, өөртөө таатай, өрөөлд таагүй хандлага 18.2%, өөртөө таагүй, бусдад таатай хандах байдал 4.1% байна. Хоёуланд таатай хандах хувь өндөр байгаа нь монгол хүний хандлага тэнцвэртэй байгааг харуулна.


2. Шударга байдлын дөрвөн хандлага

үйл
алдаа



- 1 ● Өөрийн сайныг хэлэх хялбар, бусдын сайныг хэлэх хэцүү.
- 2 ● Өөрийн сайныг хэлэх хялбар, бусдын сайныг ч хэлэх хялбар.
- 3 ● Өөрийн сайныг хэлэх хэцүү, харин бусдын сайныг хэлэх хялбар.
- 4 ● Өөрийн сайныг хэлэх хэцүү, бусдын сайныг ч хэлэх хэцүү.


Хүний
үйлдэл




- 1 ● Өөрийн мууг нуух хялбар, бусдын мууг нуух хэцүү.
- 2 ● Өөрийн мууг нуух хялбар, бусдын мууг нуух ч хялбар.
- 3 ● Өөрийн мууг нуух хэцүү, бусдын мууг ч нуух хэцүү.
- 4 ● Өөрийн мууг нуух хэцүү, харин бусдын мууг нуух хялбар.

оноогоор дүүрэн байх бөгөөд тэр нь хүнийг сайн муу хэмээн үнэлж хэлэхэд хүргэдэг. Гэхдээ хүний болон өөрийн сайныг хэлэх, эсвэл өөрийн муу хийгээд бусдын мууг хэлэх нь хүний хандлагыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг болно.

Иймд сайныг хэлэх нь хялбар уу, хэцүү юу? (Зураг 7), мөн мууг нуух хялбар уу, хэцүү юу? (Зураг 8) гэсэн асуултуудыг судалгаанд оролцогчдод өгч, хариултуудыг өөрт болон өрөөлд хялбар эсвэл хэцүү гэсэн дөрвөн хувилбаруудаас сонгуулсан.



- 1 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаг, бусдын үйл, үйлдлийг хянадаггүй.
- 2 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаг, бусдын үйл, үйлдлийг ч бас хянадаг.
- 3 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаггүй, бусдын үйл, үйлдлийг ч хянадаггүй.
- 4 ● Өөрийн үйл, үйлдлийг хянадаггүй, харин бусдын үйл, үйлдлийг хянадаг.



- 1 ● Өөртөө хариуцлагатай, бусдыг хариуцлагатай байхыг шаардахгүй.
- 2 ● Өөртөө хариуцлагатай, бусдыг ч хариуцлагатай байхыг шаардана.
- 3 ● Өөртөө хариуцлага багатай, бусдыг ч хариуцлагатай байхыг шаардахгүй.
- 4 ● Өөртөө хариуцлага багатай, харин бусдыг хариуцлагатай байхыг шаардана.

Сайн хийгээд мууг хэлэх нь хялбар эсвэл хэцүү гэсэн хариултуудад шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэх байдлаар шудрага байдлын дөрвөн хандлагыг гаргаж ирсэн (Хүснэгт 2). Ингэхэд

өөртөө болон бусдад шудрага байх хандлага 48.2%, хоёуланд шудрага бус хандлага 8.4%, харин өөртөө шудрага, бусдад шудрага бус хандах байдал 10.6%, харин өөртөө шудрага бус, бусдад шудрага хандах нь 32.9% байна. Монгол хүний шудрага байдал ерөнхийдөө тэнцвэртэй байгаа боловч өөртөө хатуухан ханддаг гэсэн онцлог бас харагдаж байна.

Хүснэгт 2

3. Хариуцлагын дөрвөн хандлага


Хариуцлага бол хүний оршихуйд нэн чухал нөлөөтэй. Иймд хүн өөртөө ч, өрөөлд ч шаардлага тавьдаг.

Дөрвөн хандлага	өөртөө шудрага	өөртөө шудрага бус
бусдад шудрага	хоёуланд шудрага = 48.2	бусдад шудрага, өөртөө шудрага бус = 32.9
бусдад шудрага бус	бусдад шудрага бус, өөртөө шудрага = 10.6	хоёуланд шудрага бус = 8.4

Бид судалгаандаа Та хариуцлагатай хүн мөн үү?, өөртөө болон өрөөлд хариуцлагатай байхыг шаарддаг уу, үгүй юу? (Зураг 9),

мөн түүнчлэн өөрийн болон өрөөлийн үйл үйлдлийг хэрхэн хянадаг вэ? (Зураг 10) гэсэн хоёр үзүүлэлтийг сонгож авсан. Ингэхдээ хариултыг дөрвөн хувилбараар өгч сонгуулсан юм. Үр дүнг боловсруулах явцдаа хариуцлагыг дөрөв ангилсан (Хүснэгт 3). Хариуцлагыг өөрөөсөө ч, өрөөлөөс ч шаардах хандлага 64.7%, харин хариуцлагыг өөрөөс болон өрөөлөөс шаардахгүй байх хандлага 3.9%, өөртөө шаардлага тавихгүй атлаа бусдаас шаардах хандлага 2.4%, өөртөө хатуу шаардлага тавьж, бусдаас шаардахгүй байх хандлага 29.1% байна.

Ийнхүү монгол хүн өөртөө шаардлага илүү тавьж, тэрхүү шаардлагаа өндөржүүлж байж хүн өөрийгөө сайжруулна гэсэн ойлголт байж болох юм.



4. Өөрчлөлттэй холбоотой хандлага

Өөрчлөх хандлага	өөрийнх хялбар	өөрийнх хэцүү
бусдын хялбар	өөрчлөгч = 6.4	захирагч = 1.9
бусдын хэцүү	зохицогч = 44	ухаарагч = 47.8

эсвэл өөрчлөлт хийх нь тийм ч амар хялбар зүйл биш юм. Иймд бид судалгаандаа Өөрчлөх нь хялбар уу, хэцүү юу? (Зураг 11), Муу зуршлыг арилгах нь хэцүү юу, хялбар уу? (Зураг 12), Та их хэрэглээг хязгаарлаж, өөрчлөхтэй санал нийлэх үү? (Зураг 13) гэх байдлаар асууж, хариултуудын дөрвөн хувилбаруудаас сонгуулах байдлаар хариулт авсан.

	Өөрчлөлтийг эсэргүүцэгч	Шинэ нөхцөлд дасан зохицогч	Урьдчилсан мэдээг ашиглан зохицогч	Урьдчилан судлаад асуудлыг шийдвэрлэгч
Эзлэх хувь	6.3%	59.5%	13.3%	21%

Өөрчлөлт шинэчлэл нь хүний ажил амьдралын нэг салшгүй хэсэг бөгөөд өөрчлөлт нь хүний дотоод ертөнц, тухайлбал, зуршилтай нь салшгүй холбоотой. Өөрчлөлтийг хүлээн авах

Хүн хүний хувьд өөрчлөлтийн тухай ойлголт төсөөлөл өөр өөр


боловч нийтлэг хандлагыг нь дүгнэн авч авч үзэхэд дөрөв ангилж болохоор байна (Хүснэгт 4). Үүнд: 1. Өөрийгөө болон бусдыг өөрчлөх нь хялбар гэж үзсэн – 6.4% (Үүнийг “өөрчлөгчид” гэж нэрлэсэн). 2. Өөрчлөлтийг хийх нь хэн хэндээ хэцүү гэж үзсэн – 47.8% (Бид “ухаарагчид” гэж нэрлэсэн). 3. Өөртэй холбоотой өөрчлөлтийг хийх нь хялбар, харин бусадтай холбоотой өөрчлөлт хэцүү гэж үзсэн – 44%. (Үүнийг “зохицогчид” гэж нэрлэсэн). 4. Өөрийн өөрчлөлт хэцүү, хүний хийх өөрчлөлт хялбар гэж үзсэн – 1.9% (Үүнийг бид “захирагчид” гэж нэрлэсэн). Монголчууд өөрчлөлт хийх нь бэрхшээлтэй зүйл гэдгийг сайн ойлгодог бөгөөд, ялангуяа хүнийг өөрчлөх нь төвөгтэй асуудал гэдгийг мэддэг байна. Харин өөрийн хэрэглээгээ хязгаарлах эсэх талаар асуусан асуултын хариултыг (Зураг 13) гадаад нөхцөл байдлын шахалтанд хэрхэн хариу үйлдэл үзүүлж болох талаас нь харьцуулан шинжилж үзээд мөн дөрвөн төрөлд ангилж үзэх боломжтой байна (Хүснэгт 5).

5. Уламжлал шинэчлэлд хандах байдал

Уламжлал шинэчлэлийн асуудал өнөөгийн даяаршлын үеийн монголчуудын тулгамдсан асуудлуудын нэг мөн билээ. Дэлхийн суурьшмал соёл иргэншил буюу орчин үеийн соёл иргэншил (ОҮСИ)-ийн түрлэг, нийгмийн өөрчлөн байгуулалт, уул уурхайн салбарын хөгжил гурав нь монголын уламжлалт мал аж ахуйн соёл иргэншил (УМААСИ)-тэй айлсаж ирлээ. Ингэснээр монголчуудын цаашдын хөгжлийн бодлого, асуудлын шийдэл нарийн төвөгтэй болж байна. Үүнтэй уялдуулан УМААСИ, ОҮСИ хоёрыг хэрхэн уялдуулах талаар судалгаанд оролцогчдын саналыг авсан (Хүснэгт 6). Уламжлалт соёл иргэншлээ орчин үеийнхтэй хослуулан авч явах саналтай 85.1%, УМААСИ нь хоцрогдсон тул орхих саналтай 10.6%, харин эсрэгээр УМААСИ нь манай газар нутагт тохирох цорын ганц хэлбэр гэсэн саналтай 4.3% байна.

6. Нийтлэг орчин нөхцлийн талаарх хандлага


Байгаль орчиноо хайрлан хамгаалах, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, улс үндэстний сайн сайхан байдлыг хангах зэрэг ард түмний хувьд нэн чухал нийтлэг асуудалд хандах байдлыг оролцогчдоос тандаж асуусан (Зураг 14, 15, 16). Ингэхдээ нийтлэг асуудлыг ойлгож хүлээн авах байдал болон түүнийг шийдэхэд өөрийн хувь нэмрийг оруулах хүсэл зоригийг бас давхар судалсан.



- 1 Байгал орчныоо нэг хэсэг гэдгээ би зөвшөөрнө, харин байгал хамгаалагч нь би биш.
- 2 Байгал орчныоо нэг хэсэг гэдгээ би зөвшөөрнө, яаж хамгаалахаа ч мэднэ, бас хийнэ.
- 3 Байгал орчныоо нэг хэсэг гэдгийг би сайн зөвшөөрөхгүй, байгал хамгаал...
- 4 Байгал орчныоо нэг хэсэг гэдгийг би сайн зөвшөөрөхгүй, гэвч би байгала...


Зураг 14

Нийтлэг орчины хандлага	орчны нэг хэсэг нь би мөн	орчин нөхцөл хэсэг нь би биш
хамгаалагч нь би биш	Үүргээ умартагч = 8.5%	Өөрийгөө тусгаарлагч = 1.2%
би хамгаална	Нийтэч өөриймсөг = 87.1%	Хамгаалагч = 3.3%



- 1 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрнө, гэвч нийгмийн орныг би сайжруулж чадахгүй.
- 2 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрнө, нийгмийн орныг сайжруулахад би хувь нэмэр оруулна.
- 3 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрөхгүй, нийгмийн орныг ч би...
- 4 Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрөхгүй, гэвч нийгмийн орныг...

Зураг 15



- 1 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрнө, харин нийтлэг эрх ашиг надад хамаагүй.
- 2 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрнө, нийтлэг эрх ашиг надад бас хамаатай.
- 3 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрөхгүй, нийтлэг эрх ашиг гэд...
- 4 Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрөхгүй, гэвч нийтлэг эрх аши...

Зураг 16

Судалгаанаас үзэхэд өөрийгөө байгал, нийгэм, үндэстнийхээ нэг хэсэг мөн эсэхийг хүлээн

зөвшөөрөх ба эс зөвшөөрөхөөс гадна тэдгээртэй холбоотой үйл ажиллагаанд хамрагдаж өөрийн хувь нэмрийг оруулах эсэх зэрэг нь тодорхой байна (Хүснэгт 7). Нийтлэг орчны нэг хэсэг нь би мөн хэмээн хүлээн зөвшөөрч, түүний сайн сайхны төлөө оролцоотой байх нь

87.1% (үүнийг бид “нийтэч, өөриймсөг гэсэн), харин оролцохгүй гэсэн нь 8.5% (“үүргээ умартагч” гэсэн), нийтлэг орчин

	УМААСИ-ээ ОҮСИ-тэй хослуулах	УМААСИ хоцрогдсон тул түүнийг орхих	УМААСИ л манайд тохирох тул түшиж орших
Хувь	85.1	10.6	4.3

нөхцлийг өөртөө хамаагүй тул оролцохгүй (“өөрийгөө тусгаарлагч”) гэсэн нь 1.2%, харин надад хамаагүй ч оролцож болно гэсэн (“хамгаалагч”) нь 3.3% байна.

Дүгнэлт

1. Монгол хүний сонголт хийх, шийдвэр гаргах, өөрийн болон бусдынхаа далд ухамсрыг хүлээн зөвшөөрөх эсэх гэсэн гурван шалгуур үзүүлэлтэд тулгуурлан тооцоолсон таатай ба таагүй хандлагын дөрвөн төрөл хоорондын харьцаа нь тэнцвэртэй байдлыг илтгэж байна.

2. Шудрага байдлын дөрвөн хандлага хоорондын харьцаа ерөнхийдөө тэнцвэртэй байгаа бөгөөд монгол хүн өөрийн сайныг дарж, мууг илчилж, өөрийгөө “ташуурдах зуршилтай” байж мэдэх нь судалгаанаас харагдаж байна.

3. Хариуцлагын дөрвөн хандлага хоорондын харьцаа мөн тэнцвэртэй байгаа бөгөөд монгол хүн өөртөө хатуу шаардлага тавьдаг нь харагдаж байв.

4. Монголчууд өөрчлөлтөнд дасан зохицох чадвар сайтай төдийгүй өөрчлөлтийг урьдчилан мэдэж, түүнд өөрийгөө бэлдэх хандлага ихээхэн хувьтай байдаг нь харагдав.

5. Уламжлал шинэчлэлд хандах байдлыг тандаж үзэхэд уламжлалт соёл иргэншлээ орчин үеийн суурьшмал соёл иргэншилтэй хослуулан авч сонирхол илт давуу байна.

6. Байгал, нийгэм, улс үндэстэн гэсэн гурван нийтлэг ашиг сонирхлын хүрээнд хандах байдлыг судалж үзэхэд монголчууд нийтлэг эрх ашгаа илэрхий мэддэг, бас түүнийхээ төлөө зүтгэж өөрийн хувь нэмрийг оруулах хандалаг илт давамгайлж байна.

Ном зүй

1. Асанга. Абхидхарма бүхнээс түүсэн. Улаанбаатар. 2005.

4.12. Дөрвөн хэлний дүйцүүлсэн толь бичиг

Буддын ухааны танин мэдэхүйн ойлголт, нэр томъёо, хэллэгийн монгол, түвд, орос, англи дөрвөн хэлний дүйцүүлсэн толь бичгийн товч тайлбар

Төслийн хүрээнд Буддын ухааны нэр томъёо, үг, хэллэгийн төвд, монгол, орос, англи дөрвөн хэлний толь бичгийн эхийг боловсруулах болсон шалтгаан нь их энгийн юм. Буддын шашны аль ч судар, шаштирыг монгол хэлээр барьж аваад уншиж эхлэхэд “үг нь монгол ч утга нь үл баригдах” үзэгдэлтэй тулгардаг. Ийм маягийн үл ойлголцол нь нилээд хэдэн шалтгаантай. Юуны өмнө шашны суурь боловсролгүйнх буюу судар шаштирыг уншихдаа лам багшаар хөтлүүлэх ёстой. Хоёрдугаарт төвд, санскрит зэрэг хэлнээс хийсэн орчуулгын онцлогтой холбоотой. Тухайлбал, судрыг орчуулахдаа сургаалыг эх хэлний бүтэцтэй хамт ямар өөрчлөлтгүйгээр буулгах ёстой (энэ тухай орчуулагч Бугат Л.Алтангэрэл хурлын эмхэтгэл өгүүлэл оруулсан байгаа). Гуравдугаарт, номын төвд уншлага, хэллэг нь “ихээхэн хураангуйлагдсан” байдаг нь шууд ойлгомжтой монгол уншлага болгоход төвөгтэй. Дөрөвдүгээрт, уншигч “миний төөрөгдөл” нь утгыг ойлгоход ихээхэн саад болдог. Учир нь буддын сургаал нь танин мэдэхүйн салбар бөгөөд өөрийн гэсэн нэр томъёо, үг хэллэгтэй байдаг тул түүнийг нь эхлээд сайтар мэдэх хэрэгтэй юм билээ. Иймээс би нэр томъёо, үг, хэллэгийн толь хийх нь цаашид бусад уншигч, судлаачдад тус болно хэмээн сэтгэсэн болно. Толийг хийх явцад бас нэг санаа төрсөн нь зарим тодорхойлолтуудыг нэмж оруулах байсан юм. Мөн түүнчлэн толинд орсон үг, хэллэг, тодорхойлолтуудыг утгын холбоосоор нь “тодруулж өгөх” нь мөн тустай байж болохыг мэдсэн тул толийг эцэслэн зангидахдаа Сумадираднагийн толийн

2018 оны хэвлэлийн “кодын систем”-ийг ашиглах нь зүйтний хэмээн үзсэн байгаа. Мөн толийг дөрвөн хэлээр хийсэн нь тэдгээрийн аль нэгийг мэддэг залуу хүн Буддын сургаалын танин мэдэхүйг сонирхвол шууд тус болно гэж үзсэнтэй холбоотой. Толинд оруулсан нэр томъёо, үг хэллэг нь өөрийн гэсэн өвөрмөц дүр төрхтэй байсан тул хэлний мэргэжлийн хүнтэй хамтран үгийн сан-утга зүйн шинжилгээ хийсэн⁶¹. Үгийн сан-утга зүйн шинжилгээ нь юуны өмнө үгс, тэдгээрийн хам сэдэвт эзлэх ач холбогдлын эрэмбийг эн тэргүүнд харгалзан үзэж, цаашилбал, үгийн утга, утгын орны хүрээ, огтлолцол зэргийг мөн хамаардаг (Д.Н.Шмелев, 1977; Лексико-семантический анализ) бөгөөд тухайн салбарын цөм үгсийн санг тодруулж өгөх ач тустай. Дөрвөн хэлний орчуулгыг харьцуулж үзэхдээ нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, дайвар үг, үйлт нэр, холбоо үг, хоршоо үг, хэлц үг, зүйрлэл, адилтгал, үгүйсгэл, үйл үг, үйлт нэр орсон нийлмэл үг, өгүүлбэр, зээлсэн үг агуулсан нэр томъёо, ерөнхий ойлголт хэмээн 15 ангилж, ангилал тус бүрд орчуулгын онцлогийг харьцуулж шинжилсэн. Үүний үр дүнд нэг үгийг, эсвэл хэллэгийг дөрвөн өөр хэлээр илэрхийлэхэд түүгээр илэрхийлэгдэх утгынх нь орон давхцах, огтлолцох, явцуурах эсвэл өргөсөх үзэгдэл ажиглагдсан. Мөн орос, монгол, англи хэлний үг хэллэг, ойлголт ухагдахууны орчуулгад утга бүрэн дүйцсэн болон үгчлэн орчуулсан тохиолдол ховор байсан бол, утгын айн хэсэгчилсэн давхцал, олон салаа болон шилжсэн утгатай үгс түгээмэл тохиолдсоны улмаас тухайн хэлнээ дүйцэх үгсийг тогтоож, оноолт хийсэн нь элбэг тохиолдож байсан. Бас нэр үг (адилтгал, үгүйсгэл, зүйрлэл), үйлт нэр, тэмдэг нэр, тооны нэр, холбоо үгнээс бүтсэн НЭР давамгайлсан нь нэр томъёо, ухагдахууныг голчлон түүсэнтэй холбоотой байсан.

Толинд судар шаштируудад агуулагдсан танин мэдэхүйн ойлголт, ухагдахуун, категори, тайлбарт шууд хамаарах үг, хэллэг, зарим нэр томъёо, тодорхойлолт зэргийг оруулсан. Толины үг, хэллэгийг түүвэрлэхдээ нэг номын монгол, түвд, орос, англи орчуулгуудыг зэрэгцүүлэн үзэж, утга дүйцүүлэн сонгосон. Ингэхдээ тухайн нэр томъёо, хэллэг, тодорхойлолт зэргийг авах эсэхээ өөрийн онолын мэдлэгт тулгуурлаж шийдвэрлэсэн. Эхийг бэлтгэхэд дараах судар шаштируудыг ашигласан болно. Үүнд:

1. Абхидхармасамуччая, Краткое руководство по высокому учению (философии) Асанга, переведено и снабжено примечаниями Валполой Рахулой; Новосибирк, 2017.
2. Abhidharmasamuccaya, The compendium of the higher teaching (philosophy) / by Asanga; английская версия составлена Сарой Буан-Уэбб. Новосибирк, 2017.
3. $\text{མཛོན་པ་ཀུན་བདུས། མཛོན་པ་པོ། འཕགས་པ་ཐོགས་མེད། མེད་མེད་ཀྱིས་རིག་མཛོན་ཆེན་མོའི་ཚུམ་སྒྲིག་ཁང་།$
4. Асанга. Абхидхарма бүхнээс түүсэн. Монголын Буддын судлалын хүрээлэн, Буддизмын эх сурвалж 5. Улаанбаатар, 2005.

4.13. Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” сэдэвт ЭШ-ний хурлын эмхэтгэл

Илтгэлүүдийн товч агуулга.

Хоёр салбарын судлаачдын хамтарсан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад төслийн багийн зүгээс ихээхэн цаг, хүч зарцуулсан болно. Энэ хугацаанд хурлын сэдвийг тогтох, сэдвийн агуулгыг өөрийн судалгааны ажлаараа тодруулж өгөх судлаачдыг олох, уулзах,

⁶¹ Х.Дондог, Ю.Цэцгээ, “Абхидхарма бүхнээс түүсэн” номын орчуулгын үгийн сан-утга зүйн зарим онцлог, Орхон Их сургуулийн ЭШБ, 2022.

ойлголцох зэрэг ажлууд хийгдсэн. Хуралд оролцогчдын тоо болон илтгэлийн сэдвийн агуулга нь хоёр салбарын танин мэдэхүйн онцлогыг илэрхийлэхүйц хэмжээнд байсан нь тун сайшаалтай хэрэг болсон юм.

1. С.Гантөмөр, Х.Дондог. Буддын шинжлэх ухааны товч

Буддын сургаалын цөм нь догма биш, шинжлэн танихуй юм. Тиймээс Будда “Аяга тахимлагууд, мэргэд та бүхэн миний зарлигийг сүсгээр бус, харин алтыг хайлуулах, таслах, цувих мэт ажин шинжээд авч үйлдээрэй” гэсэн буй. Энэ өгүүлэлд Буддын ухааны судалгааны арга зүй, суурь бодит юмсын ангилал, дотоодын үзэл онол буюу философи, мэдэгдэхүүний орны ойлголтууд, оюуны мэдэгдэхүүн лүгээ холбогдох орны бусад ойлголтууд, дүрс тэргүүтэн таван төрөн түгэхүй, нүд тэргүүтэн таван эрхтэн, номын төрөн түгэхүйн дүрс, үндсэн махбодууд, төгөлдөр бус хуран үйлдэгч, уг үрийн ойлголт, сав шим ертөнц, цаг хугацааны тухай ойлголт, хүний бие бүрэлдэх явц, бие сэтгэлийн холбоо, эрхтний мэдэл ба сэтгэлийн мэдэл, сэтгэл ба сэтгэлээс бологч, сэтгэлийн бүдүүн нарийн ба үхлийн явц, орныг танин мэдэх ухамсрын чадамжийг хөгжүүлэх зэрэг сэдвүүдийг товч хураангуйгаар авч үзсэн болно.

2. Х.Дондог. Гадаад, дотоод ертөнцүүдийн танин мэдэхүйн харьцуулалт

Буддын танин мэдэхүй нь шинжлэх ухааны иж бүрэн шинжтэй болохыг шинжлэх ухааны зарим салбаруудтай харьцуулан дараах баримтуудаар нотолж байна. Үүнд:

- Өөрийн гэсэн танин мэдэхүйн арга, нотолгооны технологитой.
- Танин мэдэхүйн шат дараалсан таамаглал, онолын хийсвэрлэлийн түвшингүүдтэй.
- Танин мэдэхүйн явц, үр дүнг илэрхийлсэн өөрийн нэр томъёоны системтэй.
- Танин мэдсэн үр дүнгээ хэрэглэж амьдрал практикийн асуудал шийддэг.
- Онолын мэдлэг, технологийн мэдлэг хоёр нь нягт барилдлагатай.
- Хоёр салбарын танин мэдэхүй нь өөр хоорондоо харшлах зүйлгүй, харин ч нарийн шүтэн барилдлагатай болох нь харагдаж байна.

3. Дийтер Яагер, Ц.Бат-Итгэл, Х.Дондог. Мэдрэлийн шинжлэх ухаан болон Буддын шашин дахь “Би”, “Чөлөөт хүсэл”, “нийгэм” хэмээх ойлголтууд

Нейросайэнс болон Буддын ухаанд оюуны үйл явцын талаарх ойлголтуудад төстэй зүйл байгааг Эморийн их сургуулийн судлаачид онцлон тэмдэглэжээ. Оюуны олон үйл явцууд нэгэн зэрэг үйлдэгддэг бөгөөд тэдгээрийн дийлэнх олонхи нь шийдвэр гаргалтанд хүчтэй нөлөөлөгч далд ухамсрын үйл ажиллагаа байна. Нейросайэнс нь оюуны зэрэгцээ процессуудыг өдөөж буй нейроны механик суурь сүлжээг танин мэдэхэд анхаардаг бол Буддизм нь нэг нэгдмэл цул зүйл мэт “би” хэмээх төөрөгдлийг арилгах замаар нийтлэг сайн сайхан сэтгэл-нигүүлслийг үүсгэх зорилтыг өмнөө тавьдаг.

4. Бугат Л.Алтангэрэл, Жадамба судрын орчуулгын тухай

Жадамба судрын найман орчуулга-ын тухай, уламжлалт орчуулгын онцлог, түүний учир шалтгааныг тайлбарласан. Эртний орчуулагчид Түвд хэл дээрх эхийг нь Бурханы зарлигтай адилтгаж, Бурханы зарлигийг огтхон ч өөрчлөхгүй, яг хэвээр нь үгчлэн буулгах ёстой гэсэн зарчмыг баримталдаг байж. Түвд хэл, монгол хэл хоёр өөр учраас түвд хэлний зүйг нь баримтлан үгчилсэн орчуулга стандарт болон тогтож “судрын хэл” хэмээх этгээд сонин, зохиомол хэлийг бий болгосон ажгуу. Иймд монгол Ганжуур, Данжуурын судар, шаштирууд ойлгоход бэрхшээлтэй байдаг.

5. Д.Отгонбаатар, Г.Ариунзаяа. Хутагт нас лугаа төгөлдөр баясагч умайд орох судрын эх бичгийн судалгаа

Бие бүтэх шалтгаан-ыг хий, шар, бадган тэргүүтэйн гэм үгүй эцгийн цагаан дусал, эхийн улаан дусал болоод зуурдад тэнэгч намш бээр урьдын үйлийн эрхээр хамт нэг дор учрах утга хэмээн авч үздэг. Ураг арвидах гол шалтгаан нь хүйс, таван махбод болон амин хий тэргүүтэй хийн үйлдлээр нийт 38 долоо хоногийн турш эрхтэн тогтолцоо үүсэж хөгжих ба 7 хоног бүр үүсэх эрхтэн тогтолцоог нэршүүлэн авч судалдаг. Ингэхдээ 11, 13 болоод 27 дахь долоо хоногтойд эх бие, сэтгэлийн явдал мөрийг сайтар нягтлах хэрэгтэй хэмээн үздэг байна. Ураг 38 долоо хоног хэтэрснийг нярайлах цаг гэж авч үзэх бөгөөд нярайлж чадах, эс чадах нь хүүхдийн урьдын буян, нүглийн үйл болон эхийн өөрийн биеийн гэмтэй ихээхэн хамааралтай байна.

6. М.Очирбүд , Л.Отгонбаатар., Хамба Номун Хан Агваанхайдавын “Бурхан урлахын увидас” зохиолд хийсэн урлаачийн ёс зүйн шинжлэл

Бурхан урлаачийн ёс зүйн асуудлыг авч үзэхдээ урлаачийн бэлгэ чанарыг гадаад болон дотоод хоёрт хуваан тайлбарласан. Бурхан бүтээх нь янагуух утгын бурхан, чанагуух утгын бурхан бүтээх хоёр талтай тул гадаад, дотоод хоёр бүтээлийг тэнцүүлэх нь чухал юм. Урлал бүхний дотроос сэтгэлийн урлал дээд нь болой. Бурханы урлал нь гурав буй. Гурван урлалын эрхэмийг дурдваас: Биеийн урлалын эрхэм нь лагшин, зарлиг, тааллын шүтээн урлах гурав. Хэлний урлалын эрхэм нь номлох, туурвих, тэмцэлдэх гурав. Сэтгэлийн урлалын эрхэм нь сонсох, санах бясалгах гурав хэмээн айлдсан ажээ.

7. Р.Оюунчимэг. Буддын ухаан ба хууль эрх зүй

Хууль эрх зүй бол гадна талаас нь засаглаж, харин Буддын гүн ухаан бол хүний сэтгэлийг дотроос нь ёс зүй, нүгэл буяныг ухааруулдаг хэдий ч харилцан уялдаатай салангид авч үзэх боломжгүй арга билгийн ухаан юм. Хууль ба эрх зүйн актыг хэн нэгэн хүн санаанаасаа зохиогоод боловсруулаагүй бөгөөд хүмүүсийн амьдралын зөв хэв маяг, ёс суртахуун, уламжлалт зан үйлийг хэлбэрт оруулж бичиж баталснаар хууль эрх зүйн бичиг баримт төрдөг. Ёс суртахууны хэм хэмжээ, бусдад болоод өөртөө хорлолгүй зөв сайхан амьдрах урлаг, ухааныг Бурханы шашин сургадаг бөгөөд тэр нь хууль эрх зүйд туссан байдаг.

8. Т.Ганбаатар, Монголын уламжлалт эмийн жоронд ордог зарим эмт бодисууд

Орчин үеийн манай эрдэмтдийн судалгаагаар монголын уламжлалт эмийн жорд дунджаар ургамлын гаралтай эм 72%, амьтны гаралтай 14%, эрдсийн гаралтай эм 14 %-ийг эзэлж байна гэж тогтоожээ. Энэ өгүүлэлд зохиогч эрдсийн гаралтай эмт жоншнууд, ургамлын гаралтай Ар-үр, түүний чулуужмал, амьтны гаралтай барагшуны талаарх судалгааг тоймлон оруулжээ. Халуун оронд ургадаг Ар үрийн оронд монголын оточ, маарамбууд Ар үр төст тэмээн хөх Fructus Cynanhi sibirici нутгийн ургамал, бас 200-300 сая жилийн тэртээ манай нутагт ургаж байсан Nussoidea модны элэнц өвөг болох чулуужмал ар үрийг хэрэглэж байсан. Чулуужмал ар үр нь жинхэнэ ар үртэй микро элементийн найрлагын хувьд тун төстэй байсан нь орчин үеийн спекрийн анализаар тогтоогдсон байна.

9. Б.Дарамбазар, Богд Жавзандамба хутагтууд Монголын оюун санааны гарамгай удирдагчид болох нь

Буддын их бага 10 ухааны ай савыг хамарч, 5000 гаруй ном зохиолоос бүрдэх 330 гаруй боть Ганжуур Данжуур хэмээх аварга том танин мэдэхүй, ухааран гэгээрэхүйн мэдлэгийн сан хөмрөгийг харь хэлнээс төрөлх хэлнээ буулгасан нь Монгол үндэстний оюуны чадвар, эрдэмтэн мэргэдийн чанар чансааг харуулдаг. Цаг хугацааны хувьд Ганжуур бол Богд Жавзандамба хутагтуудаас өмнө орчуулагдсан хэдий ч Данжуурыг орчуулах үйл явц Богд Жавзандамба хутагтын анхдугаар Өндөр гэгээний үед өрнөсөн. VIII Богд Жавзандамба хутагт зарлиг буулган

1910 онд Монголын нийслэл Да хүрээнд “Хүрээ барын Ганжуур” бүтээсэн нь оюуны сан хөмрөгийг баяжуулсан онцгой үйл явдал юм. VIII Богд Жавзандамба үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолыг манлайлан удирдаж 1911 онд Манжийн эрхшээлээс Монгол улсаа чөлөөлж түүхэн гавьяа байгуулжээ.

10. Т.Баярлах. Брагри лам Дамцагдоржийн зохиол бүтээлийн тойм, төгсгөлийн үгийн тухайд

Монголын мэргэд төвд хэлээр зохиол бүтээл бичихдээ номын төгсгөлийн үгэнд өөрийн нэр алдраа санскритаар нь эсвэл төвдөөр нь, эсвэл санскрит төвдөөс нь монголоор эргүүлэн орчуулж, тэр цагийн судар номын нэр буюу нэг ёсондоо утга зохиолын нэр болгон хэрэглэж байсан уламжлалтай холбоотой. Ингэж олон янзаар бичсэнээс шалтгаалж зохиогчийн номыг салгаж, үзэхгүйн үүднээс зохиол бүрийн төгсгөлийг үгийг сайтар шинжлэх нь зүйтэй.

Нэг онцлог нь тэдгээр номын мэргэд их бичгийн хүмүүс нь өөрсдийгөө ихэд доорд барин ном бүтээлийнхээ төгсгөлийн үгт: өтөл тэнэг, адаг эгэл, зөнөг мунхаг, ядуу бядуу, хувраг тойдын хөрөгт, эл жарын дүрст, нохойд арслангийн нэрийг өгсөн мэт, хөндий хийдэм цол нэрийг зүүгч, тийм ийм хэмээн дуудуулагч буюу тэр энэ хэмээх нэрт нэгэн бээр хэмээн өөрийгөө цохон нэрлэж, аль нэгэн хүний олон дахин дуртгаж, мунхралын нойрноос сэрээсний чөлөөнд өөртөө хувь сацуу зарим нэгэнд хэрэг тус болуужин хэмээн бичив гэх буюу заримд бүр инээдмийн үг ичгүүрийн орон болохын тулд цааш хийе гэвч гайхалзан түдгэлзэн гар татаж эргүүлэн авав гэх мэтээр бичсэн байдаг нь яасан ч даруу сайхан ном бичгийн хүмүүстэй байж вэ гэж бодохоор байдаг юм.

11. Г. Насантогтох, 1990 оноос хойш, Монголын ард түмний шашин ба оюун сэтгэлгээний өөрчлөлт

1992 оны үндсэн хуульд \ Монгол улсын үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн “Хүний эрх, эрх чөлөө хэсгийн Арван зургадугаар зүйлийн 15-д “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй” хэмээн шүтэх бишрэх эрх нь чөлөөтэй болсонтой холбоотойгоор Монголчуудыг тал талаас итгэлийг олох зорилготой гадна дотны янз бүрийн шашин болон хүнийг татах арга зальтай элдэв зүйлүүд олноор хүч түрэн гарч ирсэн. Олон янзын шашны урсгалууд нь эхлээд нийгмийн давхарга бүрд чиглэлтэй тохирсон үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Олон янзын шашин, сүсэг бишрэлийг төрүүлж итгэлийг олж оюун санааг нь эзэмдэж түүгээрээ дамжуулан Монголчууд бидний нэгдмэл хүч сулрах, уламжлалт соёл устах эх орон, Монгол гэх тодотголуудын нөлөө буурах сул талтай байх магадлалтай. Иймд бурхны шашныг Монголчууд бид голлох шашнаа хэвээр нь хадгалан, хамгаалах нь зөв. Иймд бурхны шашныг Монголчууд бид голлох шашнаа хэвээр нь хадгалан, хамгаалах нь зөв.

12. Б.Ариунзул. Мэдлэгийн уг сурвалж: илт мэдэл

Тус илтгэлд шалгадаг ухааны лоригийн гол агуулга болох илт мэдлийн талаар тодруулах болно. Эрхтний илт нь зорихуй, эзлэхүй, тэр даруй гурвын зохилдонгуй нөхцөл шалтгаанаар бий болдог байна. Илт нь адхаг лугаа хагацсан, эндүүрэл үгүй мэдэл; илт шалгадаг нь адхаг лугаа хагацсан, эндүүрэл үгүйн дээр шинэ тутам, хуурмаг үгүй мэдэл юм. Буддын философид сэтгэл нь мэдрэхүй, сэтгэхүй, сэтгэл хөдлөл, мэдрэмж, оюун ухаан зэрэг маш өргөн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, сэтгэл, оюуны бүхий л үйл явцыг багтаасан ойлголт юм. Сэтгэлийн үйл, түүнийг мэдрэх мэдрэхүй хоёр нь зэрэг явагддаг байнгын үргэлжлэлт процесс гэж үзнэ. Оногдохууныг эрхтний илт мэдэл эхэлж оносны дараа удаах агшинд нь үргэлжлэн сэтгэлийн илт мэдэл үүсдэг. «Өөрийн нийт бусын эзлэхүй нөхцөл болсон сэтгэлийн эрхтэнд шүтээд гарсан, адхаг лугаа хагацсан, эндүүрэл үгүй мэдэл» нь сэтгэлийн илт мэдэл юм.

Сэтгэлийн эрхтэн нь физик биет зүйл бус мэдэл, ухааныг илэрхийлсэн ойлголт бөгөөд түүнийг сэтгэлийн мэдлийн эхний агшин гэж томъёолсон байдаг. Түүнчлэн оюун өөрөө өөрийгөө онох буюу тодорхой үзэхийг өөрийг ухахуй гэнэ. Иймээс өөрийг ухахуй, барихуй дүртийг нэг ижил утгаар ойлгож хэрэглэнэ. Зөвхөн өөрийгөө тодруулах замаар тухайн оногдохуунаа танин барьдаг байна. Өөрийг ухахуйн хувьд оногдохуун нь онохуйгаас хамааралтай бөгөөд, тусгаар бие даасан, бодит утгат бус юм. «Өөрийн нийт бусын эзлэхүй нөхцөл болсон амарлин ахуй, үлэмж үзэхүй хослон барилдсан самадиг дадуулсны хүчээр гарсан бөгөөд өөрийн оногдохууны зөв утганд адхагаас хагацсан, эндүүрэл үгүй болгоол» нь йогийн илт мэдэл юм.

13. Р.Отгонбаатар. Хоёр шүлэглэсэн орчуулга хийгээд хорин мөр шүлэгт хоёр төгс туурвил

Мэгзэмийн нэгдүгээр хувилбар нь төвд үг нэг бүрийг нэгэн мөр монгол шүлэг болгон буулгасан байхад, мэгзэмийн хоёрдугаар хувилбар нь төвд мөр шүлэг нэг бүрийг нэгэн бадаг монгол шүлэг болгон баяжуулж буулгасан байна. Хоёр туурвилын гол томоохон ялгаа нь үүнд оршино. Би нэгэнт олж авсан буюу гарт бэлэн байгаа учир ийм амар хялбараар ам мэдэн бурж болох хэдий ч үүнийг анх санаачлан хийхэд асар их бодлого мэдлэг, авьяас билиг шаардах билээ. Улмаар иймэрхүү хязгаар хүрээтэй шүлгийг ширмэл уут саванд шаазан аягыг холхиж хөдлөхөөргүй ороож нүүдэл аян хийх мэт үгсийг чухам шигшиж сонгосон нь хад хайрцаг лугаа адил зохист аялгууны тусгай чимэг, тарни мэт уран чадварлагаар яруу сонсголонтой оруулан зохионо гэдэг хэн хүн хурууны үзүүрээр хулсан үзэг хялгасан бийр хөдөлгөөд бүтээх ажил биш гэдэг нь тодорхой. Цаашилбал монгол зохиол болтол боловсруулж тус бүрдээ үе үсгийг дэлгэрүүлэн шүлэглэсэн энэ хоёр өвөрмөц туурвил нь маш нандин ёстой өдрийн од мэт ховор тул олон зуун судар бичгийн дотроос ч олдоход бэрх эрхэм зүйл гэж хэлэхэд болно. Шөнийн түг түмэн оддын тоот ном судрын дундаас бус өдрийн од шиг энэ хоёр дурсгалыг олж үзээд түгээж байгаа хүний хувьд туйлын баяртайгаар монголын эртний уран зохиолын эгнээнд хандив болгон нэмэрлэж байна.

14. Д.Ганболд. “Зургаан зуурдын судар”-ын агуулгын тухайд товчхон

Бидний ойлгодог нөгчөөд ахин төрөл авах хоорондын хугацааг л зуурд гэж ойлгох нь арай хязгаарлагдмал зүйл бөгөөд дээрх сударт дурдсанаар бол тэр нь нэг л үе шат нь юм байна. Амьдын, зүүдний, бясалгалын, нөгчихийн, номын чанарын, дахин төрөл авахын зуурд гэх зургаа нь гурван цагийн шүтэн барилдлага хийгээд үйлийн үрд суурилсан сансар нирвааны амьдралын үргэлжлэл, ухамсар мэдэмсэр хийгээд сүнсний оршихуйн гол сургаал болох тунгалаг сэтгэл, агуу их хоосон чанарын үзэл номлолыг бүрэн багтаасан агуулгатай өргөн дэлгэр цар хүрээтэй ойлголт ажээ.

15. С.Дэмбэрэл. Их сургууль ба Буддын дацангийн хамтын ажиллагааны загварыг шинжлэх нь

Эмори их сургууль болон Буддын дацангийн хамтын ажиллагаа нь харилцан ойлголцол, хүндлэл дээр тулгуурлажээ. Буддын дацангийн шинжлэх ухааны сургалт нь математик, физик, биологи, хими, анагаах ухаан гэх мэт шинжлэх ухааны суурь салбарууд руу чиглэжээ. Эмори их сургуулийн Шашин судлал, Зүүн өмнөд Ази судлалын тэнхимийн хичээлийн хөтөлбөрөө буддын дацангийн эрдэмтэй лам нараар буддын түүх, гүн ухаан, логик, дотоод ухаан, яруу найраг, бясалгалын арга, урлахуй ухаан, зан үйлийн талаар судалгаа явуулж, хөтөлбөрөө сайжруулж байна.

Эмори их сургуулийн эрдэмтэд буддын бясалгал, энэрэн нигүүлсэхүй сэтгэл үүсгэх, учир шалтгааны ухаан дээр суурилсан “Нийгэм, сэтгэл хөдлөлийг эерэг зүгт чиглүүлэх, ёс зүйн” хичээлийн хөтөлбөр боловсруулж, иргэний сургуулийн сурагчдад заасан нь сурагчдын

харилцаанд эерэг үр дүнг авчирсан байна. Тус их сургууль, буддын дацангийн хамтын ажиллагаа нь тогтвортой, үр дүнтэй байх бодлогыг баримтлан явагдаж байна.

Эмори их сургууль болон Брайбүн дацангийн хамтран хэрэгжүүлж буй шинжлэх ухааны сургалтын хөтөлбөртэй адил төслийг Монголын буддын шашны сүм хийд, дацангууд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага өнөө үед урган гараад байна.

16. Б.Мөнхцацралт. Орчин үеийн Монголын Буддын судлалын аргазүйн онцлог

Монголын Буддын судлалын судалгаа нь хөгжлийн явцдаа эдүгээ өөрийн гэсэн өвөрмөц арга зүйн онцлогийг бүрдүүлжээ. Үүнд, ШУА-ийн сурвалжлагч гишүүн Академич Ч.Жүгдэр, академич Г.Лувсанцэрэн нарын удирдсан буддын философи судлалын аргазүй нь үндэс суурь болсоноос гадна профессор Г.Лхагвасүрэн, профессор М.Гантуяа нарын эрдэмтэд дээрх судалгааны аргазүйг үргэлжлүүлж ШУА-ийн буддын философийн судалгаа нь бүхэлдээ нэгэн цогц судалгааны аргазүйтэй явж ирснийг харуулах бөгөөд харин эрдэмтдийн авч үзэж, судалж буй сэдвийн агуулгын хүрээнээс хамаарч судалгааны аргазүйн ялгаатай тал, онцлогийг ч тод харуулж байна.

Эцэст нь бид буддын судлалыг шинжлэх ухааны үүднээс буюу шашны хүрээнээс ангид судлах үйл ажиллагааг ШУА-ийн сурвалжлагч гишүүн Академич Ч.Жүгдэр, Г.Лувсанцэрэн нарын буддын философи судлалын арга, арга зүйг баримтлан, энэ чиглэлээр уламжлалыг хадгалсан, шинэчлэлийг шингээсэн судалгааны өөрийн гэсэн өвөрмөц чиглэлийг батжуулж, цааш үргэлжлүүлэн улам бүр хөгжүүлэх нь чухал гэж үзэж байна.

17. А.Батсуурь. Буддын гүн ухаан дахь сав, шим ертөнц – оюун мандалын шүтэлцээний үндэс

Сав шим ертөнцийн зохист уялдаа холбоог танин ухаарч, түүнээс үл гажин орших нь аливаа оршигч бүхний жам хэмээж, түүнтэй зохицон амьдрах, сэтгэн бодох ухааныг олсон нь манай өвөг дээдсийн билиг ухаан ажгуу. Аливаа зүйлсийн мэдрэгдэх өлөг /матери/ нь бодис юм гэж өгүүлээд сав ертөнцийг томьёолжээ. Цааш нь ус тэргүүтэн таван махбод нь шим ертөнцийн бүрдвэр болохыг зааж, тэгээд ургамал, хүн, амьтнаар шим ертөнцийг томьёолон илэрхийлжээ. Тэрхүү сав шим ертөнцийн харилцан үйлчлэлийн үр дүнд оршихуйг оюун мандалд хамаарагдах хэлэхүй буюу ригвед хэмээн ерөнхийлжээ. Түүнээс улбаалан бий болох хүний улаг, урлахуйн аливаа эрдэм үйлсийн мөн чанарыг сав-оюун-шим хэмээх гурван мандлын шүтэлцээтэй илэрхийлсэн нь их ухааны тусгал юм. Гурван мандлын хоорондын мөнхийн эргэлдэх дээд чанарыг “сүнс” хэмээх хийн бодиор илэрхийлсэн нь бидний эргэн тойрон оршин орчигч алив бүхэн өөр өөрийн мэдээлэл агуулсан оюунлаг зүйл болохыг батлах гол амин сүнс болсон ойлголт нь тэр ажээ. Сүнс сүлдлэг бүхний хамгийн эрхэм чанар нь “дуу” хэмээн дээр дурдсан илт номын аймгийн гүн ухаанд илэрхийлсэн байна. Сав-оюун-шим мандлын гол цөм зүй тогтол нь “дуу”-“сүнс”-“амь” хэмээн чанаруудынх нь тогтолцоогоор илэрхийлэгдэнэ. Энэ чанаруудын харилцан шүтэлцэх үнэмлэхүй харьцааг “хоосон чанар” хэмээх ухагдахуунаар Буддын гүн ухаанд өгүүлдэг.

18. Ж.Даваацэрэн. Хоосон чанар, шүтэн барилдлага ба шинжлэх ухаан

Танин мэдэхүйн бүх салбар ухаанууд нь “Нэгэн уулын оройд хүрэхээр тэмүүлсэн олон салаа замууд юм шүү” буюу туйлын үнэн хөгжлийнхөө явцад олон дүр, чиглэлд хувирсныг өөрийн хэмжээнд судалгаанд үндэслэсэн олон жишээгээр тайлбарлахад анхаарсан болно. Энэ явцдаа судлаачийн төв үзэл хэмээх ёс зүй хэчнээн чухал болохыг ойлгож авлаа. Төв үзлийг шашны ухаанд ч чухалчлан тайлбарласан байдаг нь нэгд хэт туйлширч, нөгөөд хэт найр тавьж,

харах орчин, сонсох зүйлээ нэгэн хэвд түгжиж, мугуйдлан төөрөлдөхөөс сэргийлэх өргөн хүрээний ойлголт аж.

Шинжлэх ухааны физик, сэтгэл судлалын салбар ухаанууд нь “Итгэл” номын сонгогдсон хэсэгтэй мөн чанарын хувьд адил утгатай буюу “Юмс хаанаас ч ирээгүй учраас үүсэхгүй. Юмс хаашаа ч одоогүй учраас устахгүй, байдаг л газраа бий. Нэгэнт үүсэх ч үгүй, устах ч үгүй юм бол үхэл гэж байхгүй, үхдэг зүйл үгүй, хэлбэрийн л хувьсал гэж бий” хэмээх хоосон чанар, шүтэн барилдлагын тухай философитой “Ертөнцийн энерги тэг учир юу ч шинээр үүсэхгүй”, “Төгсгөл ирэхэд дахин мэндэлнэ”, “Хүний биеийн бүхий л эрүүл мэнд хоорондын харилцаа хамаарал дээр тогтдог” хэмээх үзэл баримтлалуудаараа таарч байгаа юм.

19. Д.Мөнхтамир. Бурханы шашин ба Монголчууд: 1930-1940 оны Япон, Зөвлөлтийн бодлого

Энэхүү түүхэн үйл явдлуудыг нэгтгэн дүгнэхэд Америкийн антропологич М.Мийдийн хувь хүмүүс нийгмийнхээ нийтлэг, онцлогийг хүлээн авч, нийгэм, соёлын нөлөөгөөр нийгмийн хүн болж төлөвшдөг гэсэн ойлголттой холбож тайлбарлаж болохоор байна. Хэдийгээр хувь хүний зан төлөвийн онцлог (personality) байх хэдий ч нийгмийнхээ түгээмэл шинж буюу онцлогийг шингээсэн байдаг. Энэхүү структуралист онолын хандлагаар авч үзвэл 1930-1940 онд Монголчуудын соёл, үндэсний онцлогоор дамжуулан нөлөөгөө тогтоохоор ЗХУ, Япон хоёр өрсөлдөж байжээ гэж үзэж байна. Нэг талаас ЗХУ Монголчуудын үндэсний онцлогийг өөрчлөх замаар өөрсдийн соёл, сэтгэлгээг тулгаж, ард түмний хандлага, зан байдалд нөлөөлж, цаашлаад төрийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ нь Монголчуудын бурхны шашныг хориглож, угсаа язгууртнуудыг устгаж хошууны захиргааг өөрчилсөн, барууны суурьтай Оросын боловсрол, шинжлэх ухаанд сургаж, шинэ соёлыг төлөвшүүлсэн, эдгээрийг эсэргүүцсэн бүлэг хүмүүсийг хэлмэгдүүлсэн зэргээс харагдаж байна. Нөгөө талаас Япон ЗХУ-ын бодлогыг сөрж Монголчуудын уламжлалт соёл, үндэсний онцлогийг дэмжих, хөгжүүлэх байдлаар өөрсдийн эерэг дүр төрхийг бүтээж, нөлөөгөө тогтоохыг зорьсон. Энэ нь Чингис хааны сүм байгуулсан, бурхны шашин, түүний хутагт, лам нарыг дэмжсэн, уламжлалт хошууны захиргаа, язгууртнуудыг мөн дэмжиж хэвээр үлдээсэн зэргээс харагдаж байна. Үүний учир нь нийгмийн буюу тухайн соёлын онцлог дүр төрх, үндэсний онцлог нь хувь хүмүүс буюу ард иргэдийн зан төлөв, хандлага цаашлаад сонголтод нөлөөлж, энэ том хүрээнд улс төрийн зөвтгөлийг (legitimacy) бий болгох юм. ЗХУ, Япон хэмээх гадаад хоёр хүчний аль аль нь цэргийн хатуу хүчнээс гадна Монголчуудын соёл, үндэсний онцлогт тулгуурласан зөөлөн хүчээр буюу бурхны шашнаар дамжуулан улс төрийн нөлөөгөө тогтоохоор тэмцэж байжээ.

20. С.Төмөр-Очир. Логик үнэний эрэлд...

Танин мэдэхүйн үйл явцад логикийг ашиглахдаа тухайн танин мэдэгч субъектийн сэтгэхүйн онцлогийг харгалзан үзэх явдал чухал ач холбогдолтой байдаг. Оюун ухааны баримт нь тус тусдаа байх тохиолдолд үндэслэгдээгүй байдаг тул итгэл үнэмшлийг хамгийн үр дүнтэй болгохын тулд түүнийг логик дэс дараалсан тогтолцоонд оруулах хэрэгтэй болдог. Харин энэ нь логиктой үндэслэлтэй танилцахыг шаардана. Өрнөдийнхөн сэтгэн бодохдоо ерөнхийгөөс нэгжид шилжих буюу дедуктив оюун дүгнэлтийг голлон хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл ерөнхий онолын мэдлэгтээ тулгуурлан тухайн тохиолдлын дүгнэлтүүдийг гаргадаг гэсэн үг. Харин дорно дахины ард түмэн, тухайлбал монголчууд бид нэгжээс ерөнхийд шилжих буюу индуктив магадлалт оюун дүгнэлтийг өргөн ашигладаг байна. Иймээс буддын шалгадаг ухаанд магадлалт оюун дүгнэлтийн үнэн болохыг баталдаг монгол хүнд тохирсон өвөрмөц арга байсан

нь лавтай. Үүний өвөрмөц онцлогийг судалбал сонирхолтой төдийгүй шинжлэх ухааны хувьд судлагдаагүй шинэ арга байхыг ч үгүйсгэхгүй юм.

Иймээс монголын философи сэтгэлгээний түүхийн товчоон болсон Монгол лам нарын төвөд хэлээр бичсэн логикийн ном судрыг монгол хэлнээ хөрвүүлж судалгааны эргэлтэд оруулж, залуучуудын хүчийг ашиглаж судалгаа хийлгэх нь монголын философи сэтгэлгээний нэг цагаан толбыг арилгах буянтай үйл болно гэдэгт итгэнэм.

21. Ж.Баянсан. Тархи сэтгэхүйн үйл ажиллагаа, Метафорын утгын хамаарал

Бидний тархи мэдрэл буюу сэтгэхүйд асар олон зүйл өрнөж, тэдний зонхи нь үл ухамсарлахуйн түвшинд болж байдаг ажээ. Жишээлбэл, өдөр тутам харилцахад хэрэглэгдэж байдаг энгийн үг хэллэгийн ард асар өргөн сүлжээ далдлагдан үйлчилж байдаг.

Утга гэдэг нь аливаа өгүүлбэрт дайралддаг цөөн үгээс асар баялаг зүйл байдаг. Утгын байгуулал гэдэг нь зөвхөн хэлний хүрээ, хэлж ярих орчинд үүсэж, хэрэглэгдэж байдаг зүйл биш, математик, урлаг, шашин технологи, яруу найраг зэрэг хүний бүхий л бүтээлч үйлийн хүрээнд хэрэгжиж байдаг. Танихуйн хэл шинжлэлийн хийдэг хийсвэрлэмэл зураглалын арга нь сая дурдсан, хэлнээс бусад салбарт ч гэсэн нэгэн адил хэрэглэгддэг. Бидэнд тусаж байгаа юм үзэгдэл болгон өнгөн талаасаа, нэг нь нөгөөгөөсөө илт ялгаатай, тэгээд ч бид түүнд өөр өөрөөр хандаж байдаг ч гэсэн тэдгээрийг таньж мэдэх суурь арга, ажиллагаа нь ижил, нэгдмэл юм. Энэхүү суурь танихуйд нэвтрэх цонх нь хэл байдаг учраас хэл шинжлэл бол хүний сэтгэн бодохуйг гэрэлтүүлж өгдөг ухаан юм. Гэвч хэлнээс бусад салбарт явуулж буй утгын байгууллын судалгаа нь эргээд хэл шинжлэлийг гэрэлтүүлж өгдөг.

22. Б.Түмэндэмбэрэл. Альберт Эйнштейний уран сэтгэлгээний соёл ба Монгол сэтгэлгээний соёл

Физикийн шинжлэх ухаанд сонгодог физикээс орчин үеийн физикт шилжих хувьсгал гаргасан нээлтүүдийн эзэн А. Эйнштейн, дорнын суут сэтгэгч Р.Таагүр нарын ярилцлагын тэмдэглэлд үндэслэн энэ хоёр эрхмийн бодит байдлын мөн чанарыг танин мэдэх сэтгэлгээний арга барилыг монгол хүний сэтгэлгээний арга барилтай харьцуулан шинжлэх оролдлого хийв. Монгол хүнийг сонгохдоо аргын шинжлэх ухааны нэг эрдэмтэн ба билгийн шинжлэх ухаанаас Монгол анагаах ухааны сэтгэц заслын эмчийн төлөөллийн сэтгэлгээний соёлын асуудлыг энэ өгүүлэлд жишээ болгон авч үзэв.

23. Ц.Дашдож, Д. Цогтбаатар. Алгебр, тооны онолын үүсэл хөгжил, өнөөгийн байдал, ирээдүйн хөгжлийн хандлага

XX зууны эхэнд математикт ямар чиглэлүүд зонхилж байсныг Түүхт Парижийн хуралдаан дээрх жагсаалт харуулдаг. Тэдгээрийн дотроос алгебр, тооны онолын асуудлууд нь онцгой байрыг эзэлж, математикийн шинжлэх ухааны олон салбар хөгжих үндсийг тавьжээ. Энэхүү өгүүлэлд 1960-аад оноос хойших алгебр, тооны онолд шийдэгдээгүй асуудлуудын тавил, шийдсэн байдлыг нэгтгэн дүгнэж, тэдгээрийн дотроос монголын математикчдын оруулсан хувь нэмэр, амжилтыг тайлбарлан харуулсан.

24. Н.Насанбат. Хиймэл оюун ба ухамсар

Хиймэл оюун жирийн иргэдээс хол хөндий зүйл огт биш юм. Хиймэл оюун аль хэдийнээ бидний амьдралд нэвтэрч, бидэнд үйлчлээд эхэлсэн. Жишээ нь Фэйсбүүкийг эзэмшдэг Мета компани нь хиймэл оюуныг идэвхтэй хөгжүүлэгчдийн нэг юм. Шинэ найз санал болгох, хэрэглэгчийн хэрэгцээтэй байж болох заруудыг үзүүлэх гэх мэт үйлдлүүдийг хиймэл

Фэйсбүүкийн хиймэл оюун бүхий компьютерууд гүйцэтгэдэг. Google-ийн хайлтын систем, орчуулга гэх мэт нь мөн л хиймэл оюуны үйл ажиллагааны үр дүн юм.

Одоогоор хиймэл оюуныг хоёр шатанд ангилж байна. Нэг нь машины суралцахуй бөгөөд 1960-аад оноос хөгжлийн гараагаа эхэлсэн. Товчоор өгүүлбэл их хэмжээний өгөгдлийг ангилж хиймэл оюуныг дасгалжуулж сургах бөгөөд, энэ ангиллыг шинэ өгөгдлүүд дээр хэрэгжүүлэх замаар ажилладаг. Deep learning буюу гүн гүнзгий суралцахуй гэсэн хоёр дахь төрлийн хиймэл оюун нь харьцангуй шинэ залуу салбар юм. Хүний тархины сэтгэн бодох үйл явцыг дуурайлган, хиймэл нейроны сүлжээн дээр үндэслэн бүтээсэн. Өөрөөр хэлбэл суралцах, сэтгэн бодох нь хүнтэй ижилхэн гэсэн үг. Хиймэл нейрон бүхий хиймэл оюуныг "сургаж, дасгалжуулах"-ын тулд мөн л их хэмжээний өгөгдөл хэрэгцээтэй. Хүн ч гэсэн эргэн тойрныхоо их хэмжээний өгөгдөл, мэдээллийг боловсруулж суралцдаг. Гүнзгий суралцахуй нь нейроны сүлжээ гэж нэрлэгдэх алгоритмуудын олон давхар үеүдээс тогтдог. Өмнөх машины суралцахуй бүхий хиймэл оюуны шийдэх боломжгүй асуудлуудыг шийдэх чадвартай. Тухайлбал өмнө нь огт тааралдаж байгаагүй асуудалд шийдэл хайж олох чадвартай.

Хиймэл оюуныг ердийн материалын цуглуулгаас ялгаатай болгож, оюун ухаант хүнтэй адил болгож байгаа зүйл бол түүнд хадгалагдаж байгаа мэдээлэл юм. Хэдий их хэмжээний эмх цэгцтэй мэдээлэл хадгалагдана, хиймэл оюун тэр хэмжээгээр "ухаалаг", "ухамсартай" байна. Сүүлийн үед хиймэл оюун хурдацтай хөгжиж байгаа холбоотойгоор шашин болон нийгмийн зарим суурь ойлголтууд өөрчлөгдөх нөхцөл бүрэлдэж байна.

25. Р.Отгонбаатар. Хоёрхон бадаг шүлгийн холч гүн ухаан

“... Улиас чиг мод нь ургахдаа амархан хө
Ургасныхаа эцэст унах гэдэг нь жам юмаа хө
Унаган чиг газар шороогоо болбол доо хө
Уултай устай нь хайрлаж явбал эзэн нь болсны хэрэг ээ хө
Төрснийхөө эцэст болбол төгсөх гэдэг үнэн ээ хө
Төө биенийхээ чадлыг болбол түмэндээ зориулмаар аа хө
Түмнийхээ төлөө үнэнч явбал даа хө
Төрж төгсөх насны эцэст хүн болсны хэрэг ээ хө ...”

Эл бяцхан өгүүлэлд нэгэн ардын дууны ховор чухаг хоёр бадаг шүлэгт туссан гайхамшиг мэргэн ухааныг түмэн олонд түгээн таниулахыг зорив. Үүнд тэнгэр газар, хүн зоны зүй зохист аж төрөхүйн ухааныг төгс төгөлдөр агуулсан мэт болой. Энэ нь Бурхны шашны бодь мөрийн замтай ч нийцэх мэт.

26. Х.Дондог, Б.Дарамбазар. Буддын бясалгалын товч

Буддын бясалгалыг амирлан оршихуйн болон үлэмж үзэхүйн гэж хоёр төрөлд хувааж үздэг. Амирлан оршихуйн бясалгал нь сэтгэлээ тогтоон төвлөрүүлж бясалгана. Харин үлэмж үзэхүйн бясалгал нь амирлан оршихуйн сацуу ажиглан шинжих байдлаар бясалгах болой. Амирлах үлэмж хоёр нь самади бүгдийн хураангуй мөн хэмээжээ. Бясалгалыг багшийн увидасын дагуу нягт нямбай хийнэ. Багшийн удвис гэдэг нь тухайн багшийн зааж зөвлөсөн арга аргачлал, зөв зам мөрийн удирдамж юм. Адистэд оршино гэдэг нь өөрийн үндэст урьд өмнө нь байгаагүй эрдэм, сайн онол, чадал багшаас ирж өөрт бодитой төрөхийг хэлнэ.

“Санаанд үгүй бол оршиж чадахгүй” хэмээн гүн ухаантан Беркли нэгэнтээ хэлсэн буй. Түүнтэй уялдуулан эргэцүүлбээс, Буддын бясалгалын гүн санаа нь зөв зам мөрийг өөртөө нээж, санаандаа хоногшуулан нутагшуулахад чиглэсэн, хүчин чармайлт шаардсан, цаг хугацаа

зарцуулсан нөр их хөдөлмөр юм хэмээн дүгнэж болно. Элдэв зүйлийн олон талыг олон түвшинд нэгэн зэрэг харшуулалгүйгээр харж, олсон ухаарлаа санаанаасаа алдахгүй байх, оюун санаагаа энэ чиглэлээр тууштай дадуулах, төвлөрөл хийгээд билиг билгүүний түвшинд хүртэл хөгжүүлэх нь Буддын бясалгалын зорилго ажээ.

27. Васубанду. Төв хийгээд хязгаарын тийн ялгалын тайлбар (Төвд хэлнээс хөрвүүлсэн: А. Батсуурь)

Бэлгэ чанарыг түйдэгч хоосон чанар,
Ерөндөгүүд лүгээ бясалгахуй хийгээд,
Түүний орон лугаа үрийг олвоос,

Дээд үгүйн хөлөг болой хэмээхийн эдгээр долоон утгыг энэ шастирт номлох болой.

28. Х.Дондог. Буддын сургаалын шинжлэх ухаанч мэдлэгийг эзэмшүүлэх эрх зүйн асуудалд

Монголын уламжлалт Буддын шашны сургаал номлолууд манай ард түмний ахуй амьдралд нэвт шингэж, уламжлалт анагаах ухаан, зурхай-цаг тооны бичиг, гүн ухаан, танин мэдэхүй, оршихуйн хар ухаан, байгаль экологийн холбогдолтой өв соёлд өдөр дутам илэрч, хэрэглэгдсээр байна. Буддын шашны шинжлэх ухаанч мэдлэгээр дамжин илэрч буй монголын уламжлалт оюун ухааны сургалт нь албан боловсролын тогтолцоонд тусгагдан, хууль эрхзүйн зохицуулалтад орохыг шаардаж байна.

Уламжлалт анагаах ухаан, европ анагаах ухааны сургалтын агуулга хийгээд эмчилгээний үйл ажиллагаа хоорондын уялдаа, стандарт шаардлагын түвшинд эрхзүйн зохицуулалт хэрэгтэй байна.

“Бурханы сургаалын шинжлэх ухаанч агуулгыг эзэмшүүлэгч сургууль, эрдэм шинжилгээ-судалгааны байгууллага”-ийг боловсролын байгууллагын жагсаалтад оруулах нь зүйтэй юм.

Буддын сургаалын шинжлэх ухаанч агуулгын сургалтыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олгож болох тухай заалтыг “Тусгай зөвшөөрлийн тухай” хуульд шинээр оруулах, тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төрөлд шинээр зааж өгөх шаардлага байна.

5. Тайлангийн ерөнхий үр дүн, зөвлөмж

“Буддын ухаан ба шинжлэх ухаан: шүтэн барилдлагын шинжилгээ” сэдэвт энэхүү суурь судалгааны төслийн үр дүн нь хийсвэр болон материаллаг хоёр түвшинтэй хэмээн үзэж болно.

Материаллаг үр дүн буюу бодит ажил болсон үр дүн нь дараах долоо болой. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний арван гурван өгүүлэл хэвлүүлсэн
2. “Буддын ухааны нэр томъёо, ухагдахуун, хэллэгийн монгол, түвд, орос, англи дөрвөн хэлний дүйцүүлсэн толь бичиг”-ийн эх бэлтгэсэн
3. “Буддын ухаан ба шинжлэх ухаан дахь танин мэдэхүй” сэдэвт хоёр салбарын судлаачдын хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан
4. Энэхүү хурлын илтгэлүүдийн эмхэтгэлийг хэвлүүлсэн
5. “Хүний дотоод ертөнцийн янз байдал”-ыг тандан судлах социологийн судалгааны иж бүрэн асуумжийг шинээр боловсруулсан
6. Уг асуумжийг хэрэглэн социологийн судалгаа явуулсан
7. Судалгааны зарим үр дүнг хялбаршуулан “Физикийн боловсрол” сэтгүүлд хэвлүүлсэн, зарим их дээд сургуулийн тэнхимийн Их семинарт хэлэлцүүлсэн зэргээр илэрхийлэгдэж байгаа болно.

Хийсвэр үр дүн буюу сэтгэлгээний түвшинд олж авсан танин мэдэхүйн чадамж нь төсөлд хамааралтай судлаач нар, төслийн удирдагч болон багийн гишүүдийн оюун санааны

түвшинд оршино. Энэ түвшний үр дүн нь арга зүйн зөвлөмж маягаар илэрхийлэхийг оролдож болох ч, цаашдын арав хорин жилийн эрдэм шинжилгээний хурал, өгүүлэл, хэлэлцүүлэг, сургалт, гүнзгийрүүлсэн судалгааны явц зэрэгт илрэх, илэрхийлэгдэх боломжтой. Нөгөө талаас, энэ түвшний мэдлэг, мэдээлэл нь “субъектив бодол санаа” давамгайлж, судлаач хоорондын үзэл бодол, үзэл баримтлалаар “нэгдмэл нэг ойлголт” хэлбэрээр илрэх, нийтээр хүлээн зөвшөөрөгдөх боломж нь тааруу ч байж болох талтай. Гэсэн хэдий ч танин мэдэхүйн мэтгэлцээнд хэрэгтэй байж болох цөөн тооны үзэл санааг “зөвлөмж” хэлбэрээр энд дурдаж өгөхийг хүссэн болно. Үүнд:

1. “Буддын сургаал нь оршихуйн жам ёсны тухай мэдлэг, түүнд суурилсан оршихуйн зөв зам мөрийн технологи юм” гэсэн байр сууринаас хандаж үзэх нь “байгал, нийгэм хийгээд өөртэйгээ зөрчил багатай оршихуйн боловсрол” олж авахад ач тустай байх болно.
2. “Оршихуй нь аль ч шинжлэх ухааны судалгааны объект биш” (философийг эс тооцвол) учраас судлагдахуун болгон авч үзэх уламжлал дутагдаж, сэтгэлгээний шинэ хэв маяг, инновацилаг хандлагыг биднээс шаардана. Энэ төрлийн бэрхшээл нь хоёр салбарын хамтын ажиллагааг өдий хүртэл саатуулж ирсэн ч цаашид бид Буддын шашны сургуульд шинжлэх ухааны мэдлэг олгох, шинжлэх ухааны их дээд сургуульд “Буддын оршихуйн шинжлэх ухааны мэдлэг” олгох ажлыг эхлүүлэх нь нэн тустай байх болно.
3. “Хүний сэтгэл оролцоогүй оршихуй байдаггүй” учраас сэтгэлийн танин мэдэхүй нь нэн чухал ач холбогдолтой. Буддын шинжлэх ухааны цөм нь сэтгэл бөгөөд түүнийг зөв танихуйд суурилан хүн өөрөө өөрийнхөө оршихуйг зөв ухаарч, зөв залах боломжтойг үе үеийн мэргэд нотлон харуулсан байдаг.
4. Буддын сургаалын түвшинд “оршихуй нь өөрчлөгдөн урсахуй” бөгөөд түүний механизм нь “шүтэн барилдахуй” юм. Чинад хязгаарын тэрхүү үзэгдлийг танин барих нь “хараагүй хүн хараа орохтой адил чамин тансаг сэрэхүй” бөгөөд түүнийг үл мартан, үл орхин, улмаар “өөрийгөө өрөөлөөс үл ялгаварлан тэнцвэртэй оршихуй”-н суурь, “би гэх туйлшрал”-аас ангижрах хараа-ерөндөг болгодог ажээ. Энэ нь өнөөгийн сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэгийн хүрээг тэлсэн “шинэ” танин мэдэхүй юм.

6. Хавсралтууд

"Буддын ухаан ба шинжлэх ухаан" нэгдсэн баримдлагын шинжилгээний нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2019 оны 7 сарын 12 ны өдрийн дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

Угса - 2019/56

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

д/д	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1	Буддын ухаан ба шинжлэх ухааны үндсэн ойлголт, нэр томъёоны дүйцүүлсэн хослол цэс	12 хуудас орчим	Толь бичгийн 10 хувьтай тэнцэх хэсэг	2019 он 6сар
2	Эрдэм шинжилгээний өгүүлэл	1	Мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна	2019 он 12 сар
3	Толь бичгийн үндсэн ойлголт, нэр томъёоны хослолын монгол-төвд-англи-орос орчуулга	30 хуудас орчим	Толь бичгийн 10 хувьтай тэнцэх хэсэг	2020 он 6 сар
4	Социологийн судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл	2	Мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна	2020 он 12 сар
5	Толь бичгийн үндсэн агуулгын тайлбар боловсруулалт	Тайлбар текст	Толь бичгийн 30 хувьтай тэнцэх хэсэг	2020 он 12 сар
6	Толь бичгийн үндсэн агуулгын тайлбар боловсруулалт	Тайлбар текст	Толь бичгийн 40 хувьтай тэнцэх хэсэг	2021 он 6 сар
7	Эрдэм шинжилгээний хурал	1	ЭШ-ний хурлын материал	2021 он 12 сар
7	Эрдэм шинжилгээний өгүүлэл	3	Мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна	2021 он 12 сар
8	Буддын ухаан ба шинжлэх ухааны ойлголт, нэр томъёоны дүйцүүлсэн тайлбар толь бичиг	300 орчим хуудас	Толь бичгийн агуулга, эх 100 хувь боловсруулагдсан байна.	2021 он 12 сар
9	Судалгааны ажлын нэгдсэн тайлан	Тайлан болон толь бичиг	Эцсийн тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн	2021 он 12 сар
10	Төслийн эцсийн тайлан бичиж захиалагч, санхүүжүүлэгчид хүлээлгэн өгөх	1	Төслийн эцсийн тайлан	2021 оны 12 сард багтаана

Захиалагчийг төлөөлж:

(Signature)

С.Мөнхбат

БСШУСЯ-ны ШУТБГ-ын дарга

1118120429

Улаанбаатар хот Санхүүжүүлэгчийг төлөөлж:

(Signature)

С.Намсрайжав

ШУТ Сангийн Захирал

Гүйцэтгэгчийг төлөөлж:

(Signature)

СОЁЛЫН Б.БАЙРАУЛЬ

Соёлурлагийн их сургуулийн Соёлын сургуулийн Захирал

Төслийн удирдагч:

(Signature)

Х.Дондог

СУИС-ийн Соёлын сургуулийн доктор, дэд профессор



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
СОЁЛЫН СУРГУУЛЬ

“БУДДЫН УХААН БА ШИНЖЛЭХ УХААН ДАХЬ ТАНИН МЭДЭХҮЙ”

Эрдэм шинжилгээний хурлын улирламж

Зорилго: Танин мэдэхүйн хоёр том салбар болох Буддын ухаан, Шинжлэх ухаан хоорондын харилцан ойлголцлыг сайжруулах, хамтарсан судалгааны хүрээг өргөтгөх боломжийг нээн илрүүлэх, судалгааны ажлын цаашдын чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Хуралд хэлэлцүүлэх илтгэлийн чиглэл, хамрах хүрээ:

- Буддын их, бага таван ухаан
- Буддын гүн ухаан, шашин судлал
- Буддын шашны шинжлэх ухаан
- Байгалийн шинжлэл
- Байгаль экологит
- Нийгмийн ухаан
- Философи
- Боловсрол судлал
- Сэтгэл судлал
- Нейрোসайнс
- Хэл шинжлэл
- Соёл, урлаг судлал
- Уламжлалт анагаах ухаан
- Зурхайн ухаан

Хэлэлцүүлэх илтгэлийн ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэлэлцүүлээгүй байх;
- Шинжлэх ухааны үндэслэл бүхий шинэ болон шинэлэг санаа дэвшүүлсэн байх;
- Судалгааны тодорхой арга зүй хэрэглэсэн байх;
- Олон улсын жишиг, илтгэлд тавигдах бусад нийтлэг шаардлагыг хангасан байх;

Хэлэлцүүлэх илтгэлийн техникийн шаардлага:

- Илтгэлийн нэр (*Там үгсээр, Times New Roman, үсгийн өндөр 12, тоод хар үсгээр, мөр голлосон байх*)
- Зохиогчийн овог, нэр (*Times New Roman, үсгийн өндөр 12*)
- Хураангуй (*100-150 үгстэй, үсгийн өндөр 10, үсгийн хэлбэр налуу*)
- Түүхтүүр үг (*6-8, монгол хэлээр, гарчигт орсон үгийг давхардуулахгүй*)
- Илтгэлийн эх нь 6-аас цөөнгүй нүүр байна.

Илтгэл хүлээн авах хугацаа:

Хурал зохион байгуулах комисс илтгэлийг khlondog@yahoo.com, psdmandakh@gmail.com хаягаар 2022 оны 5-р сарын 15-ны дотор хүлээн авна.

Эрдэм шинжилгээний хурал 2022 оны 5-р сарын 27-нд Онлайн хэлбэрээр зохион байгуулагдана.

Илтгэлүүдийг өгүүлдгийн хэлбэрт оруулж “Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл” болгон хэвлүүлнэ. Хурлын талаарх нэмэлт мэдээллийг psdmandakh@gmail.com, khlondog@yahoo.com цахим хаягууд болон 99273583, 99264084, 70002091 утсаар тодруулж болно.

Зохион байгуулагч: Соёлын сургууль



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
СОЁЛЫН СУРГУУЛЬ

“БУДДЫН УХААН БА ШИНЖЛЭХ УХААН ДАХЬ ТАНИН МЭДЭХҮЙ”

ОНЛАЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

2022 оны 05 сарын 27

Хурлыг нээж Соёлын сургуулийн захирал, доктор, дэд профессор **Ш.Эрдэнэцогц** уг хэлэлц. 10.05-10.10 Судалгааны шинэ чиглэлийн тавилцуулга, **Х.Дондог**, доктор, дэд профессор.

Хурлын дэг: Илтгэх хугацаа 10 минут, асуулт хариулт – 3 минут.

I хэсэг

Хурлыг **Х.Дондог**, доктор, дэд профессор удирдана.

- 10:10 - 10:20 “Бөгд Жаваандамба хутагтуд Монголын оюун санааны гарамгай удирдагчид болох нь” *Б.Дарамбаатар, МУИС-ийн докторант*
- 10:25 - 10:35 “Их сургууль ба буддын давангийн хамтын ажиллагааны загварыг шинжлэх нь” (Эмэри их сургууль, Гоман Брайбүи давангийн ажлын дээр) *С.Дамбаэрэл, докторант, МУИС, Шашин судлалын тэнхим, бали*
- 10:40 - 10:50 “Логик үзэний эрэлд” *С.Төмөр-Очир, доктор, профессор, Хангай Дээд Сургуулийн Удирдах Зөвлөлийн дарга*
- 10:55 - 11:05 “Зургаан зурамын судар”-ын агуулгын тухайд говчлон” *Д.Гандалд, доктор, профессор, МУБИС*
- 11:10 - 11:20 “Буддын ухаан ба хууль эрх зүй” *Р.Оюунчимэг, МСХ*
- 11:25 - 11:35 “Алгебр-тооны онолын үүсэл хөгжил, оноогийн байдал, ирээдүйн хөгжлийн хандлага” *Ц.Ландорж, доктор, профессор, МУИС; Д.Настбаатар, доктор, МУИС*
- 11:40 - 11:50 “Хоосон чанар, шүтнэ барилдлага ба шинжлэх ухаан” *Ж.Даваагүрэн, зөвлөлч, Жавчидвичислэн хийд*
- 11:55 - 12:05 “Тархи сэтгэхүйн үйл ажиллагаа, Метафорын утгын хамаарал” *Ж.Батсан, доктор, профессор*
- 12:10 - 12:20 “Хутагт нас лугаа төгөлдөр баясагч умайд орох судрын эх бичгийн судалгаа” *Д.Отгонбаатар, ОМИС-ийн докторант; Г.Арцунзаяа, Хүний их мич*
- 12:25 - 12:35 “Бурханы шашин ба Монголчууд” *Д.Мөнхтэмүр, магистр, МУИС, Антропологи, археологийн тэнхим*
- 12:40 - 12:50 “1990 оноос хойш, Монголын ард түмний шашин ба сэтгэлгээний өөрчлөлт” *Г.Насантосха, МУИС-ийн докторант*
- 13:00 - 14:00 Удийн завсарлага

II хэсэг

Хурлыг **Х.Дондог**, доктор, дэд профессор удирдана.

- 14:00 - 14:10 “Галаад, дотоод ертөнцүүдийн танин мэдэхүйн харьцуулалт” *Х.Дондог, доктор, дэд профессор, Тосгийн удирдагч, СУИС, Соёлын сургууль*
- 14:15 - 14:25 “Мэдэрлийн шинжлэх ухаан ба Буддын ухаан дахь “Би”, чөлөөт үзэл, шийгэм” *Ц.Бат-Итгэл, Гэвэл-Товаралма, Дээд Бодь Хийд*
- 14:30 - 14:40 “Брагри лам Дампагдоржийн зохиол бүтээлийн тойм, тогтоолын үгийн тухай” *Т.Баярлах, СУИС-ын докторант, МУ-ын Үндэсний намын сан*
- 14:45 - 14:55 “Хамба номун хан Агваандайлавын бурхан урлах уламж хөндлө хийсэн урлаачийн ёс зүйн шинжлэл” *М.Очирагч, Д.Отгонбаатар, Улаанхотын урлах ухааны Соёмбо хөвдн тов*
- 15:00 - 15:10 “Хоёрхон балаг шүтэний хэлч гүн ухаан” *Р.Отгонбаатар, доктор, ШУА, ХЗХ*
- 15:15 - 15:25 “Аалберт Эйнштейний гүн сэтгэлгээний соёл ба Монгол сэтгэлгээний соёл” *Б.Түмэндэмбэрэл, доктор, профессор, ШУТИС*
- 15:30 - 15:40 “Мэдлэгийн уг сурвалж: илт мэдэл” *Б.Арцунзаяа, магистр, ШУА-ийн философиин хүүрээгч*
- 15:45 - 15:55 “Хиймэл оюун ба ухамсар” *И.Насанбат, доктор, ШУТИС, ХИИС*
- 16:00 - 16:10 “Жаламба судрын орчуулгын тухай” *Д.Амансэрм, орчуулагч*
- 16:15 - 16:25 “Төр, шашин хоёрын түүхэн яви” *Д.Минисдорж, Монголын шашны Хөндмөө*
- 16:30 - 16:40 “Орчин үеийн Монголын Буддын судлалын арга зүйн онцлог” *Б.Монсцаргал, докторант, ШУА-ийн Философиин хүүрээгчийн Шашин судлалын салбарын ЭШД*
- 16:45 - 16:55 “Монголын уламжлалт эмийн жоронд ордог зарим эмт бодисууд” *Т.Ганбаатар, Эмийн эрдэс судлаач*
- 16:55 - 17:00 Ерөнхий хэлэлцүүлэг

Хаалт

Социологийн судалгаа

Он, Сар, Өдөр

Судалгаанд сайн дураар оролцож, чин сэтгэлээсээ хариулж буй Танд талархая.
Санамж: Зөвхөн нэг хариултыг сонгоно.

Энэхүү судалгааны зорилго нь Монголчуудын оюун санаа, дотоод ертөнцийн дүр төрх, оршихуйн суурь хандлагыг тандан судлахад оршино. Хувь хүний нэр хүнд, улс үндэстний эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байхаар бодолцсон болно.

Таны хүйс: 1. Эм 2. Эр 3. Бусад

Таны нас 1. 19 хүртэл 2. 20-29 3. 30-39 4. 40-49 5. 50-59 6. 60-69 7. 70+

Амьдарч буй хот, аймаг:

Таны боловсрол 1. Бага 2. Дунд 3. Дээд 4. Бусад

1. **Та хийсэн сонголтуудад сэтгэл ханамжтай байдаг уу?**
 - a. Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй
 - b. Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай, бас бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай
 - c. Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй, бусдын хийсэн сонголтонд ч сэтгэл ханамжгүй
 - d. Өөрийн хийсэн сонголтонд сэтгэл ханамжгүй, гэвч бусдын хийсэн сонголтонд сэтгэл ханамжтай
2. **Хүн бүр өөрийн гэсэн дотоод ертөнцтэй байдаг бөгөөд тэр ертөнцүүд нь өөр хоорондоо эрс ялгаатай байж болно. Та үүнтэй санал нэг байна уу?**
 - a. Санал нэг байна.
 - b. Зарим талаар санал нийлж байна.
 - c. Санал нийлэхгүй.
 - d. Мэдэхгүй.
3. **Хүмүүс өөр өөрсдийн дотоод ертөнцийг харилцан хүлээн зөвшөөрөх боломжтой юу?**
 - a. Бүрэн боломжтой.
 - b. Зарим талаар боломжтой
 - c. Огт боломжгүй.
 - d. Мэдэхгүй
4. **Та бие дааж хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай байдаг уу?**
 - a. Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай, бусдын хийсэн алхамуудад сэтгэл ханамжгүй
 - b. Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай, бусдын хийсэн алхамуудад бас сэтгэл ханамжтай

- c. Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжгүй, бусдын хийсэн алхамуудад ч сэтгэл ханамжгүй
 - d. Өөрийн хийсэн алхамуудад сэтгэл ханамжгүй, гэвч бусад заримын хийсэн алхамуудад сэтгэл ханамжтай
5. **Та өөрийн сэтгэлийн шүтээнээ олсон уу?**
- a. Олсон.
 - b. Олоогүй
 - c. Тийм зүйл байдаг эсэхийг мэдэхгүй.
6. **Та далд ухамсар (зөн совин, интуици)-ын нөлөөг хэр хэмжээнд хүлээн зөвшөөрдөг вэ?**
- a. Өөрийн далд ухамсрын нөлөөг хүлээн зөвшөөрнө, бусдын далд ухамсарт итгэхгүй.
 - b. Өөрийн далд ухамсрын нөлөөг хүлээн зөвшөөрнө, бас бусдын далд ухамсарыг хүлээн зөвшөөрнө.
 - c. Өөрийн далд ухамсарт итгэхгүй, бусдын далд ухамсарт ч итгэхгүй.
 - d. Өөрийн далд ухамсарт итгэхгүй, харин зарим хүмүүсийн далд ухамсарт итгэнэ.
7. **Муу зуршлыг арилгах нь хэцүү юү, хялбар уу?**
- a. Өөрийн муу зуршлыг арилгахад хялбар, бусдын муу зуршлыг арилгахад хэцүү.
 - b. Өөрийн муу зуршлыг арилгахад хялбар, бусдын муу зуршлыг арилгахад ч хялбар.
 - c. Өөрийн муу зуршлыг арилгахад хэцүү, бусдын муу зуршлыг арилгахад бас хэцүү.
 - d. Өөрийн муу зуршлыг арилгахад хэцүү, гэвч бусдын муу зуршлыг арилгахад хялбар.
8. **Сэтгэлийг ойлгох нь хялбар уу, хэцүү юү?**
- a. Өөрийн сэтгэлийг ойлгох хялбар, бусдын сэтгэлийг ойлгох хэцүү.
 - b. Өөрийн сэтгэлийг ойлгох хялбар, бусдын сэтгэлийг ойлгох ч хялбар.
 - c. Өөрийн сэтгэлийг ойлгох хэцүү, бусдын сэтгэлийг ойлгох ч хэцүү.
 - d. Өөрийн сэтгэлийг ойлгох хэцүү, бусдын сэтгэлийг ойлгох хялбар.
9. **Сайныг хэлэх нь хялбар уу, хэцүү юү?**
- a. Өөрийн сайныг хэлэх хялбар, бусдын сайныг хэлэх хэцүү.
 - b. Өөрийн сайныг хэлэх хялбар, бусдын сайныг ч хэлэх хялбар.
 - c. Өөрийн сайныг хэлэх хэцүү, харин бусдын сайныг хэлэх хялбар.
 - d. Өөрийн сайныг хэлэх хэцүү, бусдын сайныг ч хэлэх хэцүү.
10. **Муут нуух хялбар уу, хэцүү юү?**
- a. Өөрийн муут нуух хялбар, бусдын муут нуух хэцүү.
 - b. Өөрийн муут нуух хялбар, бусдын муут нуух ч хялбар.
 - c. Өөрийн муут нуух хэцүү, бусдын муут ч нуух хэцүү.
 - d. Өөрийн муут нуух хэцүү, харин бусдын муут нуух хялбар.
11. **Өөрчлөх нь хялбар уу, хэцүү юү?**
- a. Өөрийгөө өөрчлөх хялбар, бусдыг өөрчлөх хэцүү.
 - b. Өөрийгөө өөрчлөх хялбар, бусдыг өөрчлөх ч хялбар.
 - c. Өөрийгөө өөрчлөх хэцүү, бусдыг өөрчлөх ч хэцүү.
 - d. Өөрийгөө өөрчлөх хэцүү, харин бусдыг өөрчлөх нь хялбар.
12. **Сэтгэлийн хир, муу сэтгэл гэдэгт мунхаг, шунал, уур, тачаал, атаархал, омог бардамнал зэрэг орно. Та үүнтэй санал нийлж байна уу ?**
- a. Санал нийлж байна

- b. Зарим талаар санал нийлж байна.
c. Санал нийлэхгүй.
13. **Та сэтгэлийн хирийг бүрэн арилгаж болно гэдэгт итгэх үү?**
a. Бүрэн итгэнэ.
b. Бага зэрэг итгэнэ.
c. Огт итгэхгүй.
14. **Та их хэрэглээг хязгаарлаж, өөрчлөхтэй санал нийлэх үү?**
a. Үгүй, би ямар ч хэрэглээгээ хязгаарлахыг эсэргүүцнэ.
b. Хязгаарлах зайлшгүй шаардлага тулгарчихвал хязгаарлах болно.
c. Цаашдаа хязгаарлах шаардлагатай нөхцөл үүснэ гэвэл арга хэмжээ бодно.
d. Ер нь хязгаарлах шаардлагатай эсэх талаар өөрөө урьдчилан мэдээд зохицуулна.
15. **Та өөрийнхөөрөө байж чаддаг уу?**
a. Ихэнх тохиолдолд өөрийнхөөрөө байж чаддаггүй.
b. Зарим тохиолдолд өөрийнхөөрөө байдаг
c. Ихэнх тохиолдолд өөрийнхөөрөө байдаг.
16. **Та эмоци буюу сэтгэл хөдлөлөө хянаж чаддаг уу?**
a. Ихэнх тохиолдолд би сэтгэл хөдлөлөө хянаж чаддаггүй.
b. Зарим тохиолдолд би сэтгэл хөдлөлөө хянаж чаддаг.
c. Ихэнх тохиолдолд би сэтгэл хөдлөлөө хянаж чаддаг.
17. **Та бид байгал орчинтойгоо нэгэн гэр бүл (цул) болж оршдог тул түүнийг хайрлан хамгаалах талаар юу бодож хийдэг вэ?**
a. Байгал орчныхоо нэг хэсэг гэдгээ би зөвшөөрнө, харин байгал хамгаалагч нь би биш.
b. Байгал орчныхоо нэг хэсэг гэдгээ би зөвшөөрнө, яаж хамгаалахаа ч мэднэ, бас хийнэ.
c. Байгал орчныхоо нэг хэсэг гэдгийг би сайн зөвшөөрөхгүй, байгал хамгаалагч нь ч би биш.
d. Байгал орчныхоо нэг хэсэг гэдгийг би сайн зөвшөөрөхгүй, гэвч би байгалаа хамгаалах ёстой.
18. **Та өөрийгөө олсон, өөртөө эзэн болж чаддаг хүн мөн үү?**
a. Үгүй, би өөрийгөө олсон гэж хэлж чадахгүй.
b. Би өөрийгөө олсон гэж боддог.
c. Мэдэхгүй.
19. **Та уламжлал, шинэчлэлийн талаар ямар байр суурьтай байдаг вэ?**
a. Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлийг орхиж, орчин үеийн суурьшмал соёл иргэншилтэй байх нь зүйтэй хэмээн үздэг.
b. Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлээ орчин үеийн суурьшмал соёл иргэншилтэй хослуулан авч явах нь зүйтэй хэмээн үздэг.
c. Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлийг хоцрогдсон хэмээн үзэж, орчин үеийн дэвшилтэт суурьшмал соёл иргэншилтэй байх ёстой хэмээн үздэг.
d. Бид уламжлалт мал аж ахуйн соёл иргэншлээ л түшиж амьдрах нь зүйтэй, суурьшмал соёл иргэншил нь манайд сайн тохирохгүй хэмээн үздэг.
20. **Та өөрийн болон өрөөлийн үйл, үйлдлийг хянадаг уу?**
a. Өөрийн үйл, үйлдлийг хянадаг, бусдын үйл, үйлдлийг хянадаггүй.
b. Өөрийн үйл, үйлдлийг хянадаг, бусдын үйл, үйлдлийг ч бас хянадаг.
c. Өөрийн үйл, үйлдлийг хянадаггүй, бусдын үйл, үйлдлийг ч хянадаггүй.
d. Өөрийн үйл, үйлдлийг хянадаггүй, харин бусдын үйл, үйлдлийг хянадаг.

21. **Та бид нийгмийн орчны бүтээгдэхүүн тул түүний хөгжилд хувь нэмэр оруулах талаар юу бодож хийдэг вэ?**
- Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрнө, гэвч нийгмийн орчныг би сайжруулж чадахгүй.
 - Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрнө, нийгмийн орчныг сайжруулахад би хувь нэмэр оруулна.
 - Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрөхгүй, нийгмийн орчныг ч би сайжруулахгүй.
 - Нийгмийн орчин бидэнд нөлөөтэйг зөвшөөрөхгүй, гэвч нийгмийн орчныг би сайжруулахад хувь нэмэр оруулах ёстой.
22. **Та хариуцлагатай хүн мөн үү?**
- Өөртөө хариуцлагатай, бусдыг хариуцлагатай байхыг шаардахгүй.
 - Өөртөө хариуцлагатай, бусдыг ч хариуцлагатай байхыг шаардана.
 - Өөртөө хариуцлага багатай, бусдыг ч хариуцлагатай байхыг шаардахгүй.
 - Өөртөө хариуцлага багатай, харин бусдыг хариуцлагатай байхыг шаардана.
23. **Та бид нэг улс үндэстэн тул нийтлэг эрх ашгийнхаа талаар юу бодож, хийх ёстой вэ?**
- Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрнө, харин нийтлэг эрх ашиг надад хамаагүй.
 - Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрнө, нийтлэг эрх ашгаа надад бас хамаатай.
 - Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрөхгүй, нийтлэг эрх ашиг гэдэг ч надад хамаагүй.
 - Бид нэг улс үндэстэн мөн гэдгээ би зөвшөөрөхгүй, гэвч нийтлэг эрх ашиг гарвал хамгаална.
24. **Та бусдын хувьд хэр чухал хүн бэ?**
- Өөрийгөө бусдаас илүү эрхэмлэж явах нь зөв.
 - Өөрийгөө бусадтай адилд үзэж явах нь зөв.
 - Өөрийгөө бусдаас доорд барьж явах нь зөв.
25. **“Буддын ухаан ба Шинжлэх ухаан: шүтэн барилдлагын шинжилгээ” сэдэвт суурь судалгааны төслийн удирдагч, судлаач доктор, дэд профессор Х.Дондоогоос Танд талархал илэрхийлж байна. Та надаас танд таалагдах “Талархлын үгс”-ийг сонгож авна уу.**
- Танд эрүүл энх, аз жаргал хүсэн ерөөе.
 - Танд найрсаг хамт олон, ажлын амжилт хүсэн ерөөе.
 - Танд гэр бүлийн халуун уур амьсгал хүсэн ерөөе.
 - Таны юу санасан есөн хүсэл биелэх болтугай.
 - Таны үр хүүхэд, ач зээ нарт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.
 - Таны ахмад буурлууд урт насалж, удаан жаргах болтугай.
 - Бидний Монголчууд үүрд мандан бадраг.



Физикийн боловсрол, 2022, № 49, 50

АГУУЛГА

I. ФИЗИКИЙН БОЛОВСРОЛ

Редакцын зурвас..... 3

С.Төмөр-Очир Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт хийсэн шинжилгээний ерөнхий дүгнэлт 5

Х.Дондог Гэрлийн квантын зарим томьёоны гаргалгааг бясалгах жишээ..... 12

II. ФИЗИКИЙН ОЛИМПИАДЫН БОДЛОГО

Г.Батсүх "Их сорилго" олимпиадын X ангийн бодлого 16

III. ФИЗИКЧ ЭРДЭМТЭН БАГШ

Р.Галбадрах Эрдэмтдийн гэр бүлд өссөн багш 21

Г.Баатарбилэг Тэнхимийн эрхлэгчийн зүтгэл, тэмүүлэл..... 25

Ц.Содов "Тулгуур дохионы" Цэдэнбал багш..... 30

Б.Пүрэвжал Дууриалтай бүтээлч физикч багш 33

IV. ФИЗИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Х.Цоохүү Онолын физикийн цуврал: №5. ЭПР, парадокс..... 36

Х.Цоохүү Онолын физикийн цуврал: Ааронов-бомын эффект 45


Н.Түгжсүрэн суут физикч Исаак Ньютон 50

V. МЭДЛЭГИЙН ЕРТӨНЦ

Х.Дондог, Ц.Содов, Н.Түгжсүрэн Физикийн монгол-орос-англи нэр томьёо, ухагдахууны толь 60

VI. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Н.Түгжсүрэн, Х.Батболд, М.Мөнхболд Шинэ ном 71



Физикийн боловсрол, 2021, №45, 46

АГУУЛГА

I. ФИЗИКИЙН БОЛОВСРОЛ

А.Нямсүрэн, Ц.Содов ЕБС-ийн багшийн мэдээллийн соёлын ноцг чадамжийг судалсан нь..... 3

Х.Дондог Танин мэдэхүйн бясалгал, түүний талаарх зарим физик жишээ..... 12

М.Мөнхболд, Д.Пүрэвдорж, Ц.Содов Физикийн багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хийсэн анализ..... 20

II. ФИЗИКИЙН БОДЛОГУУД

Г.Батсүх Гавьяат багш Р.Бавуудоржийн нэрэмжит шигшээ сорилго олимпиадын багш нарын бодлого..... 29

III. ФИЗИКЧ ЭРДЭМТЭН, БАГШ

П.Лхагвасүрэн Нэр хүндтэй түүхийг бүтээлцнэ гэдэгт итгэлтэй байна..... 32

Н.Түгжсүрэн Судлаач- дарга багш..... 35

Б.Пүрэвжал Физикийн бүтээлч залуу багш..... 38

IV. ФИЗИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Х.Цоохүү Онолын физикийн цуврал: №1 Квант механикийн үндсэн ойлголт..... 40

Х.Цоохүү Онолын физикийн цуврал: №2 Шредингерийн тэгшитгэлтэй танилцах нь: хачирхалтай үр дүнгүүд..... 45

Х.Дондог, Ц.Содов, Н.Түгжсүрэн Физикийн монгол-орос-англи нэр томьёо, ухагдахууны толь..... 50

V. МЭДЛЭГИЙН ЕРТӨНЦ

Б.Жадамбаа Хөгжил, түүний гурвал..... 62

Д.Данзан Хөгжил: мөхөл, аврал..... 66

Д.Анхцэнэг, М.Алъяа Газархөдөлтийн тухай товчхон..... 68

VI. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

М.Ганбат Олонульсын физикийн I олимпиад..... 78

Б.Бат-Отгон, Р.Энхбат Азийн физикийн XXI олимпиад..... 80



Физикийн боловсрол, 2022, №51, 52


АГУУЛГА

I. ФИЗИКИЙН БОЛОВСРОЛ


Ш.Дауренбух, Ц.Содов Байгалийн шинжлэлийн бага боловсролын сурах бичиг, гарын авлагуудад хийсэн шинжилгээ 3

Х.Дондог, Ц.Содов, Н.Түгжсүрэн Физикийн монгол-орос-англи нэр томьёо, ухагдахууны толь..... 12

Хавсралт 5а



Хавсралт 56



ОРХОН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ
(ORKHON UNIVERSITY ACADEMIC JOURNAL)
2021, № 21

ӨМНӨХ ҮГ 6

БОЛОВСРОЛ СУДЛАЛ (EDUCATION)



Орхон их сургууль
ОРХОН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ
(ORKHON UNIVERSITY ACADEMIC JOURNAL)
2019, №19

ӨМНӨХ ҮГ 3

БОЛОВСРОЛ СУДЛАЛ (EDUCATION)

Using authentic texts in ESP teaching.....Ариунаа АМГААВАZАР...9
Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт монгол хэлний толооны үг тусгагдсан нь /1990-2019 он/.....Б. Бямбасүрэн...19
Бүх нийтийн физикийн боловсролын тухайМ. Гонгор, Ц. Содов, Л. Удвал...35
Бага боловсролын багшийг бэлтгэх, чадваржуулах зарим асуудалШ. Дауренбек, Ц. Содов...47
“Хөдөлмөрийн хүн” загвараар нийгмийн сэтгэл зүйг шинжих нь.....Х. Дондог...59
Билиг ухаанаар нотлох арга аргачлалын тухай.....Х. Дондог...79
ЕБС-ийн англи хэлний сургалтын хөтөлбөрийн хөгжлийн чиг хандлага.....Б. Дэчмаа, Б. Батчимэг...97
Организация самостоятельной работы студентов, обучающихся по русскому языку в монгольской аудиторииБ. Мөнхбаатар...109
Физикийн багшийг бэлтгэх, хөгжүүлэх тухай.....М. Мөнхболд, Д. Пүрэвдорж, Ц. Содов...121
Эцэг эхийн оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлж, хүүхэд нэг бүрийн хэл яриаг хөгжүүлж боломж.....О. Мөнхцэцэг, Ц. Цэцэгсүрэн...133
Кембрижийн хөтөлбөрийн математик чадварын судалгаа.....Б. Оюун-Эрдэнэ, Ц. Цэцэгсүрэн...143
Физикийн хичээлийн агуулга, арга зүйг сайжруулах арга зам.....Д. Сайнбаяр, Л. Долгормаа...155
Сургуулийн өмнөх боловсролын багшийн хангалт, хүртээмжийн асуудал.....Д. Сарантуяа, Г. Монголхатан...171



Орхон Их Сургууль
ОРХОН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ
(ORKHON UNIVERSITY ACADEMIC JOURNAL)
2020, № 20

ӨМНӨХ ҮГ.....### ... 6

БОЛОВСРОЛ СУДЛАЛ (EDUCATION)

Прагматик хэрэглэнд суурилсан мэргэжлийн англи хэлний сургалтД.БАТБААТАР ... 7
Зарим улс, орны ахлах сургуулийн бүтэц, хэв шинж, зохион байгуулалтаасБ.БАЯРМАА ... 23
Их хөлгөний судлагдахууныг шинжилсэн дүн Х.Дондог ... 37
Бага ангийн сурах бичигт дүн шинжилгээ хийсэн нь Л.ДУЛИМАА ... 55
Завхан аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц, байршлын зураглал Ж.ЖАМЪЯНТИВ ... 71
6-10 насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн харьцуулсан байдал Ц.ЛХАГВАСҮРЭН ... 85
Нэг бодлогыг олон аргаар бодох нь Р.МАГСАР, Б.ХАДБААТАР ... 99
ЕБС-ийн физикийн хичээлийн сурах бичгүүдэд хийсэн шинжилгээ М.Мөнхболд, Д.Пүрэвдорж, Ц.Содов ... 107
Их сургуулийн эрх зүйн багшийн цогц чадамж, шинжийг судалсан нь Л.НАРАНТУЯА, Ц.СОДОВ ... 123
Багшид мэдээллийн соёл төлөвшүүлэх нь А.НЯМСҮРЭН, Ц.СОДОВ ... 133
Судалгааны ажлын гүйцэтгэлээр оюутны сурах хурдыг нэмэгдүүлж боломж Л.Эрдэнэцэцэг... 149


- 5 -

Хавсра
лт 5в

Хавсралт 5г



БУДДЫН УХААН БА ШИНЖЛЭХ УХААН ДАХЬ ТАНИН МЭДЭХҮЙ	
ТАРЧИГ	
Удиртгалагч	5
С.Гантөмөр, Х.Дондог	Буддын шинжлэх ухааны товч..... 8
Х.Дондог	Гадаад, дотоод ертөнцүүдийн танин мэдэхүйн харьцуулалт..... 31
Дийтер Яагер, Ц.Бат-Итгэл, Х.Дондог	Мэдэрлийн шинжлэх ухаан болон Буддын ишгийн дахь "Би", "Чөлөөт хүсэл", "нийгэм" гэхээх ойлголтууд..... 42
Бугат Л.Алтангэрэл	Жадамба сүдрын орчуулгын тухай..... 50
Д.Отгонбаатар, Г.Ариунзаяа	Хутагт нас дугаа төгөлдөр баясагч умайд орох сүдрын эх бичгийн судалгаа..... 61
М.Очирбуд, Л.Отгонбаатар	Хамба Номун Хан Агванхайдавын Бурхан урлагын урьдас зохиолд хийсэн урлагчийн ёс зүйн шинжлэл..... 90
Р.Оюунчимэг	Буддын ухаан ба хууль эрх зүй..... 113
Т.Ганбаатар	Монголын уламжлалт эмийн эжоронд ордог зарим эмт бодисууд..... 121



ГАРЧИГ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ, ҮНДСЭН ИЛТГЭЛ

Ревушкин А.С. Ундэсний судалгааны Томскийн УИС, Томск.
Намдаваа Г. Монгол улсын БОАЖЯ, Улаанбаатар
ТОМСК, Ховд хотод сарыний шинжлэх ухаан-боловсролын орон зай дахь огтлолцлын зэрэгцээ болох нь 4

Ревушкин А.С. Ундэсний судалгааны Томскийн УИС, Томск.
Томск и Ховд - две пересекающиеся параллели в научно образовательном пространстве Евразии 5

О.Монхтогтох, Э.Сүргэлж, Д.Мөнхлэст, В.Лукаревский, М.Баярма
Монгол орон баруун хэсгийн Жаргалантгайрхан, Буялхайрхан, Баатархайрхан ууланд
хийсэн цоохор ирэх (рингхета циса)-ийн судалгааны ажлын үр дүн 7

Б.Нямдорж, А.Батсүрэг, Г.Пүрэвзориг
Баруун Монголчуудын түүх, хэл соёлын судалгаанд Ховд Их Сургуулийн эрдэмтдийн
орүүлсан хувь нэмэр 16

Э.Бурмаа, Ч.Аюулсүрэн, Б.Миндсайхан, Ч.Билэгмандах, Г.Ганбилэг,
Н.Жаргалсүрэн, Б.Нансалмаа
Их зууруудын хотгорын ноёр, голуудын экосистемийн судалгаа, цаашдын
мич хандлага (Хар-Ус нуурын дэд хотгорын жишээн дээр) 23

ХОЁРДУГААР БҮЛЭГ: БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ, НОЁЦ, АШИГЛАЛТ

Abdulmuayev S.N., Kargava T.S.
Visualization of digital elevation model data at preparing a map of the Altai
mountains and vicinity (Big Altai mountains, Altai mts) 34

Абдулмуянов С.Н., Каргава Т.С.
Абдульменов с.и. визуализация данных цифровой модели высот при
подготовке карты большого Алтая 37

Агатов А.Р, Непон Р.К, Отгонбаяр Д, Золбаяр Ж, Баярмаа М
Угел,сейсмологическое исследование лавинной лавины 1988 г. в массиве Цамбагаран
(Сивалинг Монголия) Система в рельефе и влияние на осадки 41

Алексеу S, Litvinov, Igov A, Vaidenov, Zolbayar J
Modern conditions of the permafrost of the Chuya basin (Russian Altay) 43

Арапова К.Д, Савина С.М, Свиридова И.Н, Ондар А.А, Комылова Ю.Г, Хаашевская
А.А Геохимия и биология пресных аржанов Тувы 49

Д.Лхамсүх, Ч.Лхагвасүрэн
Завхан аймгийн Дорвоожин сумын туулайт орчмын нутгийн хөрсний судалгаа 58

Ч.Билэгмандах
Нутаг дэвсгэрийн хөгжлөд газаруудын нөхцлийн үзүүлэх нөлөө 66

Ч.Билэгмандах, У.Беег, Ч.Лхагвасүрэн, З.Бурмаа
Ховд их сургуулийн ГМС-ийн лабораторид туулууртан хийсэн судалгааны ажлын зарим үр дүн 74

Р.Бодбаяр, Б.Сайнбуян, Д.Сайнбаяр, М.Уртнасан, Ц.Наранцайрхал
Газар усны эрвийг мэхлэхийн саанд оруулах аргаар /Ус аймгийн жишээн дээр/ 81

Бороздано Г.С, Филандовичева Л.Б, Отгонбаяр Дэмбэрэл
Климатическая структурно-функциональная трансформация
высокогорных ландшафтов юго-восточного Алтая 86

Б.Гурмандава
Ховд аймгийн Өвгөрөө ашиглалтын оноогийн байдал 90

Х.Дондог, Ш.Цэрэнгомбо
Шүтээгээ гуугаахуй т. өөрчлөгөө танахуй мон 94

Э
С
Д
О
д
Ж
Б
Э
К
М
п
Ч
Л
Э
Ж
Х
Э
Э
М
С
Л
М
П
Д
А
В
Ф
Л
П
Р
С
Т
Д
С
Т
Т
Л
Х
П
В
С
Х
П
Т
С
Н
Н
Б
Б



ЧИНГИС ХААНЫ ЕРТӨНЦ БА МОНГОЛ СУДЛАЛ

Салбар хуралдаан - III
МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ЕРТӨНЦ

Хэзээ: 2022.08.06
Хаана: СУИС-ийн хичээлийн I байр, “Оюутан театр”
Салбар хуралдааны дарга: Г.Чулуунбаатар (Монгол Улс)
Салбар хуралдааны нарийн бичгийн дарга: Ч.Алтанцэнгэ (Монгол Улс)

Нээлтийн үг	Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч
14:00-14:10		СУИС-ийн захирал, профессор Хурлын дарга: Г.Чулуунбаатар (Монгол Улс) Хурлын нарийн бичиг: Ч.Алтанцэнгэ (Монгол Улс)	Э.Совинтогос (Монгол Улс)
14:10-14:30		Монгол төрийн ой санааж дахь соёлын бодлогын асуудал	Г.Чулуунбаатар (Монгол Улс)
14:30-14:50		Монголын залуучуудын үнэт зүйлийн чиг баримжаа, хандлага	Э.Совинтогос, Д.Одсүрэн (Монгол Улс)
14:50-15:10		Соёлын бодлогын инновац ба тогтвортой хөгжлийн зорилтууд	Ж.Эрхэмтөгс (Монгол Улс)
15:10-15:30		Хэлэлцүүлэг	
15:30-16:00		Цайны завсарлага	
16:00-16:20		Монгол соёл иргэншлийн язгуур тогтолоо, түүний онцлог, тогтвортой хөгжлийн асуудал	Х.Дондог (Монгол Улс)
16:20-16:40		Экологи, соёл, хэлний шүтээг	Ж.Баянсан (Монгол Улс)
16:40-17:10		Хэлэлцүүлэг	
17:10-17:20		Дурстгалын зураг	

Хэзээ: 2022.08.07
Хаана: СУИС-ийн хичээлийн I байр, “Оюутан театр”
Хурлын дарга: Д.Бум-Очир (Монгол Улс)
Хурлын нарийн бичиг: Д.Одсүрэн (Монгол Улс)

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч
09:00-09:20	Их Монгол Улсын төрийн ёслол тусгаар тогтнолын бэлгэдэл болж бүрэлдсэн нь	С.Дулам (Монгол Улс)
09:20-09:40	XIII зууны төрийн сүлд, түүний судалгааны тухай	Н.Маралмаа (Монгол Улс)
09:40-10:00	Монгол Улс Чингис хааны онгон, тус сүлдийг Нийслэл хүрээнд залгах оролдсон нь	Ц.Гантулга (Монгол Улс)
10:00-10:20	Бурхан Халдуны урианхадын гол шүтлэг оононы тухай	Л.Ганбат (Монгол Улс)
10:20-10:40	Хэлэлцүүлэг	
10:40-11:00	Цайны завсарлага	

Хавсралт 6 (Дөрвөн хэлний толь бичгийн эх тусдаа PDF файл хэлбэрээр байгаа)